

**ҮНДСЭН ХУУЛЬ БА
ЭРХ ЗҮЙТ ЁС
ХІІІ**

Улаанбаатар хот
2022 он



ҮНДСЭН ХУУЛЬ БА ЭРХ ЗҮЙТ ЁС-ХИИ

(Илтгэлийн эмхэтгэл)

Улаанбаатар хот
2022 он

ДАА 80
ННА 93
Ү-823

ҮНДСЭН ХУУЛЬ БА ЭРХ ЗҮЙТ ЁС-ХIII (Илтгэлийн эмхэтгэл)

2021 оны 1 дүгээр сарын 12-ны өдөр Хууль зүйн үндэсний хүрээлэнд зохион байгуулсан Монгол Улсын Төр, нийгмийн нэрт зүтгэлтэн, Ардчилсан Үндсэн хуулийн эхийг баригч, Хөдөлмөрийн баатар, Ардын багш, гавьяат хуульч, доктор, профессор Ач-Хариад Бяраагийн Чимидийн нэрэмжит эрдэм шинжилгээний уралдаанд шалгарсан илтгэлийн эмхэтгэл.

Эмхэтгэсэн:	Э.Цэрэндүзээ (ХЗСМСТ-ийн студийн мэргэжилтэн)
Эхийг бэлтгэсэн:	З.Эрдэнэтөгс (Эх бэлтгэгч, дизайнер)
Хэвлэсэн хугацаа:	2022 он
Хэвлэсэн газар:	Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн хэвлэх үйлдвэр

ISBN: 978-99978-0-378-8

2022 ОНЫ ИЛТГЭЛИЙН УРАЛДААНД ШАЛГАРСАН ИЛТГЭЛ

СУДЛААЧИЙН ИЛТГЭЛ

Сайнтөрийн ЦЭРЭНДОЛГОР Хяналтын журмаар гомдол гаргах шалгуурын үзэл баримтлал ба улсын дээд шүүхийн чиг үүрэг: Хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах арга хэрэгсэл болох нь 9

Баасандоржийн БАТБАЯР, Батсайханы ЦЭНДСҮРЭН Шинэ эрүүгийн хуулиар үндсэн хуулийн хүрээнд улсын дээд шүүхэд тавьсан шинэ сорилт (боломж), шийдвэрлэх арга зам 22

Даваагийн МЯГМАРСҮРЭН Аналог ба хүний эрхийн хамгаалалт: иргэний хэргийн шүүн таслах ажиллагааны хүрээнд 33

Ганхуягийн ЦЭРЭНДЭЖИД Шүүхийг тойргийн зарчмаар байгуулахад анхаарах зарим асуудал /анхан шатны шүүхийн жишээ дээр/..... 47

Батсайханы ӨЛЗИЙСАЙХАН Шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлого ... 64

Сэргэлэнгийн ЭНХБАЯР Иргэний шүүхийн процессын алдаа ба шүүгчийн ёс зүйн шинэчлэлийн зарим асуудал 78

ОЮУТНЫ ИЛТГЭЛ

Равданбямбын ОЮУНДЭЛГЭР Монгол Улсын Үндсэн Хуулийн үзэл баримтлал Монгол Улсын дээд шүүхийн эрх зүйн хөгжилд үр нөлөө бүхий шийдвэр гаргах чиг үүрэгт тулгарч буй сорилт ба боломж 91

Мөнхтөрийн МАРАЛМАА, Баттөрийн МЯГМАРСҮРЭН Улсын дээд шүүхэд хяналтын журмаар гомдол гаргах үндэслэлийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны онцлогт нийцүүлж, хяналтын гомдлыг хэлэлцүүлэхээс татгалзсан тогтоолын үндэслэлийг сайжруулах нь 106

Зоригтын ЯНЖИНДУЛАМ, Мэндбаярын АМИНА Шүүхийн ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүний шүүгч бус гишүүдийг Улсын Их Хурлаас томилж буй өнөөгийн практик ба тулгамдсан асуудал 119

Төгөлдөрийн БИНДЭРЪАА Шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь иргэдийн төлөөлөгчийн оролцоо, дүгнэлтийн үр нөлөө, эрх зүйн ач холбогдол 131

Чинбатын БОЛОРМАА Цахимаар шүүх хуралдааныг зохион байгуулахтай холбогдох зарим асуудал 146

Хууль зүйн үндэсний хүрээлэн
www.nli.gov.mn

ӨМНӨТГӨЛ

Үндсэн хуулийн эхийг баригч, Хөдөлмөрийн баатар, Ардын багш, гавьяат хуульч, доктор, профессор Б.Чимид нь сургалт, эрдэм шинжилгээний байгууллага, хууль зүйн шинжлэх ухаан, эрдэм судлалын ажил үйлсэд жинтэй хувь нэмэр оруулсан эрдэмтэн багш, Монгол Улсын хууль тогтоох, гүйцэтгэх болон шүүх эрх мэдлийн удирдах дээд байгууллагад олон жил үр бүтээлтэй ажилласан төр, нийгмийн нэрт зүтгэлтэн билээ.

Б.Чимид багш Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн анхны Эрдэмтэн нарийн бичгийн даргаар олон жил үр бүтээлтэй ажиллаж, хүрээлэнгийн хөгжил цэцэглэлтэд үлэмж хувь нэмрээ оруулсан бичгийн их хүмүүн юм.

Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Ардын багш, гавьяат хуульч, доктор, профессор Б.Чимид багшийн нэрэмжит шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын ажилтан, сургалт, эрдэм шинжилгээний байгууллагын багш, судлаач, оюутны эрдэм шинжилгээний шилдэг илтгэлийн уралдааныг Үндсэн хуулийн өдрийг тохиолдуулан 2009 оноос эхлэн жил бүр уламжлал болгон зохион байгуулж ирсэн. Энэ жил тус уралдааныг 2022 оны 1 дүгээр сарын 11-ний өдөр 13 дахь жилдээ зохион байгууллаа.


Уралдааныг Хууль зүйн үндэсний хүрээлэн, Чимид сан, Монгол Улсын Үндсэн хуулийн Цэц, МУИС-ийн Хууль зүйн сургууль, Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комисс, Удирдлагын академи, ШУА-ийн Философийн хүрээлэн, Монголын хуульчдын холбоо, Ханнс-Зайделийн сан, Эрх зүйт ёс сан, “Легал Дата” ХХК, Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын дэргэдэх Монголын Олон Улсын арбитра зэрэг байгууллагууд хамтран зохион байгууллаа.

Энэ удаагийн илтгэлийн уралдаанд судлаачийн салбарт 13, оюутны салбарт 11 илтгэл ирүүлснээс оюутны салбарт 5, судлаачийн салбарт 6 илтгэл 2 дугаар шатанд шалгаруулсныг Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс уламжлал ёсоор эмхэтгэн хуульч, судлаач Та бүхэнд толилуулж байна.

Энэхүү шилдэг илтгэлийн эмхэтгэл нь Б.Чимид багшийн оюунлаг үйл хэргийн үргэлжлэл төдийгүй хууль зүйн шинжлэх ухааны онол, практикийн хөгжилд ач тусаа өгөхүйц чухал эх сурвалж болно гэж найдаж байна.

Номын цагаан буян үргэлжид дэлгэрэх болтугай.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН ЗАХИРАЛ,

Хууль зүйн ухааны доктор  Х.ЭРДЭМ-УНДРАХ

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

СУДЛААЧИЙН САЛБАРТ ШАЛГАРСАН ИЛТГЭЛ

Хууль зүйн үндэсний хүрээлэн
www.nli.gov.mn



Сайнтөрийн ЦЭРЭНДОЛГОР

Хуульч
(Тэргүүн байр)

ХЯНАЛТЫН ЖУРМААР ГОМДОЛ ГАРГАХ ШАЛГУУРЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ БА УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ЧИГ ҮҮРЭГ: ХУУЛЬ ХЭРЭГЛЭЭНИЙ НЭГДМЭЛ БАЙДЛЫГ ХАНГАХ АРГА ХЭРЭГСЭЛ БОЛОХ НЬ

Шүүх эрх мэдлийн зохих чиг үүрэг нь хууль тайлбарлах, хэрэглэх болохоос түүнийг батлах биш юм.

- Сандра Дэй О'Коннор¹

ТОВЧЛОЛ

Монгол Улсын хууль зүйн салбарт сүүлийн гурван жилд гарсан өөрчлөлтөөс ирэх жилүүдийн өнгө тодорхойлогдоно гэхэд хилсдэхгүй бөгөөд 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт, 2021 оны Шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулга зэрэг суурь хуулиудын хэрэгжилтийн үр нөлөө, зохицуулалтын тогтвортой байдал хэрхэх бол гэсэн томоохон сорилт биднийг хүлээж байна.

Хууль тогтоогчоос Шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад зарчмын шинжтэй шинэ зохицуулалт хэд хэдийг хуульчилсан ба салбарын мэргэжилтэн, хууль хэрэглэгч субъектүүдийн дунд өрнөх хэлэлцүүлэг эрчимтэй байгаа энэ үед судлаач, хуульч, өмгөөлөгчдийн санал, бодлоо уралдуулж байгаа сэдэв нь хяналтын журмаар гомдол гаргах үндэслэл яах аргагүй мөн билээ.

Энэ нь хэдийгээр дотоодын эрх зүйд цоо шинэ биш боловч шинэлэг зохицуулалт болсон, мөн эрх зүйн соёл өндөр хөгжсөн бусад улсуудын хувьд “шүүлтүүрийн тогтолцоо” (англ. *filtering system*); “шүүлтүүрийн арга хэрэгсэл” (англ. *filtering mechanism*); сонгох шалгуур (англ. *the Selection Criteria*) хэмээх томъёоллоор өмнө нь байсан, одоо ч байгаа ойлголт юм. Иймд энэхүү ойлголтын үзэл баримтлал, Монгол Улсын хөрсөнд “албан ёсоор” хуульчлагдсан нь бусад улсынхтай дүйх эсэх, зарим судлаачийн асууж байгаа шиг үүнийг “Stare decisis”-ийн зарчмын эхлэл тавигдсан гэж

¹ Америкийн нэгдсэн улсын Дээд шүүхийн шүүгч асан

үзэх эсэх, хэрэв тийм бол энэ нь Монгол Улсын эрх зүйн тогтолцооны соёл, уламжлалтай зөрчилдөх эсэх, үгүй бол өөрөөр хэрхэн ойлгож хэрэглэх зэрэг асуултад хариулт эрснээс үндэслэн энэхүү илтгэлийг бичлээ.

Илтгэл нь Удиртгал, Үндсэн хэсэг, Дүгнэлт гэсэн үндсэн гурван хэсгээс бүрдэх бөгөөд Үндсэн хэсэг нь 4 дэд хэсгээс бүрдэнэ.

Энэхүү илтгэлд бичсэн агуулга, санаа нь илтгэл бичигчийн хувьд судлаачийн үүднээс хандаж, гагцхүү онолын талаас нь судлахыг хичээсэн бичил судалгаа бөгөөд практик нөхцөл байдал, хэрэгжүүлэх арга замыг хөндөөгүй, мөн аливаа байгууллагын үзэл баримтлал, байр суурийг төлөөлөхгүй болохыг дурдах нь зүйтэй.

I. УДИРТГАЛ

Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн² шинэчилсэн найруулгын 25 дугаар зүйлийн 25.7.5 дахь заалтад зааснаар Улсын дээд шүүх /цаашид “УДШ” гэх/ хяналтын журмаар “хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах” зорилгоор (1) анхан болон давж заалдах шатны шүүхийн хууль хэрэглээний зөрүүг арилгах; (2) хуулийг Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн; (3) хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ноцтой зөрчил гаргасан нь шүүхийн шийдвэрт нөлөөлсөн гэсэн гурван үндэслэлийн аль нэг нь байвал хэрэг хянан шийдвэрлэхээр шалгуур тогтоосон байна.

Үүнээс өмнө үйлчилж байсан 2012 оны Шүүхийн тухай хуулийн³ 17 дугаар зүйлийн 17.1-д “Улсын дээд шүүх нь давж заалдах шатны шүүхийн иргэн, эрүү, захиргааны хэргийн магадлалтай холбогдуулан гаргасан эрх зүйн маргааныг талуудын гомдол, Улсын ерөнхий прокурор, эсхүл түүний эрх олгосон прокурорын эсэргүүцлийн үндсэн дээр хяналтын журмаар хянан шийдвэрлэнэ” гэж заасан байсан. Хэдийгээр УДШ-ийн чиг үүргийг “... давж заалдах гомдлоор хянан шийдвэрлэсэн хэргийг шүүх хэрэг хянан шийдвэрлэхдээ хууль буруу хэрэглэсэн, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг ноцтой зөрчсөн гэж үзсэн тохиолдолд хэргийн оролцогчдоос хяналтын журмаар гаргасан гомдлыг хянан хэлэлцдэг ийм шүүх”⁴ хэмээсэн, өмнө нь практикт эл ойлголт тодорхой хэмжээгээр байсан гэж хэлж болох боловч одоогийн Шүүхийн тухай хуулийн зохицуулалт хэлбэрийн төдийгүй зарчмын хувьд шинэлэг зохицуулалт болсон гэж үзэх үндэслэлтэй.

Энэхүү гомдол хүлээн авах шалгуур тогтоосон зохицуулалтыг шүүх эрх мэдлийн хүрээнд “шүүлтүүрийн тогтолцоо” (англ. *filtering system*); “шүүлтүүрийн арга хэрэгсэл” (англ. *filtering mechanism*) хэмээх томъёоллоор илэрхийлдэг ба хяналтын журмаар гомдол хүлээн авах

² Төрийн мэдээлэл эмхэтгэл (2021) №05

³ Тус хуулийг 2021 оны 3 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсон.

⁴ УДШ-ийн шүүгч асан Л.Атарцэцэгийн “Зууны мэдээ” сонины 2014 оны 6 дугаар сарын 4-ний №128/4755/ дугаарт нийтлэгдсэн ярилцлага. Л.Амгаланбаатар “Монгол Улс дахь шүүхийн жишгийн гүйцэтгэх чиг үүрэг ба механизм” *Шүүх эрх мэдэл сэтгүүл* 2019 №1: 140 дэх талаас дам эшлэв.

зохицуулалтаар нь дэлхийн улсуудыг шүүлтүүрийн тогтолцоотой, тогтолцоогүй буюу “шалгуур тогтоосон”, “шалгуур тогтоогоогүй” гэж ангилж болох юм.

Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх ердийн хугацаа⁵ болоогүй ч хуульч, судлаачдын дунд дээрх зохицуулалтын талаар УДШ гомдол хүлээн авахаас олноор нь татгалзаж байгаа нь үндэслэлтэй, үндэслэлгүй гэх маргаантай асуудал гарч байгааг дурдахгүй өнгөрч боломгүй. Гэвч судлаачийн зүгээс энэхүү илтгэлийг бичихдээ практик хэрэгжилт, тоон судалгааг хөндөөгүй, мөн гурван үндэслэл тус бүрийг дэлгэрүүлэн авч үзэхгүйгээр гагцхүү ерөнхий үзэл баримтлал, цаашдын хандлагыг онолын үүднээс бусад улсын туршлагатай харьцуулан судлахыг зорьсон гэдгийг цохон тэмдэглэмээр байна.

II. ҮНДСЭН ХЭСЭГ

2.1. УДШ хяналтын журмаар гомдол хүлээн авах шалгуурын тухай ялгаатай байр суурь

УДШ хяналтын журмаар гомдол хүлээн авах шалгуурыг Үндсэн хуулийн эрх зүй, тэр дундаа Үндсэн Хуульд заасан “шүүхэд хандах эрх”-тэй холбох, эдгээр асуудлыг хооронд нь сөргүүлэн тавих нь бий. Нэг талаас дээд шүүх хяналтын журмаар хүлээн авах гомдолд шалгуур тогтоох нь “Дээд шүүхэд хандах эрх” (англ. *Right of Access to Supreme Courts*)-ийг хөндөж байна⁶ гэж үзэх, эсрэгээрээ энэ нь хүний эрхээс илүү шүүгчийн эрх хэмжээ (англ. *Judicial discretion*)⁷-ний асуудал гэж үзэх⁸, нөгөө талаас эл ойлголт нь хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах зорилготой гэж үзэх, эсхүл шүүхийн ачааллыг бууруулах замаар шүүхийн бие даасан байдлын баталгааг хангана гэж үзэх зэрэг олон талын үзэл баримтлалыг гадаад хэлээрх холбогдох эрдэм шинжилгээний өгүүллүүдэд дурджээ.

УДШ-д хяналтын журмаар гомдол хүлээн авах шалгуурыг хуулиар тогтоосон нь Үндсэн Хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх хэсэгт заасан “шүүхэд гомдол гаргах, шүүхийн шийдвэрийг давж заалдах” эрхийг хөндсөн эсэх тухайд:

⁵ Хууль тогтоомжийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3-т зааснаар хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг 5 жил тутамд үнэлэх бөгөөд шаардлагатай бол уг хугацаанаас өмнө хийнэ.

⁶ Nikolina Katić, Matea Bašić, Morana Briški, “Right of Access to Supreme Courts in Light of the Guarantees under Article 6 § 1 of the Convention on Human Rights and Fundamental Freedoms (civil aspect)” *Croatian International Relations Review-CIRR* XXIV (81) 2018: 69-90, <https://cirj.org/index.php/cirj/article/download/87/83/78>

⁷ Judicial Discretion гэх тогтсон нэр томьёог “шүүгчийн үзэмж” гэж орчуулах нь учир дутагдалтай санагдсан хэдий ч “шүүгчийн эрх хэмжээ” гэх нь мөн л оносон орчуулга биш болохыг судлаачийн зүгээс тэмдэглэв. Ерөнхийдөө эл ойлголт нь хуулийн зарчмыг удирдлага болгон дотоод итгэл, дүгнэлтдээ үндэслэн шийдвэр гаргах шүүгчийн бүрэн эрхийг хэлдэг жишгийн эрх зүйн ойлголт юм.

⁸ Rimvydas Norkus, *The Filtering of Appeals to the Supreme Courts. Network of the presidents of the Supreme judicial Courts of the EU*, p.4 <http://www.lat.lv/download/1369/introductory%20report%20-%20the%20filtering%20of%20appeals%20to%20supreme%20courts%20> [Сүүлд үзсэн: 2021.12.10]

Хяналтын журмаар гомдол гаргах шалгуур тогтоосон нь Үндсэн Хуулиар баталгаажуулсан “шүүхэд хандах, шүүхийн шийдвэрийг давж заалдах эрх”-ийг хөндсөн, хязгаарласан эсэх асуулт урган гарах нь дамжиггүй. Олон нийтийн цахим сүлжээн дэх “бүлэг”-т эл асуудлаар Үндсэн хуулийн цэцэд гомдол гаргах тухай хэлэлцүүлэг өрнөж байсан.

Литва Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч Римвидас Норкус “Дээд шүүхэд гомдол гаргах шалгуур” сэдэвт өгүүлэлдээ “хорьдугаар зууны сүүлч үед профессор Хологицийн Дээд шүүхүүд нийтийн зорилго (англ. *public purpose*)-д түлхүү үйлчлэх ёстойтой бид бүрэн санал нийлнэ гэж байсан дүгнэлт өнөөдөр “яаж?” гэсэн асуултаар солигдох шаардлагатай боллоо”⁹ гэжээ.

Энд тухайлан жишээ дурдахад, Унгар болон Бүгд Найрамдах Чех Улсын Үндсэн хуулийн шүүхээс дээд шүүхийн норматив чиг үүргийг бэхжүүлэхэд чиглэсэн гомдол хүлээн авах шалгуур нь Үндсэн хууль зөрчсөн гэж тус тус шийдвэрлэжээ¹⁰. Чех Улсын Дээд шүүх гомдлыг хүлээн авч хэрэг хянан шийдвэрлэх гол шалгуур нь “эрх зүйн өндөр ач холбогдолтой байх” гэж заасан байсныг тийнхүү Үндсэн хуульд нийцээгүй гэж хүчингүй болгосон бол Унгар Улсад “хэрэг маргаан нь шүүхүүдийн уялдааг хангах”-аар байвал хяналтын журмаар хянан шийдвэрлэдэг байсныг мөн Үндсэн хуульд нийцээгүй, хууль зүйн тодорхой байдалд харшилсан гэж үзэж хүчингүй болгожээ¹¹.

Түүнчлэн, гомдол хүлээн авах шалгуурын процесстой холбогдуулан Польш Улсад хяналтын гомдол хүлээн авахаас татгалзсан тухайгаа бичгээр шийдвэр гаргахгүйгээр аман хуралдаанаар шийдвэрлэх нь Үндсэн хуульд нийцэхгүй гэж үзсэн байна. Армени Улсын хувьд мөн хэргийн оролцогчийн хяналтын журмаар гаргасан гомдлыг хүлээн аваагүй үндэслэлээ дурдах хууль зүйн шалгуурыг хангахгүй байх учир Үндсэн хуульд нийцэхгүй гэж шийдвэрлэсэн¹².

Дурдсан улсууд нь бичмэл Үндсэн хуультай бөгөөд шүүхэд хандах эрхийг тодорхойлохдоо чухам аль шатны шүүхэд хандах, аль хүртэл хандаж болохыг Үндсэн хуульдаа тодорхойлоогүй тул дээрх байдлаар шийдвэр гаргах нь зүйн хэрэг байж болох мэт. Гэсэн хэдий ч нөгөө талаас Дээд шүүхэд хяналтын журмаар гомдол гаргах хүрээг тогтоох нь хууль тогтоогчийн бүрэн эрх гэж үздэг Бельги, Швед, Австри, Эстони зэрэг улсууд¹³ байна. Европын Холбооны гишүүн улсуудаас авсан асуумжийн хүрээнд дээд шүүхэд хяналтын журмаар хандах эрхийг Үндсэн хуульдаа шууд тодорхой хуульчилсан улс байхгүй байсан¹⁴ тул Үндсэн хууль зөрчсөн гэж үзэх нь учир дутагдалтай юм.

⁹ Ibid.

¹⁰ Ibid.

¹¹ Ibid.

¹² Ibid.

¹³ Ibid.

¹⁴ Ibid.

Италийн судлаач эл асуудлыг хөндөхдөө “Италийн Үндсэн хууль (1948)-ийн 111 дүгээр зүйлийн долоо дахь цогцолборт заасан дээд шатны шүүх (итал. *Corte di Cassazione*)”-д хууль зөрчсөн шүүхийн шийдвэр бүрийн эсрэг хандах эрхийн зохицуулалт Италийн Дээд шүүхэд асуудал дагуулж байгааг залруулах ганц арга зам нь дээд шүүхэд хандах Үндсэн хуулийн баталгааг хүчингүй болгох юм”¹⁵ гэжээ.

Монгол Улсын хувьд Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14-т “... шүүхэд гомдол гаргах, ... шүүхийн шийдвэрийг давж заалдах ... эрхтэй” хэмээн хуульчилсан. Иймд манай хуулиар баталгаажуулсан шүүхэд хандах эрхийн агуулгад “давж заалдах эрх” гэдгийг хяналтын журмаар гомдол гаргах эрх гэж ойлгох эсэх асуудал яригдана. Монгол Улсын шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эрүү, иргэн, захиргааны эрх зүйн салбарын процессийн хуулиудад давж заалдах гомдол гаргах, хяналтын журмаар гомдол гаргахыг тусад нь зохицуулсан, мөн практикт давж заалдах эрх гэхээр хууль хэрэглэгчид хяналтын журмаар гомдол гаргах тухай ярьж байна гэж ойлгохгүй тул Үндсэн хуулийн зохицуулалтын агуулгыг гагцхүү анхан шатны шүүхийн шийдвэрийг давж заалдах эрхийг хуульчилсныг ойлгох, харин хяналтын журмаар гомдол гаргах эрхийг Үндсэн хуулиар шууд хуульчлаагүй гэж үзэх үндэслэлтэй юм.

Иймд хяналтын журмаар гомдол гаргах шалгуур нь үндсэн эрхийг хөндсөн гэхээс илүү УДШ-ийн чиг үүрэг, үндсэн зорилгод хамаарах асуудал гэсэн байр суурийг судлаачийн зүгээс дэмжиж байна.

2.2. Хяналтын журмаар гомдол гаргах шалгуурын “жинхэнэ” зорилго, мөн чанар, үндэслэл буюу УДШ-ийн үндсэн чиг үүрэг

А. Гомдол гаргах шалгуур тогтоосон зохицуулалтын үндсэн зорилгыг тодруулахыг оролдох нь

УДШ хяналтын журмаар гаргасан гомдол бүрийг хүлээн авахгүй байх зохицуулалт нь өнгөц харахад дээд шүүхийн ажлын ачааллыг бууруулах хууль тогтоогчийн зорилго мэт санагдах хэдий боловч эндээс УДШ-ийн чиг үүргийн хүрээ, тус шүүхийн үндсэн мөн чанар, зорилго юу байх ёстойг тодорхойлох шаардлага үүснэ. Түүний үндсэн дээр хууль тогтоогчийн зорилго хэрэгжих эсэхийг дүгнэх боломжтой болох билээ.

УДШ-ийн үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх чиг үүргийг үйлчлэх зорилгоор нь онолын хувьд хувийн, нийтийн гэж хоёр ангилдаг:

- УДШ хувийн зорилго (англ. *private purpose*)-д үйлчлэх: Дээд шүүх нь хэргийн оролцогчийн хүлээлтийг хангахын тулд хэрэг нэг бүрд тохирсон шийдэл олох, талуудын эрх, ашиг сонирхлын үүднээс хуулийг боловсронгуй болгох үйлд нэмэртэй биш байсан ч доод шатны шүүхүүд хуулийг зөв хэрэглэсэн эсэхийг нэг бүрчлэн хянан

¹⁵ Chiarloni, S. Fundamental Tasks of the *Corte di Cassazione*, Heterogeneous Objectives Arose from the Constitutional Right to Appeal and Recent Reforms. In *Los recursos ante Tribunales Supremos en Europa. Appeals to Supreme Courts in Europe*. Ortells Ramos, Manuel (coord.). Barcelona: Difusión Jurídica y Temas de Actualidad, 2008, p. 77, 79.

үзэхийг¹⁶ ойлгоно.

- УДШ нийтийн зорилго (англ. *public purpose*)-д үйлчлэх: Дээд шүүх хуулийг боловсронгуй болгох, нэгдмэл байдлыг хангах замаар нийтийн ашиг сонирхлыг бэхжүүлэхийг¹⁷ ойлгоно.

Европын Холбооны гишүүн орнуудын дээд шүүхээс 2015 онд авсан асуулгад олон шүүх хувийн зорилгоос илүү нийтийн зорилгод үйлчилдэг хэмээн тодорхойлсон¹⁸ байна.

Ийнхүү тунгаавал гомдол хүлээн авах шалгуур тогтоох, тийнхүү шалгуурын үндсэн дээр гомдлыг хүлээн авч хянан шийдвэрлэх нь явцуу утгаараа шүүхийн зардал, төсөв, ачааллыг бууруулах зорилготой мэт хэдий ч өргөн утгаараа дээд шүүхийн чиг үүргийг үндэсний хэмжээнд хэрхэн авч үзэх, тус шүүх дотоодын эрх зүйн тогтолцоо, соёл, уламжлалд ямар үүднээс хувь нэмэр оруулахыг тодорхойлох зорилготой гэж хэлж болох юм. Өөрөөр хэлбэл, дээд шатны шүүх нь доод шатны шүүхтэй нэгэн адил чиг үүргийг л хэрэгжүүлэх хэрэг үү, эсхүл эрх зүйн хөгжлийн үүднээс арай өөр зорилгод үйлчлэх үү гэдгийг хэрхэн тодорхойлохоос хамаарна.

Харин Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад УДШ хяналтын журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилго нь “хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангуулах” байх учиртайг хуульчилж, гомдол хүлээн авах тодорхой шалгуур тогтоосон нь хууль тогтоогчийн зүгээс дээд шүүх нийтийн зорилгод үйлчлэхийг тодорхойлсон. Үүгээрээ дотоодын эрх зүйн хөгжилд хувь нэмэр болохуйц авууштай зохицуулалт болсныг дурдах нь зүйтэй. Тус зохицуулалт нь 2017 онд Европын Шүүгчдийн Зөвлөлдөх Зөвлөл (англ. *Consultative Council of European Judges* (CCJE))-өөс гаргасан “Хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангуулах талаарх шүүхүүдийн гүйцэтгэх үүрэг” хэмээх 20 дугаар зөвлөмжид¹⁹ “Зөвлөлийн үзэж буйгаар дээд шүүхийн нийтийн чиг үүрэг нь *pro futuro*²⁰ хуулийг боловсронгуй болгох, хуулийн нэгдмэл байдлыг хангах үйл ажиллагаанд гомдол гаргах зүй ёсны шүүлтүүрийн тогтолцоогоор дамжуулан чиглэл өгөхөөс бүрдэнэ²¹” гэсэнд нийцэх юм. Монгол Улс Европын Холбооны гишүүн биш бөгөөд тус Зөвлөлд харьяалагддаггүй учир зөвлөмжийг нь заавал дагаж мөрдөх үүрэг хүлээхгүй боловч эрх зүйн соёл өндөр хөгжсөн улсууд, мөн Монгол Улстай адил эх газрын эрх зүйн бүлийн улсууд гишүүдийнх нь олонхыг бүрдүүлдэг учир тэдний хандлага, жишгийг харгалзан үзэхэд хэзээд илүүдэхгүй гэх үүднээс энд дурдлаа.

¹⁶ Jolowicz, J.A., 1997. The role of the Supreme Court at the national level a General Report. In Yessiou-Faltsi P., ed. *The Role of the Supreme Courts at the National and International Level*, Athens: Sakkoulas Publications. *Supra* note 6, p.73-аас дам эшлэв.

¹⁷ Ibid.

¹⁸ Norkus, *supra* note 8, p.8.

¹⁹ CCJE, The Role of Courts with Respect to the Uniform Application of the Law, *Opinion No 20* (2017), <https://rm.coe.int/opinion-no-20-2017-on-the-role-of-courts-with-respect-to-the-uniform-a/16807661e3> [Сүүлд үзсэн: 2021.12.24]

²⁰ “Өдгөө цагт, өнийн ирээдүйд ч хэвээр үргэлжлэх” гэсэн утгатай латин хэллэг. - С.Ц.

²¹ CCJE, *supra* note 19, p.5.

Гэхдээ чиг үүргийг нь юу ч гэж тодорхойлсон, гомдол гаргах шалгуурын ямар ч арга хэрэгслийг хэрэглэсэн бай дээд шүүхийг доод шатны шүүхээс ялгах онцлогийн нэг нь уг шүүх бол шүүх эрх мэдлийн шатлалын дээд байгууллага мөн гэдэг бодит факт юм. Энэ утгаар нь дээд шүүхээс хуулийг тодорхой болгох, түүний хэрэглээний нэгдмэл байдлыг хангах, хувьсан өөрчлөгдөх нөхцөл байдалд дасан зохицохуйц эрх зүйн жишиг тогтоохыг аяндаа хүлээж таарна²².

Түүнчлэн, УДШ цөөхөн гомдол хүлээн авах болсноор ачаалал тодорхой хэмжээгээр буурахыг үгүйсгэхгүй боловч тийнхүү гомдол хүлээн авч, хэрэг хяналтын журмаар хянан шийдвэрлэхээс татгалзахдаа өнгөцхөн хараад татгалзах бус хэргийн хавтас, хоёр шатны шүүхийн шийдвэр, магадлал, хяналтын журмаар гаргасан хэргийн оролцогчийн гомдол зэрэгтэй нэг бүрчлэн танилцсаны үндсэн дээр шийдвэрлэх нь зүйтэй ба энэ тохиолдолд ачаалал буурах бус харин эсрэгээрээ байх магадлалтай билээ. Иймд ачаалал буурсан, шүүгч нарын ажлыг хөнгөлсөн явцуу зохицуулалт гэхээс илүү практикт зөв хэрэгжүүлж чадвал өргөн утгаараа маш ач холбогдолтой, хууль хэрэглээний нэгдмэл байдал бэхжих боломжтой юм.

Б. Гомдол гаргах шалгуурын загварын төрөл

Гомдол гаргах шатлалаар нь:

(1) Дараалсан шатлал бүхий загвар (англ. *Cassation Model*): Хяналтын журмаар гомдол гаргахдаа анхан шатны шүүх, давж заалдах шатны шүүхээр аль алианаар нь шийдвэрлэсэн шийдвэрт гомдол гаргадаг загвар. Дийлэнх улсууд энэ загварт багтаж байна;

(2) Үсрэнгүй давж заалдах загвар (англ. *a Leapfrog or leave-to-ap-peal model*): Анхан шатны шүүхийн шийдвэрт дээд шүүхэд шууд хяналтын журмаар гомдол гаргаж болох загвар. Ийм загварын гол төлөөлөл нь ИБУИНХУ, Ирланд, Норвеги, Польш, Дани, Швед болно. Гэвч энэ төрлийн загварыг ашигладаг орнуудын хувьд Польшийг эс тооцвол Үндсэн хуулийн шүүх гэж тусдаа байдаггүйг²³ анхаарах нь зүйтэй байна.

Дараалсан шатлал бүхий загварыг ерөнхийд нь дараах байдлаар гурав ангилж болно:

- Хяналтын журмаар гомдол гаргах шалгуурыг тодорхой тогтоосон загвар: Шалгуур буюу үндэслэлийг тодорхой тогтоосон бол гагцхүү шалгуур хангасан гомдлыг хүлээн авч шийдвэрлэх ба доод шатны шүүх хоорондын хууль хэрэглээний зохистой байдлыг хангахад жишиг тогтоох замаар ажилладаг²⁴ гэж болно.
- Хяналтын журмаар гомдол гаргах шалгуурыг тодорхой тогтоогоогүй загвар: Шалгуур тогтоогоогүй, үндэслэл гэх зүйлийг нэг бүрчлэн авч

²² Katić, Bašić, Briški, *supra* note 6, p.72.

²³ Ibid, Katić, Bašić, Briški, p.74.

²⁴ T.Zembrzusi, "Access to the Supreme Court-Polish approach". Colloquium of the procedural law *The functions of the Supreme Court-issues of process and administration of justice*, 11-13 June 2014 (Warsaw: University of Warsaw, Faculty of Law and Administration, 2014), http://colloquium2014.uw.edu.pl/wp-content/uploads/sites/21/2014/01/ZEMBRZUSKI_-Access-to-the-Supreme-Court_-Polish.pdf [Сүүлд үзсэн: 2021.12.10.]

үздэггүй улсууд Франц, Бельги, Нидерланд, Эстони, Испани, Грек, Итали зэрэг болно. Ийм загвар бүхий улсуудад хяналтын журмаар гомдол гаргах эрхийг гагцхүү дээд шүүхэд томилогдсон тусгай буюу мэргэшсэн хуульч эсхүл холбогдох туршлагын шаардлагыг хангасан хүн эдэлдэг байна.

- Холимог загвар: Дээрх хоёр загварын холимог. Зарим тохиолдолд хяналтын журмаар гаргасан гомдлыг шалгуур тогтоон хүлээн авч шийдвэрлэх, зарим тохиолдолд шалгуур тогтоохгүй хүлээн авна. Ийм загварын жишээ нь Литва Улс юм.

Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7.5 дахь заалтаас үзвэл гомдол гаргах шалгуурыг тодорхой тогтоосон, дараалсан шатлалаар гомдол гаргах загварт хамаарагдахаар байна.

2.3. Хяналтын журмаар гомдол гаргах шалгуур тогтоосон зохицуулалтууд нь Монгол Улсад жишгийн эрх зүй хөгжих эхлэлийг тавьсан эсэх

Илтгэлийн эхэнд дурдсанчлан судлаачийн зүгээс хяналтын журмаар гомдол гаргах гурван үндэслэл тус бүрийг дэлгэрүүлэн авч үзээгүй бөгөөд практик хэрэгжилтийг хөндөхгүй байхаар шийдсэн билээ. Гэсэн хэдий ч энэ хэсэгт дурдахгүй өнгөрч болохгүй асуудал нь ийнхүү дээд шүүх нийтийн зорилгод үйлчлэх буюу хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах зорилготой юм бол энэ нь Монгол Улсад жишгийн эрх зүй хөгжих “албан ёсны” эхлэл болох эсэх тухайд дотоодын эрдэм шинжилгээний эх сурвалжуудад аль болох дурдаагүй өнцгөөс хариулт эрэхийг хичээлээ.

Юуны өмнө, шүүхийн жишиг тогтоосон шийдвэр буюу прецедент нь Монгол Улсын эрх зүйн тогтолцоонд албан ёсны заавал дагаж мөрдөх шинж бүхий эх сурвалж болдоггүй хэдий ч байх боломжтой талаар судлаач Л.Амгаланбаатар “УДШ хяналтын чиг үүргийнхээ хүрээнд тодорхой хэрэг маргааныг шийдвэрлэх замаар хуулийг тайлбарлаж хэрэглэсэн шийдвэрийг жишиг шийдвэр гэж ойлгож болохоор байна”²⁵ гээд эх газрын эрх зүйн тогтолцоотой боловч дээд шүүхийн жишиг тогтоосон шийдвэрийг доод шатны шүүх албан бусаар заавал дагаж мөрдөх шинжтэйгээр зохицуулдаг Япон Улс, АНУ-ын Луйзиана мужийн жишээгээр тайлбарласан.

Мөн судлаач, хууль зүйн ухааны доктор Ц.Цогт энэ талаар “Хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах зорилгоор анхан болон давж заалдах шатны шүүхийн хууль хэрэглээний зөрүүг арилгах үндэслэлээр хэрэг маргааныг хяналтын журмаар хянан шийдвэрлэх болсон нь stare decisis буюу жишгээр шийдвэрлэх зарчим манай улсын эрх зүйн системд нутагших эхлэлийг тавьсан уу? гэдэг асуулт урган гарч байна”²⁶ гэж

²⁵ Л.Амгаланбаатар “Монгол Улс дахь шүүхийн жишгийн гүйцэтгэх чиг үүрэг ба механизм” *Шүүх эрх мэдэл сэтгүүл* 2019 №1: 145 дахь тал

²⁶ Ц.Цогт “Захиргааны эрх зүйн хэм хэмжээг тайлбарлах нь: Шүүхийн жишиг? түүний оролцоо” *Үндсэн хуулийн болон захиргааны эрх зүйн үндсэн асуудлууд: Хямралын үеийн тулгамдсан асуудал* сэдэвт ЭНХ-д тавьсан илтгэл (УБ: 2021.11.21)

илтгэлдээ дурдахдаа мөн АНУ-ын Луйзиана мужийн жишээг авсан.

Европын Шүүгчдийн Зөвлөлдөх Зөвлөлийн зөвлөмжид “иргэнлэг эрх зүйн тогтолцоотой орнуудад ялангуяа дээд шүүхийн чиг үүрэг нь жишгийн эрх зүйн нэгдмэл байдлыг хангах болдгийн хувьд шийдвэрийг нь харгалзан үзэж байна. Иргэнлэг эрх зүйн тогтолцоонд хэдий доод шатны шүүхүүд дээд шатны шүүхийн шийдвэрт заавал баригдахгүй боловч ижил төрлийн хэрэг маргаанд дээд шүүхийн шийдвэрийг баримталдаг. Бүр зарим иргэнлэг эрх зүйн уламжлалт орнуудад дээд шүүхийн их танхим (англ. *grand chamber*; лат. *en banc*)-ийн шийдвэрийг бүх шатны шүүх болон дээд шүүхийн бүх танхим заавал дагаж мөрддөг”²⁷ гэжээ. Энэ утгаар дээд шүүхийн тодорхой төрлийн хэрэг маргаан хянан шийдвэрлэсэн шийдвэр нь эрх зүйн эх сурвалжид тооцогдох боломжтой талаар мөн зөвлөсөн байна. Иймд тэр тусмаа хууль тогтоох түвшинд шүүхийн зохион байгуулалт, ялангуяа дээд шүүхийн чиг үүрэгтэй холбогдох, дээд шүүхэд хяналтын журмаар гомдол гаргах шалгуур тогтоосон зохицуулалт зайлшгүй шаардлагатай²⁸ тэмдэглэжээ.

Монгол Улсын хуульд зохицуулсан эл зохицуулалтыг жишгийн эрх зүй нутагших эхлэл болсон үгүйг шууд дүгнэхэд эрт бөгөөд чухам ийм тохиолдолд жишгийн эрх зүй нутагшсан байна гэж үздэг тогтсон томьёо (*formula*) байхгүй учраас энэхүү асуудлыг хууль хэрэглээг боловсронгуй болгох, түүний нэгдмэл байдлыг хангах чиг үүргийн хүрээнд тайлбарлаж болох юм.

Тухайлбал, судлаач, хууль зүйн ухааны доктор Ц.Цогт дээрх илтгэлдээ шүүхийн шийдвэр боловсруулах журмын талаар товч өгүүлэхдээ шүүхийн шийдвэр гаргах үндэслэл болгож, тогтоох хэсэгт баримтлахгүйгээр шүүхийн шийдвэр, УДШ-ийн албан ёсны тайлбарыг эшилж болох талаар²⁹ дурдсан.

Хяналтын журмаар гомдол гаргах шалгуур тогтоосон зохицуулалтын гол зорилго нь УДШ хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангахад чиглэсэн гэж дүгнэж болох учраас зохицуулалтын үр нөлөө нь гагцхүү УДШ-ээс бус доод шатны шүүхүүдийн шийдвэрээс шууд хамааралтай юм. Энэ талаар Финландын дээд шүүхийн шүүгч Юкка Сиппо “гомдол гаргах шүүлтүүрийн тогтолцоо дангаараа хангалтгүй. Ийнхүү шалгуур тогтоосныг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд доод шатны шүүхүүдийн шийдвэр хуульд заасан шаардлага хангасан байх ёстой. Тэгж гэмээнэ дээд шүүх үр дүнтэй ажиллаж чадна. Нөгөө талаас шалгуур тогтоосон зүй ёсны арга хэрэгсэлгүйгээр энэ бүхэн хэрэгжих ямар ч боломжгүй юм”³⁰ гэжээ.

²⁷ CCJE, *supra* note 19, p.3.

²⁸ Ibid.

²⁹ Ц.Цогт, *supra* note 26.

³⁰ Jukka Sippo, “Filtering the Appeals to the Supreme Court: The Finnish Approach” Speech held in *The International Supreme Courts Conference “Supreme Courts in Changing Times”* in Brno, Czech Republic 6.11.2018. https://korkeinoikeus.fi/fi/index/ajankohtaista/puheet_1/2018/aspeechbyjusticejukkasisippointheinternational-supremecourts-conference8220supremecourtsinchangingtimes8221inbrnoczechrepublic6.11.2018filteringtheappealstothethefinnishapproach.html [Сүүлд үзсэн: 2021.12.10]

Иймд анхан шатны шүүхийн шийдвэр, давж заалдах шатны шүүхийн магадлалд өмнөх шүүхийн шийдвэрийг дурдах нь жишгийн эрх зүй бий болгохоор шууд санаархах, манай эрх зүйн тогтолцооны соёл, уламжлалтай харшилдах хэрэг огт биш бөгөөд харин хууль хэрэглээний нэгдмэл байдлыг боловсронгуй болгох, шүүхийн шийдвэр хууль ёсны, үндэслэлтэй байх хүрээнд хийгдэх зайлшгүй ажиллагаа юм гэсэн өнцгийг судлаачийн зүгээс дэмжиж байна.

2.4. Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7.5-д заасан гурван үндэслэл хэрэгжих боломжийн тухайд товч дурдах нь

Энэхүү илтгэлд хяналтын журмаар гомдол гаргах гурван үндэслэл буюу шалгуурыг дэлгэрүүлэн авч үзэхгүй, практик хэрэгжилт, тоон мэдээллийг хөндөхгүй байхаар шийдсэн нь дараах учир шалтгаантай: (1) Хэрэгжилтийн үр дагаврын үр нөлөөг үнэлэхэд харьцангуй эрт байгаа, учир нь асуудал хуулийн зохицуулалт, томьёололд байгаа юу, хэрэгжүүлэх арга замд байгаа юу гэдгийг эхлээд тодорхойлох шаардлагатай; (2) илтгэл бичигч миний бие практик хэрэгжилт, тоон мэдээллийг³¹ хөндөхөд хангалттай туршлагагүй бөгөөд гүнзгий мэдэхгүй зүйлийнхээ талаар аливаа дүгнэлт хийхээс зайлсхийсэн билээ.

Хэдийгээр практикт хуульч, өмгөөлөгч нар хуулийн зохицуулалтын зорилгын талаар бус, зохицуулалтын томьёолол, хэрэгжүүлж байгаа арга замын талаар түлхүү хэлэлцэж байх боловч судлаачийн зүгээс хуулийн зохицуулалтын томьёолол хэрэгжих боломжтой, боломжгүй, нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж дүгнэхээс илүү хэрэгжүүлэх арга замыг тодорхой болгох нь үр дүнтэй болохыг тэмдэглэмээр байна.

Хяналтын журмаар гомдол гаргах гурван үндэслэлийн томьёолол (ялангуяа дээд шүүхийн абстракт тайлбар³², хууль хэрэглээний зөрүүг арилгах зэрэг үндэслэл) бүрэн тодорхой хуульчлагдсан гэхгүй боловч хуулийг хэрэгжүүлэхдээ УДШ хяналтын журмаар гомдол хүлээн авах үндэслэл, аргачлал маягийн баримт бичиг боловсруулах замаар уян хатан зохицуулах, практикт үүсээд буй хоёрдмол байдлыг нэг мөр болгох боломжтой юм. Харин хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлага гарвал хяналтын журмаар гомдол гаргах хугацааг арай өөрөөр зохицуулах нь зүйтэй. Тодруулбал, хяналтын журмаар гаргасан гомдлыг хуульд заасан шалгуур, үндэслэлд нийцэхгүй үндэслэлээр хүлээн авахаас татгалзсан тохиолдолд тухайн асуудлаар дахин хяналтын журмаар гомдол гаргах эрхгүй байгаа нь хуульд заасан гомдол гаргах хугацаа өнгөрсөнтэй холбож тайлбарлаж болно.

Энэ хүрээнд хяналтын журмаар гаргасан гомдлыг хүлээн авч хянан

³¹ УДШ хяналтын журмаар гаргасан гомдлын дийлэнх олонх хувийг хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхээс татгалзаж шийдвэрлэж байгаа тухай асуудал энд багтана.

³² Европын Шүүгчдийн Зөвлөлдөх Зөвлөлөөс дээд шүүх абстракт тайлбар (лат. *in abstracto*) гаргах нь хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангахад эерэг нөлөөтэй боловч эрх мэдлийн хуваарилалтад эзлэх шүүх эрх мэдлийн зохих байр суурь, хууль зүйн тодорхой байдлыг бүдгэрүүлж, асуудал үүсгэдэг гэмтэй талаар зөвлөсөн байдаг. – CCJE, *supra* note 19, p.9.

шийдвэрлэхээс татгалзсан тохиолдолд гомдлоо засан сайжруулж, хуульд заасан үндэслэлд нийцүүлэн дахин гаргаж, хэлэлцүүлж болдог Литва Улсын туршлагыг харгалзан үзэхэд илүүдэхгүй.

Иймд хэрэгжээд удаагүй шинэ хуулийн зохицуулалтын шинэлэг үзэл баримтлал, томъёоллыг шууд шүүмжлэн өөрчлөх санал гаргахаас урьтаж хууль хэрэглэгч бүхий л субъектэд нэг мөр ойлголт төрүүлэх замаар зөв тайлбарлан хэрэглэх нь чухал болов уу. Профессор Б.Чимид багшийн “шинэ үзэл баримтлалыг ‘ухаж төнхөснөөс’, мэдээжийн хуучин зуршлаа сэргээх нь ойр дөт санагддаг, түүндээ хөтлөгддөг байж ч болох”³³ гэж бичсэнчлэн шууд засах, өөрчлөхөөс илүүтэй зөв зохистой тайлбарлан хэрэглэх, хэрэгжүүлэх сорилт шүүх эрх мэдлийн өмнө тулгарч байна.

III. ДҮГНЭЛТ

Хууль хэрэглээний нэгдмэл, тогтвортой байдлыг хангахад хяналтын журмаар гомдол гаргах шалгуур тогтоох нь дэлхийн улсуудын өнөөгийн шүүх эрх мэдлийн хүрээнд үр дүнтэй арга хэрэгсэл болж байна. Энэхүү ойлголтыг шүүлтүүрийн тогтолцоо, шүүлтүүрийн арга хэрэгсэл, сонгох шалгуур гэсэн томъёоллоор илэрхийлж ирсэн бөгөөд дээд шүүх нийтийн зорилгод үйлчлэх, нийтийн чиг үүргээ зохих ёсоор хэрэгжүүлэхэд гүүр болох учиртай юм.

Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 25 дугаар зүйлийн 25.7.5 дахь заалт нь Үндсэн хууль болон хурдацтай хувьсан өөрчлөгдөж буй цаг үеийн хандлагад нийцүүлэн дээд шүүхийн чиг үүргийг тодорхойлсноороо харьцангуй шинэлэг зохицуулалт болсон билээ. Энэхүү зохицуулалт нь өнгөц харахад дээд шүүхийн зардал, ачааллыг бууруулах зорилготой мэт байвч угтаа зохистой хэрэгжүүлж чадвал хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангахад өндөр ач холбогдолтой болохыг эрх зүйн соёл өндөр хөгжсөн, мөн Монгол Улстай адил пост-социалист замналаар явж буй улсууд хүлээн зөвшөөрч байгааг энэхүү илтгэлд эшилсэн эх сурвалжуудаас харж болно. Мэдээжийн хэрэг, ийнхүү шалгуур тогтоох нь үндсэн эрхийг хөнддөг эсэхээс авахуулаад олон эргэлзээтэй асуудал, байр суурь дагуулдаг боловч бусад орнуудын хувьд энэ талаар багагүй туршлага, түүх хуримтлуулсан байх учир тэдгээрийн туршлагаас суралцах боломжтой нь авууштай.

Судлаачийн зүгээс практикт ид ярианы сэдэв болоод буй эл зохицуулалтын тоон мэдээлэл, практик учир шалтгааныг хөндөхийг зориогүй бөгөөд гагцхүү онол, гадаад улсын туршлагыг товч харьцуулах замаар үзэл баримтлалыг нь тодруулахыг хичээсэн гэдгээ дурдах нь зүйтэй.

Түүнчлэн, хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах, эрх зүйг боловсронгуй болгоход хамгийн чухал байр суурь эзэлдэг дээд шүүхийн энэхүү чиг үүргийг хэрэгжүүлэх өөр зохистой арга хэрэгсэл ирээдүйд гарч ирэхийг үгүйсгэхгүй, угаас хяналтын журмаар гомдол хүлээн

³³ Б.Чимид, Үндсэн хуулийн үзэл баримтлал, хоёр дахь хэвлэл (УБ: Чимид сан, 2017), 255 дахь тал.

авах шалгуур тогтоох нь асуудлыг шийдвэрлэх эцсийн шийдэл биш боловч өнөөдрийн тухайд бид “өмнөө байгаа” хуулийн хэрэгжилтийг үр дүнтэйгээр хэрэгжүүлэхийг чадах чинээгээрээ эрмэлзэх учиртай болов уу. Ингэхдээ хуулийн томъёолол дутуу томъёологдсон, хэрэгжих боломжгүй гэсэн дүгнэлт шууд хийхээс урьтаж, анхан шатны шүүхийн шийдвэр, давж заалдах шатны шүүхийн магадлалыг чамбайруулахад ач холбогдол өгч, хэргийн оролцогчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлын үүднээс энэхүү зохицуулалтыг УДШ зохистой ойлгож хэрэглэх тухай нарийвчилсан үндэслэлийг аргачлал, зөвлөмж батлах замаар хэрэгжүүлэх нь чухал байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Хууль тогтоомж:

- Монгол Улсын Үндсэн хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл. №1. (1992).
- Монгол Улсын Шүүхийн тухай хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл №05. (2021).

Монгол хэлээр:

- Б.Чимид. Үндсэн хуулийн үзэл баримтлал, хоёр дахь хэвлэл (УБ: Чимид сан, 2017).
- Л.Амгаланбаатар “Монгол Улс дахь шүүхийн жишгийн гүйцэтгэх чиг үүрэг ба механизм” Шүүх эрх мэдэл сэтгүүл №1 (2019): 132-146.
- Ц.Цогт “Захиргааны эрх зүйн хэм хэмжээг тайлбарлах нь: Шүүхийн жишиг? түүний оролцоо” Үндсэн хуулийн болон захиргааны эрх зүйн үндсэн асуудлууд: Хямралын үеийн тулгамдсан асуудал сэдэвт ЭШХ-д тавьсан илтгэл (УБ: 2021.11.21)

Гадаад хэлээр:

- CCJE, The Role of Courts with Respect to the Uniform Application of the Law, *Opinion No 20 (2017)*, <https://rm.coe.int/opinion-no-20-2017-on-the-role-of-courts-with-respect-to-the-uniform-a/16807661e3>
- Chiarloni, S. Fundamental Tasks of the *Corte di Cassazione*, Heterogeneous Objectives Arose from the Constitutional Right to Appeal and Recent Reforms. In *Los recursos ante Tribunales Supremos en Europa. Appeals to Supreme Courts in Europe*. Ortells Ramos, Manuel (coord.). Barcelona: Difusión Jurídica y Temas de Actualidad, 2008, p. 77, 79.
- Jolowicz, J.A., 1997. The role of the Supreme Court at the national level a General Report. In Yessiou-Faltsi P., ed. *The Role of the Supreme Courts at the National and International Level*, Athens: Sakkoulas Publications.

- Jukka Sippo, “Filtering the Appeals to the Supreme Court: The Finnish Approach” Speech held in *The International Supreme Courts Conference “Supreme Courts in Changing Times”* in Brno, Czech Republic 6.11.2018. https://korkeinoikeus.fi/fi/index/ajankohtaista/puheet_1/2018/aspeechbyjusticejukkasippointheinternationalsupremecourtsconference8220supremecourtsinchangingtimes8221in-brnoczechrepublic6.11.2018filteringtheappealstothepremecourt-thefinnishapproach.html
- Nikolina Katić, Matea Bašić, Morana Briški. “Right of Access to Supreme Courts in Light of the Guarantees under Article 6 § 1 of the Convention on Human Rights and Fundamental Freedoms (civil aspect)” *Croatian International Relations Review – CIRR XXIV* (81) 2018: 69-90, <https://cirrj.org/index.php/cirrj/article/download/87/83/78>
- Zembrzuski, “Access to the Supreme Court – Polish approach”. Colloquium of the procedural law *The functions of the Supreme Court – issues of process and administration of justice*, 11 - 13 June 2014 (Warsaw: University of Warsaw, Faculty of Law and Administration, 2014), http://colloquium2014.uw.edu.pl/wp-content/uploads/sites/21/2014/01/ZEMBRZUSKI_-Access-to-the-Supreme-Court_-Polish.pdf



**Баасандоржийн БАТБАЯР,
Батсайханы ЦЭНДСҮРЭН**

Хуульчид
(Дэд байр)

**ШИНЭ ЭРҮҮГИЙН ХУУЛИАР ҮНДСЭН ХУУЛИЙН ХҮРЭЭНД УЛСЫН
ДЭЭД ШҮҮХЭД ТАВЬСАН ШИНЭ СОРИЛТ (БОЛОМЖ),
ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ**

ТОВЧ:

Энэхүү илтгэл нь Оршил хэсэг, Үндсэн хэсэг, Харьцуулалтын хэсэг, Санал, дүгнэлт гэсэн бүтцийн дагуу Эрүүгийн хуульд заасан гэм буруугийн санаатай хэлбэрийн нэг төрөл болох “Нөхцөлт санаа” (*Dolus eventualis*)-ны онолын ойлголтыг албан ёсоор тайлбарлаж, Монгол Улсын Эрүүгийн хуулийн ялын бодлогод нэвтрүүлэн хэрэглэх жишиг тогтоох нь Үндсэн хуулийн хүрээнд Улсын дээд шүүхэд тавьсан шинэ сорилт болох талаар бичигдсэн.

Нөхцөлт санаа нь Монгол Улсад хүчин төгөлдөр дагаж мөрдөж буй Эрүүгийн хуулийн үзэл баримтлалд хэрхэн тусгагдсан тухай болон шүүхээс хэрэг шийдэхэд нөхцөлт санаагаар үйлдэгдсэн гэмт хэргийг хэрхэн зүйлчилж, ял оногдуулах тухай оновчтой санал дэвшүүлэх зорилгоор хэд хэдэн гадаад улсын онол-практикийн туршлага, эрх зүйн зохицуулалт, Монгол Улсын Үндсэн хуулийн хүний эрх, эрх чөлөөний суурь зохицуулалт, илтгэгчдийн 2020-2021 оны хооронд Улсын дээд шүүхээс Эрүүгийн хуулийн 10.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг баримтлан ял оногдуулсан байдалд хийсэн дүн шинжилгээ зэрэгт тулгуурлан энэхүү илтгэлийг бичсэн.

Түүнчлэн 2020 онд анхан шатны шүүхээр хянан шийдвэрлэсэн нийт хэргээс хүнийг алах гэмт хэрэг 12.3 хувиар, хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах гэмт хэрэг 12.7 хувиар¹ өссөн үзүүлэлттэй байгаа тул эдгээр тохиолдол тутамд хүний эрх зөрчигдөхөөс сэргийлж эрүүгийн хариуцлага нь гэмт хэрэг, гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруугийн хэлбэрт тохирсон эсэхийг судалж, энэ талаар төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц хууль зүйн баталгааг бүрдүүлж чадаж буй эсэхэд дүгнэлт хийж, тус үүргийг төрөөс хэрхэн баталгаатай эдлүүлэх арга замыг эрэлхийлэх бодит шаардлага үүсээд байна.

¹ Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн тайлан, 2020 он, 200 дахь тал.

Илтгэлд анализ, синтезийн арга, ажиглалт, баримт шинжилгээний арга болон харьцуулалтын аргуудыг тус тус ашигласан бөгөөд харьцуулсан судалгаанд эрх зүйн адил бүлд хамаарах Холбооны Бүгд Найрамдах Герман Улс болон Бүгд Найрамдах Солонгос Улсын жишээг онцолсон болно.

ТҮЛХҮҮР ҮГ: *Хуулийн өмнө эрх тэгш байх, Хууль, журмаас гадуур эрх чөлөөгөө хязгаарлуулахгүй байх, Төрөөс хүний эрхийг хангах хууль зүйн баталгааг бүрдүүлэх, Шударга ёсны зарчим, Гэм буруугийн санаатай хэлбэр, Нөхцөлт санаа, Хууль тайлбарлах эрх.*

I. ОРШИЛ

Хууль ёс тогтсон хүний нийгэм хэрхэн үүссэн тухай эрх зүйн үндэслэлийг эрж үзвэл “хязгааргүй” эрх чөлөөт хувь хүмүүс өөрсдийн эрхийг үндэслэлтэйгээр “хязгаарлах” эрхийг төрд шилжүүлж, хариуд нь төрөөс амар амгалан аж төрөх эдийн засаг, эрх зүй, нийгэм соёлын орчинг бүрдүүлэхийг даалгах эрхийг хүлээн авах агуулгатай “нийгмийн гэрээ” байгуулсан байдаг.

Олон гишүүдтэй бүтэц урт удаан хугацаанд оршин тогтнох үндэс нь бүтэц “зөв” ажиллаж байгаа гэдэгт гишүүд итгэж, хүлээн зөвшөөрч, цааш урагшлах явдал билээ. Харин гишүүд “зөв” хэмээн итгэж, хүлээн зөвшөөрөх эсэх нь тухайн нийгэмд “шударга ёс” батжин тогтсон эсэхээс шалтгаалдаг. Шударга ёсыг тогтоох, хамгаалах, түүний төлөө тэмцэх талаар өрнүүлсэн хүн төрөлхтний түүх бүхий л цаг үед үргэлж гэмт хэрэгтэй холбогдож ирсэн байдаг. Учир нь шударга бус явдлын үр дагаварт заавал гарз, хохирол учирдаг бөгөөд ийнхүү хохирсон хохирогч шударга ёсыг тогтоохыг төрөөс шаардсаар иржээ.

Энэ түүхэн шинжтэй шаардлагын тусгал өдгөө ч амь бөхтэй оршоор, дэлхийн бүхий л улс орны Үндсэн хууль, Эрүүгийн хуульд “шударга ёсны зарчим” заавал тусгагдсан байдаг. Учир нь уг зарчмын үр нөлөө нь хүний эрх, эрх чөлөө баталгаатай хангагдаж, хамгаалагдах хөрс, суурь нь болдог аж.

Одоо үед дэлхийн ихэнх улс орон засаглалын ардчилсан хэлбэрийг сонгож, хүний эрх, эрх чөлөөг хангаж, хамгаалах хөдөлгөөнийг олон улсын төвшинд өрнүүлэх болсон. Гэвч нийгмийн хөгжлийг даган хүний эрх, эрх чөлөөг хамгаалах явдал илүү гүнзгий, нарийн төвөгтэй сорилт, бэрхшээлтэй тулгарсаар байна. Энэхүү сорилтыг амжилттай даван гарах арга зам нь энэ цаг үед өндөр төвшний харьцуулсан судалгаа хийх буюу ижил төрлийн бэрхшээлийг түрүүлж амжилттай гэтэлсэн улсын сайн туршлагыг сайтар судлан, өөрсдийн хөрсөнд амжилттай нутагшуулах явдал хэмээн илтгэгчдийн зүгээс үзэж байна.

Энэхүү илтгэлд гэм буруугийн санаатай хэлбэрийн гурав дахь төрөл болох “нөхцөлт санаа”-г Монгол Улсын Эрүүгийн эрх зүйд нутагшуулан

нэвтрүүлээгүй байгаа нь Үндсэн хуулиар баталгаажсан хүний эрх, эрх чөлөө зөрчигдсөөр ирсэн гэх саналыг дэвшүүлсэн бөгөөд өдгөө шинэ Эрүүгийн хууль батлагдсанаар үүнийг онолын төвшинд албан ёсоор тайлбарлан, практикт нэвтрүүлж, хүний эрх, эрх чөлөөг хамгаалах нэг талаас боломж, нөгөөтээгүүр сорилт Улсын дээд шүүхэд тулгарч буй талаар хөндсөн болно.

II. ҮНДСЭН ХЭСЭГ

Шинэ Эрүүгийн хуулиар Үндсэн хуулийн хүрээнд Улсын дээд шүүхэд тавьсан шинэ сорилт (боломж)

Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад (2015) “гэм буруугийн санаатай хэлбэр”-ийг **мэдэх, хүсэх** элементүүдээр² томьёолж, төрлүүдийг нь нээлттэй үлдээж, хуульчилсан нь нэг талаар шүүхэд “нөхцөлт санаа”-г онолын хувьд тайлбарлан хэрэглэх боломжийг олгож нөгөөтээгүүр шүүх уг төрлийг өөрийн албан ёсны тайлбар, зөвлөмжөөр хөндөж, хууль хэрэглээний практикт нэвтрүүлэх эсэхийг сорьж байгаа юм.

1. Нөхцөлт санаа (*Dolus eventualis*)³ гэж юу вэ?

Өөрийн үйлдэл, эс үйлдлийн улмаас хохирол учрах боломжтой болохыг мэдэж байсан ч уг эрсдэлийг хүлээн зөвшөөрч буй явдлын эсрэг хуулиар хамгаалагдсан ашиг сонирхлыг дорвитой хамгаалахын тулд гэм буруугийн санаатай хэлбэрийн уламжлалт төрлүүдээс өөр шинэ төрөл шаардлагатай болсон. Ихэнх эх газрын эрх зүйн тогтолцоотой орнууд гэм буруугийн санаатай хэлбэрийн гуравдагч төрөл болох нөхцөлт санааг хууль хэрэглээний эргэлтэд оруулж уг асуудлыг шийдсэн байдаг.

Гэм буруугийн санаатай хэлбэрийн энэ төрөл нь боломжит эрсдэлийг ухамсартайгаар хүлээн зөвшөөрөх байдлаар илэрдэг⁴. Энэ нь дараах элементүүдээс бүрдэнэ. Үүнд:

- Эрсдэлийг ойлгож, мэдэх **танин мэдэхүйн** элемент
- Эрсдэл бодит болох боломжит нөхцөлийг хүлээн зөвшөөрч буй **хүсэл зоригийн** элемент

Нөхцөлт санаагаар гэмт хэрэг үйлдэх гэдэгт гэмт хэрэгтэн зөвхөн ерсдэл учрах боломжтой талаар мэдэж байдаг бөгөөд уг эрсдэлийг **хүлээн зөвшөөрч** боломжит үр дагаврыг бодит болгох үйлдэл хийсэн эсхүл эс үйлдэхүй гаргасан байхыг ойлгоно.

1.1. Нөхцөлт санаа v Шууд ба шууд бус санаа

Шууд санаа нь хүсэх элемент давамгайлсан гэм буруугийн санаатай

² Эрүүгийн хуулийн 2.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэг “Өөрийн үйлдэл, эс үйлдэхгүйг хууль бус шинжтэй болохыг ухамсарлаж түүнийг хүсч үйлдсэн, хохирол, хор уршигт зориуд хүргэсэн бол санаатай гэмт хэрэгт тооцно.”

³ *Dolus eventualis* гэх нэр томьёог “нөхцөлт санаа” гэж орчуулсан болно.

⁴ J.Keiler, D.Roef, Comparative Concepts of Criminal Law, 3rd edition., 2019, page number. 182.

хэлбэрийн анхдагч төрөл бөгөөд гэмт хэргийн үр дагаврыг гэмт хэрэгтэн туйлын ихээр хүссэн байдаг бол нөхцөлт санааны хувьд хүсэх элемент харьцангуй бага байдаг. Харин шууд бус санаагаар гэмт хэрэг үйлдэх үед мэдэх элемент давамгайлдаг ба гэмт хэрэгтэн өөрийн үйлдэл, эс үйлдэхүйн үр дагаврыг зориогүй, хүсээгүй боловч яаж төгсөхийг **бараг тодорхой**⁵ буюу зайлшгүй байдлаар мэддэг. Тэгвэл нөхцөлт санаагаар гэмт хэрэг үйлдэх үед гэмт хэрэгтэн өөрийн үйлдэл, эс үйлдэхүйн үр дагавар **бодитоор учрах эрсдэл** байгаа талаар л мэдэж байдаг тул шууд бус санаатай харьцуулахад мэдэх элемент харьцангуй бага юм.

1.2. Нөхцөлт санаа v Хайхрамжгүй хандах ба хөнгөмсгөөр найдах

Хайхрамжгүй хандах үед гэмт хэрэгтэн өөрийн үйлдэл, эс үйлдэхүйн үр дагаврын талаар анхаарч үзээгүй, эрсдэлийг ухаарч ойлгоогүй боловч үүнийг мэдэх ёстой, мэдэх боломжтой байдаг бол нөхцөлт санаагаар гэмт хэрэг үйлдэхдээ гэмт хэрэгтэн **боломжит эрсдэлийг** ойлгож, мэдэж байдаг. Харин хөнгөмсгөөр найдах үед гэмт хэрэгтэн эрсдэлийг ойлгож, ухаарч байдгаараа нөхцөлт санаатай төстэй. Гол ялгаа⁶ нь гэмт хэрэгтний эрсдэлд хандах хандлагаар илэрдэг. Хөнгөмсгөөр найдах үед гэмт хэрэгтэн эрсдэлийг ойлгож, ухаарч байдаг боловч үүнээс зайлсхийж чадна хэмээн итгэсээр өөрийн үйлдэл, эс үйлдэхүйн үр дагавартай нүүр тулдаг бол нөхцөлт санааны үед гэмт хэрэгтэнд ийм хандлага байдаггүй.

2. Нөхцөлт санааг тайлбарлах нь шүүхэд тавьсан шинэ сорилт (боломж) болох тухайд

2002 оны Эрүүгийн хуулийн 26 дугаар зүйлд “гэм буруугийн санаатай” хэлбэрийн төрлүүдийг хязгаарлаж, явцуу утгаар⁷ тодорхойлсон. Ингэснээр гэм буруугийн санаатай хэлбэрийн дээрх төрлүүдийн дунд байх ёстой “нөхцөлт санаа”-г шүүх тайлбараараа нөхөж хэрэглэх боломжгүй байв.

Учир нь шүүхээс хуулийг тайлбарлан хэрэглэх орон зай нь хязгаарлагдмал байдаг. Тухайлбал, Роналд Дворкин “Эрхийн талаар нухацтай авч үзэх нь” (Taking Rights Seriously 1977) бүтээлдээ анх эрх зүйн позитивизмийг шүүмжилж, “Хуулийн цоорхойн онол” буюу Doughnut Theory of Law – ийн талаар хөндсөн. Товч агуулга нь хуулийг цагирган боовтой зүйрлэж, хууль тогтоогчоос баталсан хуульд эрх зүйн хийдэл байдаг гэх санааг цоорхой хэсэгтэй адилтгасан. Энэхүү хийдлийг шүүх хуулийг тайлбарлах замаар нөхдөг. Харин шүүхийн хуулийг тайлбарлах замаар эрх зүйг бүтээх ажиллагаа нь эрх зүйн хийдэлтэй үлдсэн хоосон орон зайг нөхөхөөс биш түүнээс хэтэрч хууль тогтоогчийн баталсан хязгаарыг давах ёсгүй байдаг.

⁵ J. Keiler, D. Roef, Comparative Concepts of Criminal Law, 3rd edition., 2019, page number. 180.

⁶ Greg Taylor, Concepts of Intention in German Criminal law, Oxford Journal of Legal Studies, Vol.24, No.1 (2004), page number. 111.

⁷ “Гэмт хэрэг санаатай үйлдэх нь шууд, шууд бус санаатай байна.”



Иймээс 2002 оны Эрүүгийн хуульд “гэм буруугийн санаатай хэлбэр”-ийг явцуу байдлаар хуульчилсантай холбоотойгоор шүүхээс хэрэгжүүлэх боломжгүй байсан хууль тайлбарлах үйл ажиллагаа 2015 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга батлагдсанаар нээлттэй болсон.

3. Нөхцөлт санааг тайлбарлах нь Үндсэн хуулийн хүрээнд үүссэн сорилт (боломж) болох тухайд

Нийгэмд аюултай эрсдэлийг учрах боломжтой болохыг мэдэж байсан ч хүлээн зөвшөөрч хохирол учруулж буй гэмт явдалд тохирсон ял шийтгэлийг оногдуулах хууль зүйн боломжийг баталгаатай бүрдүүлж, хангах үүргийг төр Монгол Улсын Үндсэн хуулийн дагуу хүлээсэн⁸ байдаг. Энэ үүргээ биелүүлэхгүй байгаа эс үйлдэхүй нь төрийн хуулиар хүлээсэн үүрэг зөрчигдөөд зогсохгүй Үндсэн хуулиар баталгаажсан хүний бусад суурь эрхүүд ноцтой зөрчигдөх үр дагаварт хүргэж байдаг. Тухайлбал “нөхцөлт санаа”-гаар гэмт хэрэг үйлдсэн этгээдийн үйлдэлд тохирсон ял шийтгэлийг оногдуулах эрх зүйн орчин бүрдээгүй бол түүнийг “шууд бус санаатайгаар”, эсхүл “хөнгөмсгөөр найдаж” гэмт хэрэг үйлдсэнд тооцон ял оногдуулах болно. Энэ тохиолдолд эрүүгийн хуульд заасан шударга ёсны зарчим⁹ алдагдаж, шүүгдэгчийн болоод хохирогчийн хэн алиных нь хуулийн ... өмнө эрх тэгш байх¹⁰ эрх зөрчигдөх бол шүүгдэгчийн хувьд хуульд заасан үндэслэл журмаас гадуур¹¹ эрх чөлөөгөө хязгаарлуулах эрсдэл бий болно.

Хүний эрхийг хангах хууль зүйн баталгааг зөвхөн хууль тогтоогч төдийгүй, гүйцэтгэх засаглал, шүүх мөн хангаж байх учиртай. Энэ талаар

⁸ Арван есдүгээр зүйл. 1. Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн ... баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.

⁹ Эрүүгийн хуулийн 1.3 дугаар зүйл Шударга ёсны зарчим: 1. Эрүүгийн хариуцлага нь хүн, хуулийн этгээдийн үйлдсэн гэмт хэрэг, гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруугийн хэлбэрт тохирсон байна.

¹⁰ Арван дөрөвдүгээр зүйл. 1. Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна. Мөн Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 7-р зүйлд: Хүн бүр хуулийн өмнө адил тэгш бөгөөд ямар ч алагчлалгүйгээр хуулиар нэгэн адил хамгаалуулах эрхтэй. Хүн бүр энэхүү Тунхаглалд харшлах аливаа алагчлалаас болон тийнхүү алагчлахыг өдөөсөн турхиралтаас адилхан хамгаалуулах эрхтэй.

¹¹ Арван зургадугаар зүйл. 13/ ... Хуульд заасан үндэслэл журмаас гадуур дур мэдэн хэний ... ч ... эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно.

Б.Чимид багш¹² “Үндсэн хуулийн үзэл баримтлал: Хүний эрх, шүүх эрх мэдэл” бүтээлдээ “...засаг төрийн бүх байгууллага, албан тушаалтан хэн боловч хүний эрхийн төлөө хариуцах ёстой¹³...” хэмээн товч тодорхой өгүүлсэн нь бий. Хууль тогтоогчийн зүгээс эрх зүй өндөр хөгжсөн бусад улсын жишгээр эрүүгийн хуульд гэм буруугийн хэлбэрийг шинэчлэн тодорхойлж, баталсан¹⁴ тул шүүхээс өөрийн хууль тайлбарлах¹⁵ эрхийн хүрээнд “эх газрын эрх зүйн тогтолцоот” орнууд хууль зүйн практикт нэвтрүүлээд удсан “нөхцөлт санаа”-г албан ёсоор тайлбарлах замаар хууль хэрэглээний практикт нэвтрүүлэх сорилт (боломж) ийнхүү үндсэн хуулийн хүрээнд үүсээд байна.

III. ХАРЬЦУУЛАЛТЫН ХЭСЭГ

1. Нөхцөлт санааг нарийвчлан тогтоох нь гэмт хэрэг үйлдсэн этгээдэд тохирсон ял шийтгэлийг оногдуулах хөшүүрэг болох нь:

1.1. Холбооны Бүгд Найрамдах Герман Улс (ХБНГУ)

ХБНГУ-ын Эрүүгийн хуульд санаатай гэм буруугийн хэлбэрийн төрлүүдийг тодорхойлоогүй¹⁶, нээлттэй үлдээсэн байдаг¹⁷. Харин эрүүгийн эрх зүйн онолын хүрээнд гэм буруугийн хэлбэр, тэдгээрийн төрлүүдийг нарийвчлан тодорхойлж, хэрэг маргааныг шийдвэрлэхдээ иш татан хэрэглэдэг.

Энэ нь шүүгдэгчид тохирсон ял шийтгэл оногдуулах шударга ёсны зарчим хэрэгжих баталгаа болдог. Тухайлбал ХБНГУ-ын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 16-р бүлэгт Хүний амь насны эсрэг гэмт хэргүүдийг тусгасан бөгөөд “Хүндрүүлэх нөхцөлтэйгөөр хүнийг алах¹⁸”, “Хүнийг алах¹⁹”, “Хүндэвтэр нөхцөлтэйгөөр хүнийг алах²⁰”, “Хүнийг болгоомжгүйгээр алах²¹” зэргээр хүнийг алах гэмт хэргийг ямар нөхцөлд үйлдсэнийг шалгуур болгон төрөлжүүлж, тодорхой тохиолдолд гэмт хэрэгтэн гэм

¹² Монгол Улсын төр нийгмийн нэрт зүтгэлтэн, ардчилсан үндсэн хуулийн эхийг баригч, хөдөлмөрийн баатар, ардын багш, гавьяат хуульч, доктор, профессор.

¹³ Б.Чимид, Үндсэн хуулийн үзэл баримтлал, хоёр дахь хэвлэл., 2016, 199 дэх тал.

¹⁴ Харьцуулалтын хэсэгт ингэж дүгнэсэн шалтгааныг тодорхой өгүүлсэн.

¹⁵ Тавьдугаар зүйл. 1. Монгол Улсын дээд шүүх бол шүүхийн дээд байгууллага мөн бөгөөд дараах эрхийг хэрэгжүүлнэ: 4/ Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах;

¹⁶ 15-р зүйл. Болгоомжгүй үйлдэлд эрүүгийн хариуцлага оногдуулахаар энэ хуульд тусгайлан заагаагүй бол зөвхөн санаатай гэмт хэрэгт ял оногдуулна.

¹⁷ M.Bohlander, Principles of German Criminal Law., 2009, Page number. 59.

¹⁸ 211-р зүйл. Энэ нөхцөлд хүнийг алсан бол бүх насаар нь хорих ял шийтгэнэ.

¹⁹ 212-р зүйл. 211-р зүйлд заасан нөхцөлөөс бусад байдлаар хүнийг алсан бол дор хаяж 5 жил хорих ял шийтгэнэ. 211-р зүйлд заагаагүй боловч онц ноцтой байдлаар хүнийг алсан бол бүх насаар нь хорих ял шийтгэнэ.

²⁰ 213-р зүйл. 212-р зүйлд заасан нөхцөлд гэмт хэрэгтэн өөрөөс шалтгаалахгүйгээр хохирогчийн зүй бус үйлдлийн улмаас (өөрийг нь болон өөрт хамаатай, төрөл садныг нь ноцтойгоор доромжлох, гутаах) уур хилэндээ хөтлөгдөж алах, эсхүл бусад хүндэвтэр нөхцөл байдалд хүнийг алсан бол 1-10 жилийн хугацаатай хорих ял шийтгэнэ.

²¹ 222-р зүйл. Болгоомжгүйгээр хүнийг алсан бол 5 жилээс хэтрэхгүй хорих ял оногдуулах эсхүл торгох ял шийтгэнэ.

буруугийн аль хэлбэр, төрлөөр гэмт хэрэг үйлдсэнээс хамааран тохирох ял шийтгэлд нийцсэн төрлөөр нь зүйлчлэх өргөн боломжийг хууль тогтоогчоос шүүхэд олгодог. Иймд шүүхээс гэмт хэрэгтний гэм буруугийн хэлбэрийг маш өндөр түвшинд нарийвчлан тогтоох боломжтой байдаг.

Жишээ болгон ХБНГУ-ын Холбооны улсын шүүх 1955 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр шийдсэн²² “нөхцөлт санаа”-гаар хүнийг алсан агуулгатай хэргийг авч үзье. А, Б нар О-оос мөнгийг нь авахын тулд нойрны эм өгч унтуулах гэсэн боловч тэрээр унтсангүй. Энэ арга бүтэлгүйтсэн тул арьсан бүсээр боож ухаан алдуулахаар төлөвлөсөн ч, О-г үхэж магадгүй хэмээн эмээж, элстэй уутаар толгой руу нь цохиж үзэв. Гэсэн ч О эсэргүүцсээр байсан тул арга мухардаж арьсан бүсээр боож ухаан алдуулахаар шийдэцгээв. Үр дүнд нь О хөдлөхөө больж, тэд ч мөнгийг авсан. А, Б нар О-г орхиж явах үедээ ухаан алдах биш бүр үхчихсэн байх вий гэхээс айж, сэхээн амьдруулах оролдлогууд төрөл бүрээр хийж үзсэн ч оройтсон байлаа. Холбооны Улсын Шүүхээс тэднийг “нөхцөлт санаатай”-гаар хүнийг алсан гэж үзсэн²³ тул “хүндрүүлэх болон хүндэвтэр” бүрэлдэхүүнтэйгээр хүнийг алах гэмт хэргээс бага, “болгоомжгүй”-гээр хүнийг алах гэмт хэргээс их хугацаатай хорих ялыг Эрүүгийн хуулийн 212-р зүйлийг баримтлан оногдуулсан байна.

1.2. Бүгд Найрамдах Солонгос Улс (БНСУ)

БНСУ нь Японы дарлалаас гарсны дараа 1953 оны 10 дугаар сарын 3-ны өдөр одоог хүртэл дагаж мөрдөж буй²⁴ шинэ эрүүгийн хуулиа баталсан. Уг хууль нь Күнзийн сургаал хийгээд Германы эрүүгийн эрх зүй болон Англи-Америкийн эрүүгийн эрх зүйн уламжлалуудад суурилан боловсруулагдсан юм²⁵. Тус хууль нь Германы эрүүгийн хуулийн нэгэн адил гэм буруугийн хэлбэрүүдийн төрлүүдийг хуульдаа нарийвчлан тодорхойлоогүй²⁶. Харин тус хууль батлагдах үед онолын судалгааны төвшинд нэгэнт ил болсон байсан гэм буруугийн хэлбэрүүд хийгээд түүний төрлүүдийг хэрэг маргааныг шийдвэрлэхдээ иш татан хэрэглэдэг жишиг тогтсон байв.

Тухайлбал 1994 оны 03 дугаар сарын 22-ны өдөр БНСУ-ын дээд шүүхээс хүн амины хэргийг шийдвэрлэхдээ шүүгдэгчийн гэм буруугийн хэлбэрийг нарийвчлан тодорхойлохын тулд нөхцөлт санааг тайлбарласан байдаг²⁷.

²² <https://opiniojuris.de/node/1495/daten>

²³ M.E.Badar, *Mens rea – Mistake Law & Mistake of Fact*, International Criminal Law Review 5, 2005, page number. 227.

²⁴ Сүүлийн нэмэлт, өөрчлөлт 2021 онд орсон.

²⁵ Paul Kichyun Ryu, The New Korean Criminal Code of October 3, 1953, Journal of Criminal Law and Criminology, Volume 48, Issue 3, 1957, page number. 257.

²⁶ Болгоомжгүйгээр гэмт хэргийг шинжийг бүрдүүлсэн үйлдэлд энэ хуульд заагаагүй бол ял оногдуулахгүй.

²⁷ Хохирогчийн үхлийг хүсээгүй ч хохирогч үхэх боломжтой (гарцаагүй бус) болохыг ухамсарласан байж, эрсдэлийг зөвшөөрч үйлдлээ үргэлжлүүлсэн нь шууд болон шууд бус санаа биш боловч санаатай гэмт хэрэгт тооцогдож хариуцлага хүлээнэ.

Мөн 2014 онд улс орон даяар шуугиан тарьсан Сивол хөлөг онгоцны сүйрлийн хэрэгт²⁸ улсын яллагчаас яллах дүгнэлт үйлдэхдээ уг гэмт хэргийг нөхцөлт санаагаар үйлдэгдсэн гэж үзсэн²⁹.

1.3. Монгол Улс

Дотоодын эрдэмтэн, судлаачдын ном, сурах бичгийг судалж үзэхэд хууль зүйн ухааны магистр Т.Золбоо “Гэмт хэргийн бүтээц³⁰” номондоо анх удаа *dolus eventualis* –ийг “болзолт санаа³¹” гэх нэршлээр танилцуулсан байна. Ингэхдээ өмнө нь манай улсад *dolus eventualis* судлагдаагүй байсан болохыг дурдсан боловч шинэ Эрүүгийн хуультай холбогдуулан нөхцөлт санааны талаар ямар нэгэн дүгнэлт хийгээгүй.

Харин шинэ Эрүүгийн хуулиар гэм буруугийн хэлбэрийг өмнөх хуулиас өөрчлөн баталсан нь “ухралт³²” болсон хэмээн доктор, профессор Г.Гантөмөр “Эрүүгийн эрх зүй: Ерөнхий анги” бүтээлдээ өөрийн байр суурийг илэрхийлсэн байна.

Илтгэгчид www.shuukh.mn вебсайтад нээлттэй байршсан, Улсын дээд шүүхээс Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг баримтлан 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2021 оны 12 дугаар сарын 29-ний өдрийн хооронд шийдсэн нийт 75 тогтоолд “нөхцөлт санаа”-гаар үйлдэгдсэн хэрэг байгаа эсэхэд дүн шинжилгээ хийсэн. Үр дүнд нь Эрүүгийн хуулийн 10.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэрэг нь “шууд бус” эсхүл “нөхцөл санаа”-тайгаар гол төлөв үйлдэгддэг гэсэн дүгнэлтэд хүрсэн болно. Ийнхүү нөхцөлт санаагаар болон шууд бус санаагаар үйлдэгдсэн гэж үзэж буй 2 хэргийг товчхон танилцуулъя.

Дугаар	314 (нөхцөлт санаа)
Огноо	2021.12.01
Хорих ял оногдуулсан хугацаа	8 жил
Хэргийн товч	Ч.М нь найз Н.Ч-г бусдын гар утсыг хулгайллаа хэмээн зэмлэхдээ гараараа толгой руу нь цохиж, учруулсан гэмтлийн улмаас Н.Ч 2 хоногийн дараа нас барсан.

Дугаар	683 (шууд бус санаа)
Огноо	2020.12.18

²⁸ Аюулгүй байдлын стандартыг хангаагүй хөлөг онгоц сүйрэх нь тодорхой байхад 300 зорчигчийн амь насыг эрдүүлж, өөрсдөө аврах завинд суун явсан хөлөг онгоцны багийнхны үйлдсэн гэмт хэрэг.

²⁹ http://www.koreanlii.or.kr/w/index.php/Dolus_eventualis?ckattempt=1

³⁰ 2016 онд хэвлэгдсэн.

³¹ “болзолт” гэх нэришл Монгол улсын эрх зүйн тогтолцоонд хувийн эрх зүйд “болзолт хэлцэл”-ийн ойлголтоор анх нэвтэрсэн бөгөөд энэ нь хууль зүйн фактын хувьд эрх зүйн үйл явдалд (талуудын хүсэл зоригоос үл хамаарах) хамаардаг ойлголт. Харин *dolus eventualis* нь субъектийн шийдвэрээс шууд хамаарч байдаг (эрх зүйн үйлдэл) тул нэг талаас давтагдахгүй байх нөгөөтэйгүүр хэлзүйн хувьд илүү утга дүйцэхүйц гэж үзэн “нөхцөлт санаа” хэмээн орчуулсан болно.

³² “Хууль тогтоогч уг зүйлд гэм буруугийн санаатай хэлбэрийг хуульчилсан хэдий ч шууд ба шууд бус санааг хуульчлаагүй нь өмнөх Эрүүгийн хуулийн зохицуулалтаас ухарсан зүйл болжээ. Учир нь энд гэм буруугийн санаатай хэлбэрийн төрлийн тухай асуудал нь зөвхөн эрүүгийн эрх зүйн шинжлэх ухааны, хууль хэрэглээний төдийгүй иргэдийн эрх зүйн боловсролд ч танин мэдэхүйн ач холбогдолтой бөгөөд Эрүүгийн хуулийг гагцхүү хуульчдад бус, ард иргэдэд зориулж баталдагт оршино”

Хорих ял оногдуулсан хугацаа	8 жил
Хэргийн товч	А нь Б,В,Г нарыг чулуугаар цохиж, ална хэмээн хөөсөн. В гэмтлийн улмаас 3 хоногийн дараа нас барсан.

Эхний хэргийн шүүгдэгч Ч.М нь сургуулийн манаач ажилтай бөгөөд багын найз хохирогч Н.Ч-г ажлын байран дээр нь ирж, өрөөнд нь цэнэглэж үлдээсэн бусдын гар утсыг хулгайлсан явдалд бухимдан хашраах зорилгоор гараараа толгой руу нь хэд хэд цохисон. Хохирогч Н.Ч нь зодуулсны дараа цүнхээ үүрээд явсан бөгөөд 2 хоногийн дараа гэмтлийн улмаас нас барсан. Ч.М мэдүүлэхдээ Н.Ч-тэй багаасаа найзалсан бөгөөд түүнийг асран хамгаалж, тус хэрэг болох хүртэл гэртээ байлгаж ирсэн. Хашраах зорилго байснаас гэмтээх ч сэдэл байгаагүй гагцхүү утас хулгайлсанд нь бухимдан хашраахыг хүссэн гэжээ.

Ч.М Н.Ч-г нүцгэн гараараа зодох үедээ түүний үхлийг бараг тодорхой буюу зайлшгүй болохыг нь урьдаас таамагласан хэмээн үзэх боломжгүй боловч Ч.М нь Н.Ч-ийн үхэлд өөрийгөө буруутай гэж мэдүүлсэн нь уг боломжит эрсдэлийг хүлээн зөвшөөрч үйлдлээ үргэлжлүүлсний улмаас хохирол учирсныг илэрхийлж байх тул уг хэрэг нөхцөлт санаагаар үйлдэгдсэн гэж үзэж байна.

Хоёр дахь хэргийн тухайд шүүгдэгч А үйлдлээ эхлэхдээ мохоо хэлбэртэй дунд хэмжээтэй чулуугаар хохирогчдыг нийлж архи уулаа хэмээн зодож эхэлсэн бөгөөд нэгийг нь ална хэмээн хөөж байсан болох нь тогтоогдсон. Шүүгдэгч өөрөө айлгах санаатай байсан гэж мэдүүлсэн бөгөөд алах зорилгогүй байсан гэж үзвэл чулуугаар хүний толгой руу цохих нь үхэлд хүргэх үр дагавартайг ердийн хүн энгийн ойлголтын төвшинд мэдэх боломжтой тул түүний үйлдлээ хэрэгжүүлснийг шууд бус санаатай хэмээн дүгнэсэн болно.

IV. САНАЛ, ДҮГНЭЛТ (Шийдвэрлэх арга зам)

Манай улсын хувьд “нөхцөлт санаа” онолын төвшинд “болзолт санаа” гэх нэршлээр танилцуулагдсан боловч практикт хараахан нэвтрээгүй байна. Хууль тогтоогчийн зүгээс эрх зүйн ижил бүлд хамаарах улс орнуудын жишгээр гэм буруугийн хэлбэрийг шинэчлэн хуульчилсан явдал нь цаашид “нөхцөлт санаа”-г практикт хэрэглэх боломжийг олгосон гэж үзэж байна. Харин шүүхээс энэ боломжийг ашиглах эсэх нь “сорилт” болж буй мэт.

2002 оны Эрүүгийн хууль хүчин төгөлдөр үйлчилж байх үед шүүх гэм буруугийн хэлбэрийн төрлүүдийг нарийвчлан тодорхойлж, шийдвэртээ тусгадаг байсан. Гэтэл шинэ Эрүүгийн хуулиар гэм буруугийн хэлбэрийг мэдэх, хүсэх элементээр тодорхойлж, түүний төрлүүдийг нээлттэй үлдээснээс хойш гэм буруугийн хэлбэрийг тогтоож буй боловч, түүний төрлийг огт тодорхойлохгүй байгаа нь шүүхийн шийдвэр, тогтоолд дүн шинжилгээ хийх явцад ажиглагдаж байлаа.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн нэгэн зорилт³³ нь “... гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шударгаар ял оногдуулахад ...” оршдог. Шударгаар ял оногдуулахад анхаарах шалгуурыг Эрүүгийн хуульд “...хүн, хуулийн этгээдийн үйлдсэн *гэмт хэрэг, гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруугийн хэлбэр*”³⁴ хэмээн тус тус тогтоосон байдаг. Хууль тогтоогчийн зүгээс гэмт хэргийн улмаас учрах материаллаг хохирлыг үндэслэн ялын санкцийг тогтоодог нь аль ч улс оронд тогтсон нийтлэг жишиг билээ. Харин тухайн ялын санкцийн интервал дотор шүүхээс ялыг шударгаар оногдуулах шалгуур нь “**гэм буруугийн хэлбэр**”-ийг нарийвчлан тодорхойлох явдал байдаг.

Шинэ Эрүүгийн хуулийн 10.1 дүгээр зүйлийн нэг дэх хэсэгт заасан гэмт хэрэгт 8-15 жил хорих ял шийтгэхээр хуульчилсан. Гэтэл хүндрүүлэх бүрэлдэхүүнтэйгээр хүнийг алсан бол 12-20 жил, эсхүл бүх насаар нь хорих ял оногдуулахаар байна. Үүнээс дүгнэвэл ердийн бүрэлдэхүүнтэйгээр хүнийг алах гэмт хэргийн ялын интервал нь маш өргөн хүрээтэй байхаас гадна хүндрүүлэх бүрэлдэхүүний доод хэмжээнээс өндөр байх тул шударгаар ялыг оногдуулахад “гэм буруугийн хэлбэрийн төрлийг” нарийвчлан тогтоох нь амин чухал шаардлага болоод байна.

Иймд Улсын дээд шүүхээс Үндсэн хуульд заасан хууль тайлбарлах эрхээ³⁵ хэрэгжүүлж, эх газрын эрх зүйн тогтолцоот орнуудын жишгээр гэм буруугийн санаатай хэлбэрийн гурав дахь төрөл болох “нөхцөлт санаа”-г тайлбарлаж, үүгээр үйлдэгдсэн гэмт хэрэгт шууд болон шууд бус санаатайгаар гэмт хэрэг үйлдсэн этгээдээс харьцангуй бага ял оногдуулах жишиг тогтоох нь Үндсэн хуулиар баталгаажуулсан “... хуулийн ... өмнө эрх тэгш байх, ... хуульд заасан үндэслэл журмаас гадуур эрх чөлөөгөө хязгаарлуулахгүй байх” эрхийг хангаж, Эрүүгийн хуулийн шударга ёсны зарчмыг дээдлэн, төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн ... баталгааг бүрдүүлэх үүргээ биелүүлэх шийдвэрлэх алхам болно хэмээн дүгнэж байна.

³³ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг.

³⁴ Эрүүгийн хуулийн 1.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг.

³⁵ Монгол Улсын Үндсэн хуулийн 50 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт.

V. АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

I. Дотоод эх сурвалж

Монгол Улсын хууль тогтоомж

1. Үндсэн хууль, 1992
2. Эрүүгийн хууль, 2002
3. Эрүүгийн хууль, 2015
4. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 2017

Сурах бичиг, ном, гарын авлага, тайлан

1. Гэмт хэргийн бүтээц, Т.Золбоо, УБ., 2016 он.
2. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй: Үзэл баримтлал, уламжлал, сургамж, С.Нарангэрэл, Ж.Эрдэнэбулган, УБ., 2019 он.
3. Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн удиртгал, Г.Эрдэнэбат, Ж.Эрдэнэбулган, УБ., 2004 он.
4. Үндсэн хуулийн үзэл баримтлал, Б.Чимид, УБ., 2016 он.
5. Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн тайлан, 2020 он.
6. Эрүүгийн эрх зүй: Ерөнхий анги, Г.Гантөмөр, С.Гантулга нар, УБ., 2020 он.

II. Гадаад эх сурвалж

Олон улсын конвенц, гадаад улсын хууль тогтоомж

1. БНСУ-ын Эрүүгийн хууль, 1953
2. ХБНГУ-ын Эрүүгийн хууль, 1871 (сүүлд 2021 онд нэмэлт өөрчлөлт орсон)
3. Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал, 1948

Ном, сурах бичиг, эрдэм шинжилгээний өгүүлэл

1. G.Yaffe, Conditional Intent and *Mens rea*, Legal Theory, 10 (2004)
2. Greg Taylor, Concepts of Intention in German Criminal law, Oxford Journal of Legal Studies, Vol.24, No.1 (2004)
3. J.Keiler, D.Roef, Comparative Concepts of Criminal Law, 3rd edition., 2019
4. M.Bohlander, Principles of German Criminal Law., 2009
5. M.E.Badar, *Mens rea* – Mistake Law & Mistake of Fact, International Criminal Law Review 5, 2005
6. Paul Kichyun Ryu, The New Korean Criminal Code of October 3, 1953, Journal of Criminal Law and Criminology, Volume 48, Issue 3, 1957
7. R.Dworkin, Taking Rights Seriously ., 1997



Даваагийн МЯГМАРСҮРЭН

Өмгөөллийн “Эл Би Партнерс” ХХН-д
хуулийн зөвлөх
(Гутгаар байр)

АНАЛОГИ БА ХҮНИЙ ЭРХИЙН ХАМГААЛАЛТ: ИРГЭНИЙ ХЭРГИЙН ШҮҮН ТАСЛАХ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД¹

Б.Чимид: Шүүгч бол ярьдаг хууль²

ТОВЧ УТГЫН ОРОНД: [АНАЛОГИ = ҮНДЭСЛЭГДСЭН ШИЙДВЭР =
ХУУЛЬ ҮГҮЙ БОЛ ЭРХ ҮГҮЙ]

ТҮЛХҮҮР ҮГС: [аналоги, эсрэг дүгнэлт, силлогизм, үндэслэгдсэн шийдвэр, хууль үгүй бол эрх үгүй, эрх зүйн хамгаалалт, эрх зүйн хийдэл, хэм хэмжээг төсөөтэй хэрэглэх]

ОРШИЛ

МУ-ын Үндсэн Хуулийн 19-р зүйлийн 1-д төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц хууль зүйн баталгааг бүрдүүлэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна гэж заасан. Хууль тогтоогч тухайн үеийн болон ирээдүйд үүсэх нийгмийн харилцааг бүрэн харах боломжгүй учраас эрх зүйн хийдэл үүсэх нь гарцаагүй. Иймээс шүүх хэрэг маргааныг хянан шийдвэрлэх явцад эрх зүйн хийдэл тогтоогдвол түүнийг нөхөх үүрэг хүлээдэг. Хэрэв шүүх энэ үүргээ эс биелүүлбэл, хүний эрх, эрх чөлөө эрх зүйн хамгаалалтгүй үлдэнэ. Эсрэгээрээ, Шүүх хуулийг чадварлаг хэрэглэх юм бол хүний эрхийн хамгаалалтыг тэлж, эрх зүйг хөгжүүлэх боломж бий. Хууль тогтоогч энэ арга замыг /аналоги/ ИХ-ийн 4-р зүйлээр оновчтой хуульчилсан. Үүнд:

4 дүгээр зүйл. Иргэний хуулийг төсөөтэй хэрэглэх

4.1.Иргэний хуульд тухайн харилцааг зохицуулсан хэм хэмжээ байхгүй бол түүнтэй төсөөтэй харилцааг зохицуулсан хуулийн хэм хэмжээг хэрэглэнэ.

4.2.Төсөөтэй харилцааг зохицуулсан хуулийн хэм хэмжээ байхгүй бол тухайн харилцааг иргэний эрх зүйн агуулга, зарчим, нийтээр

¹ Д. Мягмарсүрэн, МУИС-ийн ХЗС-ийн төгсөгч, Өмгөөллийн “Эл Би Партнерс” ХХН-д хуулийн мэргэжилтэн.

² Б.Чимид, “Үндсэн хуулийн мэдлэг”, УБ, 2008, 309.

хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд нийцүүлэн зохицуулна.

4.3.Тусгай харилцааг тухайлан зохицуулсан хэм хэмжээг бусад харилцаанд төсөөтэй хэрэглэж үл болно.

Дээрх зохицуулалт нь шүүх хэрэг маргааныг хянан шийдвэрлэх явцад хэм хэмжээний хомсдол үүсвэл төсөөтэй харилцааг зохицуулсан хэм хэмжээг хэрэглэнэ, ингэхдээ төсөөтэй хэрэглэж болох эсэхийг нягталж, хэрэв боломгүй бол төсөөтэй хэрэглэхээс татгалзахаар заасан байна. Гэхдээ хуулийн бичвэрээс төсөөтэй хэрэглэж болох эсэхийг тодорхойлох шалгуур юу болох, тухайн харилцааг зохицуулсан хэм хэмжээ байхгүй гэдэгт юуг ойлгох вэ гэдэг нь шууд харагддаггүй. Яагаад гэвэл хууль хэрэглэнэ гэдэг нь оюун дүгнэлтийн ажил учраас түүгээр нь хариулт өгөхийг шаарддаг. Силлогизм нь ердийн хууль хэрэглээний оюун дүгнэлтийн хэлбэр бол аналог нь хуулийг төсөөтэй хэрэглэх оюун дүгнэлтийн хэлбэр юм. Тиймээс хуулийг чадварлаг хэрэглэхэд, силлогизм, аналогийг практик хэрэглээн дээр авч үзсэн судалгааны ажил чухал үүрэг гүйцэтгэх нь маргаангүй.

Энэхүү судалгааны ажлаар аналогийг хэрхэн хийх, түүгээр дамжуулан хүний эрхийн хамгаалалтыг тэлж, эрх зүйг хөгжүүлэх бүрэн боломжтой гэдгийг жишээн дээр нотолж, харуулахыг зорив. Ингэхдээ 1/ аналогийн хэрэгцээ шаардлага, хүлээн зөвшөөрөгдөх байдал 2/ хэрэглэх аргачлалыг хөндөж, 3/УДШ-ийн тогтоолуудад дүн шинжилгээ хийж, эцэст нь, шүүхийн хууль хэрэглээний (аналог) асуудлыг тодорхойлж, санал дэвшүүлэх болно.

1. Аналогийг хэрэглэх шаардлага ба хүлээн зөвшөөрөгдөх байдал

Өгүүллийн энэ хэсэгт шүүх аналогийг хэрэглэх шаардлага, хүлээн зөвшөөрөгдөх байдлын талаар авч үзэв.

Шүүх аналогийг хэрэглэх нь шүүмжлэл дагуулдаг учраас эхлээд аналогийн хүлээн зөвшөөрөгдөх байдлын талаар товч авч үзье. Шүүх аналогийг хэрэглэх нь хуулийн тайлбараас давж, шинээр хууль бүтээж буйтай утга нэг учраас шүүх хуулийн хүрээнд байх³, эрх мэдэл хуваарилах зэрэг эрх зүйт төрийн зарчмуудтай нийцэхгүй гэх шүүмжлэл байдаг⁴. Харин шударга ёс (justice-зүй ёс), тэгш байдлын зарчим (principle of equity) аналог хэрэглэхийг шаарддаг⁵. Шүүх хууль хэрэглэх байдлаар маргаан бүхий хэргийн талаар зүй ёсны шийдвэр гаргах үүрэгтэй учраас аналог хэрэглэх эрх далд байдлаар олгогдсон гэж үзэх хандлага давамгайлдаг⁶. Түүнчлэн аналог нь тэгш байдлын зарчмыг хэрэгжүүлдэг гэж үздэг. Тэгш

³ 김영환, "법의 해석과 판결의 보충에 관한 체계적 의의- 최근의 대법원 형사판례를 중심으로", 법학논총, (2006, 23 권 1 호), 60 면.

⁴ 김부찬, "법의 해석 및 판결 보충에 관한 고찰", 법과정책, (2015, 21권3 호), 100면.

⁵ 위 논문, 120면.

⁶ 위 논문, 116면.

байдлын зарчим нь “адил эрх зүйн үндэслэл байгаа бол адил эрх зүйн үр дагавар үүсэх ёстой” (ubi eadem legis ratio, ibi eadem dispositio) гэсэн утгыг илэрхийлдэг⁷.

Аналог нь салбар эрх зүйн онцлогоос хамаарч харилцан адилгүй хүрээнд хүлээн зөвшөөрөгддөг. Эрүүгийн эрх зүйд гэмт хэрэг, ял шийтгэлийг маш тодорхой, бүрэн, хоёрдмол утгагүйгээр хуульд тусгагдсан байхыг шаарддаг бөгөөд эртний зарчим “nullum crimen, nullum poena sine lege”⁸ нь эрх зүйн хийдлийг үгүйсгэдэг⁹. Учир нь аналог хэрэглэх нь шинээр гэмт хэрэг үүсгэж байгаа хэрэг болно. Гэхдээ яллагдагчид ашигтай тохиолдолд хэрэглэхийг үгүйсгэдэггүй.¹⁰ Захиргааны эрх зүйд сахилгын хариуцлага ногдуулах тохиолдолд аналогийг хэрэглэхгүй байх нь халдашгүй байдал, эрх зүйн аюулгүй байдал, хуулийн үндэслэлгүйгээр хариуцлагад татагдахгүй байх баталгаа гэж үздэг¹¹. Харин иргэний эрх зүй нь эрүү, захиргааны эрх зүй шиг онцгой хамгаалалт шаарддаггүй учраас аналогийг өргөн хүрээнд хүлээн зөвшөөрдөг.¹²

Хууль хэрэглэгчид яагаад аналог хэрэглэх шаардлага үүсдэгийг ердийн хууль хэрэглээний аргаас (силлогизм) хялбархан харах боломжтой. Силлогизм нь хоёр нөхцөлөөс дүгнэлт гаргадаг оюун дүгнэлтийн хэлбэр. Гэхдээ бүх төрлийн хоёр нөхцөл дээр хэрэглэгдэхгүй. Харин нөхцөлүүд нь хоорондоо дундын терминээр (М) холбогдсон тохиолдолд ашиглагдах боломжтой¹³. Үүнийг ойлгоход силлогизмын бүтэц тус болох ба кейс дээр харуулъя.

Кейс 1:

(F1): Амьтны үйлдлээс **хүний амь нас, эрүүл мэндэд** учирсан гэм хорыг (М)

тухайн амьтны өмчлөгч буюу эзэмшигч хариуцна (R)

[IX-ийн §501.1].

(F2): А -ын нохой (S) **Б -гийн хөлийг** хазсан (М)¹⁴.

(E): Тиймээс А нохойн эзэн (S) тул гэм хорыг хариуцна (R).

Хууль хэрэглээний хувьд дундын термин гэдэгт хэм хэмжээний гипотез нөхцөл хэргийн үйл баримттай нийцэх явдлыг ойлгоно. Энэ кейсийн хувьд А-ын нохой Б-гийн хөлийг хазаж, бэртэл учруулсан нь **эрүүл мэндэд учруулсан гэм хор** тул хэм хэмжээний гипотез нөхцөлтэй нийцэж байна. Тиймээс силлогизмиор төвөггүй дүгнэлт гаргана.

Кэйс 2:

⁷ 김영환, “앞의 논문”, 52-54 면.

⁸ Хууль үгүй бол гэмт хэрэг үгүй

⁹ Т. Наранцогт. “Эрх зүйн хийдлийг тодорхойлох нь” Эрх зүй сэтгүүл, 2014/2, 16.

¹⁰ 김영환, “앞의 논문”, 52면.

¹¹ Т. Наранцогт. “Эрх зүйн хийдлийг тодорхойлох нь” Эрх зүй сэтгүүл, 2014/2, 16.

¹² 김영환, “앞의 논문”, 52면.

¹³ Ханс Кельзен, “Хэм хэмжээний тухай ерөнхий онол” Орч М. Хатанбаатар, УБ, 2013, 215.

¹⁴ АППШ-ийн шийдвэр, №38, 2019.01.28, <http://new.shuukh.mn/irgenanhan/82221/view>

(F1): Амьтны үйлдлээс хүний амь, эрүүл мэндэд учирсан гэм хорыг (M) тухайн амьтны өмчлөгч буюу эзэмшигч хариуцна (R) [ИХ-ийн §501.1].

(F2): А-ийн үхэр (S) Б-гийн байшингийн цонхийг хагалсан (M).
(E): А-үхрийн эзэн (S) тул гэм хорыг хариуцна (R).

Харин энэхүү кейсийн тухайд силлогизм нь мухардалд орно. Учир нь А-ын үхэр Б-гийн байшингийн цонхыг хагалсан нь *Б-гийн амь нас, эрүүл мэндэд хохирол учруулаагүй, харин эд хөрөнгийн хохирол* учруулсан. Өөрөөр хэлбэл, хэргийн үйл баримт нь хэм хэмжээний гипотез нөхцөлтэй нийцэхгүй байна. Ийнхүү хоёр нөхцөлд дундын термин байхгүй тул силлогизмоор дүгнэлт гаргах боломжгүй¹⁵. Гэхдээ энэ нь шүүх хэргийг хянан шийдвэрлэхээс татгалзах үндэслэл болохгүй [ИХШХШТХ-ийн 10.2]. Өөрөөр хэлбэл, шүүх хэргийг заавал шийдвэрлэх ба шүүхийн шийдвэрт хууль ёсны байх шаардлага тавигддаг [ИХШХШТХ-ийн 116.2]. Энэхүү зайлшгүй нөхцөл байдал нь шүүхээс аналогийг хэрэглэхийг шаарддаг. Анхан шатны шүүх нэхэмжлэлийн шаардлагыг хангаж шийдвэрлэсэн. Ингэж шийдвэрлэх болсон үндэслэлээ ийнхүү тайлбарласан:

*Иргэний хуулийн 501 дүгээр зүйлийн 501.1-д “Амьтны үйлдлээс хүний амь нас, эрүүл мэндэд учирсан гэм хорыг тухайн амьтны өмчлөгч буюу эзэмшигч хариуцна” гэж заасан заалтын дагуу нэхэмжлэгч нь шаардах эрхтэй байх тул нэхэмжлэлийн шаардлагыг хангаж, хариуцагчаас 110,000 төгрөг гаргуулж, нэхэмжлэгчид олгох үндэстэй байна.*¹⁶

Энэ шийдвэр нь зүй ёсонд нийцсэн байж болох ч хууль ёсны байх, талуудад хүлээн зөвшөөрөгдөх шинжийг агуулахгүй. Учир нь ИХ-ийн §501.1-д *амь нас, эрүүл мэнд* гэх бичвэрийг хэчнээн өргөжүүлж ойлгоод ч эд хөрөнгийн хохирол хамаарахгүй. Өөрөөр хэлбэл, шүүхийн шийдвэрийн үндэслэх хэсгээс шийдэлд хүрсэн арга зам нь харагдахгүй / үндэслэгдсэн шийдвэр биш/. Энэ нь хууль, шүүхэд итгэх итгэлийг үгүйсгэх үр дагавартай. Тиймээс шүүх силлогизмоор дүгнэлт гаргах боломжгүй бол тухайн хэм хэмжээг шууд хэрэглэхээс татгалзаж, аналогоор шийдвэрлэх боломжтой эсэхийг судлах ёстой. Ингэж байж үндэслэгдсэн шийдвэр гаргаж чадна.

1. Аналог хийх аргачлал

Өгүүллийн энэ хэсэгт аналог хийсэн шүүхийн шийдвэрийн үндэслэгээг тодорхойлох болно. Ингэхдээ аналогийн бүтцийг танилцуулж, хууль хэрэглээний үүднээс хэрхэн ойлгож, хэрэглэж болох талаар авч үзэв.

Аналог нь А объект P₁,..., P_n болон Q шинжтэй ба Б объект P₁,..., P_n шинжтэй гэх нөхцөлөөс Б-д ч мөн адил Q шинж байгаа гэж дүгнэдэг

¹⁵ 강태경, “법적 추론에 대한 인지적 분석방법 : 윈터(Steven L. Winter)를 중심으로”, (서울대학교 대학원 (박사) 2014), 26 면.

¹⁶ АШШ-ийн шийдвэр, №1167, 2019.10.14, <http://new.shuukh.mn/irgenanhan/90296/view>

магадлалт оюун дүгнэлтийн хэлбэр¹⁷. Энэхүү магадлалт шинжийг нэмэгдүүлэхийн тулд харьцуулж буй объектуудын тоо, олон талын шинж, нийтлэг тал болон дүгнэлт хоорондын холбоо хамаарал, эсрэг дүгнэлтийн боломж зэрэг зүйлсийг харгалзан үзэх ёстой¹⁸. Аналог нь хоёр нөхцөлөөс шууд дүгнэлт гаргадаггүй. Харин холбогч бодомжоор (Rn) дамжуулан дүгнэлт гаргадаг¹⁹(схем1). Иймээс хоёр объект ижил шинжтэй байгаад холбогч бодомж байхгүй бол дүгнэлт гаргах боломжгүй. Эсхүл холбогч бодомжийг алдаатай тодорхойлох юм бол буруу аналог / алдаатай дүгнэлт/ гарна.

Аналогийн оронд эсрэг дүгнэлт гарах боломж үргэлж байдаг. Эсрэг дүгнэлт гэдэг нь А объект P1,..., Pn болон Q шинжтэй ба Б объект мөн адил P1,..., Pn шинжтэй боловч эдгээр шинжүүд нь Q-ийн шалтгаан биш учраас Б нь Q шинжтэй гэсэн дүгнэлт гарахгүй гэж үздэг²⁰ (схем2). Тиймээс холбогч бодомжоос хамаарч аналог, эсхүл эсрэг дүгнэлт гарна. Холбогч бодомжийг тодорхойлох нь формал логикийн асуудал биш, харин тухайн салбар шинжлэх ухааны мэдлэгээр шийдвэрлэнэ²¹.

F1: Px, Py, Pc ... шинжтэй

F2: Px, Py, Pz ... ба Q шинжтэй

Rn: Px, Py бол Q-ийн шалтгаан

E : Иймд F1 нь Q шинжтэй.

F1: Px, Py, Pc ... шинжтэй

F2: Px, Py, Pz, ... ба Q шинжтэй

Rn: Pz бол Q-ийн шалтгаан

E : Иймд F1 нь Q шинжтэй гэж үзэхгүй.

Хууль зүйн шинжлэх ухааны хувьд аналог хийх нь тодорхой нэг факт амьдралд бий болсон байхад түүнийг зохицуулсан эрх зүйн зохицуулалт үгүй бол төсөөтэй харилцаанаас эрх зүйн үр дагаврыг шилжүүлэн хэрэглэж буй процесс юм.²² Үүнийг (F1) эрх зүйн хийдэл, (F2) төсөөтэй харилцааг зохицуулсан хэм хэмжээ, (Rn) холбогч бодомж /тухайн харилцааны аль шинж эрх зүйн үр дагавартай холбоотой тухай бодомж/, (E) шийдэл гэж аналогийн бүтцээр задлан шинжилж болно. Эдгээр дөрвөн элементийг тус бүрд нь тайлбарлая.

(F1) Эрх зүйн хийдэл /факт/: Ном, зохиолуудад эрх зүйн хийдэл гэдгийг эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагдвал зохих нийгмийн харилцааг зохицуулах хэм хэмжээ дутагдах тухай ойлголт²³ гэж тодорхойлсон байдаг. Энэ тодорхойлолт нь энгийн, ойлгомжтой мэт боловч тодорхой нэг хууль зүйн факт дээр эргэлзээ үүсгэдэг (агуулгыг нь гүйцээхийг шаарддаг).

Эрх зүйн хийдэл гэдэг нь маргаан бүхий факт хуулийн тайлбарын

¹⁷ 강태경, “앞의 논문”, 97 면.

¹⁸ 강태경, “앞의 논문”, 28 면.

¹⁹ 강태경, “앞의 논문”, 98 면.

²⁰ 김부찬, “앞의 논문”, 118 면.

²¹ 김성룡, “유추의 구조와 유추금지. 법철학연구”, (2009.12 권 2호) . 51 면.

²² Diederichsen, AcP 1998, 198, S.176f. Б. Тэмүүлэн, “Хэм хэмжээг төсөөтэй хэрэглэх аргачлал”, Эрх зүй сэтгүүл, 2018/3, 137 дахь талаас дам эшлэв.

²³ Ч.Нямсүрэн, “Эрх зүйн ерөнхий онол, хоёр дахь хэвлэл”, УБ, 2017, 313.

утгад хамаарахгүй байх тухай ойлголт.²⁴ Тиймээс эрх зүйн хийдэл мөн эсэхийг тогтоохын тулд хууль тайлбарлах шаардлагатай болдог. Хуулийг тохиромжтойгоор тайлбарлахад 1/ хуулийн утга нь бичвэртэйгээ тохирох, 2/ хуулийн тайлбарын агуулгыг хуулийн бичвэрт илэрхийлсэн байх ёстой²⁵. Өөрөөр хэлбэл, бичвэрийн боломжит утга нь хуулийн тайлбарын хязгаар болдог. Тэгвэл эндээс хуулийн тайлбарт багтахгүй амьдралын бүхий л тохиолдол эрх зүйн хийдэл мөн үү гэсэн асуулт гарч ирнэ. Эрх зүйн хийдлийн хүрээ нь 1/эрх зүйн бус харилцаа, 2/бусад салбар эрх зүйн харилцаагаар хязгаарлагдана. Учир нь нийгмийн бүхий л харилцааг эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулах шаардлагагүй²⁶. Салбар эрх зүйн харилцаа нь тус бүрийн онцлог шинжтэй ба харилцан адилгүй зарчмаар зохицуулагддаг. Жишээлбэл, эрүүгийн эрх зүйд хууль ёсны зарчмын үүднээс эрх зүйн хийдлийг үгүйсгэдэг²⁷. Тиймээс тодорхой нэг фактын талаарх зохицуулалт “н” хуульд байхгүй нь тус хуулийг хийдэлтэй гэж үзэх үндэслэл болохгүй. Харин тус факт нь “н” хуулиар зохицуулагдах ёстой бол хийдэл гэж үзнэ.

(F2) Төсөөтэй харилцааг зохицуулсан хэм хэмжээ: Төсөөтэй харилцааг зохицуулсан хэм хэмжээ гэж эрх зүйн хийдэлтэй /факт/ нийтлэг шинжтэй харилцааг хэлнэ. Энэ нь аналог хэрэглэх боломжтой эсэхийг шалгах үндэслэл болдог.²⁸ Харин хэм хэмжээний эрх зүйн үр дагавар нь зөөгдөж байгаа шинж (Q) юм.

(Rn) Холбогч бодомж : Холбогч бодомж гэдэг нь тухайн харилцааны аль шинж эрх зүйн үр дагаврын шалтгаан болсон тухай бодомж юм. Өөрөөр хэлбэл, тухайн хэм хэмжээний зорилго юу вэ гэсэн асуултад хариулдаг. Энэ алхамд шүүх аналог [ИХ-ийн §4.1], эсхүл эсрэг дүгнэлтийн [ИХ-ийн §4.3] аль нэгийг сонгох шаардлагатай болдог учраас хүнд сорилт болох нь гарцаагүй. Өмнө нь дурдсанчлан энэ асуудал нь формаль логигоор бус, эрх зүйн шинжлэх ухаан мэдлэгээр /онол, үзэл баримтлал, үнэт зүйлсийн сэтгэлгээ/ шийдвэрлэгддэг²⁹. Тиймээс хуулийн зохицуулалтын зорилгын талаар олон янзын тайлбар гарч ирэх боломжтой. Шүүх зүй ёс, тэгш байдлын зарчимд нийцсэн хамгийн сайн үндэслэлээр дэмжигдсэн тайлбарыг сонгох ёстой (анalogийг хэрэглэх үндэслэл нь шударга ёс, тэгш байдал учраас). Хэрэв **хэм хэмжээний зорилгыг** буруу тодорхойлбол хэрэглэх ёсгүй хуулийг хэрэглэх, эсхүл хэрэглэх ёстой хуулийг хэрэглэхгүй байх үр дагаварт хүрнэ.

Кейс3: Б-гийн нохой А-гийн хоёр үхрийг иджээ. А хохирлоо барагдуулах талаар Б-д хэлтэл миний буруу биш, араатан амьтны буруу учраас хохирлыг барагдуулахгүй гэж хэлсэн. Тиймээс А хоёр үхрийн

²⁴ 김영환, “앞의 논문”, 44면.

²⁵ А. Барак, “Хуулийг зорилгоор нь тайлбарлах арга зүй (Аравдугаар бүлэг- Хуулийг зорилгоор тайлбарлах онолын үндэс)”, Орч. Т. Наранбат, Шүүх эрх мэдэл сэтгүүл, 2017/3, 88.

²⁶ Т. Наранцогт, “Эрх зүйн хийдлийг тодорхойлох нь”, Эрх зүй сэтгүүл, 2013/4, 19.

²⁷ Т. Наранцогт, “Мөн бүтээл”, Эрх зүй сэтгүүл, 2014/2, 16.

²⁸ М. Отгонбаяр, “Логик”, Сурах бичиг, Уб, 2016, 141.

²⁹ 김영환, “법학방법론의 관점에서 본 유추와 목적론적 축소”, 법철학연구, (2020, 연3회), 2면.

хохирлоо барагдуулахаар шүүхэд хандсан. Давж заалдах шатны шүүх дараах үндэслэлээр нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн:

*Иргэний хуулийн 501 дүгээр зүйлийн 501.1-д амьтны үйлдлээс хүний амь нас, эрүүл мэндэд учирсан гэм хорыг амьтныг өмчлөгч буюу эзэмшигч хариуцахаар зохицуулжээ. ... нэхэмжлэгч амь нас, эрүүл мэндийн хохирол бус, эд хөрөнгийн хохирол шаардсан нь 501 дүгээр зүйлд заасантай нийцэхгүй тул эд хөрөнгөнд учирсан гэм хорын хохирлыг шаардах эрхгүй байна.*³⁰

Шүүх ИХ-ийн §501.1-д “Амьтны үйлдлээс хүний амь нас, эрүүл мэндэд учирсан гэм хорыг тухайн амьтныг өмчлөгч буюу эзэмшигч хариуцна” гэж заасныг зөвхөн хүний амь нас, эрүүл мэндтэй холбоотой үйлчилнэ гэж тайлбарласан нь эсрэг дүгнэлтийн агуулга. Өөрөөр хэлбэл, ИХ-ийн §501.1-д заасан эрх зүйн үр дагаврын шалтгааныг маргаан бүхий факт болон төсөөтэй харилцааны нийтлэг шинж бус, харин фактад байхгүй шинж /хүний амь нас, эрүүл мэнд/ гэж үзжээ. Хэрэв шүүх бүтээлч хандсан бол илүү үндэслэлтэй тайлбар хийж, аналогоор ИХ-ийн §501.1 дэх хэсгийг өргөжүүлж хэрэглэх боломж байсан. Үүнд:

ИХ-ийн 501-р зүйлийн гарчиг нь **“Амьтны учруулсан гэм хорыг хариуцах”** гэснээс үзэхэд тус зохицуулалтын зорилго нь гэм хорын объектыг тодорхойлоход бус, харин амьтны үйлдлээс учирсан гэм хорыг хэн хариуцах вэ гэдэгт оршиж байна. Харин ИХ-ийн 497-р зүйлийг “Гэм хор учруулснаас хариуцлага хүлээх үндэслэл” гэж гарчиглаж, §497.1 дэх хэсэгт эд хөрөнгийг хүний амь нас, эрүүл мэндтэй адил түвшинд хамгаалсан. Иймээс ИХ-ийн §501.1-д амь нас, эрүүл мэнд гэж заасан нь амьтны өмчлөгч бусад төрлийн гэм хорын хариуцлагаас чөлөөлөгдөх үндэслэл болохгүй. Өөрөөр хэлбэл, гэм хорын эрх зүйн хамгаалалтын объектын хүрээг ИХ-ийн 497-р зүйлээр тодорхойлно. Тиймээс амьтны үйлдлээс учирсан гэм хорыг тухайн амьтны өмчлөгч буюу эзэмшигч хариуцна.

(Е) Шийдэл: Шийдэл нь маргааны талаар шүүхээс өгч буй хариултыг илэрхийлдэг. Шүүх аналогийг хэрэглэж шийдвэр гаргаснаар хуулийн зохицуулалт тэлдэг. Энэ нь шүүх эрх мэдлийн хүрээнд хүний эрхийн хамгаалалтыг өргөжүүлж буй нэг хэлбэр боловч алдаа гаргах боломж үргэлж байдаг. Учир нь шүүх аналог, эсхүл эсрэг дүгнэлтээс сонголт хийхдээ буруу тайлбарт (хангалттай сайн үндэслэлээр дэмжигдээгүй) үндэслэсэн байж болно. Тиймээс шүүх өөрийн шийдлийг зөв байна уу гэдгийг заавал шалгах ёстой.³¹ Өөрөөр хэлбэл, эсрэг тайлбарыг няцаах, эсхүл өөрийн шийдлийг зүй ёсны эсэх талаар эргэцүүлэх шаардлагатай.

Дүгнэж хэлэхэд, Аналог нь (F1) эрх зүйн хийдэл /факт/, (F2) төсөөтэй харилцааг зохицуулсан хэм хэмжээ, (Rn) холбогч бодомж гэсэн гурван нөхцөлөөс дүгнэлт гаргадаг учир шүүх үндэслэх хэсэгтээ эдгээрийг бичиж байж дур зорын бус, үндэслэгдсэн шийдвэр болно. Холбогч бодомжийг тодорхойлох олон янзын тайлбар гарч ирэх боломжтой тул шүүх хамгийн

³⁰ ДЭШШ-ийн магадлал, №006, 2016.07.06, <http://new.shuukh.mn/irgendavah/2817/view>

³¹ 김부찬, “앞의 논문”, 100 면.

сайн үндэслэлээр дэмжигдсэн тайлбарыг сонгохыг эрмэлзэх ёстой. Энэ нь алдаа гаргах эрсдэлийг агуулж байдаг учир шүүх шийдлээ(Е) зүй ёсны эсэхийг нягталж, түүнийгээ үндэслэх хэсэгтээ бичих хэрэгтэй. Шүүхийн үндэслэгдсэн шийдвэр нь хуульд захирагдсаныг харуулах төдийгүй олон нийт хэлэлцүүлэг өрнүүлж, хөгжүүлэх боломжийг олгоно.

2. УДШ-ийн тогтоолд дүн шинжилгээ

Аналогийн ач холбогдол, арга зүйг харуулах нэгэн кейс бол шалгагдаж байсан хэрэг нь хэрэгсэхгүй болж, цагаатсан яллагдагч эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны (цаашид "эрүүгийн процесс" гэх) явцад учирсан сэтгэл санааны хохирлоо мөнгөөр нөхөн төлүүлэх нэхэмжлэл гаргасан явдал юм. Энэхүү кейс нь шүүх эрх мэдлийн хүрээнд үндэслэгдсэн шийдвэрээр хүний эрхийн хамгаалалтыг хөгжүүлэх үү, үгүйсгэх үү гэсэн сорилт болсон. Гэвч, Шүүх асуудлыг шийдвэрлэхдээ маргаан бүхий факт хийдэл мөн эсэх, төсөөтэй харилцааг зохицуулсан хэм хэмжээ байгаа эсэх, төсөөтэй хэрэглэж болох эсэх, зөв шийдэлд хүрсэн эсэх талаар хангалттай дүгнэлт өгөлгүй шийдвэрлэсэн. Ингэж шийдвэрлэхдээ 1/ IX-ийн §230.1, §511.1-ийг эшлэн, нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож 2/ IX-ийн §4.3-ийг эшлэн, §511.1-ийг төсөөтэй хэрэглэхээс татгалзаж, нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож 3/ IX-ийн §4.1-ийг эшлэн, §511.1-ийг төсөөтэй хэрэглэж, нэхэмжлэлийн шаардлагыг хангаж зөрүүтэй шийдвэр гаргасан. Тиймээс өгүүллийн энэ хэсэгт УДШ-ийн тогтоолуудын дүгнэлтийг танилцуулж, түүнд тулгуурлан аналогийн элементүүдэд дүн шинжилгээ хийж, шүүхийн дүгнэлт яагаад үндэслэгдсэн бус (эсхүл хангалттай үндэслэлтэй биш) вэ гэдгийг харуулна.

А. (F1) Эрүүгийн процессын явцад учирсан сэтгэл санааны хохирлыг мөнгөөр нөхөн төлүүлэх асуудал нь эрх зүйн хийдэл мөн

УДШ эрүүгийн процессын явцад учирсан сэтгэл санааны хохирлыг мөнгөөр нөхөн төлөх талаар хуульд тусгайлан заагаагүй учраас нэхэмжлэлийн шаардлагыг хангахгүй гэж үзсэн. Ингэж үзэх болсон ийнхүү тайлбарласан:

*Тогтоол №1: Мөн хуулийн 230 дугаар зүйлийн 230.2-т зааснаар гагцхүү хуульд тусгайлан заасан тохиолдолд эдийн бус гэм хорыг мөнгөөр нөхөн төлнө. Сэтгэл санаанд учирсан хохирлыг мөнгөөр төлөх талаар хуульд тусгайлан заагаагүй тул хяналтын гомдлыг хангах үндэслэлгүй байна*³²

Хачирхалтай нь яагаад хуульд тусгайлан заагаагүй нь нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгох үндэслэл болсон гэдгээ тайлбарлаагүй. Тиймээс энэ талаар таамаглал дэвшүүлэхээс өөр аргагүй болж байна. Сэтгэл санааны хохирлыг мөнгөөр нөхөн төлөх талаарх тухайлсан зохицуулалт байхгүй гэдэг нь нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгох хууль зүйн үндэслэл гэж үзсэн байж болох юм. Хэрэв ингэж дүгнэсэн бол шүүх хуульд дээдлэх ёс, хуульд

³² УДШ-ийн тогтоол, №001/ХТ2019/00057, 2019.01.05, <http://new.shuukh.mn/irgenhyanal/5540/view>.

үндэслэх зарчмыг зөрчсөн ноцтой асуудал болох юм. Эсхүл, ИХ-ийн §230.2 дахь зохицуулалтыг хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдлыг хориглосон гэж ойлгож хэрэглэсэн байж болох юм. Гэвч, ИХ-ийн §230.2 дахь хэсэг нь хуульд зааснаас бусад эдийн бус гэм хорыг мөнгөөр нөхөн төлөхийг хориглоогүй гэдэг нь хуулийн тайлбараар харагддаг.

Үг зүйн тайлбар: ИХ-ийн §230.2 дахь хэсгийн бичвэрийг уншвал гагцхүү гэдэг нь хориглох утгыг илэрхийлээгүй, харин хуулийн зохицуулалт байхыг шаардаж байна. Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан тольд гагцхүү гэдгийг дан ганц, зөвхөн гэсэн утгатай холбох үг гэж тайлбарлажээ.³³

Түүхчлэх тайлбар: Хууль тогтоогч тус зохицуулалтаар хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдлыг хориглох зорилготой байсан бол бичвэрийн томъёолол хориглосон шинжтэй байх байсан. Жишээлбэл, ИХ-ийн §136.2-т “Хуульд зааснаас бусад тохиолдолд голын байгалийн урсгалын чиглэлийг өөрчилж болохгүй” гэж, мөн хуулийн §446.1.4-т “хуульд зааснаас бусад тохиолдолд данс, гүйлгээтэй холбоотой нууцыг задруулахгүй байх” гэж хориглосон шинжтэй тодорхой хуульчлах хувилбар байсаар байтал уг томъёоллоос татгалзсан. Харин ИХ-ийн 551-р зүйлд бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндэд учирсан гэм хорыг мөнгөөр нөхөн төлөхөөр зааж, мөн хуулийн 4-р зүйлээр хууль хэрэглэгчид төсөөтэй хэрэглэх эрх хэмжээг олгосон. Энэ нь ИХ-ийн §230.2 дахь зохицуулалтыг амьдралын тодорхой нэг тохиолдолд тус хуулийн §511.1 дэх хэсгийг хэмжүүр болгон өргөжүүлж, хөгжүүлэх боломжийг нээлттэй үлдээсний нотолгоо юм.

Системчлэх тайлбар: Үг зохицуулалтыг хуульд зааснаас бусад тохиолдлыг хориглосон гэж тайлбарлах юм бол ИХ-ийн §228.1-д “Гэм хорыг арилгах үүрэг бүхий этгээд нөгөө талын зөрчигдсөн эрхийг гэм хор учруулахаас өмнөх байдалд сэргээх үүрэгтэй. Зөрчигдсөн эрхийг сэргээх боломжгүй, эсхүл харьцангуй их зардал гарахаар бол гэм хорыг мөнгөөр нөхөн төлж болно” гэж, мөн хуулийн §230.1-д “Эдийн бус гэм хорыг арилгуулахаар хохирогч шаардах эрхтэй” гэж тус тус заасантай зөрчилдөнө. Эдгээр зохицуулалтууд нь юун түрүүнд хохирогчийн зөрчигдсөн эрхийг өмнөх байдалд нөхөн сэргээх, хэрэв боломжгүй бол эцсийн хувилбар нь мөнгөн төлбөр гэсэн утгыг агуулж байна. Иймээс ИХ-ийн §230.2 дахь зохицуулалтыг хуульд тусгайлан заасан тохиолдолд эдийн бус гэм хорыг шууд мөнгөөр барагдуулна, харин тусгайлан заагаагүй бол зөрчигдсөн эрхийг сэргээх арга замыг урьтал болгож гэм хорыг барагдуулна гэж тайлбарлах юм бол иргэний хуулийн нэгдмэл байдлыг хангана.

Зорилгын тайлбар: Гэм хорын эрх зүйн зохицуулалт нь хохирогчийн зөрчигдсөн эрхийг нөхөн сэргээх, барагдуулах зорилготой. ИХ-ийн §230.2 дэх зохицуулалтыг хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд мөнгөөр барагдуулахыг хориглосон гэж тайлбарлавал хуульд тусгайлан заагаагүй,

³³ <http://toli.gov.mn/search?q=%D0%B3%D0%B0%D0%B3%D1%86%D1%85%D2%AF%D2%AF&t=%D0%A2%D0%9E%D0%9B%D0%AC>

мөн бусад аргаар гэм хорыг арилгах боломжгүй нөхцөлд хохирогчийн гэм хороо арилгуулах эрх бүрэн үгүйсгэгдэнэ. Харин хуульд тусгайлан заасан тохиолдлыг мөнгөөр нөхөн төлөх баталгааг хангаж өгсөн гэж ойлговол гэм хорын эрх зүйн үзэл санаанд нийцнэ.

ЭХХШТХ-ийн §45.4.1-д “Эд хөрөнгийн бус хохирол, ... мөнгөн хэлбэрээр нөхөн төлүүлэх тухай нэхэмжлэлийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу гаргана.” гэж заасан. Тиймээс Иргэний хэргийн шүүх дээрх нэхэмжлэлийг хүлээн авч шийдвэрлэхээс өөр аргагүй. Гэхдээ нэхэмжлэлийн шаардлагыг хангах, эсхүл хэрэгсэхгүй болгох талаарх тухайлсан зохицуулалт дутагдаж байгаа учраас эрх зүйн хийдэл болох нь тогтоогдож байна.

В. (F2) ИХ-ийн §511.1 дэх хэсэг нь төсөөтэй харилцааг зохицуулсан хэм хэмжээ мөн

УДШ-ийн тогтоол №1-д төсөөтэй харилцааг зохицуулсан хэм хэмжээ байгаа эсэх талаар дүгнэхгүйгээр шууд нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон. Шүүх эрүүгийн процессын явцад учирсан сэтгэл санааны хохирлыг мөнгөөр нөхөн төлөх талаар тухайлсан зохицуулалт байхгүй гэж үзсэн тохиолдолд төсөөтэй харилцааг зохицуулсан хэм хэмжээг олох ёстой байсан [ИХ-ийн 4.1]. Хэрэв төсөөтэй харилцааг зохицуулсан хэм хэмжээ байхгүй бол эрх зүйн нийтлэг үндэслэлээр [ИХ-ийн 4.2] хэргийг шийдвэрлэх учиртай. Яагаад гэвэл тухайлсан зохицуулалт байхгүй нь хэргийг шийдвэрлэх хууль зүйн үндэслэл биш, харин хуулийн зохицуулалтын утга агуулгад үндэслэж шийдвэр гаргахыг хууль дээдлэх ёс, хуульд үндэслэх зарчим шүүхээс шаарддаг.

Харин тогтоол №3-д (дараагийн элементэд танилцуулна) ИХ-ийн §511.1 дэх хэсгийг төсөөтэй хэрэглэж шийдвэрлэсэн боловч яагаад төсөөтэй харилцааг зохицуулсан хэм хэмжээ гэж үзсэн гэдгээ огт тайлбарлаагүй. Хүний нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд болон сэтгэл санааны хохирол нь эдийн бус гэм хор гэх нэг категорид хамаарч байгаа гэдэг утгаараа төсөөтэй харилцааг зохицуулсан хэм хэмжээ гэдэг нь хуульч нарын хувьд тайлбар шаардахгүй ойлгомжтой боловч аливаа шүүхийн шийдвэр нь талуудад, ялангуяа ялагдсан талд чиглэсэн³⁴ байдаг учраас шүүх энэ талаарх үндэслэлээ бичих ёстой.

С. (Rn) ИХ-ийн §511.1 дэх зохицуулалт нь халдашгүй байх эрхийг хамгаалах зорилготой

УДШ ИХ-ийн §511.1 дэх хэсэг нь тусгай харилцааг зохицуулсан хэм хэмжээ учраас төсөөтэй хэрэглэх нь хууль хэрэглээний алдаа гэж үзсэн. Ингэж үзэх болсон үндэслэлээ ийнхүү тайлбарласан:

Тогтоол №2: Иргэний хуулийн 511 дүгээр зүйлийн 511.1.-д заасан эдийн бус гэм хорыг арилгах зохицуулалтад зөвхөн бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ

³⁴ Н.Лүндэндорж, “Хууль тайлбарлан, хэрэглэх онол, арга зүй- Доктор, Проф, Лекцийн тэмдэглэл”, Шүүх эрх мэдэл сэтгүүл, 2015/1, 6.

тараасан этгээдийн үүргийг тусгажээ. Харин Иргэний хуулийн 230 дугаар зүйлийн 230.1., 230.2.-т зааснаар эдийн бус гэм хорыг арилгуулахаар хохирогч шаардах эрхтэй боловч гагцхүү хуульд тусгайлан заасан тохиолдолд эдийн бус гэм хорыг мөнгөөр нөхөн төлөх боломжтой байна. Өөрөөр хэлбэл, сэтгэл санаанд учирсан хохирол буюу эдийн бус гэм хорыг хэрхэн арилгуулах талаар Иргэний хуульд тухайлсан зохицуулалт байхгүй нөхцөлд шүүх энэ талаарх шаардлагыг хангах боломжгүй юм.

Анхан болон давж заалдах шатны шүүх нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангахдаа Иргэний хуулийн 511 дүгээр зүйлийн 511.1.-д заасан зохицуулалтыг тухайн маргаанд төсөөтэй хэрэглэсэн нь алдаатай болжээ. Иргэний хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.-д зааснаар Иргэний хуульд тухайн харилцааг зохицуулсан хэм хэмжээ байхгүй бол түүнтэй төсөөтэй харилцааг зохицуулсан хуулийн хэм хэмжээг хэрэглэх боловч мөн зүйлийн 4.3.-т зааснаар тусгай харилцааг тухайлан зохицуулсан хэм хэмжээг бусад харилцаанд төсөөтэй хэрэглэж үл болно. Сэтгэл санаанд учирсан гэм хор болон нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд гутаагдсанаас учирсан гэм хор нь эдийн бус гэх төрөлд хамаарах боловч агуулга, хэлбэрийн хувьд ялгаатай тул эдгээр харилцаанд эрх зүйн нэг хэм хэмжээг төсөөтэй хэрэглэх боломжгүй гэж үзнэ.³⁵

УДШ ИХ-ийн §230.2 дахь хэсгийн “Гагцхүү хуульд тусгайлан заасан тохиолдолд ...” гэснийг тус хуулийн §4.3 дахь хэсгийн “Тусгай харилцааг тухайлан зохицуулсан хэм хэмжээ ...” гэх утгаар ойлгож хэрэглэсэн байж болох юм. ИХ-ийн §230.2 дахь хэсэг нь маргаан бүхий фактад ИХ-ийн §511.1 дэх хэсгийг төсөөтэй хэрэглэж болох эсэх талаар хариулт өгөхгүй. Учир нь төсөөтэй хэрэглэж болох эсэхийг хуулийн заалтаар тодорхойлох боломжгүй. Аналогийн арга зүйн дагуу холбогч бодомжоор шийдвэрлэнэ. Өөрөөр хэлбэл, маргаан бүхий факт болон төсөөтэй харилцааны нийтлэг шинж нь тухайн зохицуулалтын зорилгод нийцсэн бол аналог [ИХ-ийн §4.1], харин нийтлэг шинжтэй байсан ч тэр шинж нь тухайн зохицуулалтын зорилгод чухал үүрэгтэй биш бол эсрэг дүгнэлт [ИХ-ийн §4.3] гарна. Иймээс юуны өмнө нь ИХ-ийн §511.1 дэх хэсгийн зорилго юу вэ гэдгийг, дараа нь тэр шинж эрүүгийн процессын явцад учирсан сэтгэл хохирлоо мөнгөөр нөхөн төлүүлэх шаардлага бүхий фактад буй эсэхийг авч үзье.

ИХ-ийн 511 дугаар зүйл нь хүний нэр төр, алдар хүндийг /цаашид алдар хүнд гэх/ хамгаалахад зориулагдсан зохицуулалт юм. Учир нь хүний алдар хүнд халдашгүй байх эрх бол Үндсэн хуулийн 16-р зүйлийн 13-т заасан халдашгүй байх ерөнхий эрхээр хүлээн зөвшөөрөгдсөн үндсэн эрх учраас алдар хүндийг гүтгэлэг, доромжлохоос хамгаалах шаардлага гардаг³⁶. Үндсэн хууль дахь “хамгаалах” гэх ойлголт нь урьдчилан сэргийлэх төдийгүй зөрчигдсөн тохиолдолд түүнийг нөхөн

³⁵ УДШ-ийн тогтоол, №001/ХТ2018/00169, 2018.02.02, <http://new.shuukh.mn/irgenhyanal/3809/view>.

³⁶ О. Мөнхсайхан, “Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд нийцүүлэн гүтгэлгийг зохицуулах нь”, 2. <https://legaldata.mn/buteel/pdf?id=715>

сэргээх, барагдуулах утгыг өөртөө агуулдаг³⁷ Иргэний хууль нь алдар хүндийг гутаасан хариуцагчаас нөхөн төлбөр гаргуулах замаар хамгаалж чаддаг³⁸.

ҮХ-ийн §16.13-т заасан халдашгүй байх ерөнхий эрхэд багтдаг бусад эрхүүд бол бие махбод, хувийн эрх чөлөө, орон байрны халдашгүй байдал юм.³⁹ ҮХ-ийн §1.2-т тэгш байдлыг төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим гэж, мөн хуулийн §14.1-д хүн бүр хуулийн өмнө тэгш байна гэж тус тус заасан. Тиймээс хуульд тухайлан заагаагүй нөхцөлөөр эдгээр эрхүүдийг ялгаварлан гадуурхаж болохгүй. Өөрөөр хэлбэл, бие махбод, хувийн эрх чөлөө, орон байрны халдашгүй байдлыг алдар хүндийн адил түвшинд хамгаалах шаардлагатай.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь хүний бие, орон байранд үзлэг, нэгжлэг хийх, баривчлах, цагдан хорих зэргээр тэдгээр эрхүүдэд халддаг. Иймээс ҮХ-ийн §16.13-т заасны дагуу зөвхөн хуульд заасан үндэслэлээр явагддаг. Хүний гэм бурууг урьдчилан бүрэн дүүрэн мэдэх боломжгүй учраас эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд “үндэслэл бүхий сэжиг” байх тохиолдолд явагдахаар заасан. Өөрөөр хэлбэл, Эрүүгийн процессын хууль гэм буруугүй хүнийг баривчлах, цагдан хорих, ял эдлүүлэх эрсдэлийг агуулж байдаг.⁴⁰ Тиймээс эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах сэжиг худал байсан гэдэг нь хожим тогтоогдвол процессын явцад учирсан аливаа хохирлыг барагдуулах ёстой. Гэвч, хууль тогтоогч эрүүгийн процессын явцад учирсан сэтгэл санааны хохирлыг барагдуулах талаар тухайлсан зохицуулалтыг хараахан хуульчлаагүй байна. Тиймээс шүүх ИХ-ийн §511.1 дэх хэсгийг төсөөтэй хэрэглэж, хэргийг шийдвэрлэхээс өөр аргагүй. Энэ нь ҮХ-ийн §19.1-д заасан хүний эрхийг сэргээн эдлүүлэх шүүхийн үүрэг юм.

УДШ-ийн өөр нэг тогтоолд ИХ-ийн §511.1-ийг төсөөтэй хэрэглэх нь ИХ-ийн §4.1-д нийцнэ гэж үзсэн:

Тогтоол №3: *Иргэний хуулийн 230 дугаар зүйлийн 230.2-т гагцхүү хуульд тусгайлан заасан тохиолдолд эдийн бус гэм хорыг мөнөөр нөхөн төлнө гэж заасан боловч хууль бусаар яллагдагчаар татагдсан, ял шийтгүүлсэн, баривчлагдсан иргэнд учирсан сэтгэл санааны хохирлыг арилгах талаар хуульд тусгайлан зохицуулаагүй бөгөөд Иргэний хуулийн 511 дүгээр зүйлийг төсөөтэй хэрэглэх нь мөн хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт нийцнэ*⁴¹

Шүүхийн шийдвэрийн хууль зүйн үндэслэл нь төсөөтэй харилцааг зохицуулсан хэм хэмжээ бус, түүний зорилго (холбогч бодомж) байтал

³⁷ Б.Чимид, Мөн бүтээл, 147.

³⁸ О. Мөнхсайхан, Мөн бүтээл, 16.

³⁹ Б.Чимид, Мөн бүтээл, 126.

⁴⁰ Н. Норовсамбуу, Ж. Содномдаржаа, “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад мөрдөгч, прокурор, шүүгчийн хууль зөрчсөн ажиллагааны явцад учирсан хохирлыг нөхөн төлүүлэх хэрэг: шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ” судалгааны тойм, https://www.forum.mn/index.php?sel=re-source&f=reslist&menu_id=3&resmenu_id=3

⁴¹ УДШ-ийн тогтоол, №001/ХТ2017/00432, 2017.04.13, <http://new.shuukh.mn/irgenhyanal/2545/view>

огт бичээгүй нь дур зоргоор шийдсэн гэсэн ойлголт төрүүлэх төдийгүй үндэслэлийн талаар олон нийт хэлэлцэж, шүүмжлэх, хөгжүүлэх боломжийг хязгаарлах юм.

D. (E) Эрүүгийн процессын явцад учирсан сэтгэл санааны хохирлыг мөнгөөр нөхөн төлөх нь зүй ёсонд нийцнэ

Эрүүгийн процессын явцад учирсан сэтгэл санааны хохирлыг мөнгөөр барагдуулах нь зүй ёсны гэдгийг гурван үндэслэлээр зөвтгөж харуулъя. (1) ҮХ-ийн §19.2-т Үндсэн хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг гагцхүү хуулиар хязгаарлаж болно гэж заасан. Эрүүгийн процессын явцад учирсан сэтгэл санааны хохирлыг мөнгөөр нөхөн төлөх нь ҮХ-ийн §16.3-т заасан хүний халдашгүй байх эрхийн хамгаалалтын нэг хэлбэр. Үүнийг хориглосон зохицуулалт хуульд байхгүй. Тиймээс энэ эрхийг хүлээн зөвшөөрөх нь шүүхэд нээлттэй. (2) ҮХ-ийн §19.3-т хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй гэж заасан. Энэ үндэслэлээр төр хүний халдашгүй байх эрхэд халдсан боловч хожим халдах үндэслэл худал байсан гэдэг нь тогтоогдсон. Төр өөрийн үйлдлийн улмаас учруулсан хохирлыг хариуцах нь зүй ёсны хэрэг. (3) ҮХ-ийн 16-р зүйлд хүн үндсэн эрх, эрх чөлөөгөө баталгаатай эдэлнэ гэж заасан. Эрүүгийн процессын явцад учирсан сэтгэл санааны хохирлыг барагдуулах өөр арга зам байхгүй. Өөрөөр хэлбэл, яллагдагчид холбогдох хэргийг цагаатгаж, хэрэгсэхгүй болгосноор тухайн үеийн айдас, түгшүүр, сэтгэлийн шаналал, зовнилыг арилгахгүй. Тиймээс мөнгөөр нөхөн төлбөр олгох нь сүүлийн хувилбар юм.

ДҮГНЭЛТ, САНАЛ

Энэхүү судалгааны ажлаар шүүх аналогийг хэрэглэх шаардлага, хүлээн зөвшөөрөгдөх байдал, хэрэглэх аргачлалыг хөндөж, УДШ-ийн тогтоолд дүн шинжилгээ хийв.

УДШ-ийн тогтоол, бусад шүүхийн шийдвэрүүдээс харахад, ИХ-ийн 4-р зүйлээр аналогийг оновчтой хуульчилсан боловч шүүхийн практикт түүний хэрэглээ төлөвшөөгүй байна. Үүний улмаас хуулиар тухайлан зохицуулагдаагүй орчинд үүссэн фактыг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр үндэслэгдсэн бус байхын сацуу, хүний эрхийг хамгаалж чадахгүй байна. Товчхондоо, Шүүх аналогийг хэрэглэж хэвшихгүй бол шүүхийн практикаас **хууль үгүй бол эрх үгүй зарчим** үүсэх эрсдэлтэй. Тиймээс хууль тогтоомжийг боловсронгуй болохын зэрэгцээ аналогийн ач холбогдол, арга зүйг таниулах, онол, арга зүйн судалгаа хийх, гарын авлага, ном, сурах бичиг бэлтгэх, шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ хийх зэргээр хууль хэрэглээний /аналог/ аргачлалыг хөгжүүлэх, шүүхийн хэрэглээ болгох шаардлага байна. Шүүхийн практикт аналог хэрэглэж төлөвших юм бол хүний эрхийн хамгаалалт тэлэх ба тус шийдвэрүүдийн талаар олон нийт хэлэлцэж, эрх зүйг хөгжүүлэх, хууль тогтоомжийг боловсронгуй

болгох эх сурвалж болох ач холбогдолтой.

Цаашлаад <http://new.shuukh.mn/> сайтад шүүхийн шийдвэрүүдийг байршуулахдаа эрх зүйн хийдэл бүхий хэргийн талаарх шийдвэрүүдийг тусдаа цэсэд байршуулах; Ингэснээр хууль тогтоогч, хуульч, судлаач, олон нийт түүнд анхаарал хандуулж, хэлэлцүүлэг өрнүүлэх, нөхөх (хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар хийдлийг бүрэн арилгах) боломж бүрдэх юм.



Ганхуягийн ЦЭРЭНДЭЖИД

Судлаач
(тусгай байр)

ШҮҮХИЙГ ТОЙРГИЙН ЗАРЧМААР БАЙГУУЛАХАД АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ /АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН ЖИШЭЭ ДЭЭР/

Түлхүүр үгс: *Шүүх эрх мэдэл, шүүхийг тойргийн зарчмаар байгуулах, иргэний эрх, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж*

ХУРААНГУЙ: Энэхүү илтгэлээр Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн дагуу Монгол Улсын Шүүхийн тухай хуульд тусгагдсан “анхан шатны шүүхийг тойргийн зарчмаар байгуулах” заалт нь манай улсын засаг захиргааны нэгж, төрийн үйлчилгээний одоогийн тогтолцоотой уялдаж буй эсэх, иргэд шүүхээр үйлчлүүлэхэд хүндрэл, бэрхшээл үүсгэх эсэх, шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахад сөргөөр нөлөөлөх эсэх, энэ нь хэтдээ шүүх эрх мэдэл иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, тэдгээрийн зөрчигдсөн эрхийг сэргээх чиг үүргээ түргэн, шуурхай хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх асуудалд дүгнэлт хийхийг зорив.

I.УДИРТГАЛ

Монгол Улсын Үндсэн хууль бол шударга ёс, эрх чөлөө, тэгш байдлын төлөө хууль мөн.¹ 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр батлагдсан Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн Дөчин наймдугаар зүйлийн 1.-д “Шүүхийн үндсэн тогтолцоо Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхээс бүрдэх бөгөөд *шүүхийг тойргийн зарчмаар байгуулж болно*. Шүүхийг эрүү, иргэн, захиргааны зэрэг шүүн таслах ажлын төрлөөр дагнан байгуулж болно. Дагнасан шүүхийн үйл ажиллагаа, шийдвэр нь Улсын дээд шүүхийн хяналтаас гадуур байж үл болно.” гэж заасан.

Ийнхүү Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд орсон заалтын хэрэгжилтийг хангах үүднээс холбогдох хууль тогтоомжийг нийцүүлэн өөрчлөх хэрэгцээ шаардлага үүссэн билээ. Улмаар 2021 оны

¹ Чимид Б. “Үндсэн хуулийн мэдлэг” УБ., 2008 он, 36 дахь тал

1 дүгээр сарын 15-ны өдөр батлагдсан Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4. дэх хэсэгт “Анхан болон давж заалдах шатны шүүхийг тойргийн зарчмаар байгуулж болно. Шүүхийг тойргийн зарчмаар байгуулахад энэ хуулийн 14.3-т заасныг харгалзахаас гадна шүүхэд хандах иргэний эрхийн баталгааг хангах, шүүхийн үйлчилгээг иргэнд хүртээмжтэй хүргэхэд чиглэсэн байна.”, 14 дүгээр зүйлийн 14.3. дахь хэсэгт “Шүүхийг байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах, байршлыг тогтооход түүний харьяалан ажиллах нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн амын тоо, шийдвэрлэсэн хэрэг, маргааны төрөл, тоог харгалзан үзнэ.”, 29 дүгээр зүйлийн 29.1. дэх хэсэгт “Давж заалдах шатны шүүх нь аймаг, нийслэлийн болон захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхээс бүрдэнэ.”, 29.2. дахь хэсэгт “Давж заалдах шатны шүүхийг тойргийн зарчмаар байгуулж болно.”, 30 дугаар зүйлийн 30.1. дэх хэсэгт “Сум буюу сум дундын, дүүргийн шүүх болон аймаг, нийслэлийн захиргааны хэргийн шүүх нь өөрийн харьяалах нутаг дэвсгэрт анхан шатны шүүн таслах ажиллагааг хэрэгжүүлнэ.”, 30.2. дахь хэсэгт “Анхан шатны шүүхийг тойргийн зарчмаар байгуулж болно.” гэх зохицуулалтыг тусгаад байна.

Судлаачийн зүгээс шүүхийн тойргийн зарчмаар байгуулах зохицуулалт нь манай улсын засаг захиргааны нэгж, төрийн үйлчилгээний одоогийн тогтолцоотой уялдах эсэх, иргэд шүүхээр үйлчлүүлэхэд хүндрэл, бэрхшээл үүсгэх эсэх, шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахад сөргөөр нөлөөлөх эсэх, энэ нь хэтдээ шүүх эрх мэдэл хүний эрхийг сахин хамгаалах чиг үүргээ хэрэгжүүлэх болон иргэд төрийн үйлчилгээ авах, эрхээр хамгаалуулах нөхцөлийг баталгаатай хангах эсэх асуудлыг хөндөхөөр энэхүү сэдвийг судалсан билээ.

Хэдийгээр судалгаа хийж буй одоогийн цаг хугацаанд шүүхийг тойргийн зарчмаар байгуулаагүй байгаа авч хуулийн энэ зохицуулалтын хүрээнд шүүхийг тойргийн зарчмаар байгуулах боломжийг нээсэн бөгөөд уг судалгаанд дурдсан зарим асуудлыг анхаарах нь шүүх эрх мэдлийн шинэ сорилын үед чухал ач холбогдолтой сэдэв гэж үзлээ.

Уг сэдвийн хүрээнд нэг сэдэвт ном, судалгааны материал ховор боловч хуулийн төсөлд хүргүүлсэн олон нийтийн санал, эрдэмтэн судлаачдын судалгаа, төрийн бус байгууллагын санал, дүгнэлтэд тодорхой хэмжээнд тусгагджээ. Мөн судалгааны ажлын явцад олон төрлийн санал, дүгнэлт бүхий материалаас түүвэрчлэх аргаар мэдээлэл цуглуулсан болно.

II. ШҮҮХ ЭРХ МЭДЭЛ, ТҮҮНИЙ ТУХАЙ ТОВЧ ӨГҮҮЛЭХ НЬ

Эрх мэдлийг хуваарилах зарчмаар төрийн байгууллагуудыг “хууль тогтоох”, “гүйцэтгэх”, “шүүх” гэсэн гурван салаа бүхий тогтолцоог тодорхойлон бэхжүүлсэн нь 1992 он Үндсэн хуулийн гол үзэл баримтлалын нэг, зарчмын эрс шинэлэг тал мөн.²

² Чимид Б. “Үндсэн хуулийн үзэл баримтлал” УБ, 2017 он, 56 дахь тал

Онолын хувьд, хэрэв хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийг нэг гарт төвлөрүүлбэл эрх чөлөө хэрэгжихгүй ... шүүх эрх мэдэл хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлээс тусгаарлагдаагүй тохиолдолд мөн эрх чөлөө үл оршино. Хэрэв шүүх эрх мэдэл хууль тогтоох эрх мэдэлтэй нэгдвэл, иргэдийн амьдрал, эрх чөлөө дур зоргын золиос бол болно. Хэрэв шүүх эрх мэдлийг гүйцэтгэх эрх мэдэлтэй нэгтгэвэл шүүгчид дарангуйлагчид болох бололцоог бүрдүүлнэ³ хэмээн нэрт сэтгэгч Ш.Монтескье өгүүлсэн байдаг.

Шүүх эрх мэдэл нь ардчилсан нийгэмд төрийн эрх мэдлийн нэг чухал салбар нь бөгөөд эрх зүйт ёсны хэрэгжилтийг хангуулах, улмаар хуулийг алагчлалгүй, шударга, үр нөлөөтэй хэрэглэхэд шүүхийн зорилго оршино.⁴

Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин долдугаар зүйлийн 1.-д “Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ.”, Дөчин есдүгээр зүйлийн 1.-д “Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана.” гэж шүүх эрх мэдлийн эрх зүйн үндсийг тунхаглажээ.

“Шүүх эрх мэдэл” нь нэгдүгээрт, эрүү, иргэний хэрэг төдийгүй эрх зүйн бусад (“бүх”) маргааныг эцэслэн хянан шийдвэрлэх, хоёрдугаарт, хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын үйл ажиллагаанд хуулиар тогтоосон хэмжээ хязгаарын дотор гаднын хяналт тавьж хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн эрх мэдлийн бие даасан салаа мөн⁵ билээ.

Шүүх нь нийгэмд болсон маргаан, зөрөлдөөнийг хянан үзэж түүнд хуулийг мэргэжлийн үүднээс тайлбарлан хэрэглэж эрх зүйн шийдэл гаргадаг. Ингэснээрээ шүүх хууль зүйн элдэв зөрөлдөөнд үндсэн ба бусад хууль, олон улсын гэрээгээр илэрхийлсэн эрх зүйн ноёрхлыг тогтоох үүрэгтэй. Энэ бол шүүхийн нийгэмшил, хууль зүйн үүрэг мөн.⁶

Угаас шүүх эрх мэдлийн хараат бус, бие даасан байдал нь шүүхийн байгууллагын тогтолцоо, ... шүүгчдийн хараат бус байдал, бүтцийн нэгж болох шүүхүүдийн бие даасан байдал болох үйл ажиллагааны үндсэн зарчим тэдгээрийг хангах баталгаагаар тодорхойлогддог⁷ байна.

Үүнээс үзэхэд “шүүх эрх мэдэл” бол “хууль тогтоох”, “гүйцэтгэх” эрх мэдэлтэй эн тэнцүү орших бөгөөд харилцан хяналт тавихын зэрэгцээ хараат бус бие даасан байж, хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, түүнийг сэргээн эдлүүлэх, ард иргэдийн аж амьдралыг сахин хангах баталгаа юм.

III. МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН ТОГТОЛЦОО, ШҮҮХИЙГ ТОЙРГИЙН ЗАРЧМААР БАЙГУУЛАХ ТУХАЙ

1921 онд Ардын хувьсгал ялснаар Монгол орны төр, нийгэм, эдийн засгийн бүтцэд үндсэн өөрчлөлт гарч БНМАУ-д Ардын шүүх үүсэх эх суурь

³ Монтескье Ш. “Хуулийн амин сүнс” УБ, 2009 он, 138-139 дэх тал

⁴ Шүүгчийн магни харти 2010 он, Страсбург хот

⁵ Чимид Б. “Үндсэн хуулийн үзэл баримтлал: Хүний эрх, шүүх эрх мэдэл” УБ хот, 2004, 119 дэх тал

⁶ Мөн тэнд 121 дэх тал

⁷ Чимид Б. “Үндсэн хуулийн үзэл баримтлал: Хүний эрх, шүүх эрх мэдэл” 2-р дэвтэр, УБ, 2004, 122-123 дахь тал

тавигджээ. 1921 оны 3 дугаар сард Дотоод яаманд “шүүн таслах хэлтэс”, мөн оны 7 дугаар сард Шүүх явдлын яам, орон нутагт “зарга шийтгэх түр хэлтэс”, Засгийн газрын дэргэд “түр цагийн шүүх” байгуулснаар орчин цагийн шүүх бүрэлдэн тогтох анхдагч суурь болсон юм.⁸

Улмаар 1926 оны 4 дүгээр сарын 16-ны өдөр БНМАУ-ын Засгийн газрын гишүүдийн 15 дугаар хурал, Улсын Бага хурлын Тэргүүлэгчдийн 21 дүгээр хурлаар “Аливаа шүүн таслах газруудыг шинэчлэн байгуулах тухай дүрэм”-ийг батаж, Хошуудын жинхэнэ ардын шүүн таслах газар, аймаг, Хотын шүүн таслах газар, Тусгай шүүн таслах газар, Улсын дээд шүүн таслах газар байгуулагдсан байдаг. Энэ үед Монгол Улсын шүүхийн тогтолцоо нь Улсын дээд, тусгай, аймаг, хотын болон хэсгийн (дүүргийн) шүүх хэсэг нэгдмэл “босоо” тогтолцоо, бүхэлдээ намын хяналт, Ардын Их Хурал, Засгийн газрын нөлөөнд оршиж байжээ.

Харин 1992 оны шинэ Үндсэн хуулиар шүүх эрх мэдлийг төрийн эрх мэдлийн бие даасан салаа болгон төлөвшүүлэх эх үндэс тавигдсан байдаг.

Монгол Улсын шүүх нь хэрэг маргааныг хянан шийдвэрлэх эрх хэмжээний хувьд: а/анхан шатны; б/давж заалдах шатны; в/хяналтын шатны гэсэн гурван шаттай тогтолцооноос бүрдэж⁹ байна. Мөн дээрх тогтолцооны зэрэгцээ дагнасан шүүхийн тогтолцоо байхыг хүлээн зөвшөөрч, харин ямар нэгэн тусгай шүүх байгуулахыг хоригложээ.

Улс орнуудад “ерөнхий шүүх”, “тусгай шүүх” гэсэн ойлголт байдаг. Энэ жишгийг харгалзахын хамт төрийн эрх мэдлийн “хууль тогтоох”, “гүйцэтгэх” хоёр салаа шүүхийн тэнцвэрт байдлыг хангахын тулд Монгол Улсын шүүхийн тогтолцоог “үндсэн”, “дагнасан” гэсэн хоёр дэд хэсгээс бүрдэхээр тодорхойлж, уялдаа холбоог нь тогтоосон¹⁰ байна.

Шүүхийг тойргийн зарчмаар байгуулсан туршлага, 2019 оны Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт, 2021 оны Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдахаас өмнө шүүхийн тогтолцоо нь “үндсэн” ба “дагнасан” шүүхийн тогтолцооноос бүрдэх бөгөөд шүүхийн үндсэн тогтолцоо нь Улсын Дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхээс, дагнасан шүүхийн тогтолцоонд Захиргааны хэргийн шүүх хамаарахаар тусгасан байжээ.

2012 оны 3 дугаар сарын 7-ны өдөр батлагдсан Шүүхийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1. дэх хэсэгт “Шүүхийн үндсэн тогтолцоо нь Улсын дээд шүүх /хяналтын шатны шүүх/, аймаг, нийслэлийн шүүх /давж заалдах шатны шүүх/, сум буюу сум дундын, дүүргийн шүүх /анхан шатны шүүх/-ээс бүрдэнэ.”, 10.2. дахь хэсэгт “Улсын дээд шүүхээс бусад шүүхийг нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн амын нягтаршил, шийдвэрлэгдсэн хэрэг, маргааны тоог харгалзан засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хэд хэдэн нэгжийг харьяалуулан эрүү, иргэн, захиргааны зэрэг шүүн таслах

⁸ <http://www.supremecourt.mn/c/1> , сүүлд үзсэн 2021.12.01

⁹ Совд Г, нар “Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар” УБ, 2000, 210 дахь тал

¹⁰ Чимид Б. “Үндсэн хуулийн үзэл баримтлал” УБ, 2017 он, 123 дахь тал

ажлын төрлөөр дагнан байгуулна.” гэж заасан.

Уг өөрчлөлтийн дагуу 2013 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн Шүүх байгуулах тухай хуулиар улсын хэмжээнд нутаг дэвсгэрийн ойр дөт байдал, шүүхийн ачааллыг харгалзан тус бүр 2-3 аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг харьяалсан дагнаж байгуулсан давж заалдах шатны 21, сум дундын 29, захиргааны хэргийн анхан шатны 20, дүүргийн эрүү, иргэний 8, нийт 78 шүүх шинээр зохион байгуулагдсан байдаг.

Гэвч хуулийн дээрх заалтыг Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн асуудлаар нэр бүхий иргэдээс Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд мэдээлэл гаргаж, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор¹¹ Шүүх байгуулах тухай хуулийн 1 дүгээр зүйлийн Нэг. Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх, Хоёр. Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх; мөн хуулийн 2 дугаар зүйлийн Нэг. Дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх, Хоёр. Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх, түүнчлэн Гурав. Захиргааны хэргийн анхан шатны шүүх гэсний 6, 11 дэх заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Шүүхийн үндсэн тогтолцоо ... аймаг, нийслэлийн шүүх, ... дүүргийн шүүхээс бүрдэх ...” гэсэн заалтыг зөрчсөн болохыг тогтоож, хүчингүй болгосон билээ.

Дээрх хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудлаар Ж.Бариширсүрэн нарын Шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх нь сэдэвт хэлэлцүүлэгт танилцуулсан “Шүүхийн тогтолцоог өөрчлөх бодлогын шийдвэрийн хэрэгжилт” судалгаанд¹² “... Шүүхийн тойргийн журмаар байгуулсан нь хэдийгээр тойргийн шүүхүүд орон зайн хувьд иргэдэд ойртсон мэт боловч нийтийн тээвэр, зам харилцаа, дэд бүтэц сайн хөгжөөгүй зэргээс шалтгаалан иргэдэд эдийн засгийн зардал ихсэж шүүх иргэдээс улам холджээ...” гэх дүгнэлт хийсэн байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн шинэчилсэн найруулга, 2000 онд Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт өөрчлөлт, нийгмийн хөгжлөөс үүдэн Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хэрэгцээ, шаардлага тулгамдсаар ирсэн. Улмаар 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр УИХ-ын нэгдсэн чуулганы хуралдаанаар Монгол Улсын Үндсэн хуулийн 19 зүйл, 30 гаруй хэсэгт өөрчлөлт оруулахыг дэмжиж баталсан билээ.¹³

Дээрх нэмэлт өөрчлөлтөөр шүүхийг тойргийн зарчмаар байгуулах асуудлаар Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 1.-д “Шүүхийн үндсэн тогтолцоо Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум букуу сум дундын, дүүргийн шүүхээс бүрдэх бөгөөд эрүү, иргэн, захиргааны зэрэг шүүн таслах ажлын төрлөөр шүүхийг дагнан байгуулж болно. Дагнасан шүүхийн үйл ажиллагаа, шийдвэр нь Улсын дээд шүүхийн хяналтаас гадуур байж үл болно.” гэх заалтыг “Шүүхийн

¹¹ <https://legalinfo.mn/mn/detail/10860>, сүүлд үзсэн 2021.12.01

¹² Бариширсүрэн Ж. нар, “Шүүхийн тогтолцоог өөрчлөх бодлогын шийдвэрийн хэрэгжилт” УБ, 2015, 25 дахь тал

¹³ <https://ikon.mn/n/1qis>, сүүлд үзсэн 2021.12.01

үндсэн тогтолцоо Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхээс бүрдэх бөгөөд **шүүхийг тойргийн зарчмаар байгуулж болно**. Шүүхийг эрүү, иргэн, захиргааны зэрэг шүүн таслах ажлын төрлөөр дагнан байгуулж болно. Дагнасан шүүхийн үйл ажиллагаа, шийдвэр нь Улсын дээд шүүхийн хяналтаас гадуур байж үл болно.” гэх заалтыг нэмж оруулан, өөрчлөн найруулсан байдаг.

Улмаар 2021 оны 1 дүгээр сарын 15-ны өдөр батлагдсан Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4. дэх хэсэгт **“Анхан болон давж заалдах шатны шүүхийг тойргийн зарчмаар байгуулж болно**. Шүүхийг тойргийн зарчмаар байгуулахад энэ хуулийн 14.3-т заасныг харгалзахаас гадна шүүхэд хандах иргэний эрхийн баталгааг хангах, шүүхийн үйлчилгээг иргэнд хүртээмжтэй хүргэхэд чиглэсэн байна.”, 14.3. дахь хэсэгт **“Шүүхийг байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах, байршлыг тогтооход түүний харьяалан ажиллах нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн амын тоо, шийдвэрлэсэн хэрэг, маргааны төрөл, тоог харгалзан үзнэ.”**, 29 дүгээр зүйлийн 29.1. дэх хэсэгт **“Давж заалдах шатны шүүх нь аймаг, нийслэлийн болон захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхээс бүрдэнэ.”**, 29.2. дахь хэсэгт **“Давж заалдах шатны шүүхийг тойргийн зарчмаар байгуулж болно.”**, 30 дугаар зүйлийн 30.1. дэх хэсэгт **“Сум буюу сум дундын, дүүргийн шүүх болон аймаг, нийслэлийн захиргааны хэргийн шүүх нь өөрийн харьяалах нутаг дэвсгэрт анхан шатны шүүн таслах ажиллагааг хэрэгжүүлнэ.”**, 30.2. дахь хэсэгт **“Анхан шатны шүүхийг тойргийн зарчмаар байгуулж болно.”** гэх зохицуулалтыг тусгажээ.

Шүүхийг тойргийн зарчмаар байгуулах заалттай холбоотой санал асуулга, хэлэлцүүлгийн үед дараах санал, тайлбар гарч байв.Үүнд:

2021.01.07-ны өдрийн УИХ-ын нэгдсэн хуралдаанд УИХ-н гишүүн Д.Тогтохсүрэн “ ... шүүх бол иргэдтэйгээ ойрхон л байвал зөв шийдвэр гаргадаг. Тойргийн журмаар их олон болоод ирэх тусмаа шүүхийн шийдвэрт янз бүрийн алдаа болох асуудал харагдаад байгаа юм. Анхан шатны шүүхийн хувьд орон нутаг дээр бол Захиргааны шүүхийг тухайлбал тойргийн журмаар байгуулж болно гэж боддог. Иргэн болон Эрүүгийн шүүхийг тойргийн журмаар байгуулахаар иргэд өөрөө чирэгдчихдэг юм¹⁴ ...” гэж;

Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх үнэлгээнд¹⁵ “ ... хууль тогтоогчид ... иргэдэд үүсэх эдийн засгийн дарамт, шүүхийн үйлчилгээний хүртээмж, хууль сахиулах байгууллагуудын ажлын ачааллыг харгалзан үзэж, эдгээр байгууллагын үйл ажиллагаа, чиг үүргийг уялдуулах замаар шүүхийн тогтолцоог өөрчлөх шаардлагатай байсан нь харагдаж байна.” гэж дүгнэжээ.

Харин дээрх асуудлаар хууль зүйн ухааны доктор Ч.Өнөрбаяр “ ... Шүүхийн тогтолцоог тойргийн журмаар байгуулж болохоор төсөлд тусгаад батлагдсан ... зарим сум дундын шүүхүүд, зарим аймгийн

¹⁴ <https://vip76.mn/content/73065>, сүүлд үзсэн 2021.12.01

¹⁵ <https://nli.gov.mn/pdf/shth-sudalгаа.pdf>, сүүлд үзсэн 2021.12.01

захиргааны хэргийн шүүхүүд жилдээ арав хүрэхгүй маргаан шийддэг байсан. Тойргийн тогтолцоог нэвтрүүлснээр шүүхийн зардал багасна, өөр олон ахиц дэвшил гарна гэж бодож байна¹⁶ ...” гэж;

Хууль зүйн ухааны доктор Т.Мэндсайхан, Б.Өлзийсайхан нарын “Шүүх эрх мэдлийн үндсэн хуулийн шинэчлэл” сэдэвт илтгэлд: “ ... шүүхийг тойргийн журмаар байгуулахыг зөвшөөрсөн нь шүүн таслах ажил, шүүхийн захиргааны харьцангуй тусдаа, бие даасан, мэргэшсэн байдлыг улам хөгжүүлэх шаардлагыг бий болгоно¹⁷ ...” гэж;

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс өргөн мэдүүлсэн /буцаан татсан/ Шүүхийн тухай хуулийн төслийн танилцуулгад “... шүүхийн тогтолцоонд “тойргийн” зарчмыг нэвтрүүлэх, **шүүхийг хэрэг маргааны төрлөөр дагнан байгуулах** нь шүүхийн харилцан адилгүй ачааллыг бууруулах, шүүх, шүүгчийг мэргэшүүлэх, мэргэшсэн шүүгчээр хэрэг маргаанаа шийдвэрлүүлэх эрх зүйн үндсийг бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой¹⁸ ...” гэж;

Монгол Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч Д.Ганзориг Шүүх эрх мэдэл, хууль сахиулах алба хаагчдын Үндэсний чуулганд танилцуулсан илтгэлдээ: “ ... цаашид шүүхийг тойргийн зарчмаар байгуулах, дагнасан шүүхийн төрлийг нэмэх тохиолдолд харьяалан ажиллах нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн амын тоо, шийдвэрлэсэн хэрэг, маргааны төрөл, тоог харгалзахаас гадна шүүхэд хандах иргэний эрхийн баталгааг хангах, шүүхийн үйлчилгээг шуурхай, хүртээмжтэй, чанартай, үр ашигтай хүргэх зарчимд тулгуурлах ёстой. Өнөөдөр шүүхийг хэт жижиглэн байгуулж, шүүхийн орон тоог шүүх бүрэлдэхүүний тоотой тулган ажиллуулж, мөн олон шүүхэд сул орон тоонд сонгон шалгаруулалтыг зарлахгүй, эсхүл цаг алдан зарлах байдал хэвийн мэт үзэгдэл болжээ. Үүний улмаас тухайн шүүхийн шүүгч өвдөх, гачигдах, татгалзах зэрэг ямар нэг хүндэтгэх шалтгаанаар оролцох боломжгүй болоход хэрэг маргааныг шийдвэрлэх бүрэлдэхүүн дутаж, хэргийн хугацаа сунжрах, бүрэлдэхүүн дутуу шүүхэд түр томилолтоор ажиллах тохиолдол хэт олширч байгаа нь иргэдэд шүүхээр үйлчлүүлэхэд бэрхшээл үүсгэж, санхүү талаасаа төсөвт хэвийн бус зардлыг их үүсгэж байна. Шүүх байгуулах зарчим алдагдсанаас зарим нэг аймагт 18 шүүгчид зургаан Ерөнхий шүүгч ногдож байгаа тохиолдол ч байна. Энэ бүх нөхцөл байдлыг бид шүүхийг тойргийн зарчмаар байгуулах тохиолдолд зайлшгүй харгалзан үзэх ёстой. Ингэхдээ шүүхийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй, ойр дөт, шуурхай, үр ашигтай хүргэх зарчмыг алдагдуулах учиргүй¹⁹ ...” гэж;

Монгол Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн Ч.Хосбаярын “Хүний эрхийн үндэсний форум-2021”-д тавьсан илтгэлдээ: “ ... **шүүхийг тойргийн** болон дагналтын зарчмуудын зохистой

¹⁶ <https://dnn.mn/>, сүүлд үзсэн 2021.12.01

¹⁷ ХЗҮХ “Үндсэн хуулийн эхийг баригч-Б.Чимид” ОУ-ын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл УБ, 2020 он 163 дахь тал

¹⁸ <https://president.mn>, сүүлд үзсэн 2021.12.01

¹⁹ <http://www.supremecourt.mn/news/686>, 2021.12.01

тэнцвэрээр байгуулах нь **иргэдэд шүүхийн үйлчилгээ хүртээмжтэй, чанартай хүрэх, хүний нөөцөө зөв удирдах** үндсэн нөхцөлүүдийн нэг мөн²⁰ ...” гэж үзсэн байна.

Нээлттэй нийгэм форумаас Шүүхийн тогтолцоо /тойргийн болон дагнасан шүүх/ судалгааг 2021 онд хийжээ. Уг судалгаанд²¹ “... **Шүүхийг тойргийн зарчмаар байгуулах нь шүүгчийн ажлын ачааллыг тэнцвэржүүлэх ач холбогдолтой ба үүний үр дүнд шүүхийн төсөв болон хүний нөөцийг зөв зохистой хуваарилах үндэс суурь бүрдэх**, шүүхийн үйлчилгээний хүртээмж нэмэгдэх, шударга шүүхээр шүүлгэх иргэний эрх хангагдах зэрэг олон талын ач холбогдолтой ...” гэж тайлбарлажээ.

Судлаачид болон судалгааны байгууллагын хийсэн судалгаанаас үзэхэд шүүхийг тойргийн зарчмаар байгуулах асуудлыг дэмжсэн байна. Тэдгээрийн үзэж буйгаар шүүхийг тойргийн зарчмаар байгуулах нь нэгдүгээрт, шүүхийн ачааллыг тэнцвэржүүлэх, хоёрдугаарт, шүүхийн зардлыг багасгах, хүний нөөцийн менежмент сайжрах зэрэг эерэг үр дагавартай гэж тайлбарлажээ.

Энд товч тэмдэглэхэд, Монгол Улсын нэгдсэн төсвөөс УДШ-ээс бусад шүүхүүд, шүүхийн ерөнхий зөвлөлд нийтэд нь 2018 онд 48,604.8 сая төгрөг, 2019 онд 51,072.7 сая төгрөг, 2020 онд 56,310.3 сая төгрөг, 2021 онд 61,161.3 сая төгрөгийн санхүүжилт олгожээ.²² Энэ нь дунджаар улсын төсвийн 1 хувьд ч хүрэх үзүүлэлт юм. Гэтэл дэлхийн улс орнуудад шүүх эрх мэдэлд дунджаар нийт төсвийн 2.2 хувьтай тэнцэх хэмжээний төсвийг хуваарилдаг байна.²³ Мөн УИХ-н 2016 оны 42 дугаар тогтоолоор улсын хэмжээнд нийт 699 шүүгчийн орон тоог баталсан байдаг.

Монгол Улсын Шүүхийн тайлангаас үзэхэд 2016 онд эрүү, иргэн, захиргааны нийт 62,216 хэргийг 520 шүүгч, 2017 онд 66,317 хэргийг 511 шүүгч, 2018 онд 73,033 хэргийг 503 шүүгч, 2019 онд 76,969 хэргийг 481 шүүгч, 2020 онд 89,635 хэргийг 518 шүүгчийн орон тоотой хянан шийдвэрлэжээ.

Үүнээс үзэхэд төрийн эрх мэдлийн бие даасан салаа болсон шүүх эрх мэдлийн байгууллагад жил бүр улсын төсвийн 1 хүрэхгүй хувийг зарцуулж байна. Энэ тохиолдолд шүүхийн зардлыг багасгах үр ашгийг дурдаж шүүхийг тойргийн зарчмаар байгуулах нь хэр оновчтой вэ. Мөн шүүгчийн орон тоог УИХ-аас тогтоосон хэмжээнд хүртэл нэмээгүй байгаа энэ нөхцөлд орон нутгийн буюу хэргийн ачаалал багатай шүүхийг тойргийн хэлбэрт шилжүүлэн, нийслэл буюу ачаалал ихтэй байгаа шүүхэд шүүгчийн орон тоог шилжүүлэх боломжтой гэж үзсэн нь шүүхийн хүний нөөцийн оновчтой зохицуулалт болох эсэх нь эргэлзээтэй.

Түүнчлэн Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл

²⁰ <http://www.supremecourt.mn/news/705>, 2021.12.15

²¹ https://www.forum.mn/index.php?sel=project&menu_id=446&f=one&obj_id=6072, 2021.12.15

²² Монгол Улсын 2018, 2019, 2020, 2021 оны төсвийн тухай хууль

²³ Алтансүх Ж, “Монгол Улсын Үндсэн хууль ба шүүхийн эдийн засгийн баталгаа” Хууль дээдлэх ёс сэтгүүл 2017, №2, 154 дэх тал

баримтлалын 1.1.2.-т “Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхолд монголын ард түмэн, соёл иргэншил оршин тогтнох, Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, **нутаг дэвсгэр**, хил хязгаарын халдашгүй байдал болон бүрэн бүтэн байдал, үндэсний эв нэгдэл, үндсэн хуульт байгууллын аюулгүй байдал, эдийн засгийн бие даасан байдал, экологийн тэнцвэрт хөгжил багтана.”; 1.1.3.-т “Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нэгдмэл байдлыг хамгаалан бататгах нь үндэсний аюулгүй байдлыг хангах анхдагч нөхцөл мөн.”; 1.1.4.-т “Хүний эрх, эрх чөлөө, хууль дээдлэх зарчим, парламентын засаглалд суурилсан, **нийгмийн тогтвортой байдлыг хангасан** ардчилсан төрийн тогтолцоо нь үндэсний аюулгүй байдлыг хангах баталгаа мөн.”; 1.1.5.-д “Монгол Улсын **төр, нийгэм, иргэний аюулгүй байдал харилцан уялдаатай хангагдсанаар** Монгол Улсын үндэсний аюулгүй байдал баталгаажна.”; 3.3.1.6.-д “Хууль тогтоох, гүйцэтгэх болон шүүх эрх мэдлийн байгууллагын эрх мэдлийн хяналт-тэнцлийг хангана.” гэж тодорхойлсон байна.

Судлаачийн зүгээс шүүхийг тойргийн зарчмаар байгуулах зохицуулалтаас давж заалдах шатны шүүхийг тойргийн зарчмаар байгуулах зохицуулалтыг дэмжиж, харин анхан шатны шүүхийг тойргийн зарчмаар байгуулахад дараах асуудлыг анхаарах шаардлагатай гэж үзэж байна.

Нэгдүгээрт, Монгол Улсын Үндсэн хуулийн Хоёрдугаар зүйлийн 2-т “Монгол Улсын нутаг дэвсгэр зөвхөн засаг захиргааны нэгжид хуваагдана.”; Арван зургадугаар зүйлийн 14/-т “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, ..., хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах, уучлал хүсэх эрхтэй ...”; Арван есдүгээр зүйлийн 1.-д “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.”; Тавин долдугаар зүйлийн 1.-д “Монгол Улсын нутаг дэвсгэр засаг захиргааны хувьд аймаг, нийслэлд, аймаг нь суманд, сум нь багт, нийслэл нь дүүрэгт, дүүрэг нь хороонд хуваагдана.”; Тавин наймдугаар зүйлийн 1.-д “Аймаг, нийслэл, сум, дүүрэг бол хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг, өөрийн удирдлага бүхий засаг захиргаа, нутаг дэвсгэр, эдийн засаг, нийгмийн цогцолбор мөн” гэж тодорхойлсон.

Улмаар Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.-д “Монгол Улсын нутаг дэвсгэр засаг захиргааны хувьд аймаг, нийслэлд, аймаг нь суманд, сум нь багт, нийслэл нь дүүрэгт, дүүрэг нь хороонд хуваагдана.”; 3.2.-т “Аймаг, нийслэл, сум, дүүрэг нь хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг, өөрийн удирдлага бүхий засаг захиргаа, нутаг дэвсгэр, эдийн засаг, нийгмийн цогцолбор мөн.” 7 дугаар зүйлийн 7.1. дэх хэсэгт Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын тогтолцоо нь дараахь бүтэцтэй байна: 7.1.1.-д аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал;

... 7.1.4.-т “аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга.”, 8 дугаар зүйлийн 8.1. дэх хэсэгт “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах үндсэн дээр нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие даан зохион байгуулж үйл ажиллагаандаа ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх зарчим баримтална.”, 26 дугаар зүйлийн 26.1. дэх хэсэгт “Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга нь харьяалах нутаг дэвсгэртээ төрийн удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий засаг төрийн төлөөлөгч мөн.” гэж заажээ.

Хуулийн дээрх зохицуулалтын агуулгаас үзвэл, Монгол Улсын нутаг дэвсгэр зөвхөн засаг захиргааны нэгжид хуваагдах бөгөөд тухайн нэгжийн удирдлага нь нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах үндсэн дээр хэрэгжиж байна.

Өөрөөр хэлбэл, төрийн эрх мэдэл хуваарилах зарчмын үндсэн дээр байгуулагдсан төрийн захиргааны төв болон орон нутгийн захиргааны байгууллагууд засаг захиргааны нэгж бүрт байрлаж, төрийн үйлчилгээг иргэдэд хүргэж байна.

Харин шүүх эрх мэдлийн тухайд, иргэн, хуулийн этгээдэд шууд хүрч үйлчилж буй анхан шатны шүүхүүдэд аймаг, нийслэл, сум буюу сум дундын, дүүргийн шүүхүүд хамаарч, эрх мэдлийн хяналт тэнцлийг хадгалж байна. Угаас тухайн нутаг дэвсгэрт бусад төрийн байгууллагуудтай зэрэгцэн шүүх оршиж байх нь л эрх мэдлийн тэнцлийг хангахад чухал асуудал билээ.

Иймд манай орны нутаг дэвсгэрийн онцлог, түүний зохион байгуулалт, хүн амын суурьшил, төрийн үйлчилгээг хүргэж буй засаг захиргааны нэгжийн зохион байгуулалтын бүтцийг дагуулан шүүх эрх мэдлийг хэрэгжүүлж буй анхан шатны шүүхийн тогтолцоо орших нь иргэдийн хувьд ойлгомжтой, төрийн үйлчилгээг хүргэхэд дөхөмтэй гэж үзэхээр байна.

Хоёрдугаарт, анхан шатны шүүхийг тойргийн зарчмаар байгуулахад өмнөх туршлагыг анхаарах, тухайн үед гарч байсан хүндрэл бэрхшээл одоо ч арилаагүй байна. Тодруулбал,

Судлаач Ж.Бариаширсүрэн нарын бичсэн “Шүүхийн тогтолцоог өөрчлөх бодлогын шийдвэрийн хэрэгжилт” судалгаанд дурдсанаар²⁴

Тохиолдол 1. /Иргэн/ Эрүүгийн хэргийн гэрчээр шүүх, цагдаад дуудагдаад жил орчим болж байна. Өнгөрсөн хугацаанд олон улаа дуудагдаа, их хэцүү. Анх шүүхэд дуудагдсанахаа дараа л Хархорины шүүхэд харьяалагдаж байгаагаа мэдсэн. Өмнө нь Зуунмодод очдог байсан нь илүү амар байсан. Эндээс 10.000 төгрөгөөр хот хооронд унаанд суугаад хот ордог, хотоос 2000 төгрөгөөр аймаг ордог. Аймаг орох шаардлага хүн бүхэнд байгаа. Очоод ажлаа бүтээхээс гадна амьтан ах дүүтэйгээ уулзах, буцахдаа хотоос хэрэгтэй зүйлээ худалдаж авах гээд

²⁴ ХЗҮХ “Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх үнэлгээний тайлан” УБ, 2018, 17-18 дах тал дам ишлэв.

хэд хэдэн ажил амжуулаад ирдэг байсан бол одоо Өвөрхангайд хүн танихгүй, очих айлгүй болохоор гудамжинд суугаад л шүүгч, цагдаа нь хэзээ дуудахыг хүлээгээд суух нь үнэхээр хүнд байна. Хөдөөгийн бид мөнгө төгрөг муутай. Танилгүй газар чинь аяга цай хүртэл мөнгөөр авна. Хоол, буудал гэвэл бүр ч барахгүй. Хоолны зардлаас гадна замын зардал их хүндрэлтэй, бөөн ажил, нэг талдаа 20 гаруй мянга болно ..." гэж;

Тохиолдол 2. /Прокурор/ Миний хувьд хуучин тогтолцоо нь илүү давуу талтай гэж үзэж байгаа. Манай прокурорын хувьд бол Төв аймгийн 4 сум нэмээд орон тооны хувьд нэмсэн боловч зардал нэмж тусгаагүй. Гэтэл ачаалал илт нэмэгдсэн, ачааллаа дагаад зардал ч нэмэгдсэн. Иргэдийн хувьд хүндрэлтэй асуудал байгаа. Давж заалдах шатны шүүх Дарханд байрлах болсноор амьдралын боломж хэцүү иргэд бол давж заалдахгүй хаях асуудал байгаа. Энэ бол амьдралд гарцаагүй байна ..." гэж;

Тохиолдол 3 /Прокурор/ Манай ачаалал бол бараг тал хувиар нэмэгдсэн байгаа. Орон тооны хувьд нэгээр л нэмсэн. Засаг захиргааны харьяалалтай холбоотой асуудал гардаг. Тухайлбал, төв аймгийн нэг сумын цагдаа байна гэж бодоход манай аймгийнх байсан бол бид нар тухайн цагдаагийнхаа ажлын алдаа дутагдлын талаар шууд удирдлагад нь мэдэгдээд, эсхүл зөвлөлдөөд, дэмжлэг аваад явах боломжтой бол Зуунмодод байгаа удирдлагатай бол ийм байдлаар хамтарч ажиллах боломжгүй, албан бичиг явуулдаг, хугацаа алддаг" гэх тайлбарууд гаргаж байжээ.

Цаашид Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2. дахь хэсэгт "Анхан шатны шүүхийг тойргийн зарчмаар байгуулж болно." гэж зааснаар засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хэд хэдэн нэгжийг харьяалуулан анхан шатны шүүхийг тойргийн зарчмаар байгуулсан тохиолдолд иргэн, хуулийн этгээд шүүхэд хандах, шүүхээр үйлчлүүлэхэд хүндрэлтэй нөхцөл үүсгэж болзошгүй байна.

Шүүхийг тойргийн зарчмаар байгуулахтай холбоотой асуудлаар, *Нээлттэй нийгэм форум байгууллагаас хийсэн "Шүүхийн тогтолцоо, тойргийн болон дагнасан шүүх" сэдэвт судалгаанд*²⁵ " ... 1. Баян-Өлгий, Ховд, Увс, Говь-Алтайг нэг тойрог болгох бөгөөд шүүхийн байрших газар нь Ховд аймаг. 2020 оны байдлаар дээрх дөрвөн аймгийн шүүхийн шийдвэрлэсэн хэргийн тоо нийлээд 156 байна. Тус шүүхийг гурван шүүгчийн бүрэлдэхүүнтэй байгуулна. Ингэснээр одоо ажиллаж байгаа 6.2 шүүгчийн орон тоо, батлагдсан орон тооноос есөн шүүгчийн орон тоо хасагдана ... 3. Завхан, Архангай, Баянхонгор, Өвөрхангайг нэг тойрог болгох бөгөөд шүүхийн байрших газар нь Архангай аймаг. 2020 оны байдлаар дээрх дөрвөн аймгийн шүүхийн шийдвэрлэсэн хэргийн тоо нийлээд 101 байна. Тус шүүхийг гурван шүүгчийн бүрэлдэхүүнтэй байгуулна. Ингэснээр одоо ажиллаж байгаа 7.6 шүүгчийн орон тоо, батлагдсан орон тооноос есөн шүүгчийн орон тоо хасагдана ... 11.

²⁵ Нээлттэй нийгэм форум, "Шүүхийн тогтолцоо, тойргийн болон дагнасан шүүх" УБ, 2021, 101-102, 112 дахь тал

ЗХАШШ-ийг тойргийн зарчмаар байгуулах шаардлагатай бөгөөд улсын хэмжээнд зургаан шүүх байхад тохиромжтой ... ЗХАШШ-ийг дээрх байдлаар тойргийн зарчмаар байгуулснаар улсын хэмжээнд захиргааны хэргийн нийт 34 шүүгч байхад хангалттай байх ба **одоо ажиллаж байгаа 71 шүүгчээс 37 шүүгчийн орон тоо сулрах боломжтой. Эдгээр орон тоог ажлын ачаалал өндөртэй бусад шүүхэд шилжүүлэх боломж бүрдэнэ ...**” гэж үзжээ.

Хэрэв дээрх судалгаанд дурдсан байдлаар анхан шатны шүүхийг тойргийн зарчмаар байгуулбал, нэг талаар шүүхийн төсөв багасаж, ачаалал тэнцвэржиж буй мэт боловч манай орон шиг өргөн уудам нутагтай, засаг захиргааны нэгжээ даган төрийн үйлчилгээ төвлөрсөн өнөө үед алслагдсан сум, орон нутагт амьдарч буй иргэд хэд хэдэн аймгийг нэгтгэсэн шүүхээр үйлчлүүлэхэд санхүүгийн болоод цаг хугацааны хувьд хохиролтой юм. Нөгөөтэйгүүр, шүүхийн ачаалал жил ирэх тусам нэмэгдэж буй өнөө үед шүүхийг тойрог болгох хэлбэрээр шүүгчийн орон тоог шилжүүлэх, шүүхийн зардлыг багасгах бус ачаалал ихтэй шүүхүүдэд шүүгч нэмж томилох, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх нь цаашид шүүх эрх мэдлийн бие даасан байдал эергээр нөлөөлөх боломжтой.

Гуравдугаарт, анхан шатны шүүхийг тойргийн зарчмаар байгуулах нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хүндрэл үүсгэх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаа удаашрах нөхцөлийг бүрдүүлэхээр байна. Тодруулбал, улсын хэмжээнд эрүүгийн хэргийн анхан шатны 38, иргэний хэргийн анхан шатны 38, захиргааны хэргийн анхан шатны 22 шүүх үйл ажиллагаа явуулж байна.

Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1. дэх хэсэг Шүүхийн захиргааны үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтална: 69.1.3.-т “мэргэшсэн, тогтвортой байх”, 69.1.4.-т “шүүхийн үйлчилгээ шуурхай, хүртээмжтэй байх” гэж заасан.

Одоогийн шүүхийн тогтолцоонд 2021 оны 7 дугаар сард шүүх хуралдаан хойшлолт дараах үзүүлэлттэй байна. “...ирээний хэргийн шүүх 2796 шүүх хуралдаан товлон зарласнаас 92.3 хувь нь хэргийн оролцогчоос шалтгаалан хойшилсон байна. Хэргийн оролцогч, тэдгээрийн итгэмжлэгдсэн төлөөлөгч, өмгөөлөгчөөс нотлох баримт гаргуулах хүсэлт гаргасан нь хамгийн өндөр үзүүлэлттэй байх жишээтэй. Эрүүгийн хэргийн хувьд мөн л 92.7 хувь нь хэргийн оролцогчоос шалтгаалж шүүх хуралдаан хойшилсон ... ирээний хэргийн анхан шатны шүүхүүдийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд байгаа 6486 хэргийн 23.2 хувь, Захиргааны хэргийн анхан шатны шүүхүүдийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд байгаа 878 хэргийн 35.8 хувь нь хугацаа хэтрэлтэй ...” байна.²⁶

Удаа дараа шүүх хуралдааныг хойшлуулж, хэрэг хянан шийдвэрлэх хуульд заасан хугацаа хэтэрч байгаа үндэслэл, хугацааг улсын хэмжээнд 2019 оны 5 дугаар сарын 1-ний байдлаар судалж үзвэл нийт ажиллагаанд байгаа ирээний хэргийн 47% нь 1-60 хоног, 20% нь 61-120

²⁶ https://judcouncil.mn/site/news_full/11399 , сүүлд үзсэн 2021.12.15

хоног, 6% нь 121-150 хоног, 27% нь 151-ээс дээш хоногоор буюу иргэний хэрэг үүсгэснээс хойш 240 хоног /8 сар/ өнгөрсөн байна. /Энэ хугацаанд хэрэг хянан шийдвэрлэх 90 хоногийн хугацаа ороогүй болно.²⁷

Иргэний хэргийн шүүхийн тухайд, тойргийн зарчмаар байгуулбал хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой дараах хүндрэл үүсэж болзошгүй байна. Иргэний хэргийн шүүх нь зохигч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч нараас өөрийн шаардлага ба татгалзлын үндэс болж байгаа байдлын талаарх нотлох баримтаа өөрөө гаргаж өгөх, цуглуулахыг шаарддаг. Тиймээс хэд хэдэн аймгийн газар нутгийг нэгтгэн тойргийн зарчмаар байгуулсан тохиолдолд зохигчдыг шүүхэд ирүүлэх, нотлох баримт гаргуулах болон шүүхийн журмаар өөр аймаг сумаас нотлох баримт гаргуулах захирамж, албан бичиг явуулахад баталгаат шуудангаар багадаа 10 хоногт, иргэн хуулийн этгээдээс гэрчийн мэдүүлэг авахаар дуудахад мэдэгдэх хуудас хүргүүлэх хугацаа, ирүүлсэн гэрчийн замын зардал, хоол, байрны мөнгө, өөр аймаг, суманд үзлэг хийхэд шатахуун, томилолтын зардал, шүүх хуралдаанд хэргийн оролцогч нарыг оролцуулахад тэдгээрийн шүүхэд ирэхэд боломжтой хугацаа, шүүх хуралдаан хойшилсон тохиолдол мөн дараагийн шүүх хуралдааны хугацаа зэрэг шүүхийн ажиллагаа удаашрахаар байна. Улмаар шүүхийн ажиллагаатай холбоотой хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч нар зардал, цаг хугацааны алдагдал хүлээхээр байна.

Захиргааны хэргийн шүүхийн тухайд, эрүү, иргэний хэргийн шүүхээс нотлох баримт цуглуулах үүргийг өөрөө гүйцэтгэдэг бөгөөд ихэнх нотлох баримтыг шүүхийн ажиллагаагаар цуглуулдаг онцлогтой. Хэрэв захиргааны хэргийн шүүх тойргийн зарчмаар ажиллах тохиолдолд өөр аймаг, сумдад томилолтоор ажиллаж нотлох баримт цуглуулах, гэрчийн мэдүүлэг авах, газрын үзлэг, хэмжилт хийх зэрэг шүүхийн оролцоотой хийгдэх ажиллагаа байнга гарахаар байна.

Жишээ нь одоогийн нөхцөлийн тухайд, Архангай аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн хувьд л гэхэд, захиргааны хэрэг, маргааны онцлог, орон нутгийн онцлогоос шалтгаалж тус аймгийн 19 сум, багуудад очиж үзлэг, хэмжилт хийх, бичмэл нотлох баримт цуглуулах, даалгавар гүйцэтгэх, гэрч асуух зэрэг нотлох баримт цуглуулах ажиллагаа хийх шаардлага байнга гардаг. Архангай аймгийн төвөөс хамгийн холын захын сумууд болох Цэцэрлэг сум 230 км, Жаргалант сум 227 км, Хангай сум 230 км зайтай бөгөөд ихэнх сум засмал замд холбогдоогүй байна.

Хэрэв захиргааны хэргийн анхан шатны шүүхийг тойргийн зарчмаар байгуулж өөр ойролцоох аймагтай нэгтгэсэн тохиолдолд жишээ нь Архангай аймгийн төвөөс Өвөрхангай аймгийн төв хүртэл 256 км, Завхан аймгийн төв 546 км, Баянхонгор аймгийн төв 282 километрийн зайтай байна. Энэ нь зөвхөн аймгийн төвийн зай бөгөөд тухайн аймгуудын захын сумдын километрийн зайг гаргавал үүнээс хэд дахин хол /Өвөрхангай

²⁷ <http://www.supremecourt.mn/act/view/273> , сүүлд үзсэн 2021.12.15

аймгийн төвөөс Архангай аймгийн Цахир сум хүртэл 490км, Завхан аймгийн Тэс сум хүртэл 1158км, Баянхонгор аймгийн Баянлиг сум хүртэл 480км/ зайтай байхаар байна.

Энэ тохиолдолд өөр аймгийн төвөөс нөгөө аймгийн сумдад шүүхээс тодорхой ажиллагаа хийж ажиллахад наад захын зардлаас авахуулаад шүүгч, шүүхийн захиргааны ажилтны ажиллах нөхцөл, аюулгүй байдалд ч эрсдэлтэй нөхцөлийг үүсгэж болзошгүй юм. Улсын төсөвт ч нэлээдгүй хэмжээний зардал гарах нь тодорхой байна.

Нөгөөтээгүүр захиргааны хэргийн оролцогч нэг тал нь захиргааны байгууллага, албан тушаалтан байдаг, тэдгээрийг одоогийн тогтолцоонд л гэхэд газар нутгийн онцлогоос шалтгаалан шүүхэд дуудан ирүүлэх, нэхэмжлэлийн хувь гардуулах, хэргийн материалтай танилцуулах, шүүх хуралдаанд оролцуулахад хүндрэл, бэрхшээл үүсдэг. Гэтэл анхан шатны шүүхийг тойргийн зарчмаар байгуулбал хариуцагчийг шүүхэд тухай бүр дуудаж ирүүлэх, тэдгээрийг шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг, шүүх хуралдаан болон бусад ажиллагаанд оролцуулахад хариуцагчийн ажил, үүргийн хуваарь, газар нутгийн онцлогоос шалтгаалан хүндрэл үүсэх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түргэн, шуурхай явуулахад саад учрахаар байна. Дээрх нөхцөлөөс үзвэл захиргааны хэргийн анхан шатны шүүх тойргийн зарчмаар ажиллавал хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахад хүндрэл үүсэх нь зайлшгүй байна.

Эрүүгийн хэргийн шүүхийн тухайд, тойргийн зарчмаар байгуулбал шүүгдэгч, хохирогчийг шүүхэд дуудан ирүүлэх, шүүх хуралдаанд прокурор оролцох, шүүгдэгчийг цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээ авах, тэдгээрийг шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг болон шүүх хуралдаанд оролцуулахад мөн л хүндрэл үүсэж болзошгүй байна. Мөн уг өөрчлөлтийн улмаас цагдаа, прокурор, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын байршил, бүтэц, зохион байгуулалт, орон тоо өөрчлөгдөх, түүнтэй холбоотой төсвийн зардал нэмэгдэх үр дагавар үүсэхийг анхаарах шаардлагатай.

Түүнчлэн анхан шатны шүүхийг тойргийн зарчмаар байгуулснаар одоо ажиллаж байгаа шүүгч, шүүхийн захиргааны ажилтны нийгэм, эдийн засгийн асуудал /орон байр, тэдгээрийн гэр бүлийн гишүүдийн хөдөлмөрлөх, сурч боловсрох эрх г.м/ хөндөгдөхөөр байна.

Харин давж заалдах шатны шүүхийг тойргийн зарчмаар байгуулах бүрэн боломжтой байна. Учир нь давж заалдах шатны шүүх нь анхан шатны шүүхтэй харьцуулахад нотлох баримт цуглуулахгүй, хэрэгт цугласан нотлох баримтын хүрээнд, хэргийн оролцогчийн гомдлын үндэслэлд дүгнэлт хийж хэрэг маргааныг давж заалдах журмаар хянадаг бөгөөд шүүх хуралдаанд хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчийг заавал оролцуулах шаардлагагүй байдаг. Давж заалдах шатны шүүх бол иргэн, хуулийн этгээдийн гомдлыг хянан үзэх, анхан шатны шүүхийн шийдвэрт алдаа гарсан бол залруулах эрх бүхий шүүх билээ.

IV. ДҮГНЭЛТ, САНАЛ

Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Монгол Улсын Ардын багш, гавьяат хуульч, хууль зүйн доктор, профессор Бяраагийн Чимид багш нэгэнтээ хэлсэнчлэн, Шүүх эрх мэдэл гэдэг бол нийгэмд байнга үүсдэг маргаан, зөрчилдөөнтэй асуудлыг шударгаар хянан үзэж, хуулийг мэргэжлийн үндсэн дээр зөв тайлбарлаж хэрэглэн эрх зүйн шийдэл гаргах замаар хүний эрх, эрх чөлөө, хуулийн этгээдийн ашиг сонирхол, үндсэн хуульт байгууллын ардчилсан үндсийг хамгаалах үйл ажиллагаа билээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр шүүх эрх мэдлийн хүрээнд зарчмын шинжтэй хэд хэдэн өөрчлөлт орсон. Тухайлбал, шүүгчийг сонгон шалгаруулах, шүүгчийн сахилга, хариуцлага, Ерөнхий зөвлөлийн чиг үүрэг, бүтэц бүрэлдэхүүн, Шүүхийн сахилгын хороо, нийт шүүгчдийн чуулган, УДШ-ийн эрх хэмжээ зэрэг шинэ зохицуулалт хэрэгжиж эхлээд удаагүй байна. Шүүх эрх мэдэлд хамаарах дээрх институтын зохицуулалт хэр үр нөлөөтэй, оновчтой болсон нь ирэх жилүүдэд тодорхой болох биз ээ.

Судлаачийн зүгээс шүүх эрх мэдэлд хамаарах дээрх шинэлэг зохицуулалтаас Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт болон Монгол Улсын Шүүхийн тухай хуульд туссан бөгөөд одоогоор хараахан хэрэгжээгүй боловч онцгой ач холбогдол бүхий “шүүхийг тойргийн зарчмаар байгуулах” зохицуулалтыг судлах нь шинэлэг гэж үзлээ. Ялангуяа анхан шатны шүүхийг тойргийн зарчмаар байгуулах нь оновчтой эсэх асуудлыг хөндөж, өнөөгийн шүүхийн практик болон иргэний эрх, төрийн үйлчилгээтэй уялдуулахыг зорьсон болно.

Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 1.-д “Шүүхийн үндсэн тогтолцоо Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхээс бүрдэх бөгөөд **шүүхийг тойргийн зарчмаар байгуулж болно**. Шүүхийг эрүү, иргэн, захиргааны зэрэг шүүн таслах ажлын төрлөөр дагнан байгуулж болно. Дагнасан шүүхийн үйл ажиллагаа, шийдвэр нь Улсын дээд шүүхийн хяналтаас гадуур байж үл болно.” гэж зааснаас үзвэл Монгол Улсын шүүхийн тогтолцоо нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тогтолцоотой /хамааралтай/ зэрэгцэн оршиж буйг харуулж байна.

Нөгөөтээгүүр, дээрх засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тогтолцоог даган төрийн байгууллагууд төвлөрч, төрийн үйлчилгээг иргэдэд хүргэж байна.

Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4. дэх хэсэгт “Анхан болон давж заалдах шатны шүүхийг тойргийн зарчмаар байгуулж болно. Шүүхийг тойргийн зарчмаар байгуулахад энэ хуулийн 14.3-т заасныг харгалзахаас гадна шүүхэд хандах иргэний эрхийн баталгааг хангах, шүүхийн үйлчилгээг иргэнд хүртээмжтэй хүргэхэд чиглэсэн байна.”, 14.3. дахь хэсэгт “Шүүхийг байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах, байршлыг тогтооход түүний харьяалан ажиллах нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн амын тоо, шийдвэрлэсэн хэрэг, маргааны

төрөл, тоог харгалзан үзнэ.” гэж заажээ.

Шүүхийг тойргийн зарчмаар байгуулах нь шинэлэг бөгөөд зарим талаараа оновчтой зохицуулалт байхыг үгүйсгэхгүй. Гэхдээ төрийн үйл ажиллагаа, зохион байгуулалтын цөмд ард иргэд, тэдгээрийн хүсэл зоригийг тавих нь оновчтой билээ.

Хууль тогтоогчийн зүгээс шүүхийг тойргийн зарчмаар байгуулснаар шүүхийн ачаалал тэнцвэржих, шүүхийн зардал багасах, шүүхийн үйлчилгээ иргэдэд ойртох давуу талтай гэж тайлбарлажээ.

Гэвч энэ зохицуулалт нь бодит байдалд шүүхээр үйлчлүүлж буй иргэн, хуулийн этгээдэд чирэгдэл үүсгэх, шүүхийн үйлчилгээг иргэдэд ойртуулах бус холдуулах, шүүхээр үйлчлүүлж буй иргэн, хуулийн этгээдэд зардал, цаг хугацааны хохирол үүсгэж болзошгүй байна.

Түүнчлэн Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1.3.-т “мэргэшсэн, тогтвортой байх”, 69.1.4.-т “шүүхийн үйлчилгээ шуурхай, хүртээмжтэй байх” гэж шүүхийн захиргааны үйл ажиллагаанд баримтлах зарчмыг тусгасан байдаг.

Гэтэл анхан шатны шүүхийг тойргийн зарчмаар байгуулах нь илтгэлийн өмнө хэсэгт дурдсанчлан шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахад хүндрэл үүсгэх, үүнээс үүдэн шүүх иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, тэдгээрийн зөрчигдсөн эрхийг сэргээх чиг үүргээ түргэн, шуурхай хэрэгжүүлэх боломжгүй нөхцөл үүсгэхээр байна.

Иймд анхан шатны шүүхийг тойргийн зарчмаар байгуулах тохиолдолд Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсэгт заасан шалгуур үзүүлэлтэд “шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахад хүндрэл үүсэх эсэх” асуудлыг харгалзан үзэх зохицуулалтыг нэмж тусгах шаардлагатай гэж үзлээ.

Эцэст нь тэмдэглэхэд, шүүх эрх мэдлийн байгууллагын тогтолцоо, бүтэц зохион байгуулалтын шинэчлэлийн үр дүн нь шүүхийн үйлчилгээ иргэдэд ойртсон байдал, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа түргэн шуурхай явагдаж буй эсэхээр хэмжигдэх билээ.

V.Ашигласан материал:

V.I. Хууль тогтоомжийн хүрээнд:

1. Монгол Улсын Үндсэн хууль 1992 он
2. Шүүхийн тухай хууль 2012 он
3. Шүүх байгуулах тухай хууль 2013 он
4. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль 2007 он
5. Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль
6. Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хууль
7. Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хууль
8. Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль
9. Монгол Улсын Шүүхийн тухай хууль 2021 он
10. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, 2010 он

V.II. Ном, судалгааны бүтээл:

1. Г.Совд нар “Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар” УБ., 2000 он
2. Б.Чимид “Үндсэн хуулийн үзэл баримтлал” УБ., 2004 он
3. Б.Чимид “Үндсэн хуулийн мэдлэг” УБ., 2008 он
4. Ж.Бариаширсүрэн нар, “Шүүхийн тогтолцоог өөрчлөх бодлогын шийдвэрийн хэрэгжилт” УБ, 2015
5. ХЗҮХ “Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх үнэлгээний тайлан” УБ, 2018 он
6. ННФ “Шүүхийн тогтолцоо, тойргийн болон дагнасан шүүх” УБ., 2021 он
7. Монгол Улсын Шүүхийн тайлан 2018
8. Монгол Улсын Шүүхийн тайлан 2019
9. Монгол Улсын Шүүхийн тайлан 2020
10. ХЗҮХ “Үндсэн хуулийн эхийг баригч-Б.Чимид” ОУ-ын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл УБ, 2020 он



Батсайханы ӨЛЗИЙСАЙХАН

Хууль зүйн доктор, профессор
(Тусгай байр)

ШҮҮХ ЭРХ МЭДЛИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

ХУРААНГУЙ. Монгол Улс 1992 онд батлагдсан Үндсэн хуульдаа “... хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгмийг цогцлуулан хөгжүүлэх” явдлыг Монголын ард түмний эрхэм зорилго, туйлын хүслэн болгон тунхаглаад, төрийн эрх мэдлийг хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдэлд гэж гурав хуваарилж, тэнцвэрт байдлыг хадгалан харилцахаар суурь хэм хэмжээг бэхжүүлж өгчээ. Улмаар Үндсэн хуульдаа улс төр, нийгэм, эдийн засгийн хөгжил, хувьслын нөлөөгөөр 2000, 2019 онд нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.

Үндсэн хуульд оруулсан 2019 оны нэмэлт, өөрчлөлтөөр 2012 оноос 4 хуулиар зохицуулж ирсэн харилцааг Шүүхийн тухай хууль (Шинэчилсэн найруулга)-иар нэгтгэн зохицуулахаар баталжээ. Энэхүү хуульд шүүх эрх мэдэл хөгжлийн бодлоготой байна гэж заасан нь Монгол Улсын урт хугацааны хөгжлийн баримт бичигт нийцүүлэн шүүх эрх мэдлийн шинэтгэлийг эрчимжүүлэх, төгөлдөржүүлэх хэрэгцээ шаардлага буйг хуульчилсан явдал юм.

Энэхүү илтгэлийн хүрээнд Шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлогыг боловсруулах үйл явц, анхаарал хандуулах асуудал, тус бодлогын баримт бичигт заавал тусгах зарим зүйлийн талаар байр сууриа илэрхийлэхийг зорилго.

Уг илтгэлийг удиртгал, үндсэн хэсэг, дүгнэлт, эх сурвалжийн жагсаалт гэсэн бүтэцтэйгээр бичсэн болно.

Түлхүүр үг. хөгжил, хөгжлийн бодлого, шүүх эрх мэдэл, шүүх.

УДИРТГАЛ

Монгол Улс 1992 оны Үндсэн хуулийг баталж, мөрдсөнөөр анх удаа “иргэн-төр”-ийн харилцан хамаарал бүхий төрийн эрх мэдэл хуваарилах зарчмыг хэрэгжүүлж хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн суурь зарчмыг бэхжүүлэн дэлхий нийтийн жам ёсны хандлагаар ардчилал,

зах зээлийн шинэ нөхцөлд зохицон хөгжих нийгмийн амьдралын бүхий л хүчин зүйлсийг өөрчлөн шинэчлэх үндсийг бүрдүүлсэн билээ. “Үндсэн хууль”-ийг баталж мөрдсөнөөр нийгмийн бүхий л салбарт өөрчлөлт шинэчлэлт¹ хийхээр Үндсэн хуулийн хавсралт хууль (БНМАУ-ын Үндсэн хуулиас Монгол Улсын Үндсэн хуулийг бүрнээ дагаж мөрдөхөд шилжих тухай)-ийн Гуравдугаар зүйлд Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх /шүүх, прокурорын байгууллагыг шинэчлэн байгуулах/, тухайн байгууллагын тогтолцоог шинэчлэх ажлыг 1993 онд багтаан хийж гүйцэтгэхээр хуульчилсан. Ийнхүү Монгол Улсын Эрх зүйн шинэтгэлийн үйл явцыг УБХ-ын 1992 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Төлөвлөгөө батлах тухай (Үндсэн хуулийг бүрнээ дагаж мөрдөх ажлыг зохион байгуулах)”-д Монгол Улсын Үдсэн хуульд заасан нэн тэргүүнд шаардлагатай хуулиудыг батлан гаргах тухай жагсаалтын 6/Монгол Улсын шүүхийн байгууламжийн тухай хууль, 7/Монгол Улсын шүүхийн ерөнхий зөвлөлийн тухай хууль, 9/Монгол Улсын прокурорын байгууллагын тухай хуулийг боловсруулан батлахаар зааж, нэр дурдсан зарим хуулийг 1993 онд баталжээ. Тухайн салбарын хуулийг шинэчлэн баталснаар хууль тогтоох байгууллагаас зарим арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна. Тухайлбал, УИХ-ын 1993 оны “Шүүхийг өөрчлөн байгуулсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 60 дугаар тогтоол, УИХ-ын 1996 оны “Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал батлах тухай” 26 дугаар тогтоол, УИХ-ын 1998 оны “Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр”², “Хөтөлбөр, үндсэн чиглэл, төлөвлөгөө батлах тухай” 18 дугаар тогтоол, УИХ-ын 2000 оны “Монгол Улсын шүүх эрх мэдлийн стратеги төлөвлөгөө батлах тухай” 39 дүгээр тогтоол, УИХ-ын 2003 оны “Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр батлах тухай” 41 дүгээр тогтоол, УИХ-ын 2008 оны “Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогыг батлах тухай” 12 дугаар тогтоол, УИХ-ын 2016 оны «Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030»³ 19 дүгээр тогтоол, УИХ-ын 2016 оны “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай” 51 дүгээр тогтоол, УИХ-ын 2020 оны Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай “Алсын хараа-2050» 52 дугаар тогтоолоор тус тус баталсан бодлогын баримт бичигт Монгол Улсын эрх зүйн шинэтгэл, түүний үзэл баримтлал, чиглэлийг тусгаж иржээ. Түүнчлэн НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 2015 оны 70 дугаар чуулганаар тогтвортой хөгжлийн 17 зорилго, 169 зорилт бүхий “Тогтвортой хөгжлийн зорилго”-ыг баталж, 2016 оны 1 дүгээр сарын

¹ Өөрчлөлт шинэчлэлт (хоришоо үг) Аливаа зүйлийг улам сайжруулахын тулд хийж буй өөрчлөлтийн нарийвчлан бодож боловсруулсан арга ухаан. Баярсайхан,Б. (2011). Монгол хэлний тайлбар толь. Уб., 910 дахь тал.

² Үндсэн хууль 1992 онд батлагдан, нийгмийн харилцааг зохицуулж байсан хууль тогтоомжийг бүрэн шинэчлэх ажил эхлээд, богино хугацааны бодлогын баримт бичгийн биелэлтийг дүгнэх хугацаатай адилтган авч үзвэл залгамж чанар бүхий 2 баримт бичгийн хэрэгжилтийг үнэлэхүйц хугацаа (6 жил)-ны дараа Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийг батлан хэрэгжүүлсэн байна.

³ Энэ тогтоолыг Улсын Их Хурлын 2020 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолоор хүчингүй болсонд тооцсон.

1-нээс албан ёсоор дэлхий нийтээр хэрэгжиж эхэлсэн. Энэхүү 17 зорилго нь манай улсын нийгэм, эдийн засаг, эрх зүйн бүхий л салбарын хөгжлийн баримт бичигт хэлбэржиж буйг дурдахын сацуу Шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлого боловсруулахад зайлшгүй судлах шаардлагатай баримт бичгийн эхний эрэмбэд хамаарах юм. Түүнчлэн Тогтвортой хөгжлийн 17 зорилго, эдгээрээс 5 дахь Жендэрийн эрх тэгш байдлыг хангах, 10 дахь Тэгш бус байдлыг бууруулах, 16 дахь Энхтайван шударга ёсыг цогцлоох зорилгод анхаарал хандуулах нь зүйтэй байна.

ШҮҮХ ЭРХ МЭДЛИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

Илтгэлийн үндсэн хэсгийн бичилтээс өмнө хөгжил, хөгжлийн бодлого, хөгжлийн баримт бичиг, хөгжлийн загварын талаарх товч ойлголтыг танилцуулъя.

Хөгжлийн баримт бичиг боловсруулахад тавигдах шаардлага хийгээд эрх зүйн үндэслэлд “Хөгжлийн” бодлого”⁵ гэсэн нэр томъёог Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль (2020)-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.1. “хөгжлийн бодлого” гэж улс, салбар, салбар хооронд болон бүс, орон нутгийн түвшинд, урт, дунд, богино хугацаанд хөгжлийн тодорхой асуудлаар ахиц дэвшилд хүрэхээр дэвшүүлсэн хэмжигдэхүйц зорилго, зорилт, тэдгээрийн суурь түвшин, хүрэх үр дүн, хэрэгжүүлэх үйл ажиллагаа, санхүүжилтийн эх үүсвэрээр баталгаажсан төсөв, хэрэгжилтийг хянах шалгуур үзүүлэлтийг тусгасан эрх бүхий этгээдээс баталсан баримт бичгийг, мөн хуулийн 5 дугаар зүйлд Хөгжлийн бодлого, төлөвлөлтөд баримтлах 15 зарчмыг хуульчилсан нь Монгол Улс хөгжлийн баримт бичиг боловсруулахад нэгдсэн шаардлага тавьж, баталж, хэрэгжилтэд хяналт тавих суурь хэм хэмжээг бэхжүүлсэнд оршино.

Хэдийгээр хөгжлийн баримт бичгийн боловсруулалтад тавигдах шаардлага, хугацаа, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх үйл явцыг хуульчилсан ч дэлхийн нийтийн хөгжлийн аль загварын үзэл баримтлалыг шингээсэн баримт бичиг боловсруулах эсэх нь одоо хэр нь тодорхойгүй байгаа талаар судлаачид бүтээлдээ дурдсан байна. Монгол Улсын хувьд

⁴ Хөгжил-матери ба ухамсар, тэдгээрийн түгээмэл шинжийн эргэлтгүй чиглэсэн, зүй ёсны өөрчлөлт. Чадраа, Б (ред). (2009). Монголын Үндэсний нэвтэрхий толь. Уб.,

Хөгжил (хөгжих үйлийн нэр) Давшил, дэвшил, цэцэглэл, бадрал: Нийгмийн хөгжлийн хууль (нийгмийн дэвшлийн зүй тогтол). Баярсайхан,Б. (2011). Монгол хэлний тайлбар толь. Уб., 1495 дахь тал. Цэвэл,Я. (2013). Монгол хэлний товч тайлбар толь. Уб., 967 дахь тал.

Хөгжил гэж Грекийн (аналитиксис) гэсэн үг. Энэ нь дэлгэрэх, задрах, дэвших гэсэн санааг заадаг. Аристотелийн бүтээлд дурдсанаар аливаа зүйл бүхэн мөн чанартай. Мөн чанарыг түүний хөгжил тодорхойлно. Даш-Ёндон,Б (2013). Монголын хөгжлийн философи (асуудал, аргачлал, ашиг тус). Уб., 12-13 дахь тал.

⁵ Хөгжлийн бодлого (англ. Development policy) - улс, салбар, салбар хооронд болон бүс, орон нутгийн түвшинд, урт, дунд, богино хугацаанд хөгжлийн тодорхой асуудлаар ахиц дэвшилд хүрэхээр дэвшүүлсэн хэмжигдэхүйц зорилго, зорилт, тэдгээрийн суурь түвшин, хүрэх үр дүн, хэрэгжүүлэх үйл ажиллагаа, санхүүжилтийн эх үүсвэрээр баталгаажсан төсөв, хэрэгжилтийг тусгасан эрх бүхий этгээдээс баталсан баримт бичиг. Нарангэрэл, С. (2021). Монгол Улсын хууль зүйн нэвтэрхий толь. Уб., 496 дахь тал.

нийгмийн хөгжлийн загвараа дагаж, аливаа бодлогын баримт бичгийг боловсруулан хэрэгжүүлэх нь зүйтэй юм. Харин нийгмийн хөгжлийн жишиг загвараас алийг давуу байдлаар, аль загварыг нь дагалдах байдлаар нутагшуулахыг оновчтой сонгох нь чухал. Иймд Азийн хөгжлийн загвар (Япон, Бүгд Найрамдах Солонгос, Тайван, Хонконг, Сингапур), Амьдралын америк зам (American way of life) загвар, Европын нийгмийн загвар (European social model) нь Англи-Саксон, Эх газрын, Газрын Дундад Тэнгисийн болон Умардын гэсэн 4 загварын нийтлэг нэршил юм. Манай улсын хувьд 1992 оны Үндсэн хуулиа батлахдаа Монгол Улс бүх нийтийн сайн сайхан нийгмийн хөгжлийн загвар буюу Европын нийгмийн хөгжлийн загварыг жишиг туршлага болгон хөгжихөөр эрх зүйн шинэтгэл хийсэн. Гэтэл Үндсэн хуулиа хэрэгжүүлж ирсэн 30 жилийн хугацаанд хүрэх хөгжлийн замаасаа багагүй хазайжээ⁶. Иймд манай улс Европын болон Азийн хөгжлийн загварын⁷ давуу талаас суралцан, нутагшуулах өөрийн орны хөгжлийн загварыг боловсруулах нь эрх зүйн шинэтгэлийн II дахь үйл явцтай зэрэгцэх нь дамжиггүй юм. Түүнчлэн дэлхийн эрх зүйн тогтолцоог бүрдүүлж буй 4 аймаг (Ром-Германы эрх зүй (эх газрын буюу иргэний эрх зүй), Англи-Америкийн эрх зүй (нийтлэг эрх зүй), Лалын эрх зүй, Заншлын эрх зүй (Африк)⁸) -аас манай эрх зүйн тогтолцоо Эх газрын буюу иргэний эрх зүйн аймагт хамаарч буйн тод илрэл бол 1992 оны Үндсэн хууль батлагдан хэрэгжиж ирсэн 30 жилд нийгмийн харилцааны 70 хувийг хэм хэмжээний акт (үлдсэн 30 хувь: жишиг-15 хувь, номлол-5 хувь, заншил-10 хувь)-аар зохицуулагдаж ирснээс харж болно. Тухайлбал, 2020 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар гаргасан Монгол Улсын хуулийн судалгаа: нийт хууль 764 үүнээс хэм хэмжээний акт 353 (46 хувь), хэм хэмжээний бус акт 411 (54 хувь)⁹ байжээ. Харин дараагийн урт, дунд, богино хугацааны нийгмийн хөгжлийн үйл явцыг даган өөрчлөгдөх эрх зүйн орчинд нийтлэг эрх зүйн аймгийн зөөлөн салхи сэвэлзэж хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангахад шүүхийн шийдвэр, практикт үндэслэн Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбарыг Улсын дээд шүүх бүрэн эрхийн¹⁰ хүрээнд гаргахаар хуульчилсныг Монгол Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч Д.Ганзориг: Шүүхийн тухай шинэ хуулийн дагуу хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах чиг үүрэг, арга зүй тодорхой боллоо. УДШ *нэгт*, хяналтын журмаар тодорхой хэрэг маргааныг хянан шийдвэрлэх замаар хууль хэрэглээний зөрүүтэй байдалд цэг тавих, *хоёрт*, шүүхийн шийдвэр, шүүхийн практикт тулгуурлан хууль тайлбарлах замаар хууль хэрэглээний нэгдмэл байдал тогтоох, улмаар эрх зүйн тодорхой байдлын зарчмыг хангах боломж бүрдэж байна¹¹ гэжээ. Энэ

⁶ Энхмандах, Б. Нийгмийн хөгжлийн загварын тухай. 2013. Уб., 10 дахь тал.

⁷ Мөн тэнд. 47 дахь тал.

⁸ Амарсанаа, Ж., Ариунболд, А., нар. (2019). Өрхийн эрх зүйн хөтөч Гарын авлага. Уб., 14 дэх тал.

⁹ Монгол Улсын хуулийн судалгаа (2020.12.31). Судлаачийн боловсруулсан эх сурвалж.

¹⁰ Шүүхийн тухай хууль (2021)-ийн 25 дугаар зүйлийн 25.8.4 дэх заалт.

¹¹ Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдөр зохион байгуулсан “Шүүх эрх мэдэл, хууль сахиулах байгууллагын алба хаагчдын үндэсний чуулган”-д хэлэлцүүлсэн

талаар “Монгол Улс дахь хувийн эрх зүйн шинэтгэлийн явц, тулгамдаж буй асуудал”¹² сэдэвт ОУЭШ-ний хурлын үеэр хэлэлцсэн илтгэлд дурдсан байна.

Манай улс Хөгжлийн баримт бичгийг урт (30 хүртэл жил), дунд (10 хүртэл жил), богино хугацааны гэсэн төрөлтэй¹³ байхаар хуульчилсан. Дунд хугацааны буюу 10 жилийн хугацаанд хэрэгжих хөгжлийн бодлогын баримт бичиг нь Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг “Алсын хараа-2050” хэрэгжүүлэхэд чиглэсэн зорилго, зорилт, санхүүгийн эх үүсвэрээр баталгаажсан үйл ажиллагаа бүхий, тоон болон чанарын шалгуур үзүүлэлтээр хэмжигдэх Хөгжлийн зорилтот хөтөлбөр¹⁴ байна гэжээ. Энэ хүрээнд Шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлого нь засаглалын зорилтот хөтөлбөр байх бөгөөд “Алсын хараа-2050”-ын ТАВ. ЗАСАГЛАЛ-ын зорилгыг хангахуйц дунд хугацааны хөгжлийн тодорхой асуудлаар ахиц дэвшилд хүрэхээр дэвшүүлсэн хэмжигдэхүйц зорилго, зорилт, тэдгээрийн суурь түвшин, хүрэх үр дүн, хэрэгжүүлэх үйл ажиллагаа, санхүүжилтийн эх үүсвэрээр баталгаажсан төсөв, хэрэгжилтийг тусгасан эрх бүхий этгээдээс баталсан баримт бичиг байх учиртай.

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогоос:
Зорилтыг хэрэгжүүлэх үе шат, хүрэх үр дүн
I үе шат (2021-2030): Эрх мэдлийн хуваарилалт, тэнцвэртэй байдал, түүнд тавих хяналтыг оновчтой болгох хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, тогтвортой, хяналттай засаглалыг төлөвшүүлэх үе.
3.Шүүхийн хараат бус байдал хангагдаж, хариуцлагатай, иргэн төвтэй шүүх тогтолцоо төлөвшинө.
II үе шат (2031-2040): Хариуцлагатай, үр нөлөөтэй засаглалыг бэхжүүлэх үе.
3.Иргэдийн итгэлийг бүрэн хүлээсэн шүүхтэй болно.
III үе шат (2041-2050): Урт хугацааны, тогтвортой бодлогыг дэмжсэн түншлэгч засаглалыг бий болгох үе.
3.Хариуцлагатай, иргэн төвтэй шүүх төлөвшсөн* байна.

¹² “Шүүхийн шинэтгэл: Бие даасан байдал, чиг үүрэг, хариуцлага” сэдэвт илтгэл.

¹³ Монгол Улсад орчин цагийн хууль зүйн алба үүсэж хөгжсөний түүхт 110 жилийн ойг тохиолдуулан 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдөр зохион байгуулсан ОУЭШ-ний хурал.

¹⁴ Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль (2020)-ийн 6 дугаар зүйл.

* хууль, эрх зүйн гэсэн нь оновчтой томъёолол биш эрх зүйн гэсвэл хууль зүйн гэх.

¹⁵ Хариуцлагатай, иргэн төвтэй шүүх төлөвшсөн гэсэн нь оныгн хувьд алдаатай томъёолол.

¹⁶ Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль (2020)-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.5. “Хөгжлийн зорилтот хөтөлбөр” гэж Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод тусгагдсан тодорхой зорилт, арга хэмжээг улсын хэмжээнд хэрэгжүүлэхээр салбар, салбар хоорондын болон бүс, орон нутгийн онцлогт нийцсэн, нөөцөд суурилсан, санхүүгийн эх үүсвэрээр баталгаажсан үйл ажиллагаа, тоон болон чанарын шалгуур үзүүлэлтийг тусгасан дунд хугацааны бодлогын баримт бичиг, мөн хуулийн 6.5. Дунд хугацааны буюу 10 жилийн хугацаанд хэрэгжих хөгжлийн бодлогын баримт бичиг нь Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэхэд чиглэсэн зорилго, зорилт, санхүүгийн эх үүсвэрээр баталгаажсан үйл ажиллагаа бүхий, тоон болон чанарын шалгуур үзүүлэлтээр хэмжигдэх дараах Хөгжлийн зорилтот хөтөлбөр байна: 6.5.5. засаглалын зорилтот хөтөлбөр; 6.5.5-д заасан Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн төрөлд хамаарах баримт бичгийн төслийг Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагаас боловсруулах бол үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн боловсруулж, холбогдох Байнгын хороонд хүргүүлнэ.

Шүүхийн тухай хууль (2021)-ийн 5 дугаар зүйлийн 5.11-д Шүүх эрх мэдэл хөгжлийн бодлоготой байх бөгөөд түүнийг Ерөнхий зөвлөл хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж, Улсын дээд шүүх, Засгийн газартай зөвшилцөн Улсын Их хуралд уламжилна гэж хуульчилсан. Энэхүү зохицуулалтаас үзэхэд Шүүхийн захиргааны байгууллагаас боловсруулсан Шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлогыг Улсын дээд шүүх, гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр хууль тогтоох эрх мэдлийн байгууллагад уламжилснаар тухайн хөгжлийн бодлогыг батлах эсэхээ хууль тогтоох эрх мэдлийн байгууллага бүрэн эрхийн хүрээнд шийдвэрлэхэд нь найдан үлдээжээ. Дээрх нийгмийн хөгжлийн загварын хувьд бид Европын хөгжлийн загварыг Үндсэн хуулиараа бэхжүүлсэн хэдий ч хэрэгжүүлэх явцдаа замаасаа хазайсан гэж тэмдэглэсэн. Тэгвэл төв замдаа эргэн нийлэхийн тулд засаглалын зорилтот хөтөлбөрийг нарийн чанд боловсруулан, хэрэгжилт, үр дүнг тогтмол хэмжиж олон нийтэд мэдээлж байх нь чухал юм. Тухайлбал, Эрх зүйн шинэчлэлийг ардчилал, хүний эрх, эрх чөлөөг бүрэн хангахад чиглүүлэх, Эрх зүйт төрийг бэхжүүлж, хуулийг бүх шатанд дээдлэх, хуулийн өмнө эрх тэгш байх зарчмыг хэрэгжүүлэх, Шүүх болон шүүгчийн хараат бус байдлыг хангах, шүүх эрх мэдлийн ажиллагааг олон улсын стандартад хүргэх¹⁵ гэх мэт агуулгыг дунд хугацааны хөгжлийн бодлогод тусгаж, урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх үе шат, хүрэх үр дүнг тооцоолсон байх нь зүйтэй юм. Үүнээс үзэхэд Шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлого нь дунд хугацаа (10 хүртэл жил)-ны төлөвлөлттэй байхаар тооцоолж, зорилго, зорилт, хүрэх үр дүнг оновчтой тодорхойлох шаардлагатай юм.

Шүүх эрх мэдлийн талаарх ойлголтыг авч үзье.

Шүүх эрх мэдэл бол төрийн эрх мэдлийн үндсэн гурван салааны нэг. “Төрийн гурван өндөрлөг”* гээд байдгийн нэг нь чухамдаа ямар нэг дарга биш, харин шүүх. Энэ хувьдаа засгийн бусад салаатай харилцан хяналт, тэнцэлтэй байх зарчимтай. Хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн үйл ажиллагаанд тавьдаг шүүхийн хяналт бол хараат бус, хамгийн хүчтэй нь юм. Нөгөөтээгүүр парламент хуулиа хэрхэн биелүүлж буйг шүүх хянадаг¹⁶. Энэхүү тодорхойлолтоор шүүх эрх мэдлийг хянадаг, нөлөөлдөг тогтолцоог Үндсэн хуулийн суурь зарчмын хувьд бүрэн халсныг харж болох ч сүүлийн 30 жилийн хугацаанд өрнөсөн эрх зүйн шинэтгэл тэр дундаа шүүх эрх мэдлийн шинэтгэлийг хууль тогтоомжийн хувьд 4 дэх (Шүүхийн тухай 1993, 2002, Шүүхийн багц хууль 2012, Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн нэмэлт, өөрчлөлтийн дагуу шинэчлэн найруулсан Шүүхийн тухай хууль¹⁷) удаагаа

¹⁵ Батгөмөр, Б. (2006). Хөгжлийн эдийн засаг. Уб., 67-68 дахь тал.

* Төрийн гурван өндөрлөг гэсэн сурвалжлагчийн үгийг их хэрэглэдэг болжээ. Энэ нь хууль зүйн шинжлэх ухааны ойлголт, хэллэг биш.

¹⁶ Чимид, Б. (2008). Үндсэн хуулийн мэдлэг. Уб., 303 дахь тал

¹⁷ Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн 1 дүгээр зүйл.

шинэчлэхдээ Шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлогыг боловсруулан УИХ-д уламжлахаар хуульчилсны дагуу Шүүхийн тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш 9 сарын дараа байгуулагдсан Шүүхийн ерөнхий зөвлөлд чиг үүргийн хүрээнд нэн даруй боловсруулан мөрдүүлэх, хэрэгжилтийг хангуулахаар заасан 28 дүрэм, журам, бодлого, төлөвлөгөөг хуульд нэр дурдан заажээ.

Ардчилсан нийгмийн нэг гол шинж бол бие даасан шүүх эрх мэдэл төлөвшсөн байх явдал юм. Ардчилсан тогтолцоотой ихэнх улсад шүүх эрх мэдлийг төрийн харилцан тэнцэл, хяналт бүхий бүтцийн нэг гэж үзэж Үндсэн хуулиар бататган бэхжүүлж, шүүн таслах үйл ажиллагааг зөвхөн төрийн шүүхийн байгууллага хэрэгжүүлдэг. Энэхүү суурь зарчимд нийцэхийн тулд УИХ-ын 1998 оны “Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр”, УИХ-ын 2000 оны “Монгол Улсын шүүх эрх мэдлийн стратеги төлөвлөгөө батлах тухай”¹⁸-г батлан хэрэгжүүлсэн нь өнөө цагт Шүүхийн эрх мэдлийн хөгжлийн хөтөлбөр боловсруулахад эх сурвалж болох юм. Зарим талаар Шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулга нь шүүхийн шинэтгэлийн шинэ хуудас нээж байгаа ч нийгмийн хөгжил, хувьслын үр дүнд бүтээн бий болгосон түүхэн уламжлал, шинэчлэлийн ямагт суурь нь болж байдаг энэ ч утгаар Шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлогын зорилгыг оновчтой тодорхойлох нь чухал байна. Өнөөдөр иргэд, олон нийт Шүүх эрх мэдлийг зөвхөн шүүх, шүүгчээр төсөөлөн ирсэн тэрхүү ойлголтоосоо салж, Шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд оролцогч байгууллагуудын талаарх мэдлэг, ойлголт төлөвшиж байна. Энэ цаг үед Шүүхийн тухай хуулиар Шүүхийн ерөнхий зөвлөлд даалгаж өгсөн Шүүх эрх мэдлийн хөтөлбөр боловсруулах ажил нь Үндсэн хуулийн гуравдугаар бүлгийн “Шүүх эрх мэдэл” гэсэн дөрөв дэх бүлэгт Шүүх эрх мэдлийн үндсэн зарчим, түүнийг хэрэгжүүлэгч шүүх болон оролцогч байгууллагын эрх зүйн үндсийг заасан¹⁹ талаарх суурь хэм хэмжээг өнгө оруулах чухал алхам болж байна.

Шүүх эрх мэдэл засгийн гурван салааны нэгийн хувьд биеэ даасан байна; шүүгч нь түүний бүрэлдэхүүний хувьд бусдаас хараат бус байна; энэ үндсэн дээр уул эрх мэдлийг хэрэгжүүлэхдээ зөвхөн хуульд захирагдана гэсэн нэг нь нөгөөгөө нөхөн дэмжсэн гурван зарчмыг томьёолсон гэж ойлгож хөгжүүлэх нь Үндсэн хуулийн 49 дүгээр зүйлийн гол үзэл баримтлал гэж болно²⁰. Үндсэн хуулийн үзэл баримтлал нь Олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг баримтлан шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд оролцогч байгууллагуудын

УИХ-ын 2020 оны 2 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарь” -ийн дагуу боловсруулан баталжээ.

¹⁸ Шүүх эрх мэдлийн шинэтгэлийн хөтөлбөр нь Монгол Улсын Засгийн газарт Шүүх эрх мэдлийн стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд туслалцаа үзүүлэх зорилготой АНУ-ын Олон улсын Хөгжлийн Агентлагийн санхүүжилтээр хэрэгжсэн төсөл юм. Уг төсөл нь 2001 оны 4 дүгээр сараас үйл ажиллагаагаа эхлүүлсэн.

¹⁹ Чимид, Б. (2008). Үндсэн хуулийн мэдлэг. Уб., 302 дахь тал

²⁰ Амарсанаа, Ж., Чимид, Б нар (2010). Монгол Улсын Шүүх эрх мэдлийн шинэтгэл (сүүлийн 20 жилийн тойм). Судалгааны тайлан. Нээлттэй нийгэм форум. Уб., 72 дахь тал.

үйл ажиллагааг баталгаажуулан дэмжих зорилгыг агуулж байна.

Энэ талаар Хууль зүйн доктор, профессор Б.Чимид: Шүүх эрх мэдлийг хэрэгжүүлдэг, оролцдог байгууллагын ялгааг “Бүхэлд нь дагнан эрхэлж эцсийн шийдвэр гаргадгаараа шүүх эрх мэдлийг шүүх хэрэгжүүлдэг, харин түүний тодорхой, тодорхой үе шатанд нь байцаан (хянан) шийтгэх ажиллагааны зайлшгүй шаардлагатай, зохих үүрэг, ажилбарыг хууль ёсоор гүйцэтгэдэг бол оролцогч байгууллага гэнэ”²¹ гэж тодорхойлсон байна.

Засгийн үндсэн гурван баганын нэг болох “шүүх эрх мэдэл” гэсэн цогц ойлголтод шүүхийн байгууллагын тогтолцоо, зохион байгуулалтын үндэс, бүрэн эрх, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх зарчим, боломж, шүүгч нарын эрх зүйн байдал багтдаг²² гэж тодорхойлсон зэрэг нь Шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлогыг боловсруулах ажлыг Шүүхийн ерөнхий зөвлөл гардан зохион байгуулах хэдий ч шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд оролцогч байгууллагуудын төлөөллийн оролцоо хангах зарчмыг баримтлах нь зүйтэй юм.

Шүүхийн шинэтгэлийн хоёр дахь шатны арга хэмжээ болгож үндэсний хэмжээний томоохон хөтөлбөр бий болгох нь зүйтэй. Аль нэг өнцгөөс нь хөндөж мэрсэн арга хэмжээ үр дүнд хүрэхгүй²³ гэж шүүх эрх мэдлийн шинэтгэлийн талаар илэрхийлснийг анхааран үзэж, Шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлогыг боловсруулахдаа дараах үйл явцын дагуу боловсруулахыг санал болгож байна.

Шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлого боловсруулах үйл явц:

А. Нөхцөл байдлын шинжилгээ²⁴ - нийт 6 алхам буюу дэд ажилбарыг хийж гүйцэтгэх бөгөөд тус 6 алхамын 2-4 дэх алхам нь хоорондоо харилцан уялдаатай үзэгдэл, үйл явцыг тодорхойлж байгаа ажилбар²⁵.

Алхам 1. Оролцогч талын шинжилгээ - Шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд оролцогчид тус бодлогын баримт бичгийн хүрээнд шийдвэрлэх асуудлыг тодорхойлоход тусална.

Алхам 2. Тулгамдсан асуудал тодорхойлох - Бодлогын баримт бичгийн хүрээнд шийдвэрлэх асуудлыг хүрээг тодорхойлно.

Алхам 3. Асуудлын үр дагаврыг тодорхойлох - Бодлогын баримт бичигт тусгасан асуудлуудын хоорондын уялдаа, хамаарал, эрэмбийг тодорхойлно.

Алхам 4. Асуудлын шалгаан тодорхойлох - Асуудлыг үүсгэж буй шалтгааныг тодорхойлно.

²¹ Чимид, Б. (2008). Үндсэн хуулийн мэдлэг. Уб., 333 дахь тал

²² Жанцан, С. (2003). Монгол Улсын шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын тогтолцоо. Уб., 8 дахь тал.

²³ Чимид, Б. (2014). Төрийг засах ёс. Уб., 37 дахь тал.

²⁴ Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль (2020)-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.24. “нөхцөл байдлын дүн шинжилгээ” гэж асуудлын шалтгаан, үр нөлөөг тоон болон чанарын мэдээлэлд үндэслэн хамрах хүрээний хамт тодорхойлсон бодлогын хувилбар боловсруулахад ашиглах судалгаа.

²⁵ Бямбасүрэн, Я., Доржсүрэн, П нар. (2021). Төрийн бодлого. Уб., 77 дахь тал.

Алхам 5. Бодлого зохицуулалтын шинжилгээ - бодлогын баримт бичгийн залгамж чанар, уялдааг хангах болон өмнө хэрэгжиж байсан хөтөлбөрийн алдаа дутагдлыг засаж сайжруулна.

Алхам 6. Нөхцөл байдлын нэгтгэсэн шинжилгээ - бодлогын баримт бичгийн хүрээнд шийдвэрлэх асуудлыг эцэслэн тодорхойлно.

Б. Бодлогын хувилбарын шинжилгээ²⁶ - бодлого боловсруулахдаа нөхцөл боломж, зохих нөөц байгаа үед асуудлыг шийдвэрлэх хэд хэдэн хувилбарыг санал болгож, улмаар урьдаас сонгон авсан шалгуураар үнэлж дүгнэдэг. Хувилбарыг тодорхойлохын чухал нь түүнийг шинжлэх үед бүх санал бодлыг харгалзан, тэрчлэн асуудлыг шийдвэрлэх оновчтой арга замыг сонгох урьдач нөхцөлийг бүрдүүлдэгт оршино.²⁷

Алхам 7. Хувилбар боловсруулалт - бодлогын баримт бичгийн хувилбарыг сонгохдоо эдийн засгийн, нийгмийн, улс төрийн, технологийн, үр дүнгийн гэгсэн бүлэгт хуваана. Тухайлбал, Шүүхийн төсөв бол тухайн улсад ямар ч хүндрэл бэрхшээл буй болсон хэзээ ч танаж, хасах төсөв биш бөгөөд энэхүү төсвийг Шүүхийн тухай хуульд тодорхой хувиар хуульчлах нь зүйтэй юм. бодлогын баримт бичигт хувилбар бүхий боловсруулалт хийхдээ дараах 4 шаардлагыг хангуулах бөгөөд энэ нь боловсруулалтын нийтлэг алдаа, дутагдлаас сэргийлэх юм.

А. Бодлогын хүрээнд дэвшүүлсэн хувилбарууд бүгд 1 асуудалд чиглэсэн байх;

Б. Бодлогын хүрээнд дэвшүүлсэн хувилбаруудын зорилтот бүлэг нэг ижил байх;

В. Бодлогын хувилбаруудад зарцуулах нөөц, хүрэх үр дүн ойролцоо байх;

Г. Хувилбаруудыг хэрэгжүүлэх боломжтой /арга технологи/ байх.

Алхам 8. Хувилбарын шинжилгээ – Аль түвшний бодлого, хөтөлбөрөөр ямар асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн хувилбар боловсруулж байгаагаас хамаарч хувилбарыг харьцуулах шалгуур үзүүлэлтийг боловсруулах бөгөөд дараах нийтлэг шалгуур үзүүлэлтийн дагуу харьцуулсан дүн шинжилгээ хийж болно. Үүнд: шаардагдах санхүүжилтийн хэмжээ (авбал зохих дээд оноо-2), хүлээгдэж буй үр дүн(авбал зохих дээд оноо-1), нөлөөллийн урьдчилсан үнэлгээ(авбал зохих дээд оноо-2), бусад бодлого (урт болон дунд хугацааны)-той уялдах уялдаа(авбал зохих дээд оноо-2), зарцуулах хугацаа(авбал зохих дээд оноо-1), шаардлагатай хүний нөөц(авбал зохих дээд оноо-1), оролцогч талуудын (прокурор, өмгөөлөл) дэмжих магадлал(авбал зохих дээд оноо-1) гэх мэт. Энэхүү шалгуурын дагуу 4 алхмаар шинжилгээ хийдэг²⁸ байна.

Алхам 9. Хувилбарын үнэлгээ, сонголт – өмнөх алхмын хүрээнд хийсэн тооцоолол, үнэлгээний үр дүнг нэгтгэн, сонголт хийж, хувилбарын

²⁶ Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль (2020)-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.17."бодлогын хувилбар" гэж нөхцөл байдлын дүн шинжилгээ болон нөлөөллийн урьдчилсан үнэлгээнд үндэслэн асуудлыг шийдвэрлэхээр санал болгосон бодлогын хоёроос дээш сонголт.

²⁷ Бямбасүрэн, Я., Доржсүрэн, П нар. (2021).Төрийн бодлого. Уб., 89 дэх тал.

²⁸ Бямбасүрэн, Я., Доржсүрэн, П нар. (2021).Төрийн бодлого. Уб., 92-93 дахь тал.

ерөнхий үнэлгээгээр хамгийн өндөр оноо авч, 1-т эрэмбэлэгдсэн хувилбарыг сонгох боломжийг нэмэгдүүлнэ.

*В. Бодлогын үр дүн, хэрэгжилтийн шинжилгээ*²⁹ - Бодлогын зорилго, зорилт, үйл ажиллагаа, арга хэмжээ нь тодорхой байх, хэмжигдэхүйц байх, хүрч болохуйц болон хэрэгжихүйц бодитой байх, хугацаатай байх ерөнхий шаардлагыг хангасан байна.

Алхам 10. Бодлогын зорилго тодорхойлох - Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын эхний үе шатны зорилт, хүлээгдэж буй үр дүнтэй уялдуулна³⁰.

Алхам 11. Бодлогын зорилт тодорхойлох - Шүүх эрх мэдлийн хүрээнд тулгамдаж буй асуудлыг нөхцөл байдлын дүн шинжилгээний үр дүнгийн хүрээнд харьцуулан үзэж хөтөлбөрийн зорилтыг тодорхойлно.

Алхам 12. Бодлогын хэрэгжилтийг хангах үйл ажиллагаа, арга хэмжээ тодорхойлох - Хөтөлбөрийн зорилго, зорилтын хэрэгжилтийг хангах үйл ажиллагаа, арга хэмжээ тодорхой байх, хэмжигдэхүйц байх, хүрч болохуйц болон хэрэгжихүйц бодитой байх ерөнхий шаардлагыг бүрэн хангасан байхыг шаардах бөгөөд Шүүхийн эрх мэдлийн хөгжлийн бодлогыг боловсруулахад 2012 онд батлагдан, 2021 оны 3 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл үйлчилсэн Шүүхийн багц хуулийн хэрэгжилтийн явцад хийгдсэн төрийн болон олон нийтийн байгууллагаас хийгдсэн судалгааг анхаарч үзэх нь зүйтэй.

Алхам 13. Бодлого хэрэгжүүлэх санхүүжилтийн хэмжээ, эх үүсвэрийг тодорхойлох - Хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх санхүүжилтийг зөвхөн дан ганц төсөвт хамааруулан тооцоолон үзэх нь өрөөсгөл бөгөөд санхүүжилтийн олон эх үүсвэрийг тооцож үзэх нь зүйтэй. Үүний тулд өмнө хэрэгжиж байсан эрх зүйн шинэтгэл болон шүүх эрх мэдлийн шинэтгэл хөтөлбөрийн санхүүжилт, НҮБ-ын гишүүн орнууд болон олон улсын байгууллагын дэмжлэгийг хууль тогтоомжид заасан үндэслэл журмын дагуу санхүүжилтийг шийдвэрлэх боломжтой юм.

Алхам 14. Бодлогын хэрэгжилтийн шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт боловсруулах - бодлогын баримт бичгийн зорилго, зорилт, үйл ажиллагаа тус бүрт хүлээгдэж буй үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлт³¹ боловсруулахдаа тэдгээр шалгуур үзүүлэлтийн хоорондын уялдаа

²⁹ Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль (2020)-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.13. "хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ" гэж хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулахдаа энэ хуульд заасан зарчмыг баримталсан байдал, хөгжлийн бодлого, төлөвлөлтөд оролцогчдын чиг үүргээ хэрэгжүүлсэн болон хамтран ажилласан байдал, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн явц, үр дүнд хийсэн цогц үнэлгээ.

³⁰ УИХ-ын 2020 оны Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай "Алсын хараа-2050" 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт. **Зорилт 5.1.** Эрх мэдлийн хуваарилалт, хяналт, тэнцлийг оновчтой болгож, засаглалын тогтвортой байдлыг хангана. **I үе шат** (2021-2030): Эрх мэдлийн хуваарилалт, тэнцвэртэй байдал, түүнд тавих хяналтыг оновчтой болгох хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, тогтвортой, хяналттай засаглалыг төлөвшүүлэх үе. *3.Шүүхийн хараат бус байдал хангагдаж, хариуцлагатай, иргэн төвтэй шүүх тогтолцоо төлөвшинэ.*

³¹ Шалгуур үзүүлэлт гэж бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үе шат бүрд бий болох өөрчлөлтийг хэмжих тоон болон чанарын үзүүлэлт.

холбоог хангаж боловсруулах шаардлагатай³² байна.

Шалгуур үзүүлэлтийг боловсруулахдаа дараах ерөнхий шаардлагыг харгалзан үзвэл зохилтой.

1. Тухайн үр дүнг бүрэн хэмжих шалгуур үзүүлэлтийг тодорхойлох;
2. Тухайн үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлтэд 1 шалгуур үзүүлэлтийг 2-оос дээш удаа давхардуулахгүй байх.

Г. Бодлогын шийдвэр гаргах загвар - Төрийн бодлогын шийдвэр гаргах субъект нь улс төрч эсвэл захиргааны албан хаагч байхаас хамааран шийдвэр гаргах ерөнхий дэг жаяг өөр байдаг. Шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлогыг эцэслэн батлах субъект нь энэ тохиолдолд улс төрч байна. Хэдийгээр хууль тогтоох эрх мэдлийг Үндсэн хуульд заасан хэм хэмжээнд нийцүүлэн хэрэгжүүлж байгаа хэдий ч улс төрийн байр сууринаас шүүх эрх мэдэлд хандах хандлага өнгөрсөн 30 жилийн түүхэн баримтаас харж болох юм. Иймд бодлогын шийдвэр гаргах рационализм, инкрементализм, тоглоомын онол, нийтийн сонсголын онол гэсэн загвараас аль тохирох загварыг нь шууд сонгох нь улс төрчийн шийдвэр гаргах үйл ажиллагаанд бодитой дэмжлэг болох төдийгүй, хайрцаглаж өгөх боломжтойг харж болно.

Д. Бодлогын зохицуулалтыг бодлого боловсруулалтын үеийн зохицуулалт, бодлого хэрэгжүүлэлтийн үеийн зохицуулалт гэж ерөнхий ангилж болно. Бодлого боловсруулалтын үеийн зохицуулалтыг хийх түгээмэл арга хэрэгсэл нь хамтарсан ажлын хэсэг байгуулах арга юм³³. Энэхүү ажлын хэсгийг байгуулахдаа бодлого хэрэгжүүлэлтийн явцад чиг үүрэг хамаарах байгууллага болон бусад байгууллагын төлөөллийг оролцуулах нь зүйтэй. Түүнчлэн бодлого боловсруулалтын үеийн зохицуулалтыг хийх өөр нэг арга нь боловсруулсан бодлогын баримт бичгийн төслийг оролцогч талуудад илгээн санал авах. Сүүлийн үед түгээмэл ашиглаж буй арга бол оролцогч талуудыг хамарсан хэлэлцүүлэг зохион байгуулах явдал. Хэлэлцүүлгийн үр дүнг дээшлүүлэх зорилгоор бодлогын баримт бичгийн төслийг танилцуулан, хугацаа зааж бичгээр санал авах боломжтой. Аль болох тухайн асуудлыг судалдаг, хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх мэргэжилтэн тухайн төсөлд судалгаанд үндэслэн санал өгөх нь туйлын ач холбогдолтой юм. Ийнхүү Шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлогыг боловсруулахдаа харгалзан үзэх зарим санааг илэрхийлэхийн зэрэгцээ дараах **ДҮГНЭЛТИЙГ** өгч байна.

1. Шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлого нь хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасан дунд хугацааны баримт бичиг байна.

2. Дунд хугацааны хөгжлийн баримт бичиг нь урт хугацааны хөгжлийн баримт бичиг “Алсын хараа-2050”-ын **“I үе шат (2021-2030): Шүүхийн хараат бус байдал хангагдаж, хариуцлагатай, иргэн төвтэй шүүх тогтолцоо төлөвшинө”** гэсэн зорилтыг хангахуйцаар зорилго, зорилт, үр дүнг тооцсон томъёололтойгоор хөтөлбөр хэлбэрээр

³² Бямбасүрэн, Я., Доржсүрэн, П нар. (2021).Төрийн бодлого. Уб., 103 дахь тал.

³³ Мөн тэнд. 122 дахь тал.

боловсруулагдсан байвал зохино. Харин “Алсын хараа-2050”-ын **II үе шат (2031-2040): Хариуцлагатай, үр нөлөөтэй засаглалыг бэхжүүлэх үе. 3.Иргэдийн итгэлийг бүрэн хүлээсэн шүүхтэй болно. III үе шат (2041-2050): Урт хугацааны, тогтвортой бодлогыг дэмжсэн туншилэгч засаглалыг бий болгох үе. 3.Хариуцлагатай, иргэн төвтэй шүүх төлөвшсөн байна.** гэсэн хүрэх үр дүнг стратеги төлөвлөгөө хэлбэрээр боловсруулах нь зүйтэй. Манай улс нэгэнт урт хугацааны хөгжлийн баримт бичигтээ Шүүх эрх мэдлийн хөгжлийн хүрэх үр дүнг тодорхойлсон тул тухайн хөгжилд хүрэх бүрэн зураглал бүтээхэд анхаарах шаардлагатай юм.

3. Шүүхийн захиргааны байгууллага болох Шүүхийн ерөнхий зөвлөлд Шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлогыг боловсруулах чиг үүргийг хуулиар олгосон нь шүүхийн захиргааны бие даасан загварыг бүрэн дэмжсэн чухал алхам юм. Шүүх эрх мэдлийг хэрэгжүүлдэг болон оролцогч байгууллагын өмнө тулгамдаж буй асуудлыг үндсэн хэсэгт дэлгэрэнгүй танилцуулсан бодлого боловсруулах үйл явцад нийцүүлэн ирэх 10 жилийн хөгжлийн зорилго, зорилт, үр дүнг тооцоолон боловсруулах нь Шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлогыг нэг өнцгөөс нь хөндсөн арга хэлбэрээр бус харин тус хөгжлийн бодлогыг хөтөлбөр, стратеги төлөвлөгөө хэлбэрээр боловсруулан хэрэгжүүлэгч болон оролцогч талуудын дэмжлэг, хамтын ажиллагаанд тулгуурласан байдлаар бодитой хэрэгжихүйц байдлаар боловсруулах учиртай.

4. Зөвхөн шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлого ч гэлтгүй төрийн урт, дунд, богино хугацааны бодлогыг мөрөөдлийн жагсаалт хэвээр үлдээхгүй байх арга зам бол хуулиар зөвшөөрсөн олон эх сурвалж бүхий санхүүжилт юм. Шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлогод шүүхийг төсвийн хараат байдлаас зохих түвшинд гаргахад чиглэсэн зорилт дэвшүүлэн ажиллах нь чухал байна. Энэ нь Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан Шүүх улсын төсвөөс санхүүжинэ. Шүүх үйл ажиллагаагаа явуулах эдийн засгийн баталгааг төр хангана. гэсэн зарчмыг бүрэн хэрэгжүүлэхэд өмнөх 30 жилд шийдвэрлэж чадаагүй бэрхшээлийг даван туулах арга замыг тодорхойлох боломжтой.

5. Эрх зүйн соёл, ухамсар өндөр төлөвшсөн зарим оронд хууль, шүүх эрх мэдлийн байгууллагын ачааллыг бууруулах үйлчлүүлэгчид шуурхай, итгэл хүлээхүйцээр үйлчлэх арга технологийг сүүлийн жилүүдэд идэвхтэй туршин нэвтрүүлж байгааг манай улсын шүүх эрх мэдлийн байгууллага соргогоор хүлээн авч технологийн дэвшлийг нэвтрүүлэн шүүхийн ачааллыг бууруулах оновчтой зохицуулах, программ хангамж, платформын нэвтрүүлээд ажиллаж байна. Энэхүү цахим шилжилтийг Шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлогод нарийн судалгаатай тусах шаардлагатай бөгөөд тухайн зорилтыг шинээр байгуулагдаж буй Цахим хөгжил, харилцаа холбооны яамтай хамтран хэрэгжүүлэх нь зүйтэй. Шүүх бол эрх зүйн маргааныг гомдлоор хүлээн авч эцсийн шийдвэр гаргадаг байгууллага тул шүүх хуралдаан болон шүүхийн шийдвэр гаргах үйл явцад технологийн дэвшлийн оргил хэлбэр болох

хиймэл оюун ухааныг ашиглах нь зохимжгүй болохыг судлаачийн хувьд тэмдэглэе. Түүнчлэн уламжлалгүй хөгжил дэвшил, шинэтгэл байхгүйг анхааралдаа авч Шүүх эрх мэдлийн хүрээнд хэрэгжиж эхэлсэн ажил үйлчилгээг бүрэн нэвтрүүлэхүйц байдлаар хөгжлийн бодлогын зорилтод тодорхойлох шаардлагатай. Тухайлбал, ШЕЗ 2017 оноос хэрэгжүүлж буй шүүхэд үйлчилгээний соёл нэвтрүүлэх ажлын хүрээнд шүүхийн үйлчилгээг сайжруулах зорилгоор “Чанарын удирдлагын тогтолцоо – MNS ISO9001:2016 стандарт”-ыг шүүхийн тамгын газруудад бүрэн нэвтрүүлэх нь гэх мэт.

Энэхүү илтгэлийг Үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцүүлэн бичихийг зорьсон болно.

ЭХ СУРВАЛЖ

Нэг. Хууль тогтоомж

1. Үндсэн хууль. 1992
2. Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хууль. 2019
3. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль. 2020
4. Шүүхийн тухай хууль. 1993, 2002, 2012, 2021
5. УБХ-ын 1992 оны “Төлөвлөгөө батлах тухай (Үндсэн хуулийг бүрнээ дагаж мөрдөх ажлыг зохион байгуулах)” 14 дүгээр тогтоол
6. УИХ-ын 1993 оны “Шүүхийг өөрчлөн байгуулсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 60 дугаар тогтоол
7. УИХ-ын 1996 оны “Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал батлах тухай” 26 дугаар тогтоол
8. УИХ-ын 1998 оны “Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр”, “Хөтөлбөр, үндсэн чиглэл, төлөвлөгөө батлах тухай” 18 дугаар тогтоол
9. УИХ-ын 2000 оны “Монгол Улсын шүүх эрх мэдлийн стратеги төлөвлөгөө батлах тухай” 39 дүгээр тогтоол
10. УИХ-ын 2003 оны “Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр батлах тухай” 41 дүгээр тогтоол
11. УИХ-ын 2008 оны “Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогыг батлах тухай” 12 дугаар тогтоол
12. НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 2015 оны 70 дугаар чуулганаар тогтвортой хөгжлийн 17 зорилго, 169 зорилт бүхий “Тогтвортой хөгжлийн зорилго”
13. УИХ-ын 2016 оны «Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030» 19 дүгээр тогтоол

14. УИХ-ын 2016 оны “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай” 51 дүгээр тогтоол
15. УИХ-ын 2020 оны Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай “Алсын хараа-2050» 52 дугаар тогтоол.
16. УИХ-ын 2020 оны “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарь” баталсан 2 дугаар тогтоол.

Хоёр. Ном, гарын авлага.

1. Ж.Амарсанаа, Б.Чимид нар. Монгол Улсын Шүүх эрх мэдлийн шинэтгэл (сүүлийн 20 жилийн тойм). Судалгааны тайлан. Нээлттэй нийгэм форум. Уб., 2010.
2. Ж.Амарсанаа, А.Ариунболд нар. Өрхийн эрх зүйн хөтөч Гарын авлага. Уб., 2019
3. Б.Баттөмөр. Хөгжлийн эдийн засаг. Уб., 2006.
4. Б.Баярсайхан. Монгол хэлний тайлбар толь. Уб., 2011.
5. Б.Даш-Ёндон. Монголын хөгжлийн философи (асуудал, аргачлал, ашиг тус). Уб., 2013.
6. С.Жанцан. Монгол Улсын шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын тогтолцоо. Уб., 2003.
7. С.Нарангэрэл. Монгол Улсын хууль зүйн нэвтэрхий толь. Уб., 2021.
8. Я.Цэвэл. Монгол хэлний товч тайлбар толь. Уб., 2013.
9. Б.Чадраа (ред). Монголын Үндэсний нэвтэрхий толь. Уб., 2009
10. Б.Чимид. Үндсэн хуулийн мэдлэг. Уб., 2008.
11. Б.Чимид. Төрийг засах ёс. Уб., 2014.
12. Б.Чимид. Үндсэн хуулийн үзэл баримтлал. Уб., 2017.
13. Б.Энхмандах. Нийгмийн хөгжлийн загварын тухай.Уб., 2013.

Гурав. Бусад

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдөр зохион байгуулсан “Шүүх эрх мэдэл, хууль сахиулах байгууллагын алба хаагчдын үндэсний чуулган”-д хэлэлцүүлсэн УДШ-ийн Ерөнхий шүүгч Д.Ганзориг “Шүүхийн шинэтгэл: Бие даасан байдал, чиг үүрэг, хариуцлага” сэдэвт илтгэл.
2. Монгол Улсын хуулийн судалгаа 2020.12.31



Сэргэлэн ЭНХБАЯР

Санхүү эдийн засгийн их сургуулийн
эрх зүйн тэнхимийн ахлах багш,
Хууль зүйн доктор
(Тусгай байр)

ИРГЭНИЙ ШҮҮХИЙН ПРОЦЕССЫН АЛДАА БА ШҮҮГЧИЙН ЁС ЗҮЙН ШИНЭЧЛЭЛИЙН ЗАРИМ АСУУДАЛ

ТОВЧЛОЛ

Шүүхийн шинэчлэл нь хүний эрхийн хамгааллын тогтолцооны шинэчлэл бөгөөд шүүхийг хүмүүс засаг төрийн эрх баригчдын төлөө биш харин өөрсдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалж, аж амьдралынхаа хэвийн нөхцөлийг сахин хамгаалахын төлөө байгуулдаг¹ тул хүн бүр маргаанаа шударга шүүхээр шийдвэрлүүлэх, шүүх хараат бус байх тогтолцоог бүрдүүлэх чухал алхам төдийгүй, шүүхийн шинэчлэл нь Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн зорилтыг хангаж байгаа эсэхэд бид анхаарал хандуулах нь зүй ёсны хэрэг мөн.

Шүүхийн тухай хуулийн 50 дугаар зүйлд шүүгчид хориглох зүйлийг нэг бүрчлэн зааж, хуульчилсан чухал ач холбогдолтой зохицуулалт бөгөөд шүүгчийн ёс зүй нь шүүхийн хараат бус бие даасан байдлын баталгаа төдийгүй шүүх эрх мэдлийн хэвийн үйл ажиллагааг хадгалж, эрх зүйт ёсыг хамгаалах чухал хэрэглүүр гэж хэлж болно. Ардчилсан нийгмийн хэрэг маргааныг эцэслэн шийдвэрлэгч шүүгч нь энэхүү өндөр хариуцлагатай албан тушаалдаа ямагт хүндэтгэлтэй хандаж, өөрийн үйл ажиллагаагаар шүүх эрх мэдлийн нэр төрийг хадгалж, олон нийтийн итгэлийг алдагдуулахгүй байх үүрэгтэй.²

Шүүхийн тухай хуулийн 50 дугаар зүйлд Шүүгчид хориглох зүйлд заасан зарим зохицуулалт нь функционал хууль буюу процессын хуультай уялдах бөгөөд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн боловсронгуй бус байдал, шинэчлэх зайлшгүй хэрэгцээ шаардлага бий болж байгаатай холбоотойгоор шударга шүүгч нарын эрх хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөх, шат шатны шүүхийн бие даасан байдал, шүүхийн хараат бус байдалд нөлөөлөх боломжийг бүрдүүлэх сөрөг үр дагавар үүсэх боломжтой.

Энэхүү илтгэлийг Шүүхийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1.23-д “хуулийн илт тодорхой заалтыг ноцтой, эсхүл удаа дараа зөрчсөн

¹ Б.Чимэд, Үндсэн хуулийн үзэл баримтлал. УБ., 257 дахь тал.

² Хуульчийн ёс зүй гарын авлага, УБ., 2013 он. 58 дахь тал

үйлдэл, эс үйлдэхүй гаргах”, 50.1.27-д “шүүхийн шийдвэрт үндэслэл огт бичээгүй нь дээд шатны шүүхээр тогтоогдсон”, 50.1.40. “энэ хуулийн 66.7-д заасныг биелүүлээгүй. /66.7.Шүүх бүрэлдэхүүн иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийн агуулгыг шүүхийн шийдвэрийн тодорхойлох хэсэгт бичиж, уг дүгнэлтийн талаарх үндэслэлээ үндэслэх хэсэгт тодорхой тусгана.”³ гэх хуулийн зохицуулалт нь Үндсэн хуулийн зарчимд нийцэж байгаа эсэхийг Иргэний хэргийн шүүхийн практикт тулгуурлан судалсан болно.

ИРГЭНИЙ ШҮҮХИЙН ПРОЦЕССЫН АЛДАА БА ШҮҮГЧИЙН ЁС ЗҮЙН ШИНЭЧЛЭЛИЙН ЗАРИМ АСУУДАЛ

Монгол Улс ардчилсан тогтолцоонд шилжих шилжилтийн үндэс болсон Монгол Улсын Үндсэн хууль 1992 онд батлагдсанаас хойш 30 жилийн ойн босгон дээр Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн хүрээнд Шүүх эрх мэдлийн шинэ сорилт, шинэлэг хуулийн зохицуулалтын дагуу үйл ажиллагаа явуулах хэрэгцээ шаардлага бий болж байна. Үндэсний эрх зүйн системийг боловсронгуй болгох зорилготой хууль тогтоомжийн шинэчлэлүүд хийгдэж, зарим үр дүнд хүрсэн хэдий ч 2019 онд хийгдсэн Үндсэн хуулийн өөрчлөлт нь шүүхийн системд урьд өмнө хийгдэж байгаагүй томоохон өөрчлөлтийг авчирч байна.⁴

Шүүхийн шинэчлэлийг шинэ шатанд гаргасан Үндсэн хуулийн энэ удаагийн өөрчлөлт нь шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах, шүүгчийн ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлэх, шүүх иргэдэд хүртээмжтэй байхад чиглэсэн эрх зүйн шинэ үндсийг тавьснаараа хүний эрхийг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээхэд хүчтэй дэмжлэг болж чадах томоохон өөрчлөлтийг бий болгож, шүүн таслах ажиллагааны чанар, үр өгөөжийг бодитой болгох, шүүхийн шийдвэрийн үндэслэл ил тод, эргэлзээ, маргаангүйгээр олон нийтэд хүрэх, шийдвэр гарцаагүй биелэх, хэрэг хянан шийдвэрлэх хуулиуд зорилгоо бүрэн биелүүлэх хэмжээнд боловсрогдох, шүүхийн бус журмаар шийдвэрлэх механизмыг хөгжүүлэх, шүүхийн тогтолцоог оновчтой зохион байгуулах зэргээр тодорхойлогдож байна.

Энэ өөрчлөлтөөр шүүхийн сахилгын хороог үндсэн хуулийн байгууллага болгон эрх зүйн байдлыг өргөжүүлж, улмаар шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах, шүүгчийн ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлэх, шүүх иргэдэд хүртээмжтэй байхад чиглэсэн шүүх эрх мэдлийн шинэчлэлийн эрх зүйн үндсийг тавилаа. Шүүхийн бие даасан, хараат бус байдал бол хуулийн системийн шинэчлэлийн эх үндэс мөн юм.

2021 оны нэгдүгээр сарын 15-ны өдөр батлагдсан Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулга нь Үндсэн хууль дахь шүүхийн шинэчлэл “амь орж” хэрэгжих, мөн хуулийн систем дэх цаашдын шинэчлэлүүд өрнөх нөхцөлийг бүрдүүлээ.

³ Шүүхийн тухай хууль. 2021.01.15. //Төрийн мэдээлэл. 2021. №5.

⁴ <http://itoim.mn/article/Cn8Nv/30090> /Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч Д.Ганзоригийн “Шүүхийн шинэчлэл, бие даасан байдал, чиг үүрэг, хариуцлага” сэдэвт илтгэл/

Монгол Улсын шүүхийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-аар шүүгч нар томилгооны зарчмаас татгалзаж, шүүхийн ерөнхий зөвлөлийн болон шүүхийн сахилгын хорооны шүүгч гишүүд болон ерөнхий шүүгчийн сонгох эрхийг олгосон нь ардчилсан зарчим төдийгүй шүүхийн хараат бус байдлыг хангах чухал арга зам болсон бөгөөд шүүгчийн зан үйлийн хэмжээ хязгаар буюу ямар үйлдэл, эс үйлдэхгүйг сахилгын зөрчилд тооцох, түүнд ногдуулах сахилгын шийтгэлийг тодорхой хуульчилсан нь өмнө нь байгаагүй шинэлэг олон зохицуулалт төдийгүй Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн үр дүн юм.

Дээрх шүүхийн шинэчлэл нь хүний эрхийн хамгааллын тогтолцооны шинэчлэл бөгөөд шүүхийг хүмүүс засаг төрийн эрх баригчдын төлөө биш харин өөрсдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалж, аж амьдралынхаа хэвийн нөхцөлийг сахин хамгаалахын төлөө байгуулдаг⁵ тул хүн бүр маргаанаа шударга шүүхээр шийдвэрлүүлэх, шүүх хараат бус байх тогтолцоог бүрдүүлэх чухал алхам төдийгүй, шүүхийн шинэчлэл нь Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн зорилтыг хангаж байгаа эсэхэд бид анхаарал хандуулах нь зүй ёсны хэрэг мөн.

Шүүхийн тухай хуулийн 50 дугаар зүйлд шүүгчид хориглох зүйлийг нэг бүрчлэн зааж, хуульчилсан чухал ач холбогдолтой зохицуулалт бөгөөд шүүгчийн ёс зүй нь шүүхийн хараат бус бие даасан байдлын баталгаа төдийгүй шүүх эрх мэдлийн хэвийн үйл ажиллагааг хадгалж, эрх зүйт ёсыг хамгаалах чухал хэрэглүүр гэж хэлж болно. Ардчилсан нийгмийн хэрэг маргааныг эцэслэн шийдвэрлэгч шүүгч нь энэхүү өндөр хариуцлагатай албан тушаалдаа ямагт хүндэтгэлтэй хандаж, өөрийн үйл ажиллагаагаар шүүх эрх мэдлийн нэр төрийг хадгалж, олон нийтийн итгэлийг алдагдуулахгүй байх үүрэгтэй.⁶

Английн нэрт сэтгэгч, эрх чөлөөний философийг үндэслэгч Ж.Локк хүний амь нас, өмч хөрөнгө, эрх чөлөө гурвыг хүний салшгүй эрх, юугаар ч орлуулашгүй үнэтэй ашиг сонирхол нь гэж нэгэнтээ хэлсэн. Тэгвэл шударга ёсны үйлчилгээг хүргэх замаар хүний энэ амин чухал ашиг сонирхлыг дэнслэх онцгой бүрэн эрх зөвхөн шүүгч хүнд бий.⁷ Өөрөөр хэлбэл, ёс зүйгүй хүн шүүх эрх мэдлийг хэрэгжүүлнэ гэдэг бол галзуу хүнд буу өгсөнтэй адил бөгөөд шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч шүүгч нь шүүн таслах ажиллагаанд төдийгүй бусад цагт ч нийгэмд үлгэр дуурайл үзүүлэх хэмжээнд биеэ авч явах нь ёс зүйн наад захын шалгуур юм.

Шүүхийн тухай хуулийн 50 дугаар зүйлд Шүүгчид хориглох зүйлд заасан зарим зохицуулалт нь функционал хууль буюу процессын хуультай уялдах бөгөөд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн боловсронгуй бус байдал, шинэчлэх зайлшгүй хэрэгцээ шаардлага бий болж байгаатай холбоотойгоор шударга шүүгч нарын эрх хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөх, шат шатны шүүхийн бие даасан байдал, шүүхийн хараат бус байдалд нөлөөлөх боломжийг бүрдүүлэх сөрөг үр дагавар үүсэх боломжтой.

⁵ Б.Чимэд, Үндсэн хуулийн үзэл баримтлал. УБ., 257 дахь тал.

⁶ Хуульчийн ёс зүй гарын авлага, УБ., 2013 он. 58 дахь тал

⁷ Шүүгчийн ёс зүй гарын авлага. УБ., 2018 он. 4 дэх тал

Энэхүү илтгэлийг Шүүхийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1.23-д “хуулийн илт тодорхой заалтыг ноцтой, эсхүл удаа дараа зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүй гаргах”, 50.1.27-д “шүүхийн шийдвэрт үндэслэл огт бичээгүй нь дээд шатны шүүхээр тогтоогдсон”, 50.1.40. “энэ хуулийн 66.7-д заасныг биелүүлээгүй. /66.7.Шүүх бүрэлдэхүүн иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийн агуулгыг шүүхийн шийдвэрийн тодорхойлох хэсэгт бичиж, уг дүгнэлтийн талаарх үндэслэлээ үндэслэх хэсэгт тодорхой тусгана./”⁸ гэх хуулийн зохицуулалт нь Үндсэн хуулийн зарчимд нийцэж байгаа эсэхийг Иргэний хэргийн шүүхийн практикт тулгуурлан авч үзэхээр байна.

Нэг: Хуулийн илт тодорхой заалтыг ноцтой, эсхүл удаа дараа зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүй.

Иргэний хэргийн шүүхийн практикт иргэний хэргийг хүчингүй болгож дахин хянуулахаар буцаасан тохиолдлын нэг нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн буюу процессын алдаа гаргасан гэж хүчингүй болдог. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчих нь мэргэжлийн алдаа бөгөөд Шүүхийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1.23-д “хуулийн илт тодорхой заалтыг ноцтой, эсхүл удаа дараа зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүй гаргах”-тай шууд холбоотой юм.

Улсын дээд шүүхийн Иргэний хэргийн танхимд 2017 онд хяналтын журмаар хэлэлцэгдсэн 1704 иргэний хэргийн 11.5 хувь буюу 196 хэргийн шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, дахин хэлэлцүүлэхээр буцааж, Шийдвэр, магадлалыг хүчингүй болгож хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаасан 196 хэргийн 47.4 хувь буюу 93 хэргийг шүүх өөр хуулийг, эсхүл хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн ба шийдвэрийг өөрчлөх боломжгүй гэж, 52.6 хувь буюу 103 хэргийг шүүх хуулиар тогтоосон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг зөрчсөн үндэслэлээр шийдвэр, магадлалыг тус тус хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаажээ.⁹ Иргэний хэргийн танхимд 2018 онд хяналтын журмаар хэлэлцэгдсэн 1932 иргэний хэргийн 10.8 хувь буюу 208 хэргийн шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, дахин хэлэлцүүлэхээр буцаасан бөгөөд 53.4 хувь буюу 111 хэргийг шүүх өөр хуулийг, эсхүл хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн ба шийдвэрийг өөрчлөх боломжгүй гэж, 46.6 хувь буюу 97 хэргийг шүүх хуулиар тогтоосон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг зөрчсөн үндэслэлээр шийдвэр, магадлалыг тус тус хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаажээ.¹⁰ Иргэний хэргийн танхимд 2019 онд хяналтын шатны шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэгдсэн 1004 хэргийн 10 хувь буюу 101 хэргийн шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, дахин хэлэлцүүлэхээр буцааж, Хүчингүй болгосон 101 хэргийн 50.5 хувь буюу 51 хэргийг шүүх өөр хуулийг,

⁸ Шүүхийн тухай хууль. 2021.01.15. //Төрийн мэдээлэл. 2021. №5.

⁹ Монгол Улсын Дээд Шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдаанаар 2017 онд хянагдсан захиргааны хэргийн дүн, өөрчлөгдсөн, хүчингүй болсон шийдвэр, магадлалыг судалсан тухай тойм,

¹⁰ Монгол Улсын Дээд Шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдаанаар 2018 онд хянагдсан захиргааны хэргийн дүн, өөрчлөгдсөн, хүчингүй болсон шийдвэр, магадлалыг судалсан тухай тойм,

эсхүл хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн ба шийдвэрийг өөрчлөх боломжгүй гэж, 49.5 хувь буюу 50 хэргийг шүүх хуулиар тогтоосон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг зөрчсөн үндэслэлээр шийдвэр, магадлалыг тус тус хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаажээ.¹¹

Иргэний хэргийн танхимд 2020 онд хяналтын шатны шүүх 846 хэргийг хянан шийдвэрлэснээс шийдвэр магадлалыг хүчингүй болгож хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаасан 64 хэрэг буюу 7.6 хувийг тус тус эзэлсэн үзүүлэлттэй байна.

- Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн – 12.1%
- Хууль буруу тайлбарлан хэрэглэсэн – 16.4%
- Нотлох баримтыг буруу үнэлсэн – 6.5%
- Нотлох баримтыг дутуу цуглуулсан – 15.0%
- Үндэслэл бүхий дүгнэлт хийгээгүй – 31.8 %
- Хэрэглэвэл зохих хуулийг бүрэн хэрэглээгүй – 5.6%
- Хэрэглэх ёсгүй хуулийг хэрэглэсэн – 2.3%
- Нэхэмжлэлийн шаардлага тодруулаагүй, дүгнэлт өгөөгүй – 7.5%
- Шүүхийн шийдвэрт үндэслэл бичээгүй – 0.5% зэрэг үндэслэлүүд

тус тус орж байна.¹²

Шүүхийн тухай хуулийн шинэчлэлтэй холбоотойгоор Улсын дээд шүүх нь хэргийг хуульд заасан үндэслэл байгаа тохиолдолд авч хянах болсон бөгөөд үүнтэй холбоотойгоор 2021 оны 3 дугаар сарын 01-ний өдрөөс хойш хяналтын журмаар гаргасан гомдлыг бүхэлд нь буцаасан байна.

Дээрх процессын алдаа нь хуулийн илт тодорхой заалтыг ноцтой, эсхүл удаа дараа зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүй гаргасан гэж үзэж болох тохиолдлын нэг юм.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн илт тодорхой заалтыг ноцтой, эсхүл удаа дараа зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүй нь ямар ч хэлбэрээр илэрч болно. Жишээлбэл, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан хугацааг хэтрүүлэх, процессын эрхийг хязгаарлах зэрэг олон хэлбэрээр илэрч болно. Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ерөнхий хугацаа 60 хоног, шүүгч нарын зөвлөлгөөн 30 хоногоор сунгаж болох хуулийн зохицуулалттай бөгөөд 90 хоногоос хойш хугацаа хэтэрсэн хэрэг гэж үзнэ. Мөн нэхэмжлэлийн хувийг 7 хоногийн дотор гаргуулах үүрэгтэй бөгөөд зарим тохиолдолд гардуулж чадахгүй хагас жил болох тохиолдол байдаг. Хэргийн оролцогчоос шалтгаалан шүүх хуралдаан хойшлохоос гадна, шүүхийн буруутай үйл ажиллагааны улмаас шүүх хуралдаан хойшлох тохиолдол цөөнгүй байдаг бөгөөд

¹¹ Монгол Улсын Дээд Шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдаанаар 2019 онд хянагдсан захиргааны хэргийн дүн, өөрчлөгдсөн, хүчингүй болсон шийдвэр, магадлалыг судалсан тухай тойм,

¹² Монгол Улсын Дээд Шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдаанаар 2020 онд хянагдсан захиргааны хэргийн дүн, өөрчлөгдсөн, хүчингүй болсон шийдвэр, магадлалыг судалсан тухай тойм, 2021 оны 01 дүгээр сарын 21

уг тохиолдол бүрийг алийг нь ноцтой зөрчих гэж үзэх, алийг нь энгийн зөрчил гэж үзэх нь тодорхой бус байна.

Ийм тодорхой бус нөхцөлөөс үүдэн Шүүхийн сахилгын хороонд аль зөрчлийг ноцтой¹³ гэж үзэх нь тэдний дур зорго болох магадлалтай юм.

Шүүгч нар нь мэргэжлийн түвшинд хууль хэрэглэх чадвартай хэдий ч хэргийн ачааллаас шалтгаалан хуулийн илт тодорхой заалтыг зөрчих явдал цөөнгүй байдаг. Жишээ нь Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн нэг шүүгчийн ажиллагаанд 180 иргэний хэрэг хянагдаж, жилд 400 орчим хэрэг шийдвэрлэж, 2000 захирамж, тогтоол гаргаж байгаа нөхцөлд процессын алдаа гарах нь цөөнгүй тохиолдоно.

Мөн, процессын хууль нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг тогтоож өгдөг тул шат шатны шүүх нэг байдлаар ойлгож хэрэглэх нь чухал ач холбогдолтой. Гэтэл, шат шатны шүүхийн процессын хуулийн өөр өөрөөр тайлбарлан хэрэглэж байгаа, зарим тохиолдолд нэг шүүхэд 2 өөр процесс хэрэгжиж байгаа нь нууц биш юм. Жишээлбэл, нэг шүүхэд зарим шүүгч нь гомдол гаргах эрхтэй захирамж гаргах хүсэлтийг хангаагүй тохиолдолд үр дагавар үүсээгүй гэж үзээд гомдол гаргах эрхгүй захирамж гаргадаг, гэтэл зарим шүүгч нар хүсэлтийг хангаж шийдвэрлээгүй атлаа гомдол гаргах эрхийг хангадаг зөрүүтэй практик байна.

Хяналтын шатны шүүх хэрэг маргааныг хэлэлцэхгүйгээр буцаадаг тогтолцоо бүрдсэн цагаас хойш буюу 2021 оны 3 дугаар сарын 01-ний өдрөөс хойш нийт хяналтын журмаар гомдол гаргасан хэргийн 98 хувийг буцаасан бөгөөд Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүх 2021 онд нийт 1819 хэрэг шийдвэрлэснээс 397 иргэний хэргийг хүчингүй болгож дахин шийдвэрлүүлэхээр буцаасан байна. Анхан шатны шүүхийн шүүгч нар 397 удаа процессын алдаа гаргаж, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн илт тодорхой заалтыг ноцтой, эсхүл удаа дараа зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүй гаргасан гэж үзэхээр байна.

Цаашид Улсын дээл шүүхээс Шүүхийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1.23-д “хуулийн илт тодорхой заалтыг ноцтой, эсхүл удаа дараа зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүй гаргах” гэх заалтыг нэн даруй тайлбарлахгүй бол анхан шатны шүүхийн шүүгч нар бүгд хуулийн илт тодорхой заалтыг ноцтой, эсхүл удаа дараа зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүй гаргах сахилгын зөрчил гаргаж, бүгд сургалтад сууж, уг хугацаагаар эрх нь түдгэлзэх хууль зүйн үр дагавар бий болох магадлал өндөр байна.

Хоёр: Шүүхийн шийдвэрт үндэслэл огт бичээгүй нь дээд шатны шүүхээр тогтоогдсон.

Шүүхийн шийдвэр нь шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч эрх бүхий төрийн байгууллагаас гаргадаг, эрх зүйн харилцааг тодорхойлох, түүнийг зохицуулсан хэм хэмжээг хэрэглэх хэлбэрээр тухайн хэрэг маргаанд хамааралтай этгээдэд хуулиар тодорхойлогдсон төрийн хүсэл зоригийг илэрхийлдэг нэг бүрчилсэн акт бөгөөд зөрчигдсөн буюу маргаантай эрхийг

¹³ Ноцтой гэх үг нь Монгол хэлэнд “оноцтой, ончтой, сүрхий, онцгой шинжтэй” гэх утгыг илэрхийлнэ./ Толь. Query.mn /

сэргээхээс гадна, нийт иргэдэд хүмүүжлийн нөлөө үзүүлэх зорилготой.¹⁴

Шүүхийн шийдвэр заавал биелэгдэх (Enforceability of judicial decision, исполнимость судебного решения)¹⁵ хууль зүйн агуулга нь шүүхийн шийдвэрийн үндэслэл тодорхой байх нэг шаардлага тавигдах гол шаардлагын нэг бөгөөд шүүхийн шийдвэрийн үндэслэл тодорхой байж, иргэдэд ойлгомжтой, хууль зүйн үндэслэлтэй байх нь чухал юм.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 118 дугаар зүйлийн 118.4-д “Үндэслэх хэсэгт хэрэгт байгаа болон шүүх хуралдаанаар хэлэлцэгдэж, хэргийг хянан шийдвэрлэхэд үндэс болсон нотлох баримтын хууль зүйн болон бодит үндэслэл, түүнийг шүүхээс хэрхэн үнэлж байгаа тухай заана.” гэж заажээ.¹⁶

Нотлох баримтын үнэлгээ бол шүүхийн шийдвэрийн үндэслэх хэсгийн амин чухал хэсэг юм.¹⁷ Шийдвэрийн үндэслэх хэсэгт шүүхийн шийдвэрийн үндэслэл болж буй нотлох баримтуудын хууль зүйн болон бодит үндэслэлийг зааж, тэдгээрийн талаар шүүхийн хийж буй дүгнэлтийг тусгана.

Шийдвэрийн үндэслэх хэсэг нь шүүхээр хэлэлцэгдэж буй эрх зүйн маргааны талаар шүүх ямар дүгнэлт гаргаж байгаа, энэхүү дүгнэлт нь ямар бодит нөхцөл байдалд тулгуурлаж, хуулийн ямар зүйл, заалтад үндэслэсэн гэдгийг илэрхийлдэг тул чухал ач холбогдолтой юм.¹⁸ Шүүхэд гаргаагүй шаардлага, үндэслэлийн талаар шүүх дүгнэлт хийх эрхгүйн зэрэгцээ шаардлагын үндэслэл, зүйлээс өөр үндэслэл, зүйлийг шийдвэрлэх, шаардлагын хэмжээнээс илүү хэмжээгээр шийдвэр гаргах эрх шүүхэд байхгүй болно.¹⁹

Шүүхийн дүгнэлт нь зөвхөн хуулиар зөвшөөрөгдсөн, хэрэгт хамааралтай, шүүх хуралдаанаар хянан хэлэлцэгдсэн нотлох баримтад тулгуурласан байх учиртай бөгөөд нотлох баримтаар тогтоогдоогүй үйл баримтыг шүүх тогтоогдсон гэж үзэх, хэрэгт цугларсан баримтаар хангалттай бүрэн тогтоогдсон үйл баримтыг тогтоогдоогүй гэж үзэх нь шийдвэрийн үндэслэл бүхий байх хуулийн шаардлагыг зөрчиж буй явдал мөн.

Хэргийн талаар шийдвэр гаргах үед шүүхээс хийсэн бүх дүгнэлт шийдвэрийн гол үндэслэл болох шүүх хэргийн материалд тулгуурлан нотлох баримтуудын хоорондын зөрөөг шүүх илрүүлсэн буюу шүүх бусад нотлох баримтад үндэслэн шийдвэр гаргах онцгой ач холбогдолтой.²⁰

Шүүхийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1.27-д “шүүхийн

¹⁴ Монгол Улсын Дээд шүүхийн тогтоол. 2006.04.24.//Дээд шүүхийн тогтоолыг эмхтгэл. УБ. 2015 он. XXX тал.

¹⁵ С.Нарангэрэл. Эрх зүйн эх толь бичиг. 2007 он. 583 дахь тал

¹⁶ Монгол Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль. 2002.01.10 //Төрийн мэдээлэл. 2002. №8.

¹⁷ Иоахим Кают, “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй”, УБ., 2015 он. 209 дэх тал.

¹⁸ <http://www.supremecourt.mn/act/view/145>

¹⁹ Ц.Амарсайхан нарын хамтын бүтээл. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн тайлбар. УБ., 2014. 314 дахь тал.

²⁰ Н.Чинбат нарын хамтын бүтээл. БНМАУ-ын иргэний байцаан шийтгэх хуулийн тайлбар, УБ., 1984 он. 163 дахь тал

шийдвэрт үндэслэл огт бичээгүй нь дээд шатны шүүхээр тогтоогдсон” гэж заажээ.

Шүүхийн шийдвэрийн цахим санд байршсан иргэний хэргийн 500 шүүхийн шийдвэрт түүврийн аргаар анализ хийж үзэхэд үндэслэл огт бичээгүй шүүхийн шийдвэр байхгүй бөгөөд иргэний хэргийн хувьд үндэслэл огт бичээгүй шийдвэр гэж шүүхийн шийдвэрийн үндэслэх хэсэгт үндэслэл дурдаагүй шийдвэрийг ойлгоно. Гэтэл Улсын дээд шүүхийн хяналтын шатны шүүх хуралдаанаас анхан шатны шүүхийн шийдвэрт үндэслэл бичээгүй гэх үндэслэлээр 2 иргэний хэрэг хүчингүй болсон байна.²¹

Шүүхийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1.27-д “шүүхийн шийдвэрт үндэслэл огт бичээгүй нь дээд шатны шүүхээр тогтоогдсон” гэх хуулийн зохицуулалт нь хууль зүйн техникийн хувьд алдаатай байх бөгөөд шүүхийн шийдвэрт үндэслэл огт бичээгүй нь дээд шатны шүүхээр тогтоогдсон гэх нь үндэслэл огт бичээгүй үйл баримт юм.

Шүүх шийдвэрийн үндэслэх хэсэгт нэхэмжлэлийн шаардлага тус бүрийн талаар дүгнэлт өгөх үүрэгтэй ба хариуцагчаас гарсан шаардлагыг сөрөг нэхэмжлэл, гуравдагч этгээдийн бие даасан шаардлагын талаар тус тусд нь дүгнэсэн байвал зохино. Огт дүгнээгүй гэдгийг шаардлага тус бүрт дүгнэлт өгөөгүй гэж ойлгох уу, эсхүл дутуу дүгнэсэн гэж ойлгох уу гэдэг нь дээд шатны шүүхийн эрх хэмжээний асуудал юм.

Шүүхийн шийдвэрийн үндэслэлийг огт бичээгүй бол зөвтгөх үндэслэл байхгүй бөгөөд хэрэв шаардлага тус бүрт, эсхүл дүгнэлт дутуу өгсөн гэх үндэслэлээр шүүхийн шийдвэрт үндэслэл огт бичээгүй гэж үзэх юм бол шат шатны шүүхийн бие даасан байдал давхар яригдах юм.

Шүүх эрх мэдлийг шүүх бүр бие даан хэрэгжүүлдэг. Сумын болон сум дундын шүүх гэхэд л аймгийн шүүхийн гүйцэтгэгч биш, харин хэрэг маргааныг хэнээр ч заалгахгүй, хэнд ч захирагдахгүйгээр хуульд зааснаар эцэслэн шийдвэрлэнэ. Ийнхүү шүүхүүд хуулиар хуваарилагдсан шүүх эрх мэдлийг тус тусдаа бие даан хэрэгжүүлдэг нь төрийн эрх мэдлийн нөгөө хоёр салаанаас түүний ялгарах гол онцлог бөгөөд бие даасан байх зайлшгүй байдлын /жам ёсны/ үндэс болдог.²²

Хэрэв, шүүхийн шийдвэрийн үндэслэлийн дутуу бичсэн, мөн шаардлага бүрт дутуу дүгнэлт өгсөн гэж дээд шатны шүүх үзэх нь шат шатны шүүхийн бие даасан байдал алдагдах, материаллаг хуулийн хэрэглээ болон үйл баримтын дүгнэлтийг дээд шатны шүүхийн таалалд нийцүүлэн дүгнэхээс өөр аргагүй болох магадлал өндөр юм. Шүүхийн шинэчлэл 2013 онд эхлэхээс өмнө шалган туслах гэж шат шатны шүүхүүд нэг нэгэндээ нөлөөлдөг явдлыг таслан зогсоосон нь өндөр ач холбогдолтой байсан бөгөөд хэрэв процессын алдаагаар шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, дахин шийдвэрлүүлэхээр буцаах бүрт үндэслэлийг дутуу бичсэн, дүгнээгүй гэх өгүүлбэр орсон тохиолдолд сахилгын зөрчил болох бөгөөд энэ нь шинэчлэл бус шийтгэл болох магадлалтай байна.

²¹ Монгол Улсын Дээд Шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдаанаар 2020 онд хянагдсан захиргааны хэргийн дүн, өөрчлөгдсөн, хүчингүй болсон шийдвэр, магадлалыг судалсан тухай тойм, 2021 оны 01 дүгээр сарын 21

²² Б.Чимэд, Үндсэн хуулийн үзэл баримтлал. УБ., 264 дэх тал.

Шүүхийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1.27-д “шүүхийн шийдвэрт үндэслэл огт бичээгүй нь дээд шатны шүүхээр тогтоогдсон” гэх заалтыг хэрхэн ойлгож хэрэглэх талаар Улсын дээд шүүхээс тайлбарлах, эсхүл хуулийг үгийн шууд утгаар тайлбарлан хэрэглэх зарчмын дагуу үндэслэл огт бичээгүй тохиолдолд 6 сарын цалингийн 20 хувиар хасах, 3 сар түдгэлзүүлж, сургалтад суухыг даалгах, огцруулах шийтгэл ногдуулж болох юм.

Гурав: Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийн агуулгыг дүгнээгүй бол сахилгын зөрчилд тооцох асуудал

Үндсэн хуулийн Тавин хоёрдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Анхан шатны шүүх хэрэг, маргааныг хамтран шийдвэрлэхдээ иргэдийн төлөөлөгчдийг хуульд заасан журмын дагуу оролцуулна.” гэж заасны бодитоор хэрэгжүүлэхийн тулд шүүхийн шинэчлэлтэй зэрэгцэж шүүх дэх иргэдийн оролцоо, хяналтыг нэмэгдүүлэхийн тулд шүүхийн шийдвэрт иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийг шүүх заавал анхааран үзэх асуудалд шүүхийн тухай хуулийн шинэчлэлийн зорилго чиглэсэн.

Шүүхийн иргэдийн төлөөлөгчдийн эрх зүйн байдлыг тусгаж, анхан шатны шүүх хэрэг маргааныг хамтын зарчмаар шийдвэрлэхдээ шүүх хуралдаанд оролцох иргэдийн хяналтыг сайжруулах, оролцоо үр нөлөөг нэмэгдүүлэх үүднээс иргэдийн төлөөлөгчдийн тоог нэмэх, шүүхийн шийдвэр болон иргэдийн төлөөлөгчийн гаргасан шийдвэр ялгаатай нэрлэгдэж байгааг нэг мөр болгох²³ зорилгоор шүүхийн шийдвэрт иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийн агуулгыг шүүхийн шийдвэрийн тодорхойлох хэсэгт бичиж, уг дүгнэлтийн талаарх үндэслэлээ үндэслэх хэсэгт тодорхой тусгахаар Шүүхийн тухай хуулийн үзэл баримтлалд тусгасан байна.

Өнөөдөр иргэдийн төлөөлөгчийн оролцоо нь хэлбэрийн төдий байгаа бөгөөд хамтын зарчмаар шийдвэрлэсэн 218 шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийж үзэхэд 19 шийдвэрт иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийг шүүхийн шийдвэрийн тодорхойлох болон үндэслэх хэсэгт дүгнэсэн нь учир дутагдалтай төдийгүй Үндсэн хуулийн үзэл баримтлалыг хэлбэрийн төдий оролцоо, ач холбогдолгүй байдал болгож байгаа нь учир дутагдалтай юм.

Шүүхийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1.40. “энэ хуулийн 66.7-д²⁴ заасныг биелүүлээгүй бол сануулах сахилгын шийтгэл ногдуулахаар хуульчилсан бөгөөд Шүүхийн тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.7-д “Шүүх бүрэлдэхүүн иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийн агуулгыг шүүхийн шийдвэрийн тодорхойлох хэсэгт бичиж, уг дүгнэлтийн талаарх үндэслэлээ үндэслэх хэсэгт тодорхой тусгана” гэж иргэдийн төлөөлөгчийн оролцоо, ач холбогдлыг үнэгүйдүүлсэн тохиолдлыг шүүгчийн ёс зүйтэй холбосон Үндсэн хуулийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх ач холбогдол бүхий шинэлэг зохицуулалт болжээ.

Харьцуулсан эрх зүй судлал бусад улс оронд нийтлэгээр шүүх ажиллагаан дахь иргэдийн оролцооны “jury” буюу тангарагтны шүүгчид,

²³ <https://mglbar.mn/storage/files/u8aGyWpcxKotpqAJ9s64zYxQIWVdkSBEdVEBUqYP.pdf>

²⁴ Шүүхийн тухай хууль. 2021.01.15. //Төрийн мэдээлэл. 2021. №5.

“lay judge” буюу мэргэжлийн бус шүүгч гэсэн хоёр загвар байгаа гэж үздэг. Тангарагтны шүүх нь тодорхой тооны иргэд шүүгчийн оролцоогүй хэргийг үйл баримт буюу гэм буруугийн хувьд шийдвэрлэдэг бол мэргэжлийн бус шүүгч нь мэргэжлийн шүүгч нартай хамтран гэм буруугийн болон бусад асуудлаар шийдвэр гаргахад оролцдог ялгаатай.²⁵

Шүүхийн иргэдийн төлөөлөгчдийн эрх үүргийг дэлхийн улс орнуудад өргөжүүлж байгаа нь нийтийн үйл хэрэгт иргэдийн оролцоог хангах нэг хэлбэр болоод зогсохгүй, шүүхийн шийдвэр жирийн иргэдийн шударга ёсны төсөөлөлд тулгуурласан оюун санаагаар шүүгчдэж, нийгмийн шударга ёсны ойлголттой нийцэх боломжийг шүүхэд олгодог ач холбогдолтой механизм гэдгийг дэлхий нийтээр хүлээн зөвшөөрч байна.

Улсын хэмжээнд 2020 онд анхан шатны шүүхэд шүүх бүрэлдэхүүнтэйгээр шийдвэрлэсэн нийт 2035 шүүх хуралдаанд 2066 иргэдийн төлөөлөгч оролцжээ. Иргэдийн төлөөлөгч оролцсон шүүх хуралдааны 1077 буюу 52.9 хувь нь эрүүгийн, 782 буюу 38.5 хувь нь иргэний, 176 буюу 8.6 хувь нь захиргааны хэргийн шүүхийн шүүх хуралдаан байна.²⁶

Иргэдийн төлөөлөгчийн оролцоо мөн мэргэжлийн боловсролгүй энгийн иргэд ч тухайн нийгэмдээ зөв буруу, шударга, шударга бусыг таньж ойлгох чадавхтай болохыг илэрхийлдэг боловч өнөөдөр тохиолдлоор сонгогдсон иргэдийн төлөөлөгч нь бичиг үсэг мэдэхгүй, маргааны үйл баримтыг ойлгохгүй, иргэдийн төлөөлөгчийн ач холбогдол үр нөлөөний талаар ойлголт муутай байгаагаас дүгнэлт гаргах боломжгүй байна. Жишээлбэл, хэргийн үйл баримтыг ойлгохгүй байгаагаас дүгнэлт гаргах боломжгүй буюу хэлэх зүйл алга, ойлгохгүй байна, шүүх шийднэ биз, хэнийг нь буруутайг ялгах боломжгүй байх гэх дүгнэлт зонхилж байгаа нь шүүх дүгнэх боломжгүй нөхцөл байдлыг үүсгэж байна.

Мөн шүүхийн иргэдийн төлөөлөгчийн хөлс хэт бага байгаагаас шүүхэд ирэх идэвх санаачлага бага байгаа, мөн шүүх хуралдаан олон удаа хойшилдог тул залхах зэрэг шалтгаанаар шүүхэд ирэхгүй байх нь энгийн тохиолдол болсон.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 100 дугаар зүйлийн 100.8-д зааснаар Томилогдсон иргэдийн төлөөлөгч энэ хуулийн 76.1.2-т заасны дагуу мэдэгдсээр байхад хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр шүүх хуралдаанд ирээгүй бол зохигчийн зөвшөөрлөөр түүний эзгүйд шүүх хуралдаан явуулж болно. Харин зохигчийн аль нэг нь үүнийг зөвшөөрөөгүй бол шүүх хуралдааныг хойшлуулах зохицуулалт нь нийтлэг хэрэглэгдэх бөгөөд 2021 онд Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх хуралдаанд иргэдийн төлөөлөгч ирээгүй гэх шалтгаанаас 41 удаа хурал хойшилж, 29 шүүх хуралдаанд иргэдийн төлөөлөгч оролцоогүй байна.

Ихэнх тохиолдолд иргэдийн төлөөлөгч хэргийн материалтай танилцахаас татгалзах, мөн шүүх хуралдаанд цаг тулгаж ирэх зэрэг олон бэрхшээл байгаа нь эцсийн дүндээ иргэдийн төлөөлөгч өөрийн эрх үүргээ

²⁵ <https://old.legalinfo.mn/law/details/9642?lawid=9642>

²⁶ Шүүхийн Ерөнхий зөвлөл, Шүүхийн тайлан, 2021 он, УБ., 22 дахь тал.

ойлгохгүй байгаатай шууд холбоотой.

Иймд, Үндсэн хуулийн үзэл баримтлалын дагуу иргэдийн төлөөлөгчийн үүргийг нэмэгдүүлж, шүүгчийн ёс зүйтэй холбож байгаа өнөө үед шүүхээс иргэдийн төлөөлөгчийн идэвх оролцоог нэмэгдүүлэхийн тулд сургалт зохион байгуулж, шүүх хуралдаанд суусан болон ирэх-буцах хугацааны зардлыг бүрэн хариуцах зэрэг эдийн засаг-зохион байгуулалтын арга хэмжээг авахгүй бол дүгнэх боломжгүй, тодорхойлох хэсэгт орох боломжгүй дүгнэлт гаргадгаас шүүгчийн ёс зүйтэй холбоотой асуудал яригдах нь шударга ёсонд нийцэхгүй юм.

Шүүхийн үйл ажиллагаанд мэргэжлийн түвшин үр нөлөөг дээшлүүлж эцсийн дүнд шударга ёс ялж байх ёстойгоос бус иргэдийн оролцоог хязгаарлах, хялбарчлан бүдүүвчлэх нь буруу бөгөөд ялангуяа шүүгч дангаар шийдвэрлэх практикийг хэт өргөжүүлж болохгүй билээ.²⁷

Эцэст нь дүгнэхэд дээрх гурван зохицуулалттай холбоотой тайлбар хийх, мөн эрх зүй-зохион байгуулалтын арга хэмжээг авахгүй бол хэрэгжих боломжгүй болох нь өнөөгийн шүүхийн практик, хуулийн найруулга зүйгээс шууд харагдаж байна.

²⁷ Б.Чимэд, Үндсэн хуулийн үзэл баримтлал. УБ., 264 дэх тал.

ОЮУТНЫ САЛБАРТ ШАЛГАРСАН ИЛТГЭЛ

Хууль зүйн үндэсний хүрээлэн
www.nli.gov.mn

Хууль зүйн үндэсний хүрээлэн
www.nli.gov.mn



Равданбямба ОЮУНДЭЛГЭР

МУИС-Хууль зүйн сургууль-Солонгосын эрх зүйн тэнхим V дугаар түвшний оюутан (тэргүүн байр)

**МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ
МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ЭРХ ЗҮЙН ХӨГЖИЛД ҮР НӨЛӨӨ
БҮХИЙ ШИЙДВЭР ГАРГАХ ЧИГ ҮҮРЭГТ ТУЛГАРЧ БУЙ СОРИЛТ БА
БОЛОМЖ**

ХУРААНГУЙ:

Монгол Улсын Үндсэн хуулийн тавьдугаар зүйлийн 50.1 дэх хэсэгт “Монгол Улсын дээд шүүх бол шүүхийн дээд байгууллага мөн бөгөөд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэсний дотор 50.1.2 дахь хэсэгт “... хяналтын журмаар доод шатны шүүхийн шийдвэрийг хянан үзэх”, 50.1.4 дэх хэсэгт “Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах” гэж тус тус заасан. Ийнхүү зохицуулсан нь Монгол Улсын Дээд шүүх хяналтын журмаар эрх зүйн маргааныг хянан хэлэлцэх замаар¹ нэг талаар хүний эрх, эрх чөлөөг хамгаалж, зөрчигдсөн эрхийг сэргээх, нөгөө талаар шүүхийн дээд байгууллага болохын хувьд хэрэг маргаан шийдвэрлэсэн тогтоол, албан ёсны тайлбараараа дамжуулан шүүхийн тогтолцоонд хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах, хуулийг хөгжүүлэх, эрх зүйн тогтолцоонд үр нөлөө бүхий шийдвэр гаргах чиг үүрэгтэй болохыг Үндсэн хуулиар баталгаажуулжээ.

2021 онд батлагдсан Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7.5 дахь хэсэгт Дээд шүүхийн зорилгыг “хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах” гээд, түүнтэй холбогдуулан хяналтын журмаар гомдол гаргах “1) анхан болон давж заалдах шатны шүүх хуулийг зөрүүтэй хэрэглэсэн, 2) шүүх хуулийг улсын дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр хэрэглэсэн, 3) хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ноцтой зөрчил гаргасан нь шүүхийн шийдвэрт нөлөөлсөн” зэрэг үндэслэлийг хуульчилсан. Мөн тэдгээрийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль болон Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн холбогдох хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулах байдлаар тусгасан.

¹ Б.Чимид, Үндсэн хуулийн үзэл баримтлал (Илтгэл, өгүүлэл, ярилцлага, дурсамж), УБ., 2002, 116 дахь тал

Энэхүү судалгааны ажлаар Дээд шүүхийн Үндсэн хуульчлагдсан үүрэг, түүний онолын үзэл баримтлалыг хөндөж, Монгол Улсын шүүхийн тухай хуулиар зохицуулсан Дээд шүүхийн зорилго, чиг үүрэг болон хяналтын журмаар гомдол гаргах үндэслэлүүд нь Дээд шүүхийн хуулийг хөгжүүлэх, эрх зүйн тогтолцоонд үр нөлөө бүхий шийдвэр гаргах чиг үүргийг орхигдуулсан явдалд асуудал дэвшүүлнэ. Харьцуулсан судалгааны хэсэгт эх газрын эрх зүйн бүлийн томоохон төлөөлөгчид болох Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Австри Улс болон Бүгд Найрамдах Солонгос Улсуудтай харьцуулан, судалгааны дүгнэлт саналаа хүргүүллээ.

ТҮЛХҮҮР ҮГ:

Дээд шүүхийн Үндсэн хуульчлагдсан үүрэг, хуулийн нэгдмэл байдлыг хангах, хуулийг хөгжүүлэх, эрх зүйн тогтолцоонд үр нөлөө бүхий шийдвэр гаргах, эрх зүйн харилцааг боловсронгуй болгох, гомдлын хязгаарлалт, гомдол гаргах үндэслэл, сонгох шалгуур, шүүхийн активизм, хууль тайлбарлах, хууль тайлбарлах эрх, динамик тайлбар, статик тайлбар

I. ОРШИЛ

Монгол Улсын Үндсэн хуульд Улсын дээд шүүхийг “шүүхийн дээд байгууллага мөн”² бөгөөд “хяналтын журмаар хянан үзэх”,³ “Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах”⁴ бүрэн эрхтэй гэж заасан. Онолын үүднээс Дээд шүүх хэрэг хянан шийдвэрлэх замаар хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангаж,⁵ хуулийг хөгжүүлэх буюу эрх зүйн тогтолцоонд үр нөлөө бүхий шийдвэр гаргах чиг үүргийг хэрэгжүүлж байдаг.

Монгол Улсын хувьд 2021 онд батлагдсан Шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7.5 дахь хэсэгт анх удаа Дээд шүүхийн зорилгыг “хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах” хэмээн зохицуулж, түүнд нийсэн хяналтын журмаар гомдол гаргах үндэслэлүүдийг хуульчилсан. Гэвч Дээд шүүхийн “хуулийг хөгжүүлэх” буюу эрх зүйн тогтолцоонд үр нөлөө бүхий шийдвэр гаргах, хуулийг боловсронгуй болгох чухал чиг үүргийг зохицуулаагүй орхигдуулсан бөгөөд тийнхүү хяналтын журмаар гомдол гаргах үндэслэлийг хуульчлаагүй байна. Иймээс энэхүү судалгааны ажилд, Дээд шүүхийн хуулийг хөгжүүлэх чиг үүргийг хуульчлаагүй буюу түүнтэй холбогдох хяналтын журмаар гомдол гаргах үндэслэл байхгүй байгаа нь (1) Дээд шүүхийн хууль хөгжүүлэх, эрх зүйн тогтолцоонд үр нөлөө бүхий шийдвэр гаргах боломж, (2) шүүхэд хандах эрх, (3) дээд

² Үндсэн хуулийн тавьдугаар зүйлийн 50.1 дэх хэсэг

³ Үндсэн хуулийн тавьдугаар зүйлийн 50.1.2 дахь хэсэг

⁴ Үндсэн хуулийн тавьдугаар зүйлийн 50.1.4 дэх хэсэг

⁵ Хуулийн нэгдмэл хэрэглээ гэдэг нь хууль ямар ч тохиолдол ижил үйлчлэх тухай ойлголт юм. Эрх зүйт төрд хууль ижил, төстэй тохиолдолд өмнөх шийдвэрийн адил үйлчилж, иргэд хуулийн үр дагаврыг урьдчилж таамаглах боломжтой болно. Цаашлаад иргэдийн шүүхэд шударгаар шүүлгэх, шүүхэд итгэх итгэлийг нэмэгдүүлдэг. [Source: Ottavia Dora Lo Sardo, The role of Supreme Courts in the uniform application of law, p86]

шүүхийн хууль тайлбарлах эрхийг тус тус хязгаарласан зэрэгт асуудал дэвшүүлэх болно.

II. ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Шүүх нь нийгэмд болсон маргаан зөрчилдөөнийг хянан үзэж түүнд хуулийн мэргэжлийн үүднээс тайлбарлан хэрэглэж эрх зүйн шийдэл гаргадаг.⁶ Шүүх оршдог, шүүхийн гол гавьяа нь үзэл санааны зөрөө гарах үед түүнээс зайлсхийх боломж олгох юм. Ноцтой асуудал үүсэхэд шүүх нь урд өмнө огт боломжгүй гэж үзэж байсан тэр чиглэлд анхны алхам хийх шаардлагатай болдог. Энэ механизм нь нийгмийн дэг журам, амгалан тайван байдлыг тогтооход зайлшгүй шаардлагатай.⁷

2.1. Монгол Улсын Дээд шүүх шүүхийн дээд байгууллага болох нь

Монгол Улсын Үндсэн хуулийн тавьдугаар зүйлийн 50.1 дэх хэсэгт “Монгол Улсын дээд шүүх бол шүүхийн дээд байгууллага мөн” гэж томъёолсон. Өмнө нь Улсын шүүн таслах дээд газар нь нийтлэг байдлаар “Бүгд гишүүдийн хурал” хэмээх зохион байгуулалтаар аливаа асуудлыг шийдвэрлэх, бусад шүүн таслах газруудын хэргийг хянах, улмаар захиргааны дээд байгууллагын хувьд шууд удирдах байдлаар үйл ажиллагаагаа хэрэгжүүлж ирсэн.⁸ Харин өдгөө онолын үүднээс шүүх эрх мэдлийн дээд байгууллага гэх Дээд шүүхийн онцлогийг хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах, шүүхийн тогтолцоонд эрх зүйн ач холбогдолтой маргааныг шийдвэрлэх замаар хуулийн хөгжилд хувь нэмэр оруулах боломжтой⁹ этгээд гэдэгтэй шууд нь холбож үздэг.

2.2. Монгол Улсын Дээд шүүхийн хянан шийдвэрлэх чиг үүрэг

Үндсэн хуулийн тавьдугаар зүйлийн 50.1.2 дахь хэсэгт Дээд шүүхийн бүрэн эрхийг тусгахдаа “... хяналтын журмаар доод шатны шүүхийн шийдвэрийг хянан үзэх” гэж заасан. Дээд шүүх хяналтын журмаар гомдол хянан хэлэлцэхдээ бүх гомдлыг хэлбэрэлтгүй хүлээн авах бус тодорхой үндэслэл, шалгуурт нийцсэн гомдлыг хүлээн авдаг болж хөгжжээ.¹⁰ Ач холбогдолтой гомдлыг сонгон хянан боломжийг хяналтын шүүлтүүр (filtration to the appeal) бүрдүүлж өгдөг.¹¹ Иймд улс

⁶ Б.Чимид, Үндсэн хуулийн үзэл баримтлал (Илтгэл, өгүүлэл, ярилцлага, дурсамж), 118 дахь тал

⁷ Чикагийн их сургуулийн профессор Леви Эдвардын хэлсэн үг. [Ж.Амарсанаа нар, Монгол Улсын Дээд шүүхийн тогтоолын эмхтгэл (1959-2010), Хоёр дахь хэвлэлт (Шүүхийн ерөнхий зөвлөл, 2015)] 37 дахь тал

⁸ А.Бямбажаргал, Улсын Дээд шүүхийн чиг үүргийн талаар харьцуулсан шинжилгээ, Хууль дээдлэх ёс сэтгүүл, 2020 оны №4 дугаар, 115 дахь тал

⁹ Jelena Ristik, The role of the Supreme Court in ensuring uniformity of court practice in the Republic of Macedonia, 2017, p.61

¹⁰ Р.Оюундэлгэр, Улсын Дээд шүүхийн хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах чиг үүрэг ба хяналтын журмаар гаргах гомдолд хязгаарлалт тавих асуудал, түүний учир холбогдол, Шүүх эрх мэдэл эмхэтгэл, 2021оны №3 дугаар, 142 дахь тал

¹¹ Европын холбооны гишүүн улсуудын Дээд шүүхэд хяналтын журмаар гаргах гомдолд тавигдах шүүлтүүрийг дараах загварууд (model of filtering appeals) байдаг. Үүнд (1) The leave-to-appeal system:

орнууд Дээд шүүхийнхээ зорилготой уялдуулан хяналтын журмаар гаргах гомдлын үндэслэлийг хуульчилдаг. Ийнхүү бүх гомдлыг хянан хэлэлцэх бус хязгаарлалт тогтоож, ач холбогдолтой¹² гэж үзсэн гомдлыг хүлээн авч буй механизмын гол зорилго нь Дээд шүүх хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах, хуулийг хөгжүүлэх зорилгыг хэрэгжүүлэхтэй салшгүй холбоотой.¹³

Иймд Монгол Улсын Дээд шүүхийн хувьд (1) Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээх¹⁴ буюу (2) хувь хэргүүдийг шийдвэрлэсэн шийдвэрүүдээрээ улсынхаа нутаг дэвсгэрт хэргийн эрх зүйн туйлбартай байдал,¹⁵ хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангаж, эрх зүйн тогтолцоонд үр нөлөө бүхий шийдвэр гаргах хосолмол чиг үүргийг хэрэгжүүлэх субъект юм.

2.3. Монгол Улсын Дээд шүүхийн албан ёсны тайлбар

Хуулийн тайлбар нь хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль, эрх зүйн актын хамт эрх зүйн эх сурвалж болохын зэрэгцээ хуульчдын онолын мэдлэгийг дээшлүүлэх, хууль зүйн шинжлэх ухааныг хөгжүүлэх, хууль зүйн боловсролын агуулгад ихээхэн хувь нэмэр¹⁶ болдог. Монгол Улсын Үндсэн хуулийн тавьдугаар зүйлийн 50.1.4 дэх хэсэгт Дээд шүүхийн бүрэн эрхийг “Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах” гэж хуульчилсан. Түүхэн хөгжлийн явцад Монгол Улсын Дээд шүүх норматив тайлбарыг хийж ирсэн¹⁷ бол 2012 онд батлагдсан “Монгол Улсын Шүүхийн тухай хууль”-ийн 17 дугаар зүйлийн 17.3.1 дэх хэсэгт зааснаар Улсын Дээд шүүх “Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбарыг тодорхой хэрэг маргааныг шийдвэрлэх замаар гаргах ...” бүрэн эрхийг олгосон. Энэ нь хуулийг хэрэглэх явцад бус, харин хэрэглэхээс нь өмнө угтан тайлбарлаж, эрх зүйн харилцааг боловсронгуй болгох бус, харин хууль тогтоох эрх мэдлийн “дутааг дүүргэж, дундуурыг гүйцээдэг” мини парламентын өнөөгийн чиг үүргээс татгалзах эрх зүйн үндсийг бүрдүүлсэн.¹⁸ Гэвч Монгол Улсын

Их Британи, Ирланд, Норвеги, Дани, Швед улсуудад Дээд шүүхэд хяналтын гомдлыг хүлээн авахдаа сонгох (pre-selection) буюу сонгон шалгаруулах (selection principle) зарчмыг баримталдаг. Ийнхүү нийтийн зорилгыг хангах (a matter of general importance or the interests of justice) Дээд шүүхээр зайлшгүй хэлэлцүүлэгдэх ёстой асуудлыг хийсвэр шалгуураар (abstract prevaia) дамжуулан сонгож авдаг. (2) Stricto sensu: Франц, Бельги, Нидерланд, Эстони, Испани, Грек, Италид байдаг ба хяналтын гомдлыг хуулиар тогтоосон шаардлагад нийцсэн тусгай хууль гаргах ёстой. (3) Mixed model- Аль алиных нь шинжийг агуулсан холимог загвар.

¹² Maarteen Feteris (President of the Supreme Court of the Netherlands), Development of the Law by Supreme Court in Europe, Utrecht Law Review Volume 13, Issue 1, 2017, p156

¹³ Arnfinn Bardsen (The Norwegian Supreme Court Justice), Deciding what to decide: The filtering mechanism in the Norwegian Supreme Court, 2018, p4

¹⁴ Г.Совд, Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар, УБ., 2000, 217 дахь тал

¹⁵ Мөнхсайхан, Шүүхийн тухай хуулийн төслийн хүрээнд шүүхийн хараат бус, хариуцлагатай байдлыг хангах нь, Хууль дээдлэх ёс. сэтгүүл, 2020 оны №4 дугаар, 96 дахь тал

¹⁶ Ж.Амарсанаа нар, Монгол Улсын Дээд шүүхийн тогтоолын эмхтгэл (1959-2010), Хоёр дахь хэвлэлт (Шүүхийн ерөнхий зөвлөл, 2015), 37 дахь тал

¹⁷ А.Бямбажаргал, Улсын Дээд шүүхийн чиг үүргийн талаар харьцуулсан шинжилгээ, 121 дэх тал

¹⁸ Ж.Амарсанаа нар, Монгол Улсын Дээд шүүхийн тогтоолын эмхтгэл (1959-2010), 37 дахь тал

Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 3 дугаар дүгнэлт, 7 дугаар тогтоол¹⁹ гарч «Монгол Улсын шүүхийн тухай хуулиар Улсын дээд шүүхээс хэрэг, маргааныг хянан шийдвэрлээд гаргасан шийдвэрийг хэрхэн албан ёсны тайлбар болох нөхцөл бүрэн, агуулгын хувьд зөрчилдсөн шийдвэр гарсан тохиолдолд хэрхэн шийдвэрлэх нь тодорхойгүй болж» хэмээснээс үүдэн тус заалтыг хүчингүй болгосон юм.

Улмаар 2021 оны Шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8 дахь хэсэгт Улсын дээд шүүх шүүн таслах ажиллагаанаас бусад асуудлаар хэрэгжүүлэх бүрэн эрх гэсний дотор 25.8.4 дахь хэсэгт *“шүүхийн шийдвэр, практикт үндэслэн Монгол Улсын Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбарыг танхимын саналыг үндэслэн гаргах бөгөөд тайлбарыг тогтмол нийтлэх”* гэж зохицуулсан. Шүүхийн хууль хэрэглээний практикийг судлах замаар тайлбар хийх нь зарим талаар шүүх хууль тогтоогч байхаас урьдчилан сэргийлэх нөхцөлийн нэг²⁰ хэдий ч нөгөө талаар Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбарыг нийт шүүгчдийн хуралдаанаар гаргадаг хууч хамаарлыг бүрэн халж чадаагүй байгааг энд онцлох нь зүйтэй. Учир нь Улсын дээд шүүх буюу хяналтын шатны шүүх зөвхөн эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэх чиг үүрэгтэй²¹ тул албан ёсны тайлбарыг тус үүргээс салангид хэрэгжүүлж болохгүй. Нөгөө талаар Дээд шүүх нь танхимд хуваагддаг улсуудад Дээд шүүхийн нийт шүүгчид хуралдах зохион байгуулалт бүхий тогтолцоо үгүй²² юм.

III. АСУУДАЛ ДЭВШҮҮЛЭХ НЬ

Судалгааны энэ хэсэгт Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 25.7.5 дугаар зүйлд тусгагдсан Дээд шүүхийн зорилго болон хяналтын гомдол гаргах үндэслэлд асуудал дэвшүүлж, тэдгээр нь (1) Дээд шүүхийн хууль хөгжүүлэх, эрх зүйн тогтолцоонд үр нөлөө бүхий шийдвэр гаргах боломж, (2) шүүхэд хандах эрх, (3) дээд шүүхийн хууль тайлбарлах эрхийг хязгаарласан эсэх асуудлыг тус тус авч үзлээ.

3.1. Дээд шүүхийн хуулийг хөгжүүлэх, эрх зүйн тогтолцоонд үр нөлөө бүхий шийдвэр гаргах боломж

Дээд шүүх нь зорилгоо хэрэгжүүлэхдээ нийтийн (public)²³ ба хувийн (private)²⁴ хосолмол үүргийг (dual role) гүйцэтгэдэг.²⁵ Өөрөөр хэлбэл, Дээд

¹⁹ ҮХЦ-ийн тогтоол, МУ-ын шүүхийн тухай хуулийн 17 зүйлийн 17.3.1 дэх заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг эцэслэн шийдвэрлэх тухай /Дугаар 07-2015.10.30/

²⁰ А.Бямбажаргал, Улсын Дээд шүүхийн чиг үүргийн талаар харьцуулсан шинжилгээ, 124 дэх тал

²¹ О.Мөнхсайхан, Шүүхийн тухай хуулийн төслийн хүрээнд шүүхийн хараат бус, хариуцлагатай байдлыг хангах нь, 90 дэх тал

²² А.Бямбажаргал, Улсын Дээд шүүхийн чиг үүргийн талаар харьцуулсан шинжилгээ, 122 дахь тал

²³ Дээд шүүх нь хувийн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ зөвхөн тухайн хэргийн оролцогчдын хүрээнд л маргааныг таслан шийддэг, зөрчилдсөн эрхийг сэргээдэг тул тус шийдвэр нь ирээдүйд гарах ижил, төстэй маргаанд жишиг тогтоох, хуулийн хөгжилд хувь нэмэр оруулахад төдийлөн ач холбогдолгүй байдаг.

²⁴ Дээд шүүх шийдвэрээрээ дамжуулан шүүхийн тогтолцоонд жишиг тогтоож, хуулийн нэгдмэл байдлыг хангаж, хөгжүүлж байдаг.

²⁵ Right of access to Supreme Courts in Light of the Guarantees under Article 6.1 of the Convention on Human

шүүх нь хэргийн оролцогчдын эрхийг тухайлсан тохиолдолд хамгаалахын зэрэгцээ хуулийн нэгдмэл байдлыг хангах, хуулийг хөгжүүлэх гэсэн нийтийн зорилгыг хэрэгжүүлдэг парадигмтай²⁶ ба хууль дээдлэх ёсыг бэхжүүлэхэд удаах үүрэг давамгайлдаг²⁷ болох нь улс орнуудын хяналтын гомдол гаргах шүүлтүүрээс тодорхой харагдана.²⁸

Монгол Улсын хувьд 2021 оны Шүүхийн тухай хуульд анх удаа Улсын Дээд шүүхийн зорилгыг “хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах” хэмээн зохицуулж, түүнд үйлчлэх хяналтын журмаар гомдол гаргах “1) анхан болон давж заалдах шатны шүүх хуулийг зөрүүтэй хэрэглэсэн, 2) шүүх хуулийг улсын дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр хэрэглэсэн, 3) хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ноцтой зөрчил гаргасан нь шүүхийн шийдвэрт нөлөөлсөн” зэрэг үндэслэлүүдийг хуульчилсан. Эдгээрээс “Анхан болон давж заалдах шатны шүүх хуулийг зөрүүтэй хэрэглэсэн” болон “Шүүх хуулийг улсын дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр хэрэглэсэн” гэсэн үндэслэлүүд нь хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах зорилгод хамааралтай²⁹ бол удаах үндэслэл нь хэргийн оролцогчдын зөрчигдсөн эрхийг сэргээх зорилготой³⁰ бөгөөд Дээд шүүхийн хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах, хуулийг хөгжүүлэх зорилгод төдийлөн ач холбогдолгүй байна. Ийнхүү хэдийгээр хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах үндэслэлийг хуульчилсан боловч, хуулийг хөгжүүлэх, эрх зүйн тогтолцоонд үр нөлөө бүхий шийдвэр гаргахад түлхэц үзүүлэх үндэслэл хуульчлагдаагүй байна. Тодруулбал, тодорхой нэг хуулийн чухал асуудлыг Дээд шүүх анх удаа хянан хэлэлцэж жишиг тогтоох гэтэл түүнд Дээд шүүхийн тайлбар байхгүй гэдэг үндэслэлээр хяналтын журмаар гаргасан гомдол тус тус зөвшөөрөгдөхгүй байх үр дагавартай.

Европын холбооны гишүүд улсуудад Дээд шүүхийн чиг үүрэг ба хяналтын журмаар гомдол гаргах үндэслэл дараах онцлогтой байдаг.

№	Улс	Онцлог зохицуулалт
1	Австри Улс	Иргэний хэрэгт Дээд шүүх тухайн шийдвэр нь хууль хэрэглээний нэгдмэл, тогтвортой байдал, хуулийн хөгжилд чухал ач холбогдолтой гэж үзвэл гомдлыг хүлээн авдаг.
2	Дани Улс	Хяналтын гомдол зөвшөөрөх зөвлөлөөс тухайн хэрэг, маргааны суурь асуудлыг шалгуур болгодог. Шалгуурт нь Дээд шүүхээс тухайн маргаанаар дамжуулан хуулийн практикийг бий болгох, баталгаажуулах, өөрчлөх эсхүл засах шаардлагатай нөхцөл байдлыг тооцдог.

Rights and Fundamental Freedoms (civil aspect), Croatian International Relations Review - CIRX XXIV (81) 2018, p72 [цаашид “Right of access to Supreme Courts” гэх]

²⁶ The paradigm shift: The “Leave to Appeal System” and Guidance and Developing Law as the Prevailing Tasks of the Supreme Court, p.296

²⁷ Uniform Application of Law and Promotion of its Development as a New Role of Supreme Courts, 310

²⁸ Right of access to Supreme Courts, p73

²⁹ Р.Оюундэлгэр, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 123.2 дахь заалтын хэрэгжих боломж ба хүндрэл (Улсын дээд шүүхээс хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангуулах тухай), Хууль дээдлэх ёс сэтгүүл, 2021 оны №4 дугаар, 6 дахь тал

³⁰ Мөн тэнд

3	Финлянд Улс	Дээд шүүхэд гомдол зөвшөөрөх анхдагч шалгуур нь шүүхийн шийдвэр хуулийг адил, төсөөтэй тохиолдолд хэрэглэх боломжтой байх.
4	ХБНГУ	Шүүх шийдвэрээр дамжуулан хуулийг хөгжүүлэх шаардлага тулгарсан үед Дээд шүүх иргэний хэрэгт гомдол хүлээн авдаг.
5	Швед Улс	Дээд шүүх гомдол хүлээн авах анхдагч шалгуур нь шийдвэр нь доод шатны шүүхүүдэд чиглэмж болох чухал асуудлыг хөндөх ёстой байдаг.
6	Нидерланд Улс	Тус улсад шүүлтүүр бүхий тогтолцоог хуульчлаагүй ч Дээд шүүх нь гомдол сонгох арга барилтай. 1988 оноос хойш ямар нэгэн үр дүнд хүрэхээргүй буюу шийдвэр нь хуулийн нэгдмэл байдал болон хуулийг хөгжилд хамааралгүй тохиолдолд л Дээд шүүх үндэслэлээ тайлбарлахгүйгээр татгалзах боломжтой.

Хүснэгт 3: Дээд шүүхийн чиг үүрэг ба хяналтын журмаар гомдол гаргах үндэслэлтэй холбоотой улс орнуудын зохицуулалтын онцлог

3.2. Шүүхэд хандах эрх

Шүүхэд хандах эрх туйлын эрх (absolute right) биш тул Дээд шүүхэд хандах эрхийг хязгаарлахдаа улс орнууд загвар, процедураасаа хамааран өөр өөр хязгаарлалтыг тогтоодог.³¹ Ингэхдээ шүүхэд хандах эрхийн хязгаарлалт нь хууль ёсны зорилго болон тэнцвэрийн зарчимд нийцсэн байх ёстой.³² Хэрэв Дээд шүүхэд хандах боломжгүй байх эсхүл, хяналтын гомдол гаргах үндэслэлийг хэт өргөн хүрээнд хуульчлах нь Дээд шүүхээс доод шатны шүүхүүдэд практик тогтоох, хуулийн хууль тогтоомжийн хөгжилд нөлөөлөх үүргээ гүйцэтгэхэд саад болдог.³³ Тиймээс Дээд шүүх ач холбогдолтой маргааныг шийдвэрлэх замаар хуулийн нэгдмэл байдлыг хангах, эрх зүйг хөгжүүлэх чиг үүрэг бүрэн дүүрэн хэрэгжих боломжтой байх, гагцхүү энэ л зорилгоор шүүхэд хандах эрхийг зохистой хязгаарлах гэсэн тэнцэл (balance)-ийг бүрдүүлэх нь хууль тогтоогчийн үүрэг юм. Хэрэв тус хяналтын гомдол гаргах үндэслэлүүд нь Дээд шүүхийн чиг үүргээ бүрэн дүүрэн хэрэгжүүлэх боломжид түлхэц үзүүлж чадахгүй бол шүүхэд хандах эрхийг үндэслэлгүй хязгаарласан болно. Улсын Дээд шүүхийн танхимын нийт шүүгчдийн “Гомдлыг хяналтын журмаар хэлэлцүүлэх эсэхийг шийдвэрлэх хуралдаан”³⁴-ы шийдвэрээр 2021 оны 03 сарын 01-ээс 11 сарын 01-нийг хүртэлх хугацаанд нийт гаргасан гомдлоос иргэний хэрэгт 5.3 хувийг³⁵, эрүүгийн хэрэгт 14.8 хувийг³⁶, захиргааны хэрэгт 10 хувийг³⁷ тус тус шийдвэрлэхээр хүлээн авсан байна.

³¹ Rimvydas Norkus (President of the Supreme Court of Lithuania), The Filtering of Appeals of the Supreme Courts, Network of the Presidents of the Supreme Judicial Courts in European Union, Dublin Conference, 2015, p6

³² Right of access to Supreme Courts, p85

³³ Right of access to Supreme Courts, p76

³⁴ <http://www.supremecourt.mn/>

³⁵ Нийт хяналтын журмаар 632 гомдол гаргаснаас Улсын дээд шүүхийн иргэний хэргийн танхим 34 гомдлыг шийдвэрлэхээр хүлээн авсан байна.

³⁶ Нийт хяналтын журмаар 216 гомдол гаргаснаас Улсын дээд шүүхийн эрүүгийн хэргийн танхим 32 гомдлыг шийдвэрлэхээр хүлээн авсан байна.

³⁷ Нийт хяналтын журмаар 229 гомдол гаргаснаас Улсын дээд шүүх захиргааны хэргийн танхим 26

Монгол Улсын хувьд Шүүхийн тухай хуулиар зөвхөн “хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах” зорилгыг хуульчлан зөвхөн нэгдмэл бус хэрэглээ бүхий маргааныг л Дээд шүүх хянан хэлэлцэх боломжтой байгаа нь Дээд шүүхийн хуулийг хөгжүүлэх, эрх зүйн хөгжилд үр нөлөө бүхий шийдвэр гаргах боломжийг орхигдуулжээ. Учир нь шүүх өөрийн санаачилгаар аливаа асуудлыг дэвшүүлж шийдвэрлэдэггүй, харин хэргийн оролцогчдын нэхэмжлэл, тайлбарт тусгагдсан асуудалд эрх зүйн дүгнэлт, хариулт өгдөг. Иймд ач холбогдолтой хэрэг маргааныг Дээд шүүхээр хэлэлцүүлэх боломжгүй бол дээд шүүхэд олгосон чиг үүрэг, хууль дээдлэх баталгаа бүрдэж чадахгүй.³⁸

3.3. Дээд шүүхийн хууль тайлбарлах эрх

Онолын үүднээс хэрэг маргаан шийдвэрлэх замаар албан ёсны тайлбар гаргадаг Дээд шүүхүүдийн хувьд хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах, хуулийг хөгжүүлэх чиг үүргийн хэрэгжилт нь албан ёсны тайлбараар илрэн гардаг. Дээд шүүх хууль тайлбарлаж байгаа нь эрх зүйн маргааныг шийдвэрлэх, шүүхийн нэгдсэн практик тогтоох зорилготой.³⁹ Дээд шүүхэд хууль тайлбарлах эрх чөлөө (freedom of interpretation) бүрэн олгогдсон байх нь Дээд шүүх чиг үүргээ хэрэгжүүлэх суурь болдог.⁴⁰ Хууль тайлбарлах эрхийн агуулгад Дээд шүүх хуулийн чухал асуудлыг тодруулж, доод шатны шүүхүүд жишиг тогтоосон шийдвэр гаргах, хуулийг хөгжүүлэх зэрэг асуудал цогцоороо багтдаг.

Монгол Улсын хууль зүйн шинжлэх ухааны хөгжлийн түвшинг эрх бүхий байгууллагын хууль тайлбарласан шийдвэрээр тодорхойлж болно.⁴¹ Монгол Улсын Дээд шүүхээс 1973 оноос 2008 он хүртэл хууль тайлбарласан нийт 272 тогтоол⁴², 2008-2009 оны дуустал хугацаанд нийт 35 тогтоол⁴³ тус тус гарсан байна. Үүнээс хойш буюу 2010 оноос хойш Дээд шүүх хуулийн тайлбар хийх явдлаас аль болох татгалзаж харин тайлбараа зөвлөмж хэлбэрээр буюу заавал дагаж мөрдөх шинжтэй бус гаргах болсон.⁴⁴ Тиймээс өдгөө хүчин төгөлдөр үйлчилж буй 600 гаруй хууль тогтоомжийн хувьд хууль хэрэглээ болон боловсронгуй болгох асуудалд Дээд шүүхийн идэвхтэй тайлбар маш чухал нөлөөтэй. Нөгөө талаар Дээд шүүхийн албан ёсны тайлбараас өдгөө тухайн хууль нь хүчингүй болсон, шинээр хууль, тогтоомж батлагдсан, нэмэлт өөрчлөлт орсон зэрэг асуудалд өмнөх тайлбарыг ашиглах боломж хязгаарлагдмал.

гомдлыг шийдвэрлэхээр хүлээн авсан байна.

³⁸ Right of access to Supreme Courts, p70

³⁹ Д.Гангабаатар, Үндсэн хуулийн эрх зүй Төрийн байгуулал, зарчим, үзэл баримтлал, УБ, 2017, 268 дахь тал

⁴⁰ Maarteen Feteris (President of the Supreme Court of the Netherlands), Development of the Law by Supreme Court in Europe, Utrecht Law Review Volume 13, Issue 1, 2017, p158

⁴¹ Ж.Амарсанаа нар, Монгол Улсын Дээд шүүхийн тогтоолын эмхтгэл (1959-2010), Хоёр дахь хэвлэлт (Шүүхийн ерөнхий зөвлөл, 2015), 37 дахь тал

⁴² Монгол Улсын Дээд шүүх, Монгол Улсын Дээд шүүхийн тогтоолын эмхтгэл /Тав дахь удаагийн хэвлэл/, УБ., 2010, 3 дахь тал

⁴³ Мөн тэнд

⁴⁴ А.Базар, “Улсын Дээд шүүхээс хууль тайлбарлах, хуулийн нэг мөр, зөв хэрэглээг хангах асуудал”, УБ., 2014, 52 дахь тал

Нийгэм түүхэнд байгаагүйгээрээ хөгжиж буй⁴⁵ өнөө үед Дээд шүүх тайлбар шинээр гаргах ёстой болон, тайлбараа өөрчлөх шаардлага зүй ёсоор урган гарна. Түүнчлэн Монгол Улсын эрх зүйн түүхэн уламжлалаас үзвэл Дээд шүүхээс хууль тайлбарлах чиг үүргийг хэрэгжүүлэхэд анхнаас нь хийсвэрээр тайлбарлах хандлага давамгайлж ирсэн⁴⁶ тул сүүлийн үед тогтонги тайлбар (static interpretation) -аас илүүтэйгээр хувьсаж буй тайлбар (dynamic interpretation) гаргах шаардлага, хэрэгцээ⁴⁷ зайлшгүй цаг үеийн шаардлагаар үүсжээ.⁴⁸

Тиймээс Улсын Дээд шүүхээс ийм төрлийн эрх зүйн болон бусад олон талын ач холбогдолтой маргааныг шийдвэрлэх замаар хууль хэрэглээний нэгдмэл байдлад төдийгүй хуулийг хөгжүүлэх, доод шатны шүүхүүдэд жишиг шийдвэр тогтоох шаардлагатай.

IV. ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Дээд шүүхээр хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах, хуулийг хөгжүүлэхэд чиглэсэн маргааныг сонгон хэлэлцүүлэхийн тулд улс орнууд хяналтын гомдол гаргах хязгаарлалтыг XX зуунаас эхлэн хуульчилж эхэлсэн. Гэвч бүхэл зуун дамжин хөгжихдөө⁴⁹ энэхүү үйл явц нь амар хялбар хэрэгжээгүй ба шүүхэд шударгаар шүүлгэх эрхийг үндэслэлгүй хязгаарласан, Дээд шүүх дур зоргоороо аашиллаа хэмээх шүүмжлэл, эсэргүүцэлтэй тулгарч байжээ.⁵⁰ Судалгааны энэхүү хэсэгт Дээд шүүхийг чиг үүргийг онолын үүднээс хөгжүүлж, хяналтын гомдол гаргах үндэслэлийг анхлан хуульчлан баталгаажуулсан эх газрын эрх зүйн бүлийн томоохон төлөөлөгчид болох ХБНГУ, Австри Улс мөн БНСУ-уудын эрх зүйн зохицуулалтыг харьцуулан судаллаа. Эдгээр улсуудын хувьд Дээд шүүхийг хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах, хуулийг хөгжүүлэх үүрэгтэй гэж Үндсэн хуулиараа зохицуулаагүй, харин уг асуудлыг онолын үүднээс дэвшүүлж, хяналтын гомдол гаргах үндэслэлүүдийг тус зорилгод нийцүүлэн хуульчилсан байдаг.

4.1. Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

Холбооны Бүгд Найрамдах Герман Улсад Дээд шүүхийн хяналтын гомдолд тавигдах шүүлтүүрийн үндсэн зорилго нь хуулийн чухал асуудлыг (the importance of the legal questions)⁵¹ хөндсөн маргааныг шийдвэрлэж, хуулийг тайлбарлах замаар хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах

⁴⁵ Ottavia Dora Lo Sardo, The role of Supreme Courts in the uniform application of law, p86

⁴⁶ А.Бямбажаргал, Улсын Дээд шүүхийн чиг үүргийн талаар харьцуулсан шинжилгээ, 123 дахь тал

⁴⁷ Maarten Feteris (President of the Supreme Court of the Netherlands), Development of the Law by Supreme Court in Europe, Utrecht Law Review Volume 13, Issue 1, 2017, p157

⁴⁸ Ottavia Dora Lo Sardo, The role of Supreme Courts in the uniform application of law, p86

⁴⁹ What is an important case? Admissibility of appeals to the Supreme Court in the German-speaking Jurisdiction?, p278

⁵⁰ The paradigm shift: The “Leave to Appeal System” and Guidance and Developing Law as the Prevailing Tasks of the Supreme Court, p.298

⁵¹ Krüger in M&Ko ZPO 2012, § 543 marginal numbers 1 et seq.; W. Ball in Musielak 2013, § 543 marginal numbers 1 et seq.

(ensuring the uniform application and interpretation of law)⁵², хуулийг хөгжүүлэх явдал⁵³ бөгөөд энэ зарчим 1921- оноос хэрэгжиж эхэлсэн байна.⁵⁴

ХБНГУ-д Дээд шүүхээс хууль тайлбарлах асуудал нь шүүхийн хууль хэрэглээтэй салшгүй холбоотой⁵⁵ ба маргааныг хянан шийдвэрлэх явцдаа хуулийг зөв хэрэглэх талаар шүүхийн нэгдсэн жишгийг өөрийн шийдвэрээр буюу шүүн таслах чиг үүргээ хэрэгжүүлэх замаар хэрэгжүүлж ирсэн.⁵⁶ Тухайлбал, Захиргааны хэргийн шүүхээс нь тодорхой хэрэг, маргаан хянан шийдвэрлэх явцад шүүхийн тайлбараар дамжуулан захиргааны байгууллагын баримтлах ёстой суурь зарчмуудыг хөгжүүлэх замаар одоогийн өндөр хөгжсөн захиргааны эрх зүйг бий болгож, Verwaltungsrecht буюу Захиргааны ерөнхий үйл ажиллагааны хуулиа баталсан байна.⁵⁷ Энэ бол шүүхийн тайлбараар дамжуулан эрх зүйг хөгжүүлсний тод жишээ билээ.⁵⁸ Үндсэн хуульдаа⁵⁹ Холбооны Шүүх (the Federal Court of Justice), Холбооны Захиргааны шүүх (the Federal Administrative Court), Холбооны Сангийн шүүх (the Federal Finance Court), Холбооны Хөдөлмөрийн шүүх (the Federal Labour Court), Холбооны Нийгмийн (the Federal Social Court) шүүхүүдийг Дээд шүүх болгон байгуулна гэж заасан. Эдгээр бие даасан Дээд шүүхүүд нь 1. хууль зүйн асуудлын язгуур ач холбогдол (fundamental significance), 2. хуулийн цаашдын хөгжил (the further development of the law) болон нэгдмэл байдлыг хангахад ач холбогдолтой (the interests in ensuring uniform adjudication)⁶⁰ хуулийн асуудал (points of law) хөндсөн маргааныг хүлээн авдаг ба 3. тухайн маргаанд амжилт үзүүлэхээргүй бол хүлээн авахаас татгалздаг байна (the appeal manifestly has no chance of success).⁶¹

4.2. Австри Улс

Австри Улсын Дээд шүүх нь зөвхөн хууль хэрэглээний нэгдмэл байдлыг тогтоож (ensuring a uniform law practice), өндөр ач холбогдолтой маргааныг (cases that bring up a question of high importance) шийдвэрлэдэг тогтолцоог 1983 оноос нэвтрүүлсэн.⁶² “Чухал ач холбогдол бүхий хууль,

⁵² Dr. Carsten Gonthier-Judge at the Federal Administrative Court, Administrative Justice in Europe – Report for Germany, Leipzig Administrative Justice in Europe, p8

⁵³ Urs Kramer and Tim Hinrichsen, German Law of Administrative Court Procedure: an Overview, Journal of Siberian Federal University. Humanities & Social Sciences 10 (2015 8) 2050-206, p2058

⁵⁴ Krüger in: M&K ZPO 2012, § 543 marginal numbers 1 et seq.; W. Ball in: Musielak 2013, § 543 marginal numbers 1 et seq.

⁵⁵ А.Бямбажаргал, Улсын Дээд шүүхийн чиг үүргийн талаар харьцуулсан шинжилгээ, 126 дахь тал

⁵⁶ Мөн тэнд

⁵⁷ Дам ишлэв. П.Соёл-Эрдэнэ, Шүүхийн шийдвэр ба хууль тайлбарлах арга, Шударга ёсны хэмжүүр сэтгүүл, 2012.06 сар №06 /006/, 31 дэх талаас; Хууль зүйн Үндэсний төв, Шүүх, эрх зүйн шинэчлэлт төсөл, Гадаад орнуудын захиргааны хэргийн шүүх, Цуврал 6, УБ хот, 2005 он, 8 дахь тал

⁵⁸ А.Базар, “Улсын Дээд шүүхээс хууль тайлбарлах, хуулийн нэг мөр, зөв хэрэглээг хангах асуудал”, УБ., 2014, 19 дэх тал

⁵⁹ Art 95(1), Basic Law for the Federal Republic of Germany, 1949

⁶⁰ Art 551(4)1, Civil Procedure Code of Germany

⁶¹ Art 522(2), Civil Procedure Code of Germany

⁶² What is an important case? Admissibility of appeals to the Supreme Court in the German-speaking Jurisdiction?, p279

эрх зүйн асуудал”⁶³ (legal issue of essential importance) гэдэг нэр томьёог Холбооны Үндсэн хуулийн шүүхээс тухайн шийдвэр нь Дээд шүүхийн тогтоосон практикаас хазайсан, зохицуулсан хууль нь хүчингүй болсон, эсвэл хууль дээдлэх ёсыг зөрчсөн байдлаар шийдвэрлэсэн байдал гэж тодорхойлдог⁶⁴. Австрийн Холбооны Үндсэн хуульд⁶⁵ Иргэний болон эрүүгийн хэрэг маргааныг эцсийн шат нь Дээд шүүх байна гэж зохицуулсан бөгөөд процессын хуулиудаар 1) Land-ын бие даасан захиргааны танхимын шийдвэр, бие даасан холбооны танхимын шийдвэр, эрх бүхий холбооны байгууллагын шийдвэрийг эсрэг хяналтын гомдол гаргаж буй бол; (2) шийдвэр нь олон нийтийн ач холбогдол бүхий хуулийн асуудалд хамаагүй бол; (3) шүүх харьяалан шийдвэрлэх хууль эрх зүйн акт байхгүй, эсвэл холбогдох хууль эрх зүйн асуудлыг хууль тогтоомжоор зохицуулаагүй бол гомдлыг хүлээн авахаас татгалзаж болно гэж зохицуулсан байдаг.

4.3. Бүгд Найрамдах Солонгос Улс

Хууль тогтоомж ба жишиг шийдвэр (case law)-ийн холбоо хамаарал нь Бүгд найрамдах Солонгос Улсын Дээд шүүхийн хамгийн чухал асуудлын нэг бөгөөд түүний илрэл нь албан ёсны тайлбараар дамжин хэрэгждэг.⁶⁶ Шүүхийн анхдагч чиг үүрэг нь хуулийг тайлбарлаж хэрэглэх тул⁶⁷ шүүх хуулийг зөвхөн бичвэр, үгээс гадна батлагдах болсон зорилго, үзэл санаа, тус заалтын чиг үүргийг авч үзэн албан ёсны тайлбар гаргадаг.⁶⁸ Цаашлаад шүүхийн презедент нь хууль тогтоох явцад чухал нөлөө үзүүлдэг.⁶⁹ Тодруулбал, албан ёсны тайлбар нь “нийгмийн өөрчлөлтөд нийцүүлэн, жишиг шийдвэрээр дамжуулан хууль тогтоомжийн хоосон орон зайг нөхөх, хууль тогтоох байгууллагыг чиг үүрэгт түлхэх өгөх буюу шүүхийн шийдвэр гарснаар хуулиа өөрчлөх, сайжруулах, шинээр батлах тохиолдол болон шүүх хууль тогтоомжийг цаг тухайд нь, үндэслэлтэй, бүтээлч эрх зүйн шийдлээр хангах”⁷⁰ зэргээр илэрдэг.

Үндсэн хуульдаа⁷¹ Дээд шүүх нь захиргааны тогтоол, журам, үйл ажиллагаа Үндсэн хуульд нийцсэн эсэх, хууль ёсны эсэхэд эцсийн хяналт хийх бүрэн эрхтэй гэж заасан ба Дээд шүүхэд маргаан хянан шийдвэрлэх тусгай журмын тухай хуульд⁷² 1) Шүүх хууль, тушаал,

⁶³ Tour to Europe Contribution of Austria, 05/11/2015, p16

⁶⁴ Tour to Europe Contribution of Austria, p6

⁶⁵ Art 92(1), The Federal Constitutional Law of Austria, 1920

⁶⁶ Jae Hyung Kim (Korean Supreme Court Justice), Formulating the Korean Supreme Court's Stature and Roles: with a Focus on the Relationship Between Legislation and Presedens, Conference of Chief Justices of Asia and the Pacific in Tokyo, 2017, p136 [цаашид “Jae Hyung Kim (Korean Supreme Court Justice)” гэх]

⁶⁷ Мөн тэнд, p138

⁶⁸ хууль тайлбарлах praeter legem (бичвэрээс гадуур хуулийн тайлбар хийх аргыг хууль тогтоомжид эрх зүйн дутагдал, доголдол байгаа тохиолдолд уг хийдэл, дутагдлыг нөхөх), contra legem (бичвэрт суурилж хэлний тайлбар) гэсэн хоёр тайлбарын аргыг ашигладаг.

⁶⁹ Дээд шүүх нь хууль тогтоогчоос хууль тогтоомжийг сайжруулах, боловсронгуй болгохыг хүлээхийн оронд тайлбараар дамжуулан тус хуулийн текстийн муу утга агуулгыг засаж, сайнаар хэрэглэдэг.

⁷⁰ Jae Hyung Kim (Korean Supreme Court Justice), p143-156

⁷¹ Art 107(2), Constitution of Republic of Korea, 1948

⁷² Act on special concerning procedure for trial by the Supreme court

дүрэм, захирамжийг Дээд шүүхийн тайлбараас өөрөөр тайлбарласан; 2) Аливаа хууль, тушаал, дүрэм, захирамжийг тайлбарласан Дээд шүүхийн тайлбар байхгүй; 3) Дээд шүүхийн тайлбарыг өөрчлөх шаардлагатай тохиолдлуудад хяналтын журмаар гаргасан гомдлын хүлээн авдаг байна.

V. ДҮГНЭЛТ, САНАЛ

Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлал ёсоор Улсын дээд шүүх нь “шүүхийн дээд байгууллага мөн” бөгөөд “хяналтын журмаар хянан үзэх”, “Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах” бүрэн эрхтэй. Энэ нь Дээд шүүхийн хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах, хуулийг хөгжүүлэх буюу эрх зүйн тогтолцоонд үр нөлөө бүхий шийдвэр гаргах чиг үүргийг илэрхийлнэ. 2021 оны Монгол Улсын Шүүхийн тухай хуульд Улсын Дээд шүүхийн зорилгыг “хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах” хэмээн зохицуулж тус зорилгод үйлчлэх хяналтын журмаар гомдол гаргах үндэслэлүүдийг хуульчилсан. Ингэхдээ Улсын Дээд шүүхийн эрх зүйн тогтолцоонд үр нөлөө бүхий тайлбар гаргах, хууль хөгжүүлэх, эрх зүйг боловсронгуй чиг үүргийг орхигдуулсан байна.

Тиймээс одоогийн Шүүхийн тухай хуулиар зохицуулсан хяналтын журмаар гаргах гомдлын үндэслэлүүдэд (1) хуулийг хөгжүүлэх боломж хязгаарлагдмал, (2) тодорхой нэг хуулийн чухал асуудлыг Дээд шүүх анх удаа хянан хэлэлцэж жишиг тогтооход гомдол зөвшөөрөгдөхгүй байх, (3) шүүхэд хандах эрхийг хязгаарласан зэргээс үүдэн Дээд шүүх хуулийг хөгжүүлэх ач холбогдолтой маргааныг сонгон хянах боломжгүйд хүргэжээ.

Иймд Дээд шүүхийн эрх зүйн тогтолцоонд үр нөлөө бүхий шийдвэр гаргах, хуулийг хөгжүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд:

Нэгдүгээрт, Дээд шүүхийн зорилгыг хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах гэдэг дээр нэмээд “эрх зүйн тогтолцоонд үр нөлөө бүхий шийдвэр гаргах (эрх зүйг хөгжүүлэх)” зорилгыг хуульчлах, үүний тулд

Хоёрдугаарт, өдгөө хуульчлагдсан хяналтын журмаар гомдол гаргах үндэслэл дээр нэмэх нь дараах үндэслэлийг хуульчлах шаардлагатай гэсэн саналыг дэвшүүлж байна. Үүнд:

- (1) Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбар гаргах шаардлагатай нөхцөл,
- (2) Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбарыг өөрчлөх шаардлагатай нөхцөл.

Дээрх үндэслэлүүд нэмж хуульчлагдсанаар Дээд шүүх хуулийн нэгдмэл байдлыг хангахын зэрэгцээ, шийдвэр, тогтоолоороо дамжуулан хуулийг боловсронгуй болгох, хөгжүүлэх, эрх зүйн тогтолцоонд үр нөлөө бүхий шийдвэр гаргах, цаашид онолын шүүх болох эхлэл тавигдах учиртай.

VI. ЭХ СУРВАЛЖ

Эрх зүйн эх сурвалж

1. Монгол Улсын Үндсэн хууль, 1992
2. Монгол Улсын Шүүхийн тухай хууль, 2012
3. Монгол Улсын Шүүхийн тухай хууль, 2021
4. Төрийн албаны тухай хууль, 2017
5. Basic Law for the Federal Republic of Germany, 1949 https://www.gesetze-im-internet.de/englisch_gg/
6. Civil Procedure Code of Germany, https://www.gesetze-im-internet.de/englisch_zpo/englisch_zpo.html
7. The Federal Constitutional Law of Austria, 1920, <https://www.ris.bka.gv.at/>
8. Constitution of Republic of Korea, 1948, https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?lang=ENG&hseq=1
9. Act on special concerning procedure for trial by the Supreme court, <https://www.law.go.kr/>
10. ҮХЦ-ийн тогтоол, 'МУ-ын шүүхийн тухай хуулийн 17 зүйлийн 17.3.1 дэх заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг эцэслэн шийдвэрлэх тухай' /Дугаар 07-2015.10.30/, <https://www.legalinfo.mn/law/details/11397>

Ном, бүтээл

11. Б.Чимид, *Үндсэн хуулийн үзэл баримтлал (Илтгэл, өгүүлэл, ярилцлага, дурсамж)*, УБ., 2002
12. Г.Совд, *Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар*, УБ., 2000
13. Монгол Улсын Дээд шүүх, Монгол Улсын Дээд шүүхийн тогтоолын эмхтгэл /Тав дахь удаагийн хэвлэл/, УБ., 2010
14. Ж.Амарсанаа нар, *Монгол Улсын Дээд шүүхийн тогтоолын эмхтгэл (1959-2010)*, Хоёр дахь хэвлэлт (Шүүхийн ерөнхий зөвлөл, 2015)
15. А.Базар, *Улсын Дээд шүүхээс хууль тайлбарлах, хуулийн нэг мөр, зөв хэрэглээг хангах асуудал*, УБ., 2014, <https://legalddata.mn/buteel/pdf?id=439>
16. Д.Гангабаатар, *Үндсэн хуулийн эрх зүй Төрийн байгуулал, зарчим, үзэл баримтлал*, УБ, 2017
17. А.Бямбажаргал, *Улсын Дээд шүүхийн чиг үүргийн талаар харьцуулсан шинжилгээ*, Хууль дээдлэх ёс сэтгүүл, 2020 оны №4 дугаар
18. О.Мөнхсайхан, *Шүүхийн тухай хуулийн төслийн хүрээнд шүүхийн хараат бус, хариуцлагатай байдлыг хангах нь*, Хууль дээдлэх ёс. сэтгүүл, 2020 оны №4 дугаар
19. Р.Оюундэлгэр, *Улсын Дээд шүүхийн хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах чиг үүрэг ба хяналтын журмаар гаргах гомдол*

хязгаарлалт тавих асуудал, түүний учир холбогдол, Шүүх эрх мэдэл эмхэтгэл, 2021 оны №3 дугаар

20. Р.Оюундэлгэр, *Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 123.2 дахь заалтын хэрэгжих боломж ба хүндрэл (Улсын дээд шүүхээс хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангуулах тухай)*, Хууль дээдлэх ёс сэтгүүл, 2021 оны №4 дугаар

Гадаад хэл дээрх эх сурвалж

21. Maarteen Feteris (President of the Supreme Court of the Netherlands), *Development of the Law by Supreme Court in Europe*, Utrecht Law Review Volume 13, Issue 1, 2017, <https://www.utrechtlawreview.org/articles/abstract/10.18352/ulr.401/>
22. Jae Hyung Kim (Korean Supreme Court Justice), *Formulating the Korean Supreme Court's Stature and Roles: with a Focus on the Relationship Between Legislation and Presedens*, Conference of Chief Justices of Asia and the Pacific in Tokyo, 2017, https://papers.ssrn.com/sol3/papers.cfm?abstract_id=3381963
23. Rimvydas Norkus (President of the Supreme Court of Lithuania), *The Filtering of Appeals of the Supreme Courts, Network of the Presidents of the Supreme Judicial Courts in European Union*, Dublin Conference, 2015, <https://www.lat.lt/data/public/uploads/2018/01/introductory-report-the-filtering-of-appeals-to-supreme-courts-president-rimvydas-norkus.pdf>
24. Arnfinn Bardsen (The Norwegian Surpeme Court Justice), *Deciding what to decide: The filtering mechanism in the Norwegian Supreme Court*, 2018, <https://www.domstol.no/globalassets/upload/hret/artikler-og-foredrag/deciding-what-to-decide---bardsen-23.02.2018.pdf>
25. Dr. Carsten Günther-Judge at the Federal Administrative Court, *Administrative Justice in Europe – Report for Germany, Leipzig Administrative Justice in Europe*, https://www.aca-europe.eu/en/eurtour/i/countries/germany/germany_en.pdf
26. Urs Kramer and Tim Hinrichsen, *German Law of Administrative Court Procedure: an Overview*, Journal of Siberian Federal University. Humanities & Social Sciences 10 (2015 8) 2050-206, http://elib.sfu-kras.ru/bitstream/handle/2311/19824/06_Kramer.pdf;jsessionid=790424912C93F6BBF64A833473B2BC87?sequence=4, [Сүүлд үзсэн: 2021.10.10]
27. Tour to Europe Contribution of Austria, 05/11/2015, 16 дахь тал, https://www.aca-europe.eu/en/eurtour/i/countries/austria/austria_en.pdf
28. A. Uzelac and C.H. van Rhee, *The Paradigm Shift: The 'Leave to Appeal System' and Guidance and Developing Law as the*

- Prevailing Tasks of the Supreme Court*, 2014, https://www.academia.edu/34460915/Nobodys_Perfect_Comparative_Essays_on_Appeals_and_other_Means_of_Recourse_against_Judicial_Decisions_in_Civil_Matters
29. A. Uzelac and C.H. van Rhee, *Uniform Application of Law and Promotion of its Development as a New Role of Supreme Courts*, 2014
 30. Nikolina Katic, Matea Basic and Morana Briski, *Right of Access to Supreme Courts in Light of the Guarantees under Article 6.1 of the Convention on Human Rights and Fundamental Freedoms (civil aspect)*, Croatia International Relations Review-CIRP, 2018, <https://hrcak.srce.hr/file/294499>
 31. Ottavia Dora Lo Sardo, *The role of Supreme Courts in the uniform application of law*, <https://romatrepress.uniroma3.it/wp-content/uploads/2020/07/05.ther-otlosa.pdf>
 32. Jelena Ristik, *The role of the Supreme Court in ensuring uniformity of court practice in the Republic of Macedonia*, 2017, <https://www.ceeol.com/search/article-detail?id=848891>
 33. Wydawnictwa Uniwersytetu, *The functions of the Supreme Court – Issues of process and Administration of Justice*, 2019, Warsaw, http://wuw.pl/data/include/cms/Studia_Iuridica_81_2019.pdf



Мөнхтөрийн МАРАЛМАА
Баттөрийн МЯГМАРСҮРЭН

МУИС, Хууль зүйн сургууль
Эрх зүйн V түвшний оюутнууд
(дэд байр)

**УЛСЫН ДЭЭД ШҮҮХЭД ХЯНАЛТЫН ЖУРМААР ГОМДОЛ ГАРГАХ
ҮНДЭСЛЭЛИЙГ ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ
ОНЦЛОГТ НИЙЦҮҮЛЖ, ХЯНАЛТЫН ГОМДЛЫГ ХЭЛЭЛЦҮҮЛЭХЭЭС
ТАТГАЛЗСАН ТОГТООЛЫН ҮНДЭСЛЭЛИЙГ САЙЖРУУЛАХ НЬ**

*Түлхүүр үгс: Улсын дээд шүүх, хяналтын гомдол, хязгаарлалт,
хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны онцлог*

I. УДИРТГАЛ /хураангуй/

2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр шүүх эрх мэдлийн бие даасан, хараат бус байдлыг хангах үндсэн загварт зарчмын өөрчлөлт орсон тул үүнийг шинэчлэлийн түвшинд анхаарч авч үзэх ёстой хэмээгээд Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарийн¹ дагуу 2020-2021 онд “Шүүх эрх мэдлийн шинэчлэл”-ийг хийж, Шүүхийн тухай багц хуулийг 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр баталсан. Тус үйл явдал нь Үндсэн хууль дахь шүүхийн шинэчлэл “амь орж” хэрэгжих, мөн хуулийн систем дэх цаашдын шинэчлэлүүд өрнөх нөхцөлийг бүрдүүлж байгаа² тухай хуульчид, судлаачид байр сууриа илэрхийлсээр байна.

Тус шинэтгэлийн хүрээнд сүүлийн үеийн чиг хандлагын үүднээс Улсын дээд шүүхийн гол чиг үүрэг нь хууль хэрэглээний нэгдмэл байдлын хангах гэдгийг хуульчилж уг чиг үүргийн хүрээнд (i) анхан болон давж заалдах шатны шүүхийн хууль хэрэглээний зөрүүг арилгах; (ii) хуулийг Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн; (iii) хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ноцтой зөрчил гаргасан нь шүүхийн шийдвэрт нөлөөлсөн тохиолдолд давж заалдах шатны шүүхийн магадлалыг хяналтын журмаар хянан шийдвэрлэхээр Шүүхийн тухай хуульд зохицуулсан. Материаллаг хуулийн буюу Шүүхийн

¹ Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарь <https://legalinfo.mn/mn/detail?lawId=14950> сүүлд 2021.12.29-ний өдөр хандав.

² Д.Ганзориг, “Шүүхийн шинэчлэл: Бие даасан байдал, чиг үүрэг, хариуцлага” илтгэл. <http://www.su-premiecourt.mn/news/686> сүүлд 2021.12.29-ний өдөр хандав.

тухай хуулийн тус гурван үндэслэлийг процессын хуулиуд буюу хэрэг хянан шийдвэрлэх хуулиудад ижил томъёоллоор оруулсан нь зарим нэг хийдлийг үүсгэж мөн салбар эрх зүйн хэрэг маргаануудын онцлогийг харгалзаж үзээгүйн дээр Дээд шүүхийн хувийн шинжтэй зорилгыг үгүйсгэсэн байгаа юм.

Иймд, хяналтын гомдолд тавигдах хязгаарлалтын асуудлыг боловсронгуй болгохын тулд олон улсын чиг хандлага, жишиг зохицуулалтуудыг өөрийн орны тулгамдсан асуудал, эрх зүйн зохицуулалттай харьцуулсан судалгаа, шинжилгээний ажил шаардлагатай хэмээн үзэж хяналтын гомдолд тавигдах хязгаарлалтын асуудлыг судалж, Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Литва Улс болон Норвеги Улсын зохицуулалтуудыг судлан, сайн туршлага бүхий зохицуулалт, практикийг илрүүлэх замаар дотоодын эрх зүйн тулгамдсан асуудлыг боловсронгуй болгох арга замыг тодорхойлоход чиглэсэн дүгнэлт, санал боловсруулахыг зорилоо.

II. ҮНДСЭН ХЭСЭГ

2.1. Шаталсан шүүхийн тогтолцоон дах Дээд шүүхийн чиг үүрэг ба иргэний шударгаар шүүлгэх эрхийн харилцан хамаарал

Улс орон бүр өөр өөрийн онцлогт тохирсон шүүхийн тогтолцоотой байдаг боловч тогтолцооноос үл хамааран Дээд шүүхийг доод (энгийн) шүүхээс ялгаж буй гол шинжүүдийн нэг нь Дээд шүүх нь шүүхийн шатлалын дээд хэсэгт байдаг явдал юм.

Улсын дээд шүүх нь үндэсний эрх зүйн тогтолцоонд онцгой үүрэг гүйцэтгэдэг учраас нийтийн болон хувийн зорилгыг³ хэрэгжүүлж дотоодын хууль тогтоомжид давхар үүрэг гүйцэтгэдэг⁴. Хувийн зорилго гэдэг нь шүүх маргаанд оролцогчдын хувьд маргааныг нь шийдвэрлэж байгаагийн хувьд хуулийн дагуу шударга ёсыг дээд зэргээр хэрэгжүүлж байгаа явдал гэж тодорхойлж болно. Нөгөөтэйгүүр, доод шатны шүүхийн шийдвэр хууль ёсны эсэх, доод шатны шүүхүүд нь Дээд шүүхээс тогтоосон өмнөх нөхцөл байдал, байр сууринд захирагдсан эсэх нь Дээд шүүхийн нийтийн зорилгод хамаарч байдаг тул Дээд шүүхийн хувийн зорилгоос нийтийн зорилго нь илүү өргөн хүрээтэй гэж үздэг⁵ ч Дээд шүүхийн хувийн зорилгыг үгүйсгэдэггүй.

Монгол Улсын Үндсэн хуулийн дөчин наймдугаар зүйлийн 48.1-д “Шүүхийн үндсэн тогтолцоо Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхээс бүрдэх бөгөөд шүүхийг

³ Public and Private Purpose /Анг./

⁴ Дам эшлэв, Jolowicz, J.A., 1997. The role of the Supreme Court at the national level a General Report. In Yessiou-Faltsi P., ed. The Role of the Supreme Courts at the National and International Level, Athens: Sakoulas Publications.

⁵ Nikolina Katić, Matea Bašić, Morana Briški, “Right of Access to Supreme Courts in Light of the Guarantees under Article 6 § 1 of the Convention on Human Rights and Fundamental Freedoms (civil aspect)”, CIRR XXIV (81)-2018, p.p.72-73.

тойргийн зарчмаар байгуулж болно...” гэж шүүхийн үндсэн тогтолцоог заасан. Үүнээс үзвэл Монгол Улсын Шүүх нь хэрэг маргааныг хянан шийдвэрлэх эрх хэмжээний хувьд: (i) анхан шатны; (ii) давж заалдах шатны; (iii) хяналтын шатны гэсэн гурван шатаас бүрдэх⁶ шаталсан тогтолцоотой. Энэхүү шаталсан тогтолцоон дах Дээд шүүхийн чиг үүргийг тодорхойлохдоо Шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7.5-д “Улсын дээд шүүх хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах зорилгоор...” гэж Дээд шүүхийн зөвхөн нийтийн зорилгыг буюу хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах чиг үүргийг л тодорхойлсон нь Дээд шүүхийн хувийн зорилго болох хэрэг маргааны талуудын шударга шүүхээр шүүлгэх эрх, давж заалдах эрхийг бүрэн хамраагүй байна.

Шүүхийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4-д зааснаар шүүхийн эрхэм зорилгын нэг нь “шударга шүүхээр шүүлгэх иргэний эрхийг хангах” явдал юм. Шударга шүүхээр шүүлгэх эрх нь шударгаар шүүлгэх эрхийн нэг агуулга бөгөөд хуулийн дагуу дээд шатны шүүхэд давж заалдах эрх ч мөн тус эрхийн бүрэлдэхүүн хэсэг болдог.

Монгол Улсын Үндсэн хуулийн арван зургадугаар зүйлийн 16.14-д “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, ..., шударга шүүхээр шүүлгэх, ... шүүхийн шийдвэрийг давж заалдах ... эрхтэй ...” гэж шударгаар шүүлгэх эрхийг баталгаажуулсан бөгөөд үүнд хуулиар хэргийн харьяаллыг тусгайлан өөрөөр тогтоосноос бусад тохиолдолд анхан шатны шүүхийн шийдвэрийг давж заалдах шатны шүүхэд давж заалдах, давж заалдах шатны шүүхийн магадлалыг хяналтын шатны шүүхэд давж заалдах эрхийг ойлгоно.

Дээд шүүхэд гаргах гомдлыг хязгаарлах нь зөвхөн хууль тогтоогчийн шийдвэрээс хамаардаггүй.⁷ Шүүх эрх мэдэл нь чиг үүргээ хэрэгжүүлэхдээ эрх мэдэл хуваарилах зарчмын дагуу хуулийг хэрэглэж, маргаан хянан шийдвэрлэх; хууль дээдлэх зарчмын дагуу гагцхүү хуульд захирагдах, хууль дээдлэх ёсыг хэрэгжүүлэх; төрийн халдлагаас хүний эрх эрх чөлөөг хамгаалах зэрэг Үндсэн хуулийн эрх зүйн зарчимд нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулах үүрэгтэй.⁸

Иймд Улсын дээд шүүхэд хандах эрх зүйн зохицуулалт нь нийтийн зорилго болон хувийн зорилгын зөрчилдөөн, нөгөө талаас талуудын шударгаар шүүлгэх эрхийн хоорондох шаардлагатай тэнцвэрт байдлыг хангах ёстой байдаг⁹. Манай Улсын хувьд Дээд шүүхэд гомдол гаргах

⁶ Г.Совд нар, “Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар”, УБ., 2000 он, 210 дах тал.

⁷ Rimvydas Norkus, “The Filtering of Appeals to the Supreme Court”, Network of the Presidents of the Supreme Judicial Courts of the European Union Conference, 2015, p.3. <https://www.lat.lt/data/public/uploads/2018/01/introductory-report-the-filtering-of-appeals-to-supreme-courts-president-rimvydas-norkus.pdf> сүүлд 2021.12.29-ний өдөр хандав.

⁸ Д.Гангабаатар, “Үндсэн хуулийн эрх зүй: Төрийн байгууллал, зарчим, үзэл баримтлал”, УБ., 2019, 265 дах тал.

⁹ Nikolina Katić, Matea Bašić, Morana Briški, “Right of Access to Supreme Courts in Light of the Guarantees under Article 6 § 1 of the Convention on Human Rights and Fundamental Freedoms (civil aspect)”, CIRR XXIV (81)-2018, p.73.

үндэслэлүүдийг тодорхойлохдоо Үндсэн хуулийн эрх зүйн зарчмаас явцууруулж Дээд шүүхийн зөвхөн нийтийн зорилго болох хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах гэж тодорхойлсон нь иргэний шударгаар шүүлгэх эрхийг бүрэн хамгаалж чадахгүй байгаа явдал юм. Тиймээс Дээд шүүхийн чиг үүргийг иргэний шударгаар шүүлгэх эрхтэй нийцүүлж, харилцан хамаарлын тэнцвэрт байдлыг хангах шаардлагатай.

2.2. Хяналтын гомдлыг хязгаарлах хандлага

Хяналтын гомдлыг хязгаарлах маш олон янзын загвар, механизм, процедур байдаг бөгөөд 2015 онд Европийн Холбооны шүүхийн шүүгч Римвидас Норкус хяналтын гомдлыг хязгаарлах үндсэн 3 загварыг томъёолсон. Өгүүллийн энэ хэсэгт түүний тодорхойлсноор хяналтын гомдлыг хязгаарлах үндсэн 3 загварыг авч үзлээ.

Давж заалдах зөвшөөрөл олгодог загвар¹⁰

Энэхүү загвар нь Дээд шүүхээр хэлэлцэж, шийдвэрлэх хэргүүдийг нэлээн хийсвэр шалгуураар сонгон хуульчилдаг¹¹ бөгөөд Дээд шүүхийн шүүгчид эсхүл зарим улс оронд байдаг¹² Давж заалдах зөвшөөрлийн зөвлөл¹³ нь тухайн маргааныг Дээд шүүхээр хэлэлцэх эсэхийг шийдвэрлэдэг. Ингэхдээ Дээд шүүхийн чиг үүрэгтэй холбогдуулан тухайн маргааны ерөнхий ач холбогдол, өмнө шийдвэрлэгдэж байгаагүй байдал эсвэл шударга ёсны үүднээс Дээд шүүхээр хэлэлцэх шаардлагатай хэмээн Дээд шүүхийн шүүгчид эсхүл Давж заалдах зөвшөөрлийн зөвлөлөөс үзсэн хэргүүдийг авч шийдвэрлэдэг байна. Тус загвар Их Британи, Ирланд, Норвеги, Дани, Швед зэрэг улсуудад бий.

Энэ загвар нь хэргийг сонгох эсэхийг шийдвэрлэдэг Дээд шүүхийн шүүгчид эсхүл Давж заалдах зөвшөөрлийн зөвлөлийн гарт маш их эрх мэдэл өгдөг сул талтай.

Шүүхийн оролцоогүй загвар¹⁴

Энэ загварын хувьд хяналтын гомдлыг хэлэлцэх эсэх асуудлыг шийдвэрлэхэд шүүхийн оролцоо байдаггүй. Хяналтын гомдлыг зөвхөн Дээд шүүхээс томилогдсон тусгай хуульч эсвэл тодорхой тогтоосон туршлагыг хангасан хүн л Дээд шүүхэд гаргаж болдог. Зарчмын хувьд

¹⁰ Leave to Appeal /Анг./, Oxford Reference болон World Law Dictionary-д тус холбоо үгийг “шүүхийн шийдвэрийг давж заалдах албан ёсны зөвшөөрөл” хэмээн тайлбарласан байх тул үгчлэн биш тайлбартай нь холбогдуулан утгачлан орчуулан өгүүлэлдээ хэрэглэлээ. /М.М, Б.М/ <https://www.oxfordreference.com/view/10.1093/oi/authority.20110803100056563> <https://dictionary.translegal.com/en/leave-to-appeal/noun> сүүлд 2021.12.29-ний өдөр хандав.

¹¹ Rimvydas Norkus, “The Filtering of Appeals to the Supreme Court”, Network of the Presidents of the Supreme Judicial Courts of the European Union Conference, 2015, p.11. <https://www.lat.lt/data/public/uploads/2018/01/introductory-report-the-filtering-of-appeals-to-supreme-courts-president-rimvydas-norkus.pdf> сүүлд 2021.12.29-ний өдөр хандав.

¹² Дани, Норвеги зэрэг улсад Дээд шүүхийн нэг хэсэг болсон Давж заалдах зөвшөөрлийн хороо байдаг. Тус хорооны бүрэн эрх, ажиллах журам зэргийг нь Шүүхийн тухай хууль, Хэрэг хянан шийдвэрлэх хуулиудаар тогтоодог ба хороо нь Дээд шүүхээс тогтоосон өөрийн гэсэн дүрэмтэй байдаг. /М.М, Б.М/

¹³ Appeals Permission Board /Анг./

¹⁴ No Judicial Filtration /Анг./

мэргэжлийн хуульчид үйлчлүүлэгчиддээ гарч болзошгүй үр дүнгийн талаар зөвлөгөө өгөх, улмаар Дээд шүүхэд үндэслэлгүй гомдол гаргах шүүлтүүрийн нэг хэлбэр болж ажиллах ёстой байдаг.¹⁵ Энэ загвар нь Франц, Бельги, Нидерланд, Эстони, Испани, Грек, Итали зэрэг улсуудад байдаг.

Холимог загвар

Энэ загвар нь үндсэндээ Процесс хуулиуддаа хяналтын гомдлыг хүлээн авах нарийвчилсан үндэслэлүүдийг хуульчилснаас Дээд шүүхээс гомдлыг хүлээн авах эсэхээ шийдвэрлэдэг, эсхүл гомдлыг хүлээн авах эсэхээ мэтгэлцээний үндсэн дээр шийдвэрлэдэг байна. Энэ загварын жишээ нь Литва Улс юм.¹⁶

2.3. Хяналтын гомдлын хязгаарлалт ба тулгамдсан асуудал

2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр батлагдсан Шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 25 дугаар зүйлийн 25.4-д “Улсын дээд шүүх давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу хянан үзэх замаар хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангана.” гээд 25.7.5¹⁷-д Улсын дээд шүүх хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах зорилгоор давж заалдах шатны шүүхийн магадлалыг хяналтын журмаар хянан шийдвэрлэх 3 тохиолдлыг хуульчилсан. Үүний дагуу хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиудад¹⁸ холбогдох нэмэлт, өөрчлөлт¹⁹ орсон. Хяналтын гомдол гаргах үндэслэл бүрийг тус бүрд нь

¹⁵ Nikolina Katić, Matea Bašić, Morana Briški, “Right of Access to Supreme Courts in Light of the Guarantees under Article 6 § 1 of the Convention on Human Rights and Fundamental Freedoms (civil aspect)”, CIRR XXIV (81)-2018, p.75.

¹⁶ Rimvydas Norkus, “The Filtering of Appeals to the Supreme Court”, Network of the Presidents of the Supreme Judicial Courts of the European Union Conference, 2015, p.12. <https://www.lat.lt/data/public/uploads/2018/01/introductory-report-the-filtering-of-appeals-to-supreme-courts-president-rimvydas-norkus.pdf> сүүлд 2021.12.29-ний өдөр хандав.

¹⁷ Шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7.5.а.анхан болон давж заалдах шатны шүүхийн хууль хэрэглээний зөрүүг арилгах; 25.7.5.б.хуулийг Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн; 25.7.5.в.хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ноцтой зөрчил гаргасан нь шүүхийн шийдвэрт нөлөөлсөн.

¹⁸ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль

¹⁹ Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.2-т “Дараах үндэслэлээр Улсын дээд шүүхэд хяналтын журмаар гомдол гаргана.” гээд “123.2.1.анхан болон давж заалдах шатны шүүх хуулийг зөрүүтэй хэрэглэсэн; 123.2.2.хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ноцтой зөрчил гаргасан нь шүүхийн шийдвэрт нөлөөлсөн; 123.2.3.шүүх хуулийг Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн.” гэж, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 40.1 дүгээр зүйлийн “1.1.анхан болон давж заалдах шатны шүүх Эрүүгийн хуулийг зөрүүтэй хэрэглэсэн; 1.2.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг ноцтой зөрчсөн нь шүүхийн шийдвэрт нөлөөлсөн; 1.3.шүүх хуулийг Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн.” гэж, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 127 дугаар зүйлийн 172.2-т “Хяналтын журмаар дараах үндэслэлээр гомдол гаргана.” гээд “172.2.1.анхан болон давж заалдах шатны шүүх хуулийг зөрүүтэй хэрэглэсэн; 172.2.2.хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ноцтой зөрчил гаргасан нь шүүхийн шийдвэрт нөлөөлсөн; 172.2.3.шүүх хуулийг Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн.” гэж тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан.

авч үзвэл,

Анхан болон давж заалдах шатны шүүх хуулийг зөрүүтэй хэрэглэсэн гэх үндэслэлийн тухайд: Шүүхүүд хуулийг зөрүүтэй хэрэглэх боломж нь хэвтээ болон босоо чиглэлд байдаг. Босоо чиглэл гэдэгт анхан болон давж заалдах шатны шүүхүүд хуулийг ялгаатай байдлаар хэрэглэхийг хэлэх бол хэвтээ чиглэлд гэдэг нь шатлалын хувьд ижил төвшний шүүхүүд буюу нэг сумын анхан шатны шүүх өөр нэг дүүргийн анхан шатны шүүх хоорондоо, эсхүл нэг аймгийн давж заалдах шатны шүүх нийслэлийн давж заалдах шатны шүүх хоорондоо ялгаатай байдлаар хуулийг хэрэглэхийг хэлнэ.

Тэгвэл “анхан болон давж заалдах шатны шүүх хуулийг зөрүүтэй хэрэглэсэн” гэх үндэслэлийн томьёоллыг үгийн шууд утгыг баримтлан тайлбарлавал зөвхөн босоо чиглэлд хууль хэрэглээний зөрүү гарсан тохиолдолд Дээд шүүхээс хянан хэлэлцэхээр байна. Хэдийгээр Монгол Улсын Дээд шүүхээс Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн гишүүнд хүргүүлсэн 2021 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн “Тайлбар хүргүүлэх тухай” 2/3466 тоот албан бичгээр тус заалтыг босоо чиглэлээс гадна хэвтээ чиглэл дэх хууль хэрэглээний зөрүүг арилгах агуулгаар тайлбарлан хэрэглэх тухай дурдсан байх боловч хуульч, өмгөөлөгчид хэвтээ чиглэлийн хууль хэрэглээний зөрүүтэй тохиолдлыг Дээд шүүх хянан шийдвэрлэхгүй тохиолдлууд гарсан тухай байр сууриа илэрхийлсээр байгаа тул уг томьёоллын ойлголтын зөрүүтэй байдлыг арилгаж, хэвтээ чиглэлийн хууль хэрэглээний зөрүүтэй байдлыг хамруулсан байхаар томьёолох шаардлагатай.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ноцтой зөрчил гаргасан нь шүүхийн шийдвэрт нөлөөлсөн гэх үндэслэл нь хяналтын журмаар гаргах гомдлыг тодорхой тохиолдлоор хязгаарладаг улс орнуудад түгээмэл хуульчлагдсан байхаас гадна Дээд шүүхийн хувийн зорилгод хамаарах үндэслэл байх тул төрөлжсөн шүүх бүрийн хэрэг маргааныг хяналтын журмаар шийдвэрлэх ажиллагаанд зайлшгүй байх нь зүйтэй үндэслэл юм.

Шүүх хуулийг улсын дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн гэх үндэслэл нь Дээд шүүхийн нийтийн зорилго болох хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах, үндэсний практикийг тогтоох чиг үүрэгт хамаардаг. Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах эрх нь Дээд шүүхэд Үндсэн хуулиар олгогдсон чиг үүрэг юм. Гэвч ийнхүү албан ёсны тайлбар буюу абстракт тайлбар гаргах нь хууль хэрэглээний бүхий л тохиолдлыг хамарч чаддаггүй сул талтай. Албан бус статистик тоо баримтаас харахад Улсын дээд шүүх 1993 оноос хойш 20 жилийн хугацаанд хуулийн заалтыг тайлбарласан 200 гаруй тогтоол гаргасан байна²⁰.

Улсын дээд шүүхийн абстракт тайлбар нь судлаачид, хуульчдын зүгээс Эрүүгийн хуулийг өргөжүүлэн тайлбарлаж хууль ёсны байх

²⁰ А.Базар, “Улсын дээд шүүхээс хууль тайлбарлах, хуулийн нэг мөр, зөв хэрэглэх хангах асуудал”, УБ., 2014 он. 3 дах тал.

зарчимд халдсан тайлбар гаргасан, шүүгчийн хараат бус байдалд халдсан гэх зэрэг шүүмжлэлийг дагуулсаар ирсэн.²¹ Иймд Улсын дээд шүүхээс хуулийн албан ёсны тайлбар гаргах журмыг оновчтой, тодорхой болгох шаардлагатай байна.

Түүнчлэн, ерөнхий 3 үндэслэл нь салбар эрх зүйн онцлогийг тусгаагүй тул цаашид асуудал дагуулах эрсдэлтэй. Шүүхийн ерөнхий зөвлөлийн гаргасан 2020 оны Монгол улсын шүүхийн тайлангаас үзвэл Хяналтын шатны шүүх тус онд нийт 2498 хэргийг хянан шийдвэрлэжээ. Үүнээс эрүүгийн нийт хэргийн 51.5 хувьд нь²² буюу хяналтын шатанд гомдол гаргасан 2 хэрэг тутмын 1-д Дээд шүүхээс доод шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулсан эсхүл хүчингүй болгосон байгаа нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг эцэслэн шийдвэрлэхэд Дээд шүүхийн оролцоо их байдаг нь харагдаж байна. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь хүний Үндсэн хуулиар баталгаажсан эрх, эрх чөлөөг хуулийн дагуу шууд хязгаарлаж, ял шийтгэл ногдуулдагаараа бусад салбар эрх зүйг бодвол “хүнд” гэж нэрлэгддэг. Тиймээс ч Дээд шүүхэд гомдол гаргах эрхийг тодорхой тохиолдлоор хязгаарласан улс орнуудын хувьд эрүүгийн хэрэгт бусад салбар эрх зүйгээс бага босго тавих хандлагатай байна (*Харьцуулсан судалгааны хэсгээс дэлгэрэнгүй үзнэ үү*). Иймд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хяналтын журмаар гомдол гаргах эрхийг хязгаарлахдаа эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны онцлог, Дээд шүүхийн оролцоог харгалзаж, босгыг багасгах зайлшгүй шаардлагатай.

Иргэний нийт хэргийн хувьд 2020 онд хяналтын журмаар нийт 1104 хэрэг шийдвэрлэснээс 43.4 хувьд нь²³, захиргааны нийт хэргийн 31.6 хувьд нь²⁴ Хяналтын шатны шүүх доод шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулсан эсхүл хүчингүй болгосноос үзвэл Хяналтын шатны шүүхийн оролцоо нь эрүү, иргэн, захиргааны төрөлжсөн хэрэг бүр дээр өөр өөр байгаа тул төрөлжсөн шүүх бүрийн онцлогоос шалтгаалж Хяналтын

²¹ Мөн тэнд, 48-49 дэх тал.

²² Хяналтын шатны шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэсэн нийт 685 хэргээс 332 хэрэгт буюу 48.5 хувьд нь тогтоол, магадлалыг хэвээр үлдээж, 152 хэрэгт буюу 22.2 хувьд нь өөрчлөлт оруулж, 201 хэрэгт буюу 29.3 хувьд нь тогтоол, магадлалыг хүчингүй болгож шийдвэрлэсэн.

²³ Хяналтын шатны шүүх нийт 846 хэргийг шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэснээс шийдвэр, магадлалыг хэвээр үлдээж гомдлыг хангахгүй орхисон нь 479 хэрэг буюу 56.6 хувь, шийдвэр, магадлалд нэмэлт өөрчлөлт оруулсан нь 188 хэрэг буюу 22.2 хувь, шийдвэр, магадлал, тогтоолыг бүхэлд нь буюу зарим хэсгийг хүчингүй болгож, шийдвэрийг хэвээр үлдээх буюу өөрчилсөн нь 78 хэрэг буюу 9.2 хувь, шийдвэр, магадлал, тогтоолыг хүчингүй болгож, хэргийг хэрэгсэхгүй болгосон нь 18 хэрэг буюу 2.1 хувь, шийдвэр, магадлал, тогтоолыг хүчингүй болгож, нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон нь 19 хэрэг буюу 2.2 хувь, шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаасан 64 хэрэг буюу 7.6 хувийг тус тус эзэлсэн үзүүлэлттэй байна.

²⁴ 2020 онд хяналтын шатны шүүх хуралдаанаар шийдвэрлэсэн нийт 437 хэргийн 299 буюу 68.4 хувьд шийдвэр, магадлалыг хэвээр үлдээж, гомдлыг хангахгүй орхисон, 46 буюу 10.5 хувьд нь шийдвэр, магадлалд нэмэлт өөрчлөлт оруулсан, 46 буюу 10.5 хувьд нь шийдвэр, магадлал, тогтоолыг бүхэлд нь буюу зарим хэсгийг хүчингүй болгож, шийдвэрийг хэвээр үлдээх буюу өөрчилсөн, 20 хэрэгт буюу 4.6 хувьд нь шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, хэргийг буюу нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон эсхүл нэхэмжлэлийг хангаж, 26 хэрэгт буюу 5.9 хувьд нь шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцааж шийдвэрлэжээ.

шатны шүүхэд гомдол гаргах эрхийг ялгаатай зохицуулах шаардлагатай.

2.4. Хяналтын гомдлыг хэлэлцүүлэхээс татгалзах тухай тогтоол ба түүний үндэслэл

Хэргийн оролцогчдын зүгээс хяналтын журмаар гаргасан гомдлыг Дээд шүүхийн холбогдох танхимын нийт шүүгчдийн хуралдаанаар хэлэлцээд хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиудад заасан гурван үндэслэлд хамаарч байгаа эсэхийг дүгнэж, 4 ба түүнээс дээш шүүгч хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх санал гаргаагүй²⁵ бол энэ тухайн тогтоол гардаг.

Монгол Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн танхим, Иргэний хэргийн танхим, Эрүүгийн хэргийн танхимын нийт шүүгчдийн хуралдааны 2021 оны 06 дугаар сарын 18-ны өдрөөс 11 дүгээр сарын 16-ны хоорондох “Хяналтын гомдлыг хэлэлцүүлэхээс татгалзах тухай” тус тус 8 тогтоолыг судлахад, бүх тогтоолууд хянавал хэсэгтээ “хяналтын журмаар гаргасан гомдлыг хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх талаар дөрөв, түүнээс дээш шүүгч санал гаргаагүй, уг гомдол нь (хэрэг хянан шийдвэрлэх хуулийн холбогдох заалт)-д заасан үндэслэлүүдэд хамаарахгүй байна” гэсэн байх бөгөөд тогтоол нь үндсэндээ 1 нүүр ба 1 нүүрний гуравны нэг хэмжээтэй буюу нийтдээ 2 нүүр 4 хүрэхгүй тогтоол байна.

Шүүгчид тогтоолын үндэслэлдээ хуулийн зүйл заалт, хууль зүйн факт хоёрыг субсумци хийх, эсвэл энэ үйл явцад шүүгч хэрхэн хандсаныг мөн давхар субсумци хийж, эрх зүйт ёсны зарчим, онолын нийтлэг тайлбарыг хэрхэн яаж хэрэглэж²⁶ шийдвэрт хүрснээ бичихийн оронд “дөрөв, түүнээс дээш шүүгч санал гаргаагүй, хуульд заасан үндэслэлд хамаарахгүй байна” гэж бичиж байгаа нь (i) тогтоолыг авсан талууд тус тогтоолд итгэл үнэмшил төрөх байтугай, оньсого мэт үлдэж, шүүх, шүүгчийг хардах нөхцөл бүрдэх²⁷, (ii) шүүгчид хуулийн зүйл заалт, хууль зүйн фактыг хэрхэн дүгнэж, тус үйл явцад шүүгч хэрхэн хандсаныг иргэд, хуульч, судлаачдад мэдэх боломжийг олгохгүй байгаа нь цаашдын хөгжлийг сааруулах нөхцөлийг бүрдүүлж байна.

Хяналтын гомдлыг хэлэлцүүлэхээс татгалзах тухай тогтоол нь нэг талаасаа(нийтийн зорилго) анхан болон давж заалдах шатны шүүх хууль хэрэглээний хувьд нэгдмэл бөгөөд Дээд шүүхийн албан ёсны тайлбараас гажаагүй болохыг баталж байгаа бөгөөд нөгөө талаасаа(хувийн зорилго) иргэний давж заалдах эрх²⁸, шүүхээр шударгаар шүүлгэх эрхийг

²⁵ Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль(2016)-ийн 124 дүгээр зүйлийн 124.3 дах хэсэг; Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль(2002)-ийн 173 дугаар зүйлийн 173.5 дах хэсэг; Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль(2017)-ийн 40.2 дугаар зүйлийн 40.2.3 дах хэсэг.

²⁶ Н.Лүндэндорж, “Шилжилтийн үе: Улс төр, эрх зүйн асуудал”, УБ.,2010, 146-147 дах тал.

²⁷ Мөн тэнд, 147 дах тал.

²⁸ Монгол Улсын Үндсэн хуульд “давж заалдах эрх” гэж томъёолсон байх бөгөөд үүнийг Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар(2000)-т “Иргэнээс анхан шатны шүүхийн тогтоол, шийдвэрийг хуулийн хугацаанд давж заалдсан тохиолдолд хоёрдугаар шатны шүүх хэргийг заавал хянан үздэг” хэмээн тайлбарласан байна. Тус тайлбараас үзвэл, хяналтын шатны шүүхэд гомдол гаргах нь иргэний давж заалдах эрхэд хамаарахгүй мэтээр ойлгогдож байгаа боловч хяналтын шатны шүүх хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах, хуулийг хөгжүүлэх зэрэг нийтийн зорилгоос гадна яг тухайн хэрэг маргааныг

хуульд заасан журмын дагуу хязгаарлаж байгаа явдал болохын хувьд үндэслэлтэй бөгөөд үндэслэлээ тогтоолдоо бичсэн байх ёстой.

III. ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Холбооны Бүгд Найрамдах Герман Улс /ХБНГУ/

ХБНГУ-ын хувьд салбар эрх зүйн онцлогийг харгалзан холбогдох процесс хуулиудын дагуу хяналтын гомдол гаргах тохиолдлуудыг хуульчилсан байдаг.

ХБНГУ-ын Захиргааны хэргийн шүүх хуралдааны тухай хуулийн²⁹ 124 дүгээр зүйлийн 124.2 дах хэсэгт хяналтын гомдол гаргах 5 үндэслэлийг хуульчилжээ. Үүнд: (i) шийдвэрийн үнэн зөв эсэхэд ноцтой эргэлзээ байгаа бол, (ii) тухайн хэрэг нь онцгой факт бүхий, хууль зүйн талаасаа хүндрэлтэй³⁰ маргаан бол, (iii) ач холбогдол бүхий маргаан бол³¹, (iv) шүүхийн шийдвэр нь Холбооны Ердийн дээд шүүх, Холбооны Захиргааны дээд шүүх, Холбооны Үндсэн хуулийн цэцийн хамтарсан шүүх, Холбооны Үндсэн хуулийн цэцийн шийдвэрүүдээс зөрүүтэй байдлаар гарсан бол, (v) Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зөрчил гарсан бол зэрэг нөхцөлүүд хамаарна. Дээрхээс үзвэл, Дээд шүүхийн нийтийн зорилго буюу хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах чиг үүрэгт (ii), (iii), (iv) дах үндэслэлүүд хамаарч байгаа бол, хувийн буюу тухайн хэрэг маргааны оролцогчийн хувьд шүүхийн шийдвэр үнэн зөв гаргах зорилго (i), (v) дахь үндэслэлүүд хамаарч байна.

ХБНГУ-ын Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн³² 543 дугаар зүйлд хяналтын гомдол гаргах 2 үндэслэлийг хуульчилсан. Үүнд: (i) Хууль зүйн хувьд ач холбогдолтой, (ii) Хуулийн цаашдын хөгжил, эсхүл хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангахад хянан хэлэлцэх шүүхээс шийдвэр гарах шаардлагатай.

Литва Улс

Литва Улсын хувьд Европ дах анхны үндсэн хууль батлагдахаас хамаагүй өмнө буюу 1588 онд батлагдсан Литвийн Их Гүнт улсын Гуравдугаар дүрмийн дагуу хяналтын гомдлыг хязгаарлаж байсан³³

үнэн зөв шийдвэрлэх хувийн зорилготой хэмээн үзвэл, давж заалдах эрх нь хуулийн дагуу дээд шатны шүүхэд давж заалдах эрх гэдэг утгаар ойлгогдоно. Иймээс энд давж заалдах эрхийг өргөн утгаар ашиглалаа. /М.М, Б.М/

²⁹ Code of Administrative Court Procedure /Анг./, Verwaltungsgerichtsordnung /Теп./ https://www.gesetze-im-internet.de/englisch_vwgo/englisch_vwgo.html сүүлд 2021.12.29-ний өдөр хандав.

³⁰ Special Factual or Legal Difficulties /Анг./

³¹ Fundamental significance /Анг./

³² Code of Civil Procedure /Анг./, Zivilprozessordnung /Теп./, https://www.gesetze-im-internet.de/englisch_zpo/englisch_zpo.html сүүлд 2021.12.29-ний өдөр хандав.

³³ Rimvydas Norkus, "The Filtering of Appeals to the Supreme Court", Network of the Presidents of the Supreme Judicial Courts of the European Union Conference, 2015, p.1. <https://www.lat.lt/data/public/uploads/2018/01/introductory-report-the-filtering-of-appeals-to-supreme-courts-president-rimvydas-norkus.pdf> сүүлд 2021.12.29-ний өдөр хандав.

бөгөөд тус улсын зохицуулалт хөгжлийн хамаагүй удаан хугацааг туулсан тул харьцуулан судлав.

Тус улсын хувьд салбар эрх зүйн онцлогийг харгалзан хяналтын гомдолд хязгаарлалт тавьдаг байна. Эрүүгийн процесс хуульд Эрүүгийн хуулийг ноцтой зөрчсөн, эсхүл Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг ноцтой зөрчсөн үндэслэлүүдийн аль нэг нь байгаа тохиолдолд л давж заалдах гомдлыг Улсын дээд шүүх хянан хэлэлцэнэ гэж заасан байдаг.³⁴ Эрүүгийн хэргийг ял шийтгэл нь хүний амин чухал эрхийг хязгаарлах боломж олгож байдаг бөгөөд эрүүгийн ял шийтгэлийн өмнө хүн илүү эмзэг болдог учраас эрүүгийн хэргийг хяналтын журмаар хянан хэлэлцэх босго хамгийн бага байх ёстой аж.

Харин Иргэний хэргийн давж заалдах гомдлыг зөвхөн үндэслэлүүдийн аль нэг нь байгаа тохиолдолд л Дээд шүүх нь хянан хэлэлцдэг байна. Үүнд: Материаллаг болон процесс хуулийг зөрчсөн бөгөөд тус зөрчил нь шүүхийн шийдвэр гаргахад нөлөөлсөн бол; 2) шүүхийн шийдвэрт хуулийг хэрэглэхдээ Дээд шүүхээс боловсруулсан хуулийг хэрэглэх, тайлбарлах практикаас гажсан бол; 3) Практик хууль нэгдмэл биш байгаа тохиолдлууд хамаардаг байна.³⁵

Норвеги Улс

Норвеги Улсад үндсэндээ эрүү, иргэн, захиргааны аль ч төрлийн маргааныг “онцгой ач холбогдол бүхий” гэсэн ерөнхий шалгуураар Давж заалдах комисс³⁶ нь аливаа хэрэг маргааныг хяналтын журмаар хянан хэлэлцэх эсэхийг шийддэг. Тухайлбал, Норвеги Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 323 дугаар зүйлийн 1 дүгээр дэд хэсэгт “Улсын дээд шүүхийн Давж заалдах комиссын зөвшөөрөлгүйгээр Улсын дээд шүүхэд давж заалдах гомдол гаргаж болохгүй. Давж заалдах гомдол нь өмнө шийдвэрлэгдэж байгаагүй асуудалтай холбоотой, эсхүл хэргийг Улсын дээд шүүхэд хянан шийдвэрлэх нь онцгой ач холбогдолтой тохиолдолд л тус зөвшөөрлийг олгоно.”³⁷ гэсэн байдаг бөгөөд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийнх нь 30 дугаар зүйлийн 30.4 дэх хэсэгт үүнтэй ижил заалт байдаг.³⁸ Норвеги Улсын нэг онцлог нь зөвхөн эрүүгийн хэргийн тухайд “Хяналтын журмаар хэлэлцүүлэхээс татгалзсан” зөвлөлийн тогтоолд гомдол гаргаж болдог байна.³⁹ Комиссын тогтоол нь чухал асуудлыг анхаараагүй эсвэл

³⁴ Rimvydas Norkus, “The Filtering of Appeals to the Supreme Court”, Network of the Presidents of the Supreme Judicial Courts of the European Union Conference, 2015, p.12. <https://www.lat.lt/data/public/uploads/2018/01/introductory-report-the-filtering-of-appeals-to-supreme-courts-president-rimvydas-norkus.pdf> сүүлд 2021.12.29-ний өдөр хандав.

³⁵ Мөн тэнд,

³⁶ Appeals Selection Committee /Анр/

³⁷ Arnfinn Berdsen, “Deciding what to decide: The filtering mechanism in the Norwegian Supreme Court”, 2018, p.5. <https://www.domstol.no/globalassets/upload/hret/artikler-og-foredrag/deciding-what-to-decide---bardsen-23.02.2018.pdf> сүүлд 2021.12.29-ний өдөр хандав.

³⁸ Мөн тэнд,

³⁹ Мөн тэнд, 20 дах тал.

процедурын томоохон алдаатай гарсан болохыг хүсэлт гаргагч нотлох шаардлагатай байдаг. Зөвлөлийн тогтоолыг өөрчлөх тухай хүсэлтийг тогтоол гарснаас хойш гурван сарын дотор гаргах эрхтэй байдаг.

Түүнчлэн, тус улсын “Хяналтын гомдлыг хэлэлцүүлэхээс татгалзсан” комиссын шийдвэр нь бүрэн үндэслэл бүхий дүгнэлттэй маш ойролцоо⁴⁰ буюу үндэслэлээ хүсэлт гаргагчийн гаргасан үндэслэл бүрийг няцаах замаар гаргадаг байна. Хэд хэдэн шийдвэрийг судалж үзвэл⁴¹, зөвхөн үндэслэл хэсэг нь л гэхэд 6-7 нүүр байгааг дурдах нь зүйтэй.

IV. ДҮГНЭЛТ, САНАЛ

Дээд шүүх доод шатны шүүхийн шийдвэрийг хянах явдлыг тодорхой үндэслэл, тохиолдлоор хязгаарлах нь шүүхийн үр нөлөөг сайжруулах, ачааллыг бууруулах зэрэг ач холбогдолтой.

Манай Улсын хувьд шинэчлэл хийхдээ материаллаг хуулийн буюу Шүүхийн тухай хуулийн холбогдох зүйл заалтыг процесс хуулиуд буюу хэрэг хянан шийдвэрлэх хуулиудад ижил томъёоллоор оруулсан нь салбар эрх зүйн хэрэг маргаануудын онцлогийг харгалзаж үзээгүй хэрэг бөгөөд үүний улмаас зарим нэг хийдлийг үүсгэж, иргэний шүүхээр шударгаар шүүлгэх эрхийг бүрэн хамгаалж чадахгүй байна. Мөн Монгол Улсын шүүхийн тухай хуульд Дээд шүүхийн чиг үүргийг тодорхойлохдоо Дээд шүүхийн хувийн⁴² шинжтэй зорилгыг үгүйсгэсэн байгаа нь Үндсэн хуулийн эрх зүйн зарчмаас явцууруулж буй хэрэг юм. Шүүх эцсийн дүнд хүний эрх, шударга ёсны төлөө юм гэдгийг үгүйсгэж, мартаж болохгүй.⁴³ Түүнчлэн, “Хяналтын гомдлыг хэлэлцүүлэхээс татгалзсан” тухай тогтоол нь үндэслэлээ тодорхой тайлбарлахгүй байгаа нь хэргийн оролцогч, хуульч, судлаачдын дунд Улсын дээд шүүх хяналтын гомдлыг хүлээн авах эсэхийг үзэмжээрээ шийдэж байна гэх эргэлзээ төрүүлж байна.

Уг дүгнэлтэд үндэслэн дараах саналуудыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Шүүхийн тухай хууль буюу материаллаг хуульд Дээд шүүхийн хувийн⁴⁴ шинжтэй чиг үүргийг хуульчлах.
2. Эрүүгийн хэргийн онцлог, мөн чанарын үүднээс, Герман, Литва зэрэг улсуудын жишгээр Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд хяналтын журмаар гомдол хүлээн авах үндэслэлийг бүрэн өөрчилж, өргөжүүлэх.
3. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль болон Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиудад “тухайн хэрэг нь онцгой факт бүхий, хууль зүйн талаасаа хүндрэлтэй маргаан бол”, “ач холбогдол бүхий маргаан бол” гэж

⁴⁰ Мөн тэнд, 21 дэх тал.

⁴¹ Норвеги Улсын Дээд шүүхийн Давж заалдах комиссын 2017 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн шийдвэр <https://www.domstol.no/globalassets/upload/hret/decisions-in-english-translation/sak-2017-778-eng.pdf>

⁴² Private purpose /Анг./

⁴³ Б.Чимид, “Үндсэн хуулийн үзэл баримтлал” тэргүүн дэвтэр, УБ., 2002, 118 дах тал.

⁴⁴ Private purpose /Анг./

нэмэх.

4. Шүүхийн тухай хууль болон хэрэг хянан шийдвэрлэх хуулиуд дахь “Анхан болон давж заалдах шатны шүүх хуулийг зөрүүтэй хэрэглэсэн” гэх үндэслэлийг эргэлзээгүй, тодорхой болгох үүднээс “Шүүх хуулийг зөрүүтэй хэрэглэсэн” гэж томъёоллыг өөрчлөх.
5. Улсын дээд шүүхээс хуулийн албан ёсны тайлбар гаргах журмыг илүү тодорхой, оновчтой байдлаар батлах.
6. Улсын дээд шүүхээс “Хяналтын гомдлыг хэлэлцүүлэхээс татгалзсан” тогтоолоо Норвеги Улсын Давж заалдах комиссын тогтоолын адилаар хуулийн зүйл заалт, хууль зүйн факт хоёрыг субсумци хийх, эсвэл энэ үйл явцад шүүгч хэрхэн хандсаныг мөн давхар субсумци хийж бичдэг болох. “Хяналтын гомдлыг хэлэлцүүлэхээс татгалзсан” тогтоолыг хэрэг хянан шийдвэрлэсэн тогтоолын нэгэн адил Монгол Улсын Шүүхийн шийдвэрийн нэгдсэн санд⁴⁵ нийтэлдэг болох.

V. ЭХ СУРВАЛЖ

Ашигласан хууль тогтоомж

1. Монгол Улсын Үндсэн хууль (1992)
2. Монгол Улсын Шүүхийн тухай хууль (2021)
3. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль (2016)
4. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль (2002)
5. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (2017)
6. Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Захиргааны процессын хууль
7. Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Иргэний процессын хууль
8. Норвеги Улсын Эрүүгийн процессын хууль
9. Норвеги Улсын Иргэний процессын хууль

Ашигласан ном, сурах бичиг, гарын авлага

1. А.Базар, “Улсын дээд шүүхээс хууль тайлбарлах, хуулийн нэг мөр, зөв хэрэглээг хангах асуудал”, УБ., 2014 он.
2. Д.Гангабаатар, “Үндсэн хуулийн эрх зүй: Төрийн байгуулал, зарчим, үзэл баримтлал”, УБ., 2019.
3. Монгол Улсын Дээд шүүхээс Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн гишүүнд хүргүүлсэн 2021 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн “Тайлбар хүргүүлэх тухай” 2/3466 тоот албан бичиг
4. Г.Совд нар, “Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар”, УБ., 2000.
5. Б.Чимид, “Үндсэн хуулийн үзэл баримтлал” тэргүүн дэвтэр, УБ., 2002.

⁴⁵ Монгол Улсын Шүүхийн шийдвэрийн нэгдсэн сан. <https://shuukh.mn> сүүлд 2021.12.29-ний өдөр хандав.

6. Н.Лүндэндорж, “Шилжилтийн үе: Улс төр, эрх зүйн асуудал”, УБ.,2010.
7. Шүүхийн ерөнхий зөвлөл, “Монгол Улсын Шүүхийн тайлан 2020”, УБ.,2021.
8. Jolowicz, J.A., 1997. The role of the Supreme Court at the national level a General Report. In Yessiou-Faltsi P., ed. The Role of the Supreme Courts at the National and International Level, Athens: Sakkoulas Publications
9. Nikolina Katić, Matea Bašić, Morana Briški, “Right of Access to Supreme Courts in Light of the Guarantees under Article 6 § 1 of the Convention on Human Rights and Fundamental Freedoms (civil aspect)”, CIRР XXIV (81)-2018.

Ашигласан цахим материал

1. Д.Ганзориг, “Шүүхийн шинэчлэл: Бие даасан байдал, чиг үүрэг, хариуцлага” илтгэл. <http://www.supremecourt.mn/news/686>
2. Монгол Улсын Шүүхийн шийдвэрийн нэгдсэн сан. <https://shuukh.mn>
3. Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарь <https://legalinfo.mn/mn/detail?lawId=14950>
4. Норвеги Улсын Дээд шүүхийн Давж заалдах комиссын 2017 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн шийдвэр. <https://www.domstol.no/globalassets/upload/hret/decisions-in-english-translation/sak-2017-778-eng.pdf>
5. Хяналтын шатны шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэсэн хэргийн статистик мэдээ, Улсын Дээд шүүхийн албан ёсны цахим хуудас, 2021.12.29-ны өдөр хандав. <http://www.supreme-court.mn/stat>
6. Arnfinn Berdsen, “Deciding what to decide: The filtering mechanism in the Norwegian Supreme Court”, 2018.
7. <https://www.domstol.no/globalassets/upload/hret/artikler-og-foredrag/deciding-what-to-decide---bardsen-23.02.2018.pdf>
8. Leave to Appeal /Анг./ Oxford Reference <https://www.oxfordreference.com/view/10.1093/oi/authority.20110803100056563>
9. Leave to Appeal /Анг./ World Law Dictionary <https://dictionary.translegal.com/en/leave-to-appeal/noun>
10. Rimvydas Norkus, “The Filtering of Appeals to the Supreme Court”, Network of the Presidents of the Supreme Judicial Courts of the European Union Conference, 2015. <https://www.lat.lt/data/public/uploads/2018/01/introductory-report-the-filtering-of-appeals-to-supreme-courts-president-rimvydas-norkus.pdf>



**Мэндбаярын АМИНА
Зоригтын ЯНЖИНДУЛАМ**

МУИС-ийн 4 дүгээр
түвшиний оюутнууд
(Гутгаар байр)

ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮНИЙ ШҮҮГЧ БУС ГИШҮҮДИЙГ УЛСЫН ИХ ХУРЛААС ТОМИЛЖ БҮЙ ӨНӨӨГИЙН ПРАКТИК БА ТУЛГАМДСАН АСУУДАЛ

УДИРТГАЛ:

Монгол Улсын хувьд /цаашид МУ-ын гэх/ 1992 оны ардчилсан Үндсэн хуулиа баталсантай холбоотойгоор эрх мэдлийн хуваарилалт, тэдгээрийн хараат бус, бие даасан байдлын баталгааг Үндсэн хуульдаа тусгаж органик хуулиараа бэхжүүлэхээр зохицуулсан. Шүүх эрх мэдлийн шинэчлэлийн салшгүй нэг хэсэг бол шүүхийн захиргааны удирдлагын буюу Шүүхийн Ерөнхий Зөвлөл /цаашид ШЕЗ гэх/-ийн шинэчлэл юм. Үүний дагуу Шүүх эрх мэдлийн хараат бус, бие даасан байдлын баталгааг ШЕЗ бүрдүүлэхээр¹ тусгайлан заасан байна. 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтөөс өмнө Үндсэн хуульд ШЕЗ-ийн эрх хэмжээг органик хуулиар зохицуулахаар зааж ирсэн. Харин 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтөөр ШЕЗ-ийн гишүүдийн тавыг нь шүүгч нар дотроосоо, таван шүүгч бус гишүүнийг нээлттэйгээр сонгон шалгаруулах буюу нийт арван гишүүнтэй байхаар Үндсэн хуульд тусгасан нь эрх зүйн хувьд томоохон дэвшил болсон юм. Гэхдээ тус нэмэлт өөрчлөлт нь органик хуульд тусгагдаагүйгээс хэрэгжихгүй явсаар 2021 оны шинэчлэн баталсан Шүүхийн тухай² хуулиар ШЕЗ-ийн бүрэлдэхүүн нь арван гишүүнтэй байх бөгөөд таван гишүүнийг шүүгч нар дундаас шүүгч бус таван гишүүнийг Улсын Их Хурал /цаашид УИХ гэх/ томилохоор зохицуулсан байна. Энэ нь Шүүх эрх мэдэлд нэгэн шинэ тогтолцоог бий болгож байна гэж үзэх үндэслэлтэй юм.

Шүүгчийн сонгон шалгаруулалт, шүүгчийн томилгоонд голлох үүрэгтэй оролцдог ШЕЗ нь шүүгчид нэр дэвшигчийг шударгаар үнэлдэг байхын тулд түүний хараат бус, бие даасан байдлаар ажиллах нөхцөл бүрдсэн байх учиртай³. Үүнээс үзвэл ШЕЗ-ийн хараат бус, бие даасан

¹ Монгол Улсын Үндсэн хууль, (1992), дөчин есдүгээр зүйлийн 49.3.

² Монгол Улсын Шүүхийн тухай хууль, Шинэчилсэн найруулга (2021), 76 дугаар зүйлийн 76.2.

³ П. Баттулга М. Мөнхжаргал Ж. Хунан нар, Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлын

байдалтай байх нь эргээд нийт шүүгч нарын хараат бус байдалд нөлөөлдөг, харилцан хамаарал бүхий байдаг байна. Шүүх эрх мэдэл хараат бус байхын эрх зүйн баталгаа нь тэрээр бие даасан, шүүгч хараат бус байх нөхцөл бүрэлдсэн байх явдал мөн⁴. Гэтэл УИХ-аас ШЕЗ-ийн шүүгч бус гишүүнийг томилж буй нь шүүх эрх мэдлийн бие даасан, хараат бус байдалд нөлөөлөх боломжтой байх юм. Иймд 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтөөс өмнө Үндсэн хуульд ШЕЗ-ийн эрх хэмжээг органик хуулиар зохицуулахаар зааж ирсэн. Харин 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтөөр ШЕЗ-ийн гишүүдийн тавыг нь шүүгч нар дотроосоо, таван шүүгч бус гишүүнийг нээлттэйгээр сонгон шалгаруулах буюу нийт арван гишүүнтэй байхаар Үндсэн хуульд тусгасан нь эрх зүйн хувьд томоохон дэвшил болсон юм. Гэхдээ тус нэмэлт өөрчлөлт нь органик хуульд тусгагдаагүйгээс хэрэгжихгүй явсаар 2021 оны шинэчлэн баталсан Шүүхийн тухай⁵ хуулиар ШЕЗ-ийн бүрэлдэхүүн нь арван гишүүнтэй байх бөгөөд таван гишүүнийг шүүгч нар дундаас шүүгч бус таван гишүүнийг Улсын Их Хурал /цаашид УИХ гэх/ томилохоор зохицуулсан байна.

НЭГ. ОЙЛГОЛТ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

1.1. Шүүхийн ерөнхий зөвлөлийн тухай ойлголт

Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлалд шүүх эрх мэдлийн хараат бус байдлыг дотор нь “шүүгчийн хараат бус”, “шүүхийн бие даасан байдал” гэсэн хоёр хэсэгт салган авч үзсэн байна⁶. ШЕЗ нь хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагаас хараат бусаар, бие даан ажиллах нөхцөлийг хамтын удирдлагатай тусгай байгууллага байгуулж, түүний зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтоож, тэрхүү байгууллага нь шүүн таслах ажиллагаанд оролцохгүйгээр хүний нөөц, төсөв санхүү зэрэг шүүхийн байгууллагын бие даан, тогтвортой, хараат бус ажиллах нөхцөлийг хангаж ажиллахаар хуульчилсан нь шүүх эрх мэдлийн бие даасан байдлын зохион байгуулалтын нэг үндэс мөн⁷. Үүнээс үзвэл ШЕЗ-ийн гол үүрэг нь Үндсэн хуульд заасанчлан шүүгчийн хараат бус байдал болон шүүхийн бие даасан байдлыг хангах байна. Үндсэн хуульд ШЕЗ-ийн эрх зүйн байдлыг шүүхийг удирдах байгууллага гэсэн утгаар биш, харин хараат бус хийгээд бие даасан байдлыг хангах баталгаа гэсэн байр сууринаас тодорхойлжээ. Үүнээс үзэхэд ШЕЗ бол засаг төрөөс шүүхэд үзүүлэх нийтийн үйлчилгээг эрхэлсэн, бие даасан

баталгаа: шүүгчийн томилгоо, Нээлттэй Нийгэм Форум, (2015), 36. <https://legalddata.mn/b/128>

⁴ Л.Бямбаа, Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлын тухай Үндсэн хуулийн эрх зүйн үндэслэл, Ч. Өнөрбаяр, А. Бямбажаргал нар, Үндсэн хуулийн эрх зүйн судалгаа шинжилгээний тойм, бүтээл, (УБ, 2019) 268.

⁵ Монгол Улсын Шүүхийн тухай хууль, Шинэчилсэн найруулга (2021), 76 дугаар зүйлийн 76.2.

⁶ Л.Бямбаа, Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлын тухай Үндсэн хуулийн эрх зүйн үндэслэл, Ч. Өнөрбаяр, А. Бямбажаргал нар, Үндсэн хуулийн эрх зүйн судалгаа шинжилгээний тойм, бүтээл, (УБ, 2019) 268.

⁷ Мөн тэнд.

гүйцэтгэх байгууллага мөн⁸. Иймд, ШЕЗ-ийн хараат бус, бие даасан байдал болон шүүх эрх мэдлийн хараат бус, бие даасан байдал нь хоорондоо харилцан хамаарал бүхий юм.

ШЕЗ-ийн үүрэг болох Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангана гэдэг нь төрийн бусад эрх мэдэл (хууль тогтоох, гүйцэтгэх)-ээс шүүх эрх мэдлийг бүрэн тусгаарлаж, шүүгч чиг үүргээ зөвхөн хуульд нийцүүлэн чөлөөтэй, айдасгүй мэргэжлийн өндөр түвшинд хэрэгжүүлэх хууль зүйн болон хувийн баталгаа бүрдүүлэхийг хэлнэ⁹. Үүнээс үзвэл ШЕЗ нь төрийн бусад эрх мэдлээс шүүх эрх мэдлийг тусгаарлах үүрэг хүлээж байх боловч эргээд тэр тусгаарлах үүрэг хүлээж буй этгээд нь хууль тогтоох эрх мэдлээс хараат болох нөхцөлийг 2021 оны шүүхийн тухай хуулиар бүрдүүлсэн гэж үзэж болохуйц байх буюу тус ШЕЗ-ийн нийт гишүүний тавин хувийг УИХ дангаараа томилохоор заажээ.

Шүүхийн захиргааны чиг үүргийг хэрэгжүүлэхэд түүний бүрэлдэхүүн чухал үүрэгтэй билээ. Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангаж хамгаалах чиг үүргийг хэрэгжүүлэх бүрэлдэхүүнийг Үндсэн хуулийн түвшинд дэлхийн улс орнууд хуульчилдаг аж. Манай улс ШЕЗ-ийн бүрэлдэхүүний гишүүний томилгоо, арга ажиллагааг органик хуулиар зохицуулсан нь хэврэг төдийгүй, шүүхийн хараат бус байдлыг хамгаалах субъект чадамжгүй болж, шүүх манаачгүй болоход хүрч болзошгүй тул дэлхийн улс орнуудын жишгээр ШЕЗ-ийн бүрэлдэхүүнийг өргөжүүлэн Үндсэн хуулиар тодорхойлох нь олон улсын чиг хандлагад нийцнэ¹⁰ гэж үздэг аж. Шүүхийн захиргааг Үндсэн хуулийн түвшинд онцгойлон анхаарч зохицуулах шаардлага нь, нэгдүгээрт, шүүхийн байгууллага өөрөө бие даасан, хараат бус байдлаа бусад эрх мэдлээс хамгаалах нь ашиг сонирхлын зөрчилд хүргэж болзошгүй юм. Хоёрдугаарт, шүүгч өөрийн хараат бус байдлаа хангаж, хамгаалах нь хараат бус байдлаа алдах эрсдэлийг ямагт дагуулдаг тул ШЕЗ-ийг Үндсэн хуулиараа зохицуулах нь зохистой. Гуравдугаарт, шүүх эрх мэдэл бусад эрх мэдэл шиг олон нийтийн шууд дэмжлэгт тулгуурладаггүй, харин итгэл, хяналтад оршдог учраас Үндсэн хуулиараа бэхжүүлэх шаардлагатай учраас шүүхийн захиргааны суурь асуудлыг олон улсын жишгийн дагуу Үндсэн хуулийн түвшинд нарийвчлан зохицуулах нь зөв билээ.

2021 оны “Монгол Улсын Шүүхийн тухай” хуулийн 76 дугаар зүйлийн 76.2-т “Ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүнд бусад таван гишүүнийг нээлттэй сонгон шалгаруулалтын үндсэн дээр Улсын Их Хурал томилно” хэмээн шинэчлэн найруулсан нь шүүгч бус гишүүнийг УИХ дангаар томилох шийдвэр гаргах эрх зүйн орчныг бүрдүүлж, улмаар ШЕЗ-ийг хууль тогтоох байгууллагаас хараат болгож байгаа нь түүний хараат бус, бие даасан байх шинжийг сулруулж болзошгүй юм.

⁸ Б.Чимид, *Үндсэн хуулийн мэдлэг*, (УБ, 2008) 328.

⁹ Н. Лүндэндорж, *Төрийн онол*, (УБ, 2008) 228.

¹⁰ Н.Лүндэндорж, *Үндсэн хууль ба шүүх эрх мэдэл*, Ч. Өнөрбаяр, А. Бямбажаргал нар, Үндсэн хуулийн эрх зүйн судалгаа шинжилгээний тойм, бүтээл, (УБ, 2019) 114.

1.2. Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн шүүгч бус гишүүнийг Улсын Их Хурлаас томилох нь шүүгчийн хараат бус байдалд нөлөөлөх эсэх

ШЕЗ “шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах зорилгоор ажиллана” хэмээн Үндсэн хуулийн 49 дүгээр зүйлийн 3-т заасан. Энэ заалтаас шүүхийн бие даасан байдал ба шүүгчийн хараат бус байдлыг хангах нь ШЕЗ-ийг байгуулах анхдагч үзэл баримтлал, гол чиг үүрэг¹¹ нь мөн боловч ШЕЗ нь шүүгчийг сонгон шалгаруулах, албан тушаалаас нь чөлөөлөх, бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх зэрэг чиг үүргээр дамжуулан шүүхийн шүүн таслах чиг үүрэгт хөндлөнгөөс нөлөөлөх эрсдэлтэй байдаг¹². Үүнээс үзвэл ШЕЗ-ийн гишүүдийн шүүх эрх мэдэлд нөлөөлөх боломжийг хязгаарлах болон хариуцлагын механизмыг сайжруулах шаардлагатай. Түүнчлэн ШЕЗ-ийн гишүүдэд нөлөөлж болохуйц буюу томилж буй субъектийн нөлөөллийг хязгаарлахгүйгээр шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах боломжгүй юм.

Шүүхийн бие даасан байдлыг хангах гэдэг нь хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлээс шүүхийг бие даасан байлгах тухай ойлголт билээ. ШЕЗ-ийн гишүүнийг хэн нэр дэвшүүлэх, томилох, эсхүл хэн албан тушаалаараа орох вэ гэдгээс шүүхийн бие даасан, хариуцлагатай байдлыг хамгаалах зорилгод үйлчлэх эсэх нь хамаардаг. ШЕЗ шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах зорилгод үйлчлэх гол баталгаа нь түүний гишүүдийн олонхыг шүүгчдээс бүрдүүлэх хэрэгтэй гэж зөвлөдөг. Монгол Улсад ШЕЗ-ийн бүрэлдэхүүний олонхыг дандаа шүүгчид бүрдүүлж ирсэн. Гэвч, ШЕЗ дэх шүүгчийн төлөөлөл олонх байсан нь Монголын нийт шүүгчдийн төлөөллийг хангаж байсан гэвэл өрөөсгөл юм. Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн ажилласан эхний 20 жилд бүрэлдэхүүнд Улсын Дээд Шүүхийн нөлөө шууд болон шууд бусаар хамгийн хүчтэй байжээ¹³. Иймд, ШЕЗ-ийн гишүүний бүрэлдэхүүнийг томилохдоо нийт шүүхийн нийт шүүгчдийн тоог харгалзан төлөөллийг бий болгох шаардлагатай. Тухайлбал, манай улсын хувьд анхан шатны шүүхийн шүүгч болон хяналтын шатны шүүхийн нийт шүүгчдийн тоо харьцангуй ялгаатай байх тул тус ялгаан дээр суурилж төлөөллийг бий болгох нь зохистой юм.

Шүүхийн бие даан ажиллах нөхцөлийг хангахын тулд засаглалын бусад байгууллагуудтай харилцан үйл ажиллагаагаа уялдуулсны дүнд хэрэгжих өргөн хүрээ бүхий энэхүү үүргийг ШЕЗ-д Үндсэн хуулиар ногдуулсан нь ШЕЗ-ийн бүрэлдэхүүнд засаглалын бусад байгууллагын төлөөллийг оролцуулах шаардлагыг нөхцөлдүүлж, хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагуудын хоорондын харилцааны эрх зүйн

¹¹ Б.Чимид, *Үндсэн хуулийн үзэл баримтлал: Хүний эрх, шүүх эрх мэдэл*, Хоёрдугаар дэвтэр (УБ, 2004), 140-141

¹² П.Баттулга, *Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн бүрэлдэхүүнийг үндсэн хуулиар тодорхойлсны ач холбогдол юу вэ?*, (УБ, 2020) 2. <https://legaldata.mn/b/656>

¹³ О.Мөнхсайхан, Ж.Алтансүх, Ж.Цагаанбаяр, *Монгол Улс дахь шүүхийн захиргааны загвар: Тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам*, (УБ., 2015) 45-46

үндэс болдог¹⁴. ШЕЗ-ийн төлөөлөх чадавхыг нэмэгдүүлэх, бие даасан байдлыг бэхжүүлэхийн тулд ШЕЗ-ийн гишүүдийн тоог 10-аас дээш болгон нэмэгдүүлэх, шүүгчдийн зөвлөгөөнд ШЕЗ-ийн гишүүнийг сонгоход чөлөөтэй, шууд, тэгш байх зарчмыг баримталж шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлын хамгаалалтыг сайжруулахын тулд ШЕЗ-ийн гишүүдийг ерөнхийлөгч томилдог зохицуулалтыг өөрчлөх нь 2021 оны Шүүхийн тухай хуулийн төслийн үзэл баримтлал¹⁵ байсан. Гэтэл Шүүхийн тухай хуульдаа шүүгч бус таван гишүүнийг буюу ШЕЗ-ийн нийт гишүүдийн тавин хувийг УИХ томилно гэж зохицуулсан нь нэг субъектийн нөлөөллөөс гарч өөр нэгэн субъектийн нөлөөлөлд орох нөхцөлийг бүрдүүлсэн буюу төслийн үзэл баримтлалдаа нийцээгүй байх юм.

1.3. Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн шүүгч бус гишүүнийг Улсын Их Хурлаас томилох нь үндэслэлтэй эсэх

Үндсэн хуульд шүүх эрх мэдэл засгийн гурван салааны нэгийн хувьд бие даасан байх, шүүгч нь түүний бүрэлдэхүүний хувьд бусдаас хараат бус байхыг онцгойлон зохицуулсан бөгөөд үүний хүрээнд ШЕЗ нь төрийн бүх л байгууллага, албан тушаалтан, бусад хүний хөндлөнгийн оролцоо, болзошгүй дарамтаас шүүхийг сэргийлэхэд үйл ажиллагааныхаа голыг чиглүүлэх учиртай¹⁶. Мөн ШЕЗ нь шат шатны шүүхээс шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд шаардагдах хүний нөөц, боловсон хүчин, материал техникийн хэрэгцээ, ялангуяа шүүгчийн эрх ашгийг хамгаалах, шүүхийн бие даасан байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлэхийн тулд төвлөрч ажиллах учиртай¹⁷. Үүнээс үзвэл ШЕЗ-ийн хараат бус байх нь эргээд шүүх эрх мэдэл, шүүгчийн хараат бус байдалтай шууд холбоотой байх юм.

Нээлттэй нийгэм форумаас явуулсан судалгаанд “ШЕЗ-ийг ямар байгууллага, албан тушаалтны төлөөллөөс бүрдүүлэх нь зохистой вэ?” гэсэн тухайлсан асуултад судалгаанд оролцогчдын хариулсан байдлыг авч үзвэл шүүгчдийн дийлэнх нь ШЕЗ-ийг шүүх, Монголын хуульчдын холбоо, Монголын шүүгчдийн холбоо, ТББ-ын төлөөллөөс бүрдүүлэх нь зүйтэй гэж үзсэн байх бөгөөд харин ШЕЗ-ийн гишүүнийг төрийн байгууллага, албан тушаалтан санал болгох болон томилдог байхыг дэмжихгүй байгаа нь харагдаж байна. Мөн судалгаанд хамрагдсан нийт шүүгчдийн 64 хувь нь ШЕЗ-ийн гишүүнийг улс төрийн байгууллага, албан тушаалтан санал болгох, томилохгүй байх нь хараат бусаар ажиллахад нөлөөлөх чухал хүчин зүйл гэж үзсэн байна¹⁸. Үүнээс үзвэл ШЕЗ-ийн хараат бусаар үйл ажиллагаа явуулахад нөлөөлж буй хүчин зүйлийн нэг нь гишүүдийг нь

¹⁴ Ц.Нямдорж, *Шүүхийн хараат бус байдлын эдийн засаг, зохион байгуулалтын баталгаа*, Ханнес Зайделийн сан “Шүүх эрх мэдэл-шинэ зуун” олон улсын онол-практикийн бага хурал, (УБ, 2001) 107 дахь тал

¹⁵ Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлал, (2021) <https://mgl-bar.mn/storage/files/u8aGyWpexKotpqAJ9s64zYxQlWVdkSBEdVEBUqYP.pdf>

¹⁶ Б. Чимид, *Үндсэн хуулийн үзэл баримтлал: Хүний эрх, шүүх эрх мэдэл*, (2004) 143.

¹⁷ Ц.Цогт, УХНӨ: Шүүхийн ерөнхий зөвлөлийн чиг үүрэг юу вэ, (2019) <https://legaldata.mn/b/777>

¹⁸ П. Баттулга М. Мөнхжаргал Ж. Хунан нар, *Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлын баталгаа: шүүгчийн томилгоо, Нээлттэй Нийгэм Форум*, (2015), 36. <https://legaldata.mn/b/128>

томилж буй эрх бүхий албан тушаалтан байх юм. Хэдийгээр ШЕЗ-ийн шүүгч бус гишүүдийг хууль тогтоогчоос сонгох нь зүйтэй гэсэн үзэл байх боловч энэ нь тодорхой шалгууртай байх шаардлагатай байна.

“Транспэрэнси Интернэшнл” Олон улсын байгууллагын судалгаанд дурдсанаар шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдалд халдах гэсэн улс төрийн нөлөөлөл, санал санаачлага нь шүүгчийн томилгоо, шүүхийн тогтолцоог системээр нь өөрчлөх зэрэг арга, хэлбэрээр илэрдэг¹⁹. Үүнээс үзвэл ШЕЗ буюу шүүгчийг томилох эрх бүхий байгууллагын нийт бүрэлдэхүүний тал гаруй гишүүнийг УИХ-аас томилох нь шүүгчийн хараат бус байдалд нөлөөлөх эрсдэл бүхий байх тул тодорхой хязгаарлалтыг хуульчлах шаардлагатай байна. О. Мөнхсайхан судлаач ШЕЗ-ийн шүүгч биш таван гишүүний дөрвийг УИХ-ын Хууль зүйн байнгын хороо гуравны хоёрын саналаар томилох, нэгийг Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн томилохоор зохицуулах саналтай байна. Салбарын бодлого боловсруулж хэрэгжүүлдэг гол яамны сайдаас ШЕЗ-ийн шүүгч биш гишүүний нэгийг томилох нь зохистой хүрээнд тус яам болон ШЕЗ-ийн уялдааг хангах, шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах тал дээр илүү сайн ойлголцож итгэлтэй хамтран ажиллахад тустай. ШЕЗ-ийн шүүгч таван гишүүнийг бүх шатны шүүгчдээс бүрдсэн бүрэлдэхүүн сонгож, шүүгч биш таван гишүүний дөрвийг УИХ дахь олон цөөнхийн аль алины хүлээн зөвшөөрснөөр буюу дийлэнх олонхоор томилох, үлдсэн шүүгч биш нэг гишүүнийг хууль зүйн салбарын бодлогыг хариуцсан сайд томилох нь ШЕЗ-ийн бүрэлдэхүүнийг зохистой тэнцвэржүүлж улс төрийн аль нэг нам, эвсэл давамгайлахаас сэргийлж шүүгчийн хараат бус, хариуцлагатай байдлын баталгаа болно²⁰. Үүнээс үзвэл одоо даган мөрдөж буй Шүүхийн тухай хуульд²¹ Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар нэр дэвшигчийг Ерөнхий зөвлөлийн гишүүнээр томилно гэж зааснаас үзвэл тухайн УИХ-д давамгай суудал эзэлдэг аль нэг нам эвслийн хүсэл зоригоос хамааран ШЕЗ-ийн гишүүдийг томилох эрх зүйн орчин бүрдсэн байна. Үүний нэг тод илрэл нь УИХ-ийн 2021 оны Намрын улирлын ШЕЗ-ийн гишүүдийг томилох хуралдаанаар 41-н гишүүн ирж, 53.9 хувьтай ирц бүрдсэн бөгөөд Н. Отгончимэгийг томилохыг 66.7-н хувь буюу 27 гишүүн дэмжсэнээр томилогдсон, харин Д.Эрдэнэчимэгийг 42.9 хувь буюу 17 гишүүн дэмжсэнээр сонгоогүй²² байна. Шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгаар ШЕЗ-ийн шүүгч бус гишүүдийг УИХ томилохдоо олонхын саналаар гэж зохицуулснаас 21-н гишүүний саналыг авсан нэр дэвшигч ШЕЗ-ийн гишүүн болж томилогдох нөхцөл бүрдэж байх юм. Манай улсын хувьд нэг нам давамгайлсан буюу УИХ-ын нийт гишүүдийн

¹⁹ Б. Эрхэмбаяр, М. Мөнхжаргал нар, *Шүүхийн шинэтгэл ба шүүгчийн хараат бус байдал*, (2013), <https://legaldata.mn/b/21>

²⁰ О.Мөнхсайхан, *Монгол Улсын шүүхийн тухай хуулийн төслийн талаарх санал*, (УБ, 2020) 24. <https://legaldata.mn/b/772>

²¹ Монгол Улсын Шүүхийн тухай хууль, 77 дугаар зүйлийн 77.7 дахь заалт.

²² Монцамэ агентлаг, ШЕЗ-ийн шүүгч бус дөрвөн гишүүнийг томиллоо.

<https://www.montsame.mn/mn/read/282259> -аас хамгийн сүүлд 2021.12.29-нд хандав.

61 суудал²³ нь Монгол Ардын Нам /цаашид МАН гэх/-ын харьяалалтай буюу 80 гаруй хувийг нь нэг нам дангаар эзэлж буй нөхцөлд нийт ирсэн гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэх нь нэг намын нөлөөлөлд орж болзошгүй байна.

ХОЁР. ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Хамгийн анх Бүгд Найрамдах Франц улс /цаашид Франц гэх/ болон Бүгд Найрамдах Итали улсуудад /цаашид Итали гэх/ ардчилсан бус дэглэмийг халсны дараа шүүх эрх мэдлийн бие даасан, хараат бус байдлыг бэхжүүлэхийн тулд “Шүүхийн зөвлөл”-ийг байгуулж байжээ. Өмнөд Европын шүүхийн захиргааны загварыг анх Франц (1946), Итали (1958) улсад туршиж хэрэглэснээс хойш Испани, Португали, Латин Америкийн орнууд, Пост-социалист орнуудад нутагшуулан авсан²⁴. Иймд, Итали болон Франц улсын эрх зүйн тогтолцоог судлах болно.

2.1. Бүгд Найрамдах Итали улс

“Freedom House”-ийн судалгаагаар ардчиллын үзүүлэлтээр 100 онооноос 90 оноо авч эрх чөлөөтэй гэсэн үзүүлэлттэй байдаг Итали улсын хувьд Шүүхийн бие даасан байдлын үзүүлэлтээр 4-өөс 4 оноо авдаг буюу бие даасан, хараат бус шүүхтэй байна. Шүүх нь ерөнхийдөө хараат бус, бие даасан байдаг. Шүүхийн дотоод засаглалыг хянадаг Шүүхийн дээд зөвлөлийн гишүүдийн эрх мэдлээ урвуулан ашигласан, авилга хээл хахуулийн гэмт хэрэг үйлдсэн гэх үндэслэлээр 2020 оны 8-р сард Зөвлөлийн хариуцлага, ил тод байдлыг сайжруулах, санал оруулах зэрэг шинэчлэлийн хүчин чармайлтад хүргэсэн байна²⁵. Иймд шүүхийн дээд зөвлөл нь Шүүх эрх мэдэл, шүүгчийн хараат бус байдлыг бий болгох зорилготой байтал өөрсдөө авлига авч, зүй бус нөлөөлөлд автсан нь ажлын хариуцлага алдсан үйлдэл юм. Манай Улсын хувьд хариуцлага болоод ил тод байдлыг сайжруулах талын арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай юм.

Италийн Үндсэн хуульд Зөвлөл хэдэн гишүүнээс бүрдэх ёстойг шууд заагаагүй, зөвхөн үндсэн болон энгийн гишүүдийн эзлэх хувь хэмжээг заадаг тул энэ асуудлыг нарийвчилсан хуулиар зохицуулдаг²⁶. Одоогоор арван зургаан гишүүн (хоёр нь давж заалдах шатны шүүхийн шүүгч, дөрөв нь прокурор, арав нь анхан шатны шүүгч), шүүгч бус найман гишүүн байна. Ийнхүү Зөвлөл нийт хорин долоон гишүүнтэй байна. Эдгээр гишүүд бүрэн эрхийн хугацаа нь дууссаны дараа шууд дахин сонгогдох боломжгүй бөгөөд тэдгээрт парламентын гишүүн, бүсийн зөвлөлийн гишүүн байж

²³ Монгол Улсын Их Хурал-ын албан ёсны сайт, <http://parliament.mn/cv?tid=2&pid=1> -аас хамгийн сүүлд 2021.12.29-нд хандав.

²⁴ О.Мөнхсайнхан, Ж.Алтансүх, Ж.Цагаанбаяр, Монгол Улс дахь шүүхийн захиргааны загвар: Тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам, (УБ., 2020) 157

²⁵ Freedom House, *Italy: Freedom in the World 2021*, Country Report. <https://freedomhouse.org/>

²⁶ Бүгд Найрамдах Итали улсын Үндсэн хууль, (1947) [Imparato ok\(senato.it\)](http://imparlato.ok(senato.it))

болохгүй гэсэн хязгаарлалт тавигддаг. Зөвлөлийн сонгогдсон гишүүд дөрвөн жилийн хугацаатай ажилладаг²⁷. Үндсэн хуульдаа шүүхийн дээд зөвлөлийн гишүүдийн ерөнхий зохицуулалтыг хуульчилж нарийвчилсан хуулиар бүтэц, чиг үүргийг нь зохицуулж буй нь нийтлэг байх юм.

Итали улсын шүүхийн дээд зөвлөлийг албан ёсоор Италийн Ерөнхийлөгч тэргүүлдэг. Улсын Дээд шүүхийн Тэргүүн Ерөнхийлөгч, Ерөнхий Прокурор ч мөн энэ албан тушаалд суудаг. Зөвлөлийн бусад хорин дөрвөн гишүүнийг сонгодог. Сонгогдсон гишүүдийн гуравны хоёр нь («албан ёсны гишүүд») шүүх засаглалд харьяалагдах шүүгч нар байх бөгөөд бүх үлдсэн хэсэг нь шүүгч бус гишүүд сонгогддог. Шүүгч бус гишүүдийг Италийн парламентын нэгдсэн чуулганаар сонгодог бөгөөд хууль эрх зүйн чиглэлээр ажилладаг их сургуулийн профессорууд эсвэл мэргэжлээрээ дор хаяж арван дөрвөн жил ажилласан хуульчид байх ёстой зэрэг шаардлага тавьдаг. Эдгээр шүүгч биш гишүүд бие даасан, хараат бус шүүх засаглалыг улсын ашиг сонирхолд захирагдаж, хэн нэгний нөлөөнд автахгүй байхыг баталгаажуулах ёстой. Иймд, Италийн Ерөнхийлөгч Зөвлөлийг тэргүүлдэг боловч Ерөнхийлөгчийн үүрэг нь ихэвчлэн албан ёсны бөгөөд бэлгэдлийн шинж чанартай байдаг. Учир нь зөвлөл нь зөвлөлийн ерөнхийлөгчийн бүх үүргийг бодитоор гүйцэтгэдэг шүүгч биш гишүүдийн дундаас Дэд ерөнхийлөгчийг сонгодог²⁸. Үүнээс үзвэл Итали улсын хувьд шүүхийн дээд зөвлөлийн шүүгч бус гишүүдэд тавигддаг шаардлага нь хууль зүйн өндөр мэдлэгтэй, мэргэжлээрээ дор хаяж арван дөрвөн жил ажилласан хуульч, их сургуулийн профессор нар байх бөгөөд улс төрд нөлөө бүхий этгээд, парламентын гишүүн, бүсийн зөвлөлийн гишүүн байхыг хориглосон зэрэг тодорхой шаардлагыг тавьсан байна.

2.2. Бүгд Найрамдах Франц улс

Бүгд Найрамдах Франц улсын шүүхийн захиргааны чиг үүргийг Магистрантын Дээд Зөвлөл хэрэгжүүлдэг бөгөөд Зөвлөлийн бүрэлдэхүүнийг Үндсэн хуулиараа зохицуулдаг ба энэ нь хууль тогтоох байгууллагын нөлөөллийг хязгаарлах механизм болдог аж. Уг зөвлөл нь дараах гурван гол чиг үүрэгтэй байна. (1) шүүхийн бие даасан байдлыг хамгаалахад Ерөнхийлөгчид туслах; (2) шүүгчийг томилох, дэвшүүлэх; (3) магистрантад сахилгын шийтгэл оногдуулах.²⁹ Уг зөвлөл нийт 16 гишүүнтэйгээр ажиллаж, эдгээрийн 6 гишүүнийг Бүгд найрамдах улсын Ерөнхийлөгч, Үндэсний ассамблейн, Сенатын дарга, Төрийн зөвлөлийн ерөнхий ассамблей гэх байгууллага, үлдсэн 10 гишүүнийг Шүүхийн байгууллагаас төлөөллийн зарчмаар сонгогддог.³⁰ Энэхүү зарчим нь эрх мэдлийн тэнцвэрийг хангах ач холбогдолтой хэмээн Францын эрдэмтэд судлаачид үздэг аж. Мөн, Магистрантын зөвлөлийн бүрэлдэхүүнийг

²⁷ Wikipedia, *High Council of the Judiciary in Italy*, (2021) <https://en.wikipedia.org/>

²⁸ Wikipedia, *High Council of the Judiciary in Italy*, (2021) <https://en.wikipedia.org/>

²⁹ Garapon, *Judicial Independence in France*, (2019)

³⁰ Voermans and Albers, *Councils for the Judiciary in EU Countries*, 57.

шүүгч гишүүдээр бүрдүүлэхийг зөвлөж³¹ байна. Магистрантын зөвлөлийн бүрэлдэхүүний гишүүнд төлөөллийн зохистой харьцааг нэмэгдүүлэхийн ач холбогдлыг тус улсын судлаачдын үзлээр шүүхийн бие даасан, хараат бус байдлыг хангах гол шаардлага хэмээн үзжээ.

Франц улс Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтөөр Магистрантын Дээд Зөвлөлийн бүрэлдэхүүний гишүүнийг томилох зохицуулалтыг нарийвчлан зохицуулжээ. Энэхүү Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн онцлог нь Ерөнхийлөгчийн нөлөөг хязгаарлах, эрх мэдлийн тэнцвэрийг хангасан³² гэж судлаачид дүгнэдэг аж. Франц Улсын шүүхийн захиргааны байгууллагын бүрэлдэхүүний томилгоог төрийн бусад салаа болох хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлүүдэд жигд хуваарилж, төлөөллийн зохистой харьцааг бий болгохыг зорьсон байна.³³ Үүнээс үзэхэд Магистрантын Дээд Зөвлөлийн гишүүний бүрэлдэхүүнийг төрийн байгууллагуудыг жигд хуваарилах нь хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн нөлөөллийг хязгаарлах нөхцөлийг бүрдүүлж байна.

Мөн, Магистрантын Дээд Зөвлөлийн гишүүний бүрэлдэхүүнийг зөвхөн Үндсэн хуулиараа зохицуулах нь шүүх эрх мэдэл хууль тогтоох байгууллагаас бие даасан, хараат бус байх гол баталгаа болдог³⁴ аж. Үүнээс үзэхэд манай улсын хувьд шүүх эрх мэдлийн бие даасан, хараат бус байдлыг хангахын тулд ШЕЗ-ийн шүүгч бус гишүүнийг УИХ-аас дангаар томилох бус гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын хяналтыг тусгах зайлшгүй шаардлагатай гэж үзэж байна.

ДҮГНЭЛТ, САНАЛ

1992 оны Үндсэн хуульд эрх мэдэл хуваарилах онолын дагуу төрийн гурван эрх мэдлийг бие даасан, хараат бус байх баталгааг бүрдүүлсэн байх бөгөөд Шүүх эрх мэдлийн бие даасан, хараат бус байдлыг хангах үүргийг ШЕЗ хүлээхээр тусгайлан зохицуулсан байна. ШЕЗ-ийн бүтэц бүрэлдэхүүнийг 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлт хүртэл органик хуулиар зохицуулж ирсэн бөгөөд энэ нь хууль тогтоогч өөрийн дур зоргоор ШЕЗ-ийн бүтэц, бүрэлдэхүүнийг өөрчлөх явдлыг бий болгож байсан ба тус Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр тусгайлан ШЕЗ-ийн бүтцийг тусгасан нь дэвшил болсон боловч шүүгч бус гишүүнийг томилох эрх бүхий субъектийг органик хуулиар зохицуулах боломжийг хууль тогтоогчид олгосон гэж үзэж болохоор байна. 2021 оны Шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгаар ШЕЗ-ийн шүүгч бус таван гишүүнийг хууль тогтоогч дангаар томилохоор зохицуулсан нь УИХ-аас ШЕЗ-д нөлөөлөх улмаар, шүүгчийн хараат бус байдал алдагдахад хүрч болзошгүй

³¹ Prof. Wim Voermans and Dr Pim Albers, *European Commission for the Efficiency of Justice* (CEPEJ) Councils for the Judiciary in EU Countries (2008), 56-58.

³² Мөн тэнд

³³ О.Мөнхсайхан, Ж.Алтансүх, Ж.Цагаанбаяр, Монгол Улс дахь шүүхийн захиргааны загвар: Тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам, (УБ., 2015) 45-46.

³⁴ Prof. Wim Voermans and Dr Pim Albers, *European Commission for the Efficiency of Justice* (CEPEJ) Councils for the Judiciary in EU Countries (2008) 61-62.

юм. Хэдийгээр ШЕЗ-ийн шүүгч бус гишүүдийг хууль тогтоогч томилох практик онолын хувьд зөвтгөгддөг боловч тодорхой хязгаарлалтыг хийж өгөөгүйгээс улс төрийн намын нөлөөнд орох эрсдэл бүрдэж буй юм. Тухайлбал, ШЕЗ-ийн шүүгч бус гишүүдийг УИХ-ын чуулганы хуралдаанд ирсэн нийт гишүүдийн олонхын саналаар томилохоор заасан байх бөгөөд үүний улмаас ердөө 21 гишүүний саналаар шүүгч бус гишүүнийг томилох эрх зүйн орчин бүрдсэн гэж үзэж байна. Энэ нь УИХ-д олон суудал бүхий намын нөлөө орох боломжтойн тод илрэл буюу эрх мэдэл хуваарилах онолын дагуу эрх мэдлүүд бие даасан, хараат бус байх явдлыг зөрчиж буй хэрэг юм.

Шүүхийн захиргааны тогтолцоо өндөр хөгжсөн, шүүгчийн хараат бус, бие даасан байдлаараа тэргүүлдэг Итали улсын хувьд Шүүхийн Дээд Зөвлөлийн шүүгч гишүүдийн тоо болон шүүгч бус гишүүдийн тооны харьцааг Үндсэн хуульдаа зохицуулдаг бөгөөд шүүгч гишүүн нь дийлэнх байх нь үндэслэлтэй гэж үздэг. Учир нь Шүүхийн Дээд Зөвлөл нь шүүхийн бие даасан байдал, шүүгчийн хараат бус байдлыг бэхжүүлэх гол үүрэгтэй тул Шүүхийн Дээд Зөвлөл болон Шүүгчийн хараат бус байдалд халдсан тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг мөн нарийвчлан зохицуулсан нь зүйтэй байна. Түүнчлэн шүүгч бус гишүүдийг парламент нь томилох боловч бусад эрх мэдлийн субъектүүд нь мөн төлөөллөө хэрэгжүүлдэг буюу Ерөнхийлөгч, Улсын дээд шүүхийн тэргүүн, Ерөнхий прокурор нь Шүүхийн Дээд Зөвлөлийн гишүүн байдаг. Энэ нь Шүүхийн Дээд Зөвлөл эрх мэдлийн аль нэг субъект нөлөөлөх эрсдэлээс сэргийлэх давуу талтай байх юм.

Түүнчлэн, Бүгд Найрамдах Франц улсын хувьд шүүх эрх мэдлийн бие даасан, хараат бус байдлыг хангах зорилгоор шүүхийн захиргааны байгууллагын бүрэлдэхүүнийг зөвхөн Үндсэн хуулиараа зохицуулдаг аж. Энэ нь хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын төлөөллийг жигд хуваарилсан байдаг. Ингэснээр хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагаас шүүх эрх мэдэлд нөлөөлөх нөлөөллийг хязгаарлах механизм болдог байна.

Иймд судлаачын зүгээс дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

- ШЕЗ-ийн шүүгч бус таван гишүүнийг бүгдийг нь хууль тогтоогч баталдаг тогтолцоог шинэчлэх буюу бусад субъектээс мөн адил томилох боломжийг олгох.
- УИХ-аас шүүгч бус гишүүнийг томилохдоо олонхийн бус дийлэнх олонхийн саналд үндэслэдэг байх.

ЭХ СУРВАЛЖ

1. Хууль тогтоомж

- Монгол Улсын Үндсэн Хууль, 1992 он.
- Монгол Улсын Шүүхийн тухай хууль, Шинэчилсэн найруулга, 2021 он.
- Бүгд Найрамдах Итали улсын Үндсэн хууль, (1947)
- Бүгд Найрамдах Франц улсын Үндсэн хууль, (1958) Constitution française

2. Ном зохиол

- Б. Чимид, Үндсэн хуулийн үзэл баримтлал, нийтлэг асуудал, УБ хот, 2004 он.
- Б.Чимид, Үндсэн хуулийн үзэл баримтлал: Хүний эрх, шүүх эрх мэдэл, Хоёрдугаар дэвтэр УБ хот, 2004 он.
- Б.Чимид, Үндсэн хуулийн мэдлэг, УБ хот, 2008 он.
- Н. Лүндэндорж, Төрийн онол, УБ хот, 2008 он.
- Ч. Өнөрбаяр, А. Бямбажаргал нар, Үндсэн хуулийн эрх зүйн судалгаа шинжилгээний тойм, бүтээл, УБ хот, 2019 он.
- П. Баттулга М. Мөнхжаргал Ж. Хунан нар, Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлын баталгаа: шүүгчийн томилгоо, Нээлттэй Нийгэм Форум, 2015 он, <https://legalddata.mn/b/128>
- Ханнс Зайделийн сан “Шүүх эрх мэдэл-шинэ зуун” олон улсын онол-практикийн бага хурал, УБ хот., 2001 он.


3. Илтгэл өгүүлэл, ярилцлага

- Ц.Цогт, ҮХНӨ; Шүүхийн ерөнхий зөвлөлийн чиг үүрэг юу вэ, УБ хот, 2019 он <https://legalddata.mn/b/777>
- Б. Эрхэмбаяр, М. Мөнхжаргал нар, Шүүхийн шинэтгэл ба шүүгчийн хараат бус байдал, 2013 он, <https://legalddata.mn/b/21>
- О.Мөнхсайхан, Ж.Алтансүх, Ж.Цагаанбаяр, Монгол Улс дахь шүүхийн захиргааны загвар: Тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам, УБ хот, 2015 он
- О.Мөнхсайхан, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн төслийн талаарх санал, УБ, 2020 он. <https://legalddata.mn/b/772>
- П.Баттулга, Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн бүрэлдэхүүнийг үндсэн хуулиар тодорхойлсны ач холбогдол юу вэ?, УБ хот, 2020 он, <https://legalddata.mn/b/656>
- Freedom House, Italy: Freedom in the World 2021, Country Report. <https://freedomhouse.org/>
- Wikipedia, High Council of the Judiciary in Italy, (2021) [https://en.wikipedia.org/wiki/High_Council_of_the_Judiciary_\(Italy\)#cite_note-9](https://en.wikipedia.org/wiki/High_Council_of_the_Judiciary_(Italy)#cite_note-9)
- Garapon, Judicial Independence in France, 2019

- Prof. Wim Voermans and Dr Pim Albers, European Commission for the Efficiency of Justice Councils for the Judiciary in EU Countries (2008)

4. Цахим эх сурвалж

- Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, <https://www.legalinfo.mn/>
- Хууль зүйн судалгааны бүтээлийн цахим сан, <https://legaldata.mn/>
- Монгол Улсын Их Хурал-ын албан ёсны сайт, <http://parliament.mn/>
- Үгийн алдаа шалгасан, <http://spellcheck.gov.mn/>
- Мэдээллийн сайт, <https://www.montsame.mn>



Төгөлдөрийн БИНДЭРЬЯА

МУИС, Хууль зүйн сургуулийн Эрх зүй
IV түвшний оюутан
(тусгай байр)

ШҮҮХЭД ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААН ДАХЬ ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ОРОЛЦОО, ДҮГНЭЛТИЙН ҮР НӨЛӨӨ, ЭРХ ЗҮЙН АЧ ХОЛБОГДОЛ

Товч утга: 2021 онд Шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсанаар шүүх бүрэлдэхүүн шийдвэртээ иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийг тусгах эрх зүйн үндэс бүрдсэн. Хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээс хойших хугацаанд гарсан шүүхийн шийдвэрт иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийг тусгаж буй эсэхийг судлахад шүүх бүрэлдэхүүн шүүхийн шийдвэртээ дүгнэлтийн агуулгыг заах, түүнийг хэрхэн үнэлж дүгнэснийг тусгах бодит шаардлага байсаар байна. Шүүх иргэдийн төлөөлөгчийн оролцоотойгоор, түүний дүгнэлтийг харгалзан анхан шатны журмаар хэрэг маргааныг шийдвэрлэж байгаа нь асуудалд бодитой, бүрэн дүүрэн, бүх талаас нь хандаж шударга шийдвэр гаргах, улмаар шударга шүүхийн тогтолцоо бүрдэх үндэс суурь болно. Энэхүү судалгаагаар ардчиллыг хамгаалах “араа шүд” гэгддэг шүүхийн¹ процесс ажиллагаан дахь иргэдийн үүрэг оролцоо, дүгнэлтийн үр нөлөө, эрх зүйн ач холбогдлыг нэмэгдүүлэх асуудлыг авч үзсэн болно.

I. УДИРТГАЛ

1992 оны 1-р сарын 13-ны өдөр батлагдсан Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14-т “... шударга шүүхээр шүүлгэх эрхтэй” хэмээн хувь хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг **хамгаалах тэр дундаа шүүхийн механизмыг оролцуулан хуульчилсан болно**. Хувь хүний үнэ цэнэ, түүний эрх, ашиг сонирхлыг төр хүлээн зөвшөөрч буй нь юун түрүүнд хүн бүрийн эрх, эрх чөлөөг хууль бус аливаа хязгаарлалт, зөрчлөөс хамгаалах боломжийг бүрдүүлсэн шүүх эрх мэдлийн байгууллагын шударга үйл ажиллагаагаар баталгаажих ёстой. Б.Чимид “...Шударга шүүх байхын эрх зүйн үндэс нь шүүх эрх мэдлийн үндсэн зарчмууд бөгөөд... “анхан шатны шүүх хэрэг маргааныг хамтран шийдвэрлэхдээ иргэдийн төлөөлөгчийг хуульд заасан журмын дагуу оролцуулах”...”² нь шүүх эрх мэдлийн үндсэн

¹ Б.Чимид “Үндсэн хуулийн мэдлэг”, Уб., 2008, 305 дахь тал.

² Б.Чимид “Хууль дээдлэх ёсыг хангадаг шударга шүүхийн үүрэг” Үндсэн хуульд ба үндэсний эрх

зарчим хэмээн үзсэн байдаг. Шударга шүүх ажиллагааны амин сүнс нь субъектив талаасаа шүүгчийн хараат бус байдал болдог ч объектив талаасаа шүүх ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах, шүүхэд олон нийтийн хяналтыг тогтооход оршино. Тэгвэл шүүхийн үйл ажиллагаа нээлттэй, ил тод байдлыг хангах гол нөхцөл нь шүүхийн үйл ажиллагаанд иргэдийг оролцуулах явдал юм.

УИХ-аас 2012 онд баталсан “Шүүхийн багц хууль”-иар зохицуулсан харилцааг Үндсэн хуулийн үзэл баримтлалыг хангах, мөн хуулийн хэрэглээ болон хуулийн тогтвортой хэрэгжилтийг нэг мөр байлгах үүднээс төрөлжүүлэн нэгтгэж 2021 оны нэгдүгээр сарын 15-ны өдөр Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан. Тус хууль 2021 оны 3 дугаар сарын 1-ны өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээс хойших хугацаанд гарсан эрүү, иргэн, захиргааны шүүхийн 60 шийдвэрт судалгаа хийхэд шүүх бүрэлдэхүүн иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийн агуулгыг шүүхийн шийдвэрийн тодорхойлох хэсэгт бичиж, уг дүгнэлтийн талаарх үндэслэлээ үндэслэх хэсэгт тодорхой тусгасан шүүхийн шийдвэр 15 байгаа нь нийт сонгон судалсан шийдвэрийн 25 хувийг эзэлж байна. Цахимаар нийтэд байрших шүүхийн шийдвэр нь батлагдан хэрэгжиж буй хуулийг хэрэг маргааны тодорхой тохиолдолд хэрэглэхэд хаана давхцал, хийдэл, зөрчил байгааг олж харах боломжийг олгодогт оршино.³ Үүнээс үндэслэн шүүхийн шийдвэрийг судалсан болно. Монгол улсад шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа иргэдэд нээлттэй, ил тод, байж иргэдийн хяналтаар дамжуулан шүүхийн хараат бус, хариуцлагатай байдлыг тогтоох, иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийн ач холбогдлыг нэмэгдүүлэх, шүүх бүрэлдэхүүн шүүхийн шийдвэртэй дүгнэлтийн агуулгыг заах, түүнийг хэрхэн үнэлж дүгнэснээс тусгах бодит шаардлага байсаар байна. Шүүх бүрэлдэхүүн хэргийг шийдвэрлэхдээ иргэдийн төлөөлөгчийн үйл ажиллагааны гол үр дүн болох дүгнэлтийг харгалзан үздэггүй, иргэдийн төлөөлөгч ач холбогдол багатай шүүх хуралдаанд оролцох аваас шүүх дэх иргэдийн төлөөлөгчийн үүрэг оролцоо нь **хэлбэр төдий** болж хувирах юм. Анхан шатны шүүх хэрэг маргааныг хамтын зарчмаар шийдвэрлэхдээ иргэдийн төлөөлөгчийг оролцуулах, шүүн таслах ажиллагаанд иргэдийн оролцоо, итгэлийг нэмэгдүүлэх зэрэг Үндсэн хуулийн зарчим жинхэнэ утгаараа хэрэгжихэд учир дутагдалтай байх тул энэхүү илтгэлээрээ шүүх дэх иргэдийн оролцооны онолын ойлголт, иргэдийн төлөөлөгчийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр болох дүгнэлтийн эрх зүйн ач холбогдол, үр нөлөөний талаар хөндлөө. 2021 оны Шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын хүрээнд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд иргэдийн төлөөлөгчөөс гаргасан дүгнэлт, саналыг шүүхийн шийдвэрт тусгаж буй эсэхт эрх зүйн дүн шинжилгээ хийх замаар дотоодын эрх зүйн тулгамдсан асуудлыг боловсронгуй болгох арга замыг гадаадын сайн туршлагад үндэслэн тодорхойлохыг зорилоо.

зүйн тогтолцоо олон улсын симпозиум II. Уб., 2009 он, 28 дахь тал.

³ Д.Ганзориг: “Шүүхийн шинэчлэл: бие даасан байдал, чиг үүрэг, хариуцлага” илтгэл (2021)

II. ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Иргэдийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь оролцоо нь хэд хэдэн үндсэн чиг үүрэгтэй бөгөөд дараах ач холбогдлоор илэрдэг. Нэгдүгээрт, иргэд шүүхийн процесс ажиллагаанд оролцож өөрсдийн хувь нэмрээ оруулснаар шүүгч иргэдийн төлөөлөгчийн зүгээс гаргасан олон хувилбарт саналыг харгалзан үзээд асуудалд бодитой, бүрэн дүүрэн бүх талаас нь хандаж хуулийн зорилгод тулгуурласан, ард иргэдийн хууль зүйн сэтгэлгээнд илүү тохирсон шударга шийдвэр гаргах⁴, шүүхийн шийдвэр чанаржих боломжтой юм. Хоёрдугаарт, иргэд нийгмийн янз бүрийн зөрчилдөөнийг шийдвэрлэхэд оролцох замаар шүүхийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй болгож, улмаар иргэдийн эрх зүйн ухамсар дээшлэх, шүүхэд итгэх итгэлийг нэмэгдүүлдэг. Гуравдугаарт, шүүх эрх мэдлийн үйл ажиллагаанд иргэд хяналт тавих нэг хэлбэр болдог.

Шүүхийн үйл ажиллагаан дахь иргэдийн оролцоо нь шүүх эрх мэдлийн чанарын үзүүлэлтийг тодорхойлдог⁵ бөгөөд ардчилсан төр, иргэд хоорондын харилцааны үндсэн зарчим⁶, ард түмний бүрэн эрхт байдлыг хэрэгжүүлэх хэлбэр⁷, ард түмэнд эрх мэдлээ шууд хэрэгжүүлэх боломжийг олгодог шүүхийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтын чиг үүргийг хэрэгжүүлдэг⁸ үндсэн хуулийн эрх зүйн онцгой ач холбогдолтой ойлголт юм⁹.

Хууль, эрх зүйн бүтээлүүдэд энэ ангиллыг өргөн ба явцуу гэсэн хоёр чиглэлээр авч үздэг. Нэгдүгээрт, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь иргэдийн шууд бус оролцоог дурдаж болно. Д.Г. Мицай нь энэ төрлийн хэлбэрийн иргэдийн оролцоог шүүхийн дээд албан тушаалд нэр дэвшигчдийг өргөн мэдүүлэх, доод шатны шүүхийн шүүгчдийг томилох эрх бүхий төрийн тэргүүнийг сонгох жишээгээр тодорхойлжээ.¹⁰ Шүүхийн үйл ажиллагаан дахь иргэдийн оролцооны энэ хэлбэрийн мөн чанар нь

⁴ Ц.Мандах “Шүүхийн иргэдийн төлөөлөгч: Тайваний шүүхийн иргэдийн төлөөлөгчийн тогтолцооны хэтийн төлөв” лавлагаа, “Судалгааны тайлангийн эмхтгэл (2014)”, Улаанбаатар, 2015 он, 179 дэх тал (дам эшлэв)

⁵ Насонов С.А. Участие граждан в осуществлении правосудия как принцип, определяющий качественные характеристики судебной власти // Юридическая наука. М., 2016. № 2. С. 95—102.

⁶ Прокудина Л.А. Реализация конституционного права граждан на участие в отправлении экономического правосудия // Право. Журнал Высшей школы экономики. М., 2015. № 4. С. 55.

⁷ Ляднова Э.В. Право граждан на участие в отправлении правосудия: конституционно-правовое содержание и механизм реализации : автореф. дис. ... канд. юрид. наук. Белгород, 2010. С. 6.

⁸ Определение Конституционного Суда РФ от 2 июля 2013 г. № 1052-О «Об отказе в принятии к рассмотрению жалобы гражданина Мирошниченко Владимира Ивановича на нарушение его конституционных прав частью второй статьи 379 Уголовно-процессуального кодекса Российской Федерации» // СПС «КонсультантПлюс»

⁹ Постановление Конституционного Суда РФ от 19 апреля 2010 г. № 8-П «По делу о проверке конституционности пунктов 2 и 3 части второй статьи 30 и части второй статьи 325 Уголовно-процессуального кодекса Российской Федерации в связи с жалобами граждан Р. Р. Зайнаутдинова, Р. В. Кудаева, Ф. Р. Файзулина, А. Д. Хасанова, А. И. Шаваева и запросом Свердловского областного суда» // СЗ РФ. 2010. № 18. Ст. 2276.

¹⁰ Мицай Д.Г. Институт участия населения в отправлении правосудия // Вестник Владивостокского государственного университета экономики и сервиса. – 2009. – С.192-194

иргэд ард түмнээс сонгогдсон төрийн тэргүүнээрээ дамжуулан шүүх эрх мэдлийн байгууллагыг бүрдүүлэхэд оролцдогт оршино. Удаах хандлага нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь иргэдийн шууд оролцоо, өөрөөр хэлбэл төрөөс иргэдийг шүүхийн процесс ажиллагаанд татан оролцуулах тогтолцоо бүрдүүлэх явдлаар тодорхойлогддог. Энэ хүрээнд шүүхийн процесс ажиллагаанд иргэдийг татан оролцуулах зайлшгүй шаардлагыг тодорхойлох хэрэгтэй болно. Хариултыг нь ард түмний бүрэн эрхт байдал, эрх мэдлийн эх сурвалж, мөн чанараас олдог. Өөрөөр хэлбэл, шүүхийн процесс ажиллагаан дахь иргэдийн оролцоо нь төрийн ардчилсан институцийн илэрхийлэл юм. Агуу сэтгэгч Аристотель: “Иргэн хүний гол шинж шүүх, төрийн эрх мэдэлд оролцож байгаа байдлаар тодорхойлогдоно. Хэдийгээр эрх чөлөө, тэгш ёс нь ардчиллын чухал шинж хэдий ч төрийн удирдлагад иргэд оролцсоноор энэ нь биелэлээ олдог” гэж хэлсэн байдаг. Ард түмэн шүүхийн процесс ажиллагаанд оролцох эрхээ ухамсарлаж, хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын үйл ажиллагаанд оролцох төдийгүй эрх мэдлийг хуваарилах зарчмын үндсэн дээр түүний нэг тогтолцоог бүрдүүлдэг шүүх эрх мэдлийн үйл ажиллагаанд оролцох юм.

III. ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Судалгааны ажлын энэ хэсэгт эх газрын эрх зүйн тогтолцоотой улс болох Оросын Холбооны Улс, Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, түүнчлэн Тайванийн шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эцсийн бөгөөд гол ач холбогдолтой үйл ажиллагаа болох шүүх хуралдаанд дүгнэлт гаргах, шүүх бүрэлдэхүүн дүгнэлтийг харгалзан үзээд, хэрхэн үндэслэж шийдвэрлэдэг талаар эрх зүйн зохицуулалт, туршлагыг нарийвчлан авч үзэхийн зэрэгцээ иргэдийн төлөөлөгчид тавигдах шаардлагыг судлах болно.

3.1 Оросын Холбооны Улс

Тангарагтны шүүхийн загвар бүхий тогтолцоотой улс орнуудын тангарагтны шүүгчдийн гаргасан дүгнэлтэд шүүх хэрхэн үнэлэлт өгч байгаа, тэдгээрийн эрх зүйн ач холбогдлыг авч үзлээ.

Шүүхийн процесс дахь иргэдийн оролцооны зарчим ба уг оролцооны хоёр хэлбэрийг (тангарагтны шүүх, арбитрын гэх мэт) “ОХУ-ын шүүхийн тогтолцооны тухай” Холбооны Үндсэн хуулийн 8-р зүйлд тусгасан.¹¹ Тангарагтны шүүхийн загвар бүхий тогтолцоотой улс орнуудад тангарагтнуудын дүгнэлтийг **вердикт** гэж нэрлэдэг. Иргэдийн төлөөлөгчдийн “вердикт”, “verdictum” буюу дүгнэлтийг хэлэлцэх нь үндсэн шүүх хуралдааны хоёр дахь шат бөгөөд дүгнэлтийн агуулгаас хамаарч шүүх хуралдааны дарааллыг тогтоодог байна. Энэ нь шүүх

¹¹ Энэхүү заалтыг мэргэжлийн бус шүүгчийн оролцоо бүхий ангиллын хэргийг хянан шийдвэрлэх үндэслэл, нөхцөл, журмыг нарийвчлан зохицуулдаг ОХУ-ын Эрүүгийн байцаан шийтгэх хууль, ОХУ-ын Арбитрын байцаан шийтгэх хууль зэрэг салбарын процессын хуулиудаар дэлгэрүүлэн авч үздэг.

дүгнэлтийг зайлшгүй харгалзан үзэх, ач холбогдол өгч үнэлэх нөхцөлийг бүрдүүлж дүгнэлтийг хэлэлцүүлэхгүй байх аваас шүүх хуралдааныг цааш үргэлжлүүлэх боломжгүй, сөрөг үр дагаварт хүргэх юм. Иргэдийн төлөөлөгчид цагаатгах дүгнэлт гаргасан тохиолдолд шүүгдэгчийг шүүх танхимаас нэн даруй суллах¹² бөгөөд уг дүгнэлтийн эрх зүйн үр дагавар нь эргэлт буцалтгүйгээр шүүхийн цагаатгах тогтоол гаргахад хүргэж шүүхээс шийтгэх тогтоол гаргах нөхцөлийг хязгаарладаг. Харин гэм буруутайд тооцох дүгнэлт гарсан тохиолдолд уг дүгнэлт нь эрх зүйн шууд үр дагавар үүсгэдэггүй. Даргалагч шүүгч дүгнэлтийг харгалзан үзээд хоёр тохиолдолд дүгнэлттэй санал нийлэхгүй байх эрхтэй.¹³ Мэтгэлцээний явцад талууд шүүхийн шийдвэрт ач холбогдолтой хууль хэрэглээний аливаа асуудлыг хөндөж болох ч иргэдийн төлөөлөгчдийн дүгнэлтийн зөв эсэхэд эргэлзэхийг хориглодог.

Цагаатгах болон шийтгэх¹⁴ тогтоолын үндэслэх хэсэгт тухайн төрлийн тогтоол гаргах болсон шүүгдэгчийн гэмт үйлдлийн шинж, **иргэдийн төлөөлөгчдийн дүгнэлтийн талаарх үндэслэл**, цагаатгах эсхүл шийтгэх үндэслэлийг заавал тусгадаг¹⁵. Монгол улсаас ялгаатай нь ОХУ-д шүүхийн шийдвэрийн удиртгал хэсэгт иргэдийн төлөөлөгчдийн нэрсийг тусгадаггүй байна. Энэ нь иргэдийн төлөөлөгчийн оролцоог үгүйсгэж буй хэрэг биш бөгөөд гагцхүү тэдний хараат бус, аюулгүй байдлын баталгааг бүрдүүлэхтэй холбоотой юм.

ОХУ-д шүүхийн процесс ажиллагаан дахь иргэдийн төлөөлөгчдийн дүгнэлтийн ач холбогдол, үр нөлөө дараах байдлаар тодорхойлогдож байна: 1. Шүүх бүрэлдэхүүн иргэдийн төлөөлөгчдийн дүгнэлтийг зайлшгүй харгалзан үзэж хэлэлцдэг, хэлэлцээгүй тохиолдолд шүүх хуралдааныг үргэлжлүүлэх боломжгүйд хүрдэг. 2. Дүгнэлтийг үндэслэн шүүх шийдвэрээ гаргадаг бөгөөд дүгнэлтийн төрлөөс хамаарч дүгнэлт нь шууд болон шууд бусаар шүүхийн шийдвэрт нөлөөлдөг. 3. Шүүх шийдвэрийнхээ үндэслэх хэсэгт иргэдийн төлөөлөгчдийн дүгнэлтийн талаарх үндэслэлээ заавал тусгадаг. 4. Талуудыг дүгнэлтийн зөв эсэхэд эргэлзэхийг хориглодог.

3.2 Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

Холимог шүүхийн загвар бүхий тогтолцоотой улс орнуудын иргэдийн төлөөлөгч буюу шеффений гаргасан дүгнэлтэд шүүх хэрхэн үнэлэлт өгч байгаа, тэдгээрийн эрх зүйн ач холбогдлыг авч үзлээ.

¹² ОХУ-ын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 346-р зүйл

¹³ 1) Иргэдийн төлөөлөгч гэм буруутайд тооцсон шүүгдэгчийн үйлдэл гэмт хэргийн шинжгүй гэдгийг хүлээн зөвшөөрвөл шүүгч цагаатгах шийдвэр гаргадаг; 2) Шүүгдэгчийг гэм буруутайд тооцох хангалттай үндэслэл байгааг даргалагч хүлээн зөвшөөрсөн тохиолдолд иргэдийн төлөөлөгчдийн бүрэлдэхүүнийг татан буулгаж, хэргийг урьдчилсан хэлэлцүүлгийн үе шатаас эхлэн өөр бүрэлдэхүүнээр шинээр хэлэлцүүлэх тухай тогтоол гаргана.

¹⁴ Шийтгэх тогтоолын үндэслэх хэсэгт дээрхээс гадна гэмт хэргийн зүйлчлэлийн талаархи үндэслэл бүхий дүгнэлт, иргэдийн төлөөлөгчид хүлээн зөвшөөрсөн тохиолдолд эрүүгийн хариуцлага хөнгөрүүлэх дүгнэлтийг харгалзан оноох тухай тусгадаг байна.

¹⁵ ОХУ-ын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 302 дугаар зүйлийн 2 дахь хэсэг

Германы хуульд эрүүгийн шүүхийн олон нийтийн шүүгчдийг¹⁶ шеффен (Герман: Schöffen) гэх бөгөөд иргэд шүүгч нартай хамт хэргийн үйл баримт болон эрх зүйн асуудлыг шийдвэрлэдэг онцлогтой. Шеффенүүд шүүгчтэй адил тэгш эрхтэй байдаг: тэд шүүх хуралдаанд шүүгчтэй адил тэгш оролцож, гэрч, шүүгдэгч, шинжээчээс асуулт асууж, хэргийн үйл баримтыг шинжлэн судалж шийдвэр гаргадаг. Гэхдээ мэргэжлийн шүүгчээс ялгаатай нь шеффенүүд хэд хэдэн тусгай эрх, үүрэг хүлээдэг. Тухайлбал, тэд хэргийн материалтай урьдчилж танилцдаггүй бөгөөд тангараг өргөснөөр шүүгчийн дүгнэлтээс тусдаа, өөрсдийн хараат бус үйл ажиллагааны үр дүн болох **бие даасан дүгнэлтийг гаргадаг**. (DRiG § 45 Abs 2-6) Хэрэв дүгнэлт хуульд заасан хэлбэрийн шаардлага хангаагүй буюу дутуу байна гэж үзвэл энэ тухай даргалагч мэдэгдэж, иргэдийн төлөөлөгчид тасалгаанд буцаж орно.

Германы шүүхэд шеффенүүд их эрх мэдэлтэй байдаг. Холимог шүүхийн аливаа шийдвэрийг гуравны хоёрын саналаар гаргах бөгөөд энэ нь хоёр шеффен, гурван шүүгчийн бүрэлдэхүүнтэй шүүхийн шийдвэр гаргахад доод тал нь дөрвөн хүний санал авах шаардлагатай гэсэн үг. Үүнээс үзвэл, хоёр шеффен үндсэндээ шүүхэд хориг тавих эрхтэй байгаа нь түүний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь нөлөөлөл, ач холбогдлыг тодорхойлж байна. Иймээс хоёр шеффен, нэг шүүгчээс бүрдсэн шүүх хуралдаанд иргэдийн төлөөлөгчид шүүгдэгчийг яллах, цагаатгах бүрэн эрхтэй. Эдгээр нөхцөл байдлаас шалтгаалан хамгийн чадварлаг хүнийг шүүхийн бүрэлдэхүүнд сонгон шалгаруулдаг. Тухайлбал, шүүхийн иргэдийн төлөөлөгчөөр ажиллах этгээдэд ерөнхий¹⁷ шаардлагаас гадна **дараах тусгай шаардлага тавигддаг**: хэрэг, маргааны оролцогчийн төлөөлөгч буюу түүнтэй хамааралгүй байх; эрх зүйн чадвар, чадамжтай байх; эрх зүйн мэдлэг, чадвартай байх; хянан хэлэлцэж буй хэрэг, маргааны оролцогч болоогүй байх зэрэг нөхцөлийг хангасан байна.

Шеффенд нэр дэвшигчийн нэрсийн жагсаалтыг тухайн муж улсын засаг захиргааны нэгж гаргах бөгөөд уг жагсаалтыг олон нийтийн хяналт, ил тод байдлыг хангах зорилгоор ийнхүү бэлтгэснээс хойш 7 хоногийн туршид олон нийтэд нээлттэй зарладаг. Энэ хугацаанд хэн бүхэн жагсаалтад багтсан этгээдийг шүүхийн иргэдийн төлөөлөгч байхад тохиромжгүй гэж үзэх, тухайн этгээдийн талаар гомдол гаргах боломжтой. Үүний дараагаар жагсаалт гаргасан муж улсын засаг захиргааны нэгжийн дарга буюу ахлагч жагсаалт болон жагсаалтын талаарх гомдол, эсэргүүцлийг хамтад нь тухайн нэгжийн харьяалах тойргийн шүүхийн шүүгчид хүргүүлдэг байна.

¹⁶ “Ehrenamtliche Richter” – “олон нийтийн” буюу “хүндэт шүүгчид”

¹⁷ Шеффенд 25-70 насны Германы иргэн (эрэгтэй, эмэгтэй) байхаас гадна шеффений нэр дэвшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах үед тухайн орон нутагт оршин суудаг, эрүүл мэндийн хувьд тэнцэхүйц, төлбөрийн чадвартай байх гэсэн шаардлага тавигддаг (GVG § 33).

3.3 Тайвань

*Тайваньд иргэд шүүх бүрэлдэхүүнд оролцох нь Тайванийн Үндсэн хуульд Шүүгч нь хуулийн дагуу бие дааж шүүн таслах эрхтэй байж, хэн ч хөндлөнгөөс нөлөөлөхийг хориглоно*¹⁸ гэж заасныг зөрчих тул иргэдийн төлөөлөгч шүүн таслах ажиллагаанд зөвхөн ажиглагчийн байр суурьнаас оролцох боломжтой байгаа нь манай улсын эрх зүйн зохицуулалттай ойролцоо юм.

Энэ тогтолцоо нь нэг талаараа, мэргэжлийн бус шүүгчийг шүүх хуралдаанд оролцуулснаас үүсэх үл итгэлцэл, Үндсэн хууль болон бусад хуулийг зөрчинэ гэсэн хардлагаас сэргийлж байдаг ч нөгөө талаар шүүх хуралдаан болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шүүхийн ажиглагч-иргэдийн төлөөлөгч биечлэн оролцож, тухайн үйл ажиллагааг ил тод, нээлттэй болгож, улмаар хэргийн нотлох баримтыг үнэлэх, хууль хэрэглэх, ялын хэмжээг тогтоох зэрэг ажиллагааны талаар цогц ойлголттой болгоход оршино.

Шүүгч иргэдийн төлөөлөгчийн саналыг харгалзан үзэж шийдвэртээ тусгадаг шалтгаан нь: Энгийн иргэдийг шүүх хуралдаанаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулах бололцоогоор хангадаг байх; Энгийн иргэдийг шүүх хуралдааны шийдвэр гаргах явцад саналаа илэрхийлж, тухайн саналыг шүүгч шийдвэрээ гаргахад харгалзан үздэг байх явдал юм. Гэхдээ тухайн хэрэгт ял оногдуулах эсэх болон эцсийн шийдвэр гаргах эрх нь зөвхөн шүүгчид хадгалагдана. Шүүгч иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийг харгалзан үзэх нь зүйтэй гэж үзвэл, саналыг шийдвэртээ тусгах бөгөөд иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийг эс зөвшөөрсөн, иргэдийн төлөөлөгчийн олонхийн саналтай шүүгчийн санал зөрсөн тохиолдолд шийдвэртээ иргэдийн төлөөлөгчийн **дүгнэлтийн үндэслэл, тайлбараа** тодорхой бичих шаардлагатай тул дүгнэлтэд ач холбогдол өгч харгалзан үзэх боломж бүрддэг.

IV. АСУУДАЛ ДЭВШҮҮЛЭХ НЬ:

Монгол улсад 1992 оны Үндсэн хуулиас ч өмнө иргэдийн төлөөлөгчийг шүүн таслах ажиллагаанд оролцуулж ирсэн түүхэн уламжлал бий.¹⁹ 1992 онд батлагдсан Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин хоёрдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Анхан шатны шүүх хэрэг,

¹⁸ Тайваний Үндсэн хуулийн 80 дугаар зүйл. (1947)

¹⁹ 1926 оны 4 дүгээр сарын 16-ны өдрийн БНМАУ-ын аливаа шүүх таслах газруудыг байгуулах дүрмийн 1.1-г “Хошуудын жинхэнэ ардын шүүх таслах газруудад аливаа хэргийг нэг түшмэл ба ард олноор сонгосон хоёр төлөөлөгчөөр шийтгүүлбэл зохино”. 1940 оны Үндсэн хуулийн 50 дугаар зүйлд “Аливаа шүүх таслах газруудаас хэргийг таслахдаа хэрэв хуульд зориуд заасан хэрэг биш бол байнга суух шүүн таслагчаас ардын төлөөлөгчийг оролцуулан гүйцэтгэж байх” гэсэн нь иргэдийн төлөөлөгчийн шүүн таслах ажиллагаанд шийдвэр гаргах эрхтэй оролцох тогтолцоог бататгасан зохицуулалт болжээ. 1960 оны Үндсэн хуулийн 64 дүгээр зүйлд “Бүх шатны шүүхэд хэрэг шүүн таслах явдлыг хэрэв хуульд зориуд тусгайлан заагаагүй бол ардын төлөөлөгчдийг оролцуулан байнгын шүүгч нар гүйцэтгэнэ” гэсэнээ үзвэл, зөвхөн анхан шатны шүүхүүд бус давж заалдах болон хяналтын шатны шүүх дээр хэрэг шийдвэрлэхэд иргэдийн оролцоотой шийдвэр гаргадаг байсан байна.

маргааныг хамтран шийдвэрлэхдээ иргэдийн төлөөлөгчийг хуульд заасан журмын дагуу оролцуулна” гэснийг хууль тогтоогч “Хэрэг, маргааныг анхан шатны журмаар шийдвэрлэх шүүх бүрэлдэхүүнд иргэдийн төлөөлөгчийг таслах эрхтэйгээр оролцуулахыг хүлээн зөвшөөрсөн” гэж үзсэн. Үүний дагуу Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуулийг (ШИТЭЗБтХ) 2012 онд баталсан.²⁰ Үндсэн хуулийн цэц тус хуулийн шүүх бүрэлдэхүүнд иргэдийн төлөөлөгчийг оролцуулах тухай заалтууд нь мэргэжлийн шүүгчийн хууль хэрэглэх, шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцож байна²¹ гэж үзэн хүчингүй болгосон юм. Иргэд шүүхийн үйл ажиллагаанд оролцох ёстой эсэх нь маргааны сэдэв байхаа больсон. Олон улсад ямар тогтолцоо тухайн улсын онцлогт тохирох тухайд эрдэмтдийн судалгаа шинжилгээ хийгдэж байна²². Харин Монгол улсад шүүх бүрэлдэхүүнд иргэдийн төлөөлөгчийг оролцуулах буюу холимог шүүхийн загвар бүхий тогтолцоо руу шилжих нь Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх асуудлыг Үндсэн хуулийн цэц нэгэнт шийдвэрлэж, судлаачид өөрсдийн байр суурийг илэрхийлсэн тул шүүхийн иргэдийн төлөөлөгчийн тогтолцоо руу чиглэсэн асуудлыг хөндөх бус аль ч тогтолцооны үндсэн зорилго болох шүүн таслах ажиллагаанд иргэдийг хэрхэн үр нөлөөтэй, бодитой оролцуулах тал дээр өөрийн орны эрх зүйн орчинд үндэслэн дараах асуудлыг дэвшүүлж байна.

4.1 Иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийн ач холбогдол, агуулга, хэлбэрийн шаардлага.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2015 онд гүйцэтгэсэн “Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн тогтолцоог оновчтой бүрдүүлэх нь” судалгааны “Шүүхийн сонгомол шийдвэрийн эмхэтгэл”-д орсон шүүхийн шийдвэр, магадлал, тогтоолд хийсэн дүн шинжилгээнээс үзвэл шүүхийн иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийн ач холбогдол бага, дүгнэлтийг шүүх шийдвэртээ тусгаж үнэлдэггүй гэж үзэж болно. Монгол Улсын Их Хурлаас ШИТЭЗБтХ-д хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг хийлгүүлж 2017 оны 11 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д “Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлыг тодорхой болгох, ажиллах журмыг нарийвчлан хуульчлах, хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгох зорилгоор ШИТЭЗБтХ-ийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулна” гэж тусгасан. Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлттэй нийцүүлэх, хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээнд дурдсан хэрэгцээ шаардлагад үндэслэн “Шүүхийн багц хууль”-иар зохицуулсан харилцааг нэгтгэн Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан. Тус хуулийн арван гуравдугаар бүлэгт шүүхийн иргэдийн төлөөлөгчтэй холбоотой харилцааг

²⁰ О.Мөнхсайхан “Цэцийн шийдвэрийн шүүмж: анхан шатны шүүх бүрэлдэхүүнд иргэдийн төлөөлөгчийг оролцуулах нь үндсэн хууль зөрчөөгүй” өгүүлэл. 2 дахь тал (2014)

²¹ УИХ э. О.Баясгалан, ҮХЦ, Тогтоол 01, 2014.01.08, Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, <https://legalinfo.mn/mn/detail/9642>

²² Нээлттэй Нийгэм Форум П.Бадамрагчаа “Шүүхэд хэрэг маргааныг хянан хэлэлцэх ажиллагаан дахь иргэдийн оролцоо” бодлогын судалгаа, зөвлөмж. 2 дахь тал (2011)

зохицуулж 66.7 “Шүүх бүрэлдэхүүн иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийн агуулгыг шүүхийн шийдвэрийн тодорхойлох хэсэгт бичиж, уг дүгнэлтийн талаарх үндэслэлээ үндэслэх хэсэгт тодорхой тусгана.” 66.9 “Шүүх бүрэлдэхүүн энэ хуулийн 66.7-д заасныг биелүүлээгүй бол шүүгчид сахилгын шийтгэл оногдуулах үндэслэл болно.” гэж тус тус хуульчилсан нь ШИТЭЗБТХ-д шийдлээ хүлээж байсан асуудал болох шүүхээс иргэдийн төлөөлөгчийн гаргасан дүгнэлтэд ач холбогдол өгч, шүүхийн шийдвэрт тусгах, үнэлэх хүрээнд шүүгчийг үүргээ биелүүлээгүй тохиолдолд хариуцлага хүлээлгэх замаар тодорхой арга хэмжээ авсан гэж үзэж болох юм. Шүүхийн тухай хуулийн (ШТХ) 66.7 дахь зохицуулалтыг сонгон авч хэрэгжилтийн үр дагаварт дүн шинжилгээ хийхэд шүүх бүрэлдэхүүн иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийн агуулгыг шүүхийн шийдвэрийн тодорхойлох хэсэгт бичиж, уг дүгнэлтийн талаарх үндэслэлээ үндэслэх хэсэгт тодорхой тусгасан шүүхийн шийдвэр 15 байгаа нь нийт сонгон судалсан шийдвэрийн 25 хувийг эзэлж байна. Тухайлбал, ШТХ-ийн шинэчилсэн найруулга хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээс хойших хугацаанд захиргаа, иргэн, эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн бүрэлдэхүүнтэйгээр шийдвэрлэсэн тус бүр 20 шийдвэрээс авч үзвэл дараах дүгнэлтийг хийж болно.

	Шүүх бүрэлдэхүүн иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийн агуулгыг шүүхийн шийдвэрийн тодорхойлох хэсэгт бичсэн эсэх	Шүүх бүрэлдэхүүн иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийн талаарх үндэслэлээ үндэслэх хэсэгт тодорхой тусгасан эсэх
ИРГЭНИЙ ХЭРГИЙН АНХАН ШАТНЫ ШҮҮХ	- Нийт шийдвэрийн 80 хувьд нь иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийн агуулгыг шүүхийн шийдвэрийн тодорхойлох хэсэгт тусгасан - Нийт шийдвэрийн 20 хувьд нь иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийн агуулгыг шүүхийн шийдвэрийн тодорхойлох хэсэгт тусгаагүй	- Нийт шийдвэрийн 35 хувьд нь иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийн талаарх үндэслэлээ үндэслэх хэсэгт огт тусгаагүй - Нийт шийдвэрийн 20 хувьд нь иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийн талаарх үндэслэлээ үндэслэх хэсэгт тодорхой тусгаагүй - Нийт шийдвэрийн 45 хувьд нь иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийн талаарх үндэслэлээ үндэслэх хэсэгт тодорхой тусгасан

ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН АНХАН ШАТНЫ ШҮҮХ	• Нийт шийдвэрийн 80 хувьд нь иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийн агуулгыг шүүхийн шийдвэрийн тодорхойлох хэсэгт тусгасан • Нийт шийдвэрийн 10 хувьд нь иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийн агуулгыг шүүхийн шийдвэрийн тодорхойлох хэсэгт тусгаагүй • Нийт шийдвэрийн 10 хувьд нь иргэдийн төлөөлөгч дүгнэлт гаргаагүй	• Нийт шийдвэрийн 50 хувьд нь иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийн талаарх үндэслэлээ үндэслэх хэсэгт огт тусгаагүй • Нийт шийдвэрийн 20 хувьд нь иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийн талаарх үндэслэлээ үндэслэх хэсэгт тодорхой тусгаагүй • Нийт шийдвэрийн 20 хувьд нь иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийн талаарх үндэслэлээ үндэслэх хэсэгт тодорхой тусгасан • Нийт шийдвэрийн 10 хувьд нь иргэдийн төлөөлөгч дүгнэлт гаргаагүй
ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН АНХАН ШАТНЫ ШҮҮХ	• Нийт шийдвэрийн 20 хувьд нь иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийн агуулгыг шүүхийн шийдвэрийн тодорхойлох хэсэгт тусгасан • Нийт шийдвэрийн 35 хувьд нь иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийн агуулгыг шүүхийн шийдвэрийн тодорхойлох хэсэгт тусгаагүй • Нийт шийдвэрийн 35 хувьд нь иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийн агуулгыг шүүхийн шийдвэрийн тодорхойлох хэсэгт тодорхой тусгаагүй	

Шүүхийн тухай хуулийн арван гуравдугаар бүлгээс үзвэл, шүүхийн иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийн агуулга, хэлбэрийн шаардлагыг ШИТЭЗБТХ-ийн нэгэн адил тодорхой тусгаагүй бөгөөд тодорхой бус шаардлагыг бүрэн бус хангасан буюу хангаагүй дүгнэлтийг шүүх хэрхэн үнэлэх асуудал өмнөхийн нэгэн адил нээлттэй үлджээ. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд (ЗХШХШТХ) дүгнэлтийн агуулгын шаардлагыг хэргийн үйл баримт, захиргааны үйл ажиллагаа үндэслэлтэй эсэх талаар бичсэн байх, хэлбэрийн шаардлагад бичгээр үйлдсэн байх тухай заасан. Түүнчлэн шүүхийн шийдвэрийн тодорхойлох хэсэгт иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийн агуулгыг тусгахаар зохицуулсан бол үндэслэх хэсэгт уг дүгнэлтийн талаарх үндэслэлийг тодорхой тусгах талаар заагаагүй нь шүүн таслах ажиллагааны төрлөөс хамаарч ШТХ-ийн 66.7

дахь хэсгийн зохицуулалтыг өөрөөр хэрэглэх буюу дүгнэлтийн талаарх үндэслэлээ үндэслэх хэсэгт тодорхой тусгахгүй байж болох боломжийг нээж өгчээ. Энэхүү зохицуулалт нь сонгон судалсан захиргааны хэргийн нийт шийдвэрийн 50 хувь нь иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийн талаар үндэслэлээ үндэслэх хэсэгт огт тусгаагүй үр дагавартай шууд холбоотой зохицуулалт гэж үзэж болох юм. ЗХШХШТХ-ийн **73 дугаар зүйлийн 73.1** дэх хэсэгт “Шүүх хуралдаанд иргэдийн төлөөлөгчийг Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасан журмын дагуу оролцуулна.” гэж заасны дагуу хүчингүй болсон хуулиар тухайн харилцааг зохицуулах боломжгүй бөгөөд хуулийн хийдлийг бий болгож байна.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд (**ИХШХШТХ**) дүгнэлтийн агуулгын шаардлагыг зохигчийн гэм буруугийн талаар бичсэн байх, хэлбэрийн шаардлагад бичгээр үйлдсэн байх тухай заасан. Мөн хуулийн 118-р зүйлийн 118.3-т шүүхийн шийдвэрийн тодорхойлох хэсэгт, 118-р зүйлийн 118.4-т шүүхийн шийдвэрийн үндэслэл хэсэгт тусгах зүйлсийг нэг бүрчлэн тодорхой заасан байх боловч иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийг орхигдуулсан байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн (**ЭХХШТХ**) 3.4 дүгээр зүйлийн 2.2 дахь хэсэгт “шүүгдэгчийн гэм буруугийн талаар санал бичих, уншиж сонсгох” гэснээс үзвэл, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд иргэдийн төлөөлөгчийн үйлдэх баримт бичиг нь дүгнэлт бус санал хэмээн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны төрлөөс хамааран иргэдийн төлөөлөгчийн дүгнэлт эрх зүйн ялгаатай нэршилтэй, тодорхойгүй үр дагаварт хүргэхээр байна. ЭХХШТХ-д Эрүүгийн хэргийн шүүхийн шийтгэх тогтоолын тодорхойлох хэсгийн шүүгдэгчийг гэм буруутайд тооцох хэсэгт иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийг няцаан үгүйсгэсэн үндэслэл, шүүхийн цагаатгах тогтоолын тодорхойлох хэсэгт иргэдийн төлөөлөгчийн саналыг няцаан үгүйсгэсэн үндэслэлийг тусгахаар зохицуулсан нь ШТХ-ийн 66 дугаар зүйлийн 66.7 дахь хэсэгт заасан иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийн үндсэн агуулгыг бүрэн эхээр нь шийдвэрийн тодорхойлох хэсэгт тусгах, дүгнэлтийн талаарх үндэслэлээ үндэслэх хэсэгт тусгах ухагдахуунтай зөрчилдөж шүүхийн шийдвэрт дүгнэлтийн агуулгыг огт тусгахгүй байх, зөвхөн түүнийг няцаасан үндэслэлийг л тусгах, дүгнэлт үндэслэлтэй гэж үзсэн тохиолдолд дүгнэлтийг тусгахгүй орхих үр дагаварт хүргэж байна. Түүнчлэн шүүхийн цагаатгах эсхүл шийтгэх тогтоолоос шалтгаалж иргэдийн төлөөлөгчийн үйл ажиллагаа нь санал эсхүл дүгнэлт байхаар харилцан адилгүй, ойлгомжгүй нөхцөлийг бүрдүүлжээ.

Эрх зүйн хэм хэмжээний үүрэг нь нийгмийн харилцаанд бүрэн хүртээмжтэй хүрч нийгмийн амьдралын хэвийн зохицолдолгоог хангах явдал байдаг²³ боловч хууль, эрх зүйн зохицуулалтын хийдэл, хоорондын зөрчил нь иргэд шүүхийн шийдвэр гаргах процесст оролцож байгаагийн гол шинж болох хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд иргэдийн төлөөлөгчөөс гаргасан дүгнэлтийг шүүхийн шийдвэрт тодорхой, үндэслэлтэй тусгахгүй байхад нөлөөлж иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийн агуулга, ач

²³ Ц.Цогт. “Эрх зүйн хийдэл, түүнийг шийдвэрлэх арга зам”. 2 дахь тал (2016)

холбогдлыг бууруулах нөхцөлийг бүрдүүлж байх боломжтой юм.

4.2 Иргэдийн төлөөлөгчид тавигдах шаардлага.

Бусад улс орнуудад иргэдийн төлөөлөгчид нэмэлт шаардлага тавьдаг бөгөөд энэ нь хүн бүр иргэдийн төлөөлөгчөөр сонгогдох боломжгүй нөхцөл байдлыг бий болгодог. Тиймээс шүүхийн процесс ажиллагаанд оролцож байгаа шүүх хуралдааны бусад оролцогчдоос, шүүх дэх иргэдийн төлөөллийг ялгах шаардлагатай. Судлаач В.А Смирновагийн хэлснээр, “Иргэдийн төлөөлөгчийн шүүх хуралдааны ил тод байдалд хяналт тавих эрхийг иргэд ардын төлөөлөгчийн хувиар шүүгчийн нэгэн адил хэргийн үйл баримтыг шинжлэн судлах, шүүхийн процесст оролцох боломж гэж үзэх ёстой.”²⁴ Энэ утгаараа түүнд тавигдах шалгуурыг эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх, эрх зүйн чадамж, нас, оршин суух хаяг²⁵ төдийгөөр хязгаарлах нь үүргээ ухамсарлаагүй, хариуцлагагүй иргэдийг шүүх хуралд татан оролцуулж улмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд иргэдийн хяналтыг сулруулж уг тогтолцооны ач холбогдол, үнэлэмжийг бууруулах, хууль тогтоогч ба шүүгчийн зүгээс иргэдийн чадварт үл итгэх, иргэдийн төлөөлөгчөөр ажиллах нөхцөлийг хангахгүй байх зэрэг нөхцөл байдалд хүргэж хуулийн хэрэгжилтэд саад болж байна. ХБНГУ-д хамгийн чадварлаг буюу хариуцлагатай хүмүүсийг олон нийтэд нээлттэй байдлаар иргэдийн төлөөлөгчөөр сонгон шалгаруулдаг нь иргэдийн төлөөлөгчийн хэрэг маргааныг шийдвэрлэдэг шүүгчийн нэгэн адил эрх хэмжээтэй холбоотой бус аль болох үр нөлөөтэй оролцоо, иргэдийн хяналтыг цогцлоох зорилготой холбоотой гэдгийг анхаарах шаардлагатай. Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн нэрсийн жагсаалтыг олон нийтэд нээлттэй байлгах замаар олон нийтийн хяналт, ил тод байдлыг хангах зорилгод нийцүүлэх нь жагсаалтад багтсан этгээдийн ёс суртахуун, зан байдлын талаар бусдын үнэлэмж, гомдол, мэдээлэл авах боломжийг бүрдүүлж иргэдийн төлөөлөгч байхад тохиромжтой эсэхт үнэлэлт, дүгнэлт өгөх боломжийг бүрдүүлэх юм.

V. ДҮГНЭЛТ, САНАЛ

Шүүхийн шинэчлэлийн хүрээнд 2021 онд Шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсанаар шүүх бүрэлдэхүүн шийдвэртээ иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийг тусгах гол зохицуулалт, үүнийг зөрчсөн тохиолдолд шүүгчид хүлээлгэх хариуцлагыг хуульчилсан ч шүүхийн зүгээс иргэдийн төлөөлөгчөөс гарах дүгнэлтийг үнэлэх улмаар дүгнэлтийн агуулга, ач холбогдлыг нэмэгдүүлэх шаардлага байсаар байна. Гадаадын улсуудад иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтэд тавигдах шаардлага, дүгнэлт хэрхэн гаргах, түүнийг танилцуулах нөхцөл, журам, шүүх шийдвэртээ хэрхэн тусгах зэрэг асуудлыг хуулийн давхардал, хийдэл, зөрчлөөс ангид, цогц байдлаар нарийвчлан зохицуулсан нь

²⁴ Смирнова В.А. Конституционное право граждан на участие в отправлении правосудия. – С. 156.

²⁵ Шүүхийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ (2021) 59 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг

хуулийн хэрэгжилт өндөр байгаагийн нэг томоохон хүчин зүйл гэж үзэж байна. Уг дүгнэлтэнд үндэслэн хууль тогтоомжийн хэрэгжилтийг илүү хүртээмжтэй, үр нөлөөтэй болгох талаар дараах саналыг гаргаж байна. Үүнд:

1. ЗХШХШтХ, ЭХХШтХ, ИХШХШтХ-иудыг Шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгатай нийцүүлж зохицуулалтыг нэг мөр болгох;
2. Иргэдийн төлөөлөгчийн гаргасан шийдвэр дүгнэлт санал зэрэг ялгаатай нэршилтэй байгаа нь ойлгомжгүй байдал үүсгэж байгааг анхаарч нэр томъёог нэг мөр жигдлэх;
3. Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн нэрсийн жагсаалтыг тодорхой хугацаанд олон нийтэд нээлттэй байлгах;
4. Иргэдийн төлөөлөгчөөр сонгогдсон иргэдийг шүүхийн үйл ажиллагаанд идэвхтэй, **хариуцлагатай** оролцуулах үүднээс тэдний эрх зүйн боловсролыг дээшлүүлэх.

ЭХ СУРВАЛЖ

Ашигласан хууль тогтоомж

- Монгол Улсын Үндсэн хууль (1940)
- Монгол Улсын Үндсэн хууль (1960)
- Монгол Улсын Үндсэн хууль (1992)
- Шүүхийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ (2021)
- Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль (2016)
- Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль (2002)
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (2017)
- БНМАУ-ын аливаа шүүх таслах газруудыг байгуулах дүрэм (1926)
- Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хууль (2012)
- ОХУ-ын Эрүүгийн байцаан шийтгэх хууль (2001)
- Тайванийн Үндсэн хууль (1947)
- ХБНГУ-ын шүүхийн тухай хууль (1972)

Ашигласан ном, сурах бичиг, өгүүлэл, илтгэл

- Б.Чимид “Үндсэн хуулийн мэдлэг”, УБ., 2008
- Б.Чимид “Хууль дээдлэх ёсыг хангадаг шударга шүүхийн үүрэг” Үндсэн хуульт ёс ба үндэсний эрх зүйн тогтолцоо олон улсын симпозиум II. УБ., 2009
- Б.Баярсайхан, Д.Баянбилэг /ред/, “Монгол Улсын хууль тогтоомжийн түүхэн эмхэтгэл”, УБ., 2010
- Ц.Цогт “Эрх зүйн хийдэл, түүнийг шийдвэрлэх арга зам” (2016)
- О.Мөнхсайхан “Цэцийн шийдвэрийн шүүмж: анхан шатны шүүх бүрэлдэхүүнд иргэдийн төлөөлөгчийг оролцуулах нь үндсэн хууль зөрчөөгүй” өгүүлэл (2014)
- Д.Ганзориг: “Шүүхийн шинэчлэл: бие даасан байдал, чиг үүрэг, хариуцлага” илтгэл (2021)

Гадаад эх сурвалж

- Смирнова В.А. Конституционное право граждан на участие в отправлении правосудия.
- Мицай Д.Г. Институт участия населения в отправлении правосудия // Вестник Владивостокского государственного университета экономики и сервиса. М., 2009
- Насонов С.А. Участие граждан в осуществлении правосудия как принцип, определяющий качественные характеристики судебной власти // Юридическая наука. М., 2016
- Прокудина Л.А. Реализация конституционного права граждан на участие в отправлении экономического правосудия // Право. Журнал Высшей школы экономики. М., 2015
- Ляднова Э.В. Право граждан на участие в отправлении

правосудия: конституционно-правовое содержание и механизм реализации : автореф. дис. ... канд. юрид. наук. Белгород, 2010.

- Определение Конституционного Суда РФ от 2 июля 2013 г. № 1052-О «Об отказе в принятии к рассмотрению жалобы гражданина Мирошниченко Владимира Ивановича на нарушение его конституционных прав частью второй статьи 379 Уголовно-процессуального кодекса Российской Федерации» // СПС «КонсультантПлюс»
- Постановление Конституционного Суда РФ от 19 апреля 2010 г. № 8-П «По делу о проверке конституционности пунктов 2 и 3 части второй статьи 30 и части второй статьи 325 Уголовно-процессуального кодекса Российской Федерации в связи с жалобами граждан Р. Р. Зайнагутдинова, Р. В. Кудяева, Ф. Р. Файзулина, А. Д. Хасанова, А. И. Шаваева и запросом Свердловского областного суда» // СЗ РФ. 2010.

Бусад эх сурвалж

- <http://www.gesetze-iminternet.de/bundesrecht/drif/gesamt.p>
- Шүүхийн иргэдийн төлөөлөгч, шүүгчийн сонгон шалгаруулалт. Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэн. Судалгааны тайлангийн эмхтгэл-2014, УБ., 2015



Чинбатын БОЛОРМАА

МУИС-ийн ХЗС-ийн V түвшний оюутан
(тусгай байр)

ЦАХИМААР ШҮҮХ ХУРАЛДААНЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДОХ ЗАРИМ АСУУДАЛ

Түлхүүр үг: сорилт, цар тахал, цахим хуралдаан, цахим систем, төхөөрөмжийн хүрэлцээ, цахим гарын үсэг

Хураангуй: Дэлхий нийтийг хамарсан цар тахлын нөхцөл байдал болон дижитал хувьсалтай холбогдуулан манай улсын хувьд цахим шүүхийг хөгжүүлэх сорилт тулгараад байна. Энэ ч утгаараа Шүүхийн тухай хууль (Шинэчилсэн найруулга)-д цахимаар шүүх хуралдааныг зохион байгуулах, түүний журмыг батлах эрхийг Шүүхийн ерөнхий зөвлөлд олгосон.

Цар тахлын нөхцөл байдалтай¹ холбоотойгоор цахим шүүхийн хэрэглээ нь өмнөхөөсөө нэмэгдсэн ч нэгдсэн систем, холбогдох эрх зүйн зохицуулалт хангалтгүй байгаагийн улмаас шүүхүүд өөрийн байгаа хүчин чадлын хүрээнд үйл ажиллагаагаа явуулсаар² байна. Цахимаар шүүх хуралдааныг зохион байгуулсан тохиолдлууд нь хэргийн оролцогчдын шүүхээр хэрэг маргаанаа шийдвэрлүүлэх эрхийг хангалттай хэмжээнд хангаж чадахгүй³ байна. Учир нь цар тахлын үед шүүхүүдийн хүлээн авах хэргийн тоо буурсан бөгөөд энэ нь иргэд хэрхэн цахимаар нэхэмжлэл, гомдлоо гаргах талаар хангалттай мэдээлэлгүй байх, цаашлаад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахимаар явуулахад шүүхийн байгууллага болон талуудын хооронд шуудангаар баримт хүргэгдэх ажиллагаа явагдаж байсан нь хугацаа алдах, шүүхүүдийн техник хэрэгсэл хангалтгүйн улмаас зарим хэргийн оролцогчдын шүүх хуралдаан хойшлох зэрэг нэлээдгүй асуудлыг дагуулсан.⁴

Иймд энэхүү илтгэлээрээ цахим шүүхийн ойлголт, шүүхээс цар тахлын үед хэрэг, маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг явуулж буй

¹ Шүүх эрх мэдэл сэтгүүл, 2020, №1, Коронавирустай холбогдуулан батлагдсан хууль: шүүх болон тусгай трибуналуудын ажиллагаанд үзүүлэх сөрөг нөлөө, үүсэх үр дагавар, 144 дэх тал

² Нэхэмжлэлийг шуудангаар хүлээн авах, нэхэмжлэлийг шуудангаар хүргүүлэх, хүсэлтийг цахим шуудангаар хүлээн авах, шүүх хуралдааны товыг шуудангаар болон цахим шуудангаар мэдэгдэх, товлох, шүүх хуралдааныг ЗҮҮМ (Zoom) платформоор явуулах г.м

³ Энэхүү илтгэлийн хүрээнд хийсэн практик судалгаанаас үр дүн харагдах болно.

⁴ Энэхүү илтгэлийн хүрээнд хийсэн практик судалгааны үр дүнд дэлгэрэнгүй харагдах болно.

нөхцөл байдал, цахимаар шүүхийн ажиллагааг явуулахад эрх зүйн зохицуулалт хангалттай байгаа эсэх болон гадаад улсуудын холбогдох сайн туршлагыг судалж, өөрийн санал дүгнэлтийг өгөхийг зорилоо.

I. УДИРТГАЛ ХЭСЭГ

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх хэсэгт эрх нь зөрчигдсөн хэн боловч шүүхээр хэрэг маргаанаа шийдвэрлүүлэх эрхтэй талаар заасан байдаг. Уг эрх нь дан ганц шударга шүүхээр шүүлгэх эрхээс гадна тасралтгүй, хүрэлцээтэй байдлаар шийдвэрлүүлэх эрхийг ч мөн хамардаг.⁵

Дэлхий нийтийг хамарсан цар тахлын улмаас бүхий л салбар ковидын сорилттой тулгарсан. Гэвч бүх нийтийн өндөржүүлсэн бэлэн байдал зарласан үед шүүхээс цахимаар хэрэг маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг тусгайлсан⁶ цахим системийн хүрээнд явуулаагүй бөгөөд “Шүүхийн ерөнхий зөвлөл”-ийн баталсан хөдөлгөөний түр аргачлалын дагуу шүүх хэргийн оролцогчдод шуудан болон цахим шуудангаар хэрэг танилцуулах, нэхэмжлэл гардуулах, шуудангаар нэхэмжлэл хүлээн авах зэрэг ажиллагаануудыг явуулж байсан. Ийнхүү шүүхийн ажиллагаа явагдах нь хэргийн нууцлалын асуудал, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа удааших, шийдвэрлэх хугацаа хойшлох, шүүх хурлын тов мэдэгдсэн өдөр тодорхой хүсэлт нотлох баримтыг шүүхэд гаргах тохиолдолд хэрхэх гээд олон асуудлыг дагуулж байна.

Уг асуудлыг боловсронгуй болгох хүрээнд 2021 онд батлагдсан Шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д Шүүхийн ерөнхий зөвлөл нь “...шүүхийн бие даасан байдлыг хангах талаар ...хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүртгэл, хяналтын нэгдсэн систем, цахимаар шүүх хуралдааныг зохион байгуулах программ хангамжийг хөгжүүлэх, хэвийн ажиллагааг хангах”;⁷ шүүх хуралдааны дууны, дуу-дүрсний бичлэг хийх, архивлах болон шүүх хуралдаанд оролцогчийг зайнаас буюу цахимаар оролцуулах ажлыг зохион байгуулах журмыг хуульд заасны дагуу батлах⁸ бүрэн эрхтэй хэмээн шинээр тусгаж өгсөн байна.

Гэвч манай улсын төсвийн хувьд шүүхэд хангалттай хэмжээний төсөв хуваарилагддаггүйгээс цахимаар шүүх хуралдааны явцын тоо баримт⁹, нийтлэгдсэн шийдвэр¹⁰ зэргийг цахимаар харж болохоос хэрэг маргаан хянан шийдвэрлэх, хэргийг хүлээн авах цахим систем одоогоор байхгүй байна.

Бусад улс орнуудын жишгээс харахад цахимаар хуралдах эрх зүйн үндсийг цар тахлын нөхцөл байдлаас өмнө бүрдүүлсэн, технологийн

⁵ Г.Совд, Хүний эрхийн тайлбар толь, 2000, 86 дахь тал

⁶ Тусгайлсан цахим системийн хувьд

⁷ Шүүхийн тухай хууль, 2021, 71 дүгээр зүйлийн 1.12 дахь хэсэг

⁸ Шүүхийн тухай хууль, 2021, 71 дүгээр зүйлийн 1.14 дэх хэсэг

⁹ <https://livecourt.mn/>

¹⁰ <https://shuukh.mn/>

хүрэлцээт байдлыг ч мөн нэмэгдүүлж зарим улс орнуудын хувьд иргэний болон захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны 60 орчим хувь¹¹ нь цахимаар явагддаг жишиг хэдийнээ тогтжээ.

Иймд энэхүү илтгэлээрээ цахимаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулахад манай улсад хангалттай эрх зүйн зохицуулалт бий эсэх, цаашид эрх зүйн зохицуулалтгүйгээр системийн хүрээнд хөгжүүлэх эсэх, уг ажиллагааг бүх тохиолдолд хийдэг үү эсхүл тодорхой тохиолдлуудад хийх үү, гадаад улсуудын хувьд хэрхэн зохицуулдаг, тэдгээрийн сайн туршлагыг манай улс төсөөтэй байдлаар хэрэглэх боломжтой эсэхийг судлахыг зорьсон болно.

II. ҮНДСЭН ХЭСЭГ

2.1. Цахим шүүхийн талаар онолын ойлголт, төрөл:

Цахим шүүх гэдэг нь шүүх эрх мэдлийн хүртээмжийг сайжруулах, хуулийн байгууллагуудын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, шударга ёсны тогтолцоог бэхжүүлэх, хуулийн институци, хуулийн ерөнхий удирдлагыг боловсронгуй болгоход чиглэсэн мэдээлэл, харилцаа холбооны технологийг ашиглахыг үйл ажиллагаа юм.¹²

Анх тус нэр томъёо, шүүхийн зарим үйл ажиллагааг цахим шилжүүлэх эхлэлийг¹³ 1993 онд ДеЛон, Маклин нар шүүхийг цахим хэлбэрт хослуулах талаар анхны санааг гаргасан бөгөөд улмаар 2003 онд шүүхийн цахим хэлбэрийн мэдээллийн системийг үүсгэсэн нь цахим шүүхийн эхлэл байсан гэж үздэг байна.¹⁴

Цахим шүүхийн хувьд аль хэдийн нэвтэрсэн (Америкийн Нэгдсэн Улс, Бүгд Найрамдах Сингапур Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс г.м) гадаадын зарим улсын жишгээс харахад дараах нөхцөлийг бүрдүүлсэн шүүхийг ойлгодог байна¹⁵. Үүнд:

1. **E-Filing:** Нэхэмжлэл, хариу тайлбар болон бичгийн хэлбэрээр шүүхэд гаргадаг бусад мэдүүлэг, тайлбар хүсэлт, бичмэл нотлох баримтыг цахим хэлбэрээр мэдүүлэх;
2. **E-court:** Шүүх хурал болон урьдчилсан хэлэлцүүлэг зэрэг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэргийн оролцогчид шүүхэд биечлэн ирэлгүйгээр TV conference, Web conference зэрэг технологийг ашиглан оролцох;
3. **E-case management:** Зохигчид болон тэдний итгэмжлэгдсэн төлөөлөгчид нэхэмжлэл, хариу тайлбар, бусад баримт бичиг,

¹¹ <file:///C:/Users/User/Downloads/DB14-Improving-court-efficiency.pdf> Improving court efficiency: the Republic of Korea's e-court experience

¹² <https://libreresearchgroup.org/en/a/e-justice> What is the e Justice

¹³ TOMLINSON, JOE. "Front Matter." Justice in the Digital State: Assessing the Next Revolution in Administrative Justice, 1st ed., Bristol University Press, 2019, pp. i–iv, <https://doi.org/10.2307/j.ctvndv808.1>.

¹⁴ <https://www.jstor.org/stable/pdf/j.ctt1wn0qx3.7.pdf> Evaluating e-Justice: The Design of an Assessment Framework for e-Justice Systems p-5

¹⁵ <https://efiling.court.go.ke/> E-Filing, E-Court, [file:///C:/Users/User/Downloads/53-122-1-SM%20\(1\).pdf](file:///C:/Users/User/Downloads/53-122-1-SM%20(1).pdf) Differentiated Use of Electronic Case Management Systems

нотлох баримт гэх мэт цахим мэдээлэлд шаардлагатай үед хялбар байдлаар онлайн орчинд нэвтэрч, хэргийн хөдөлгөөнд хяналт тавьдаг байх гэсэн 3 үндсэн шаардлагыг хангасан шүүхийг ойлгодог байна.¹⁶

Гэсэн хэдий ч дээрх орнуудын туршлагаас харахад e-Filing, e-Case Management нь цахим шүүхийн үйл ажиллагааны гол цөм хэсэг байна. Харин цахим шүүх нэвтэрсэн байсан ч зохигчдын өмгөөлөгч шүүх хуралд биечлэн оролцох нь зүйтэй бөгөөд шүүх хуралдаанд оролцох боломжгүй тохиолдолд Web conference¹⁷ хэрэглэгчдэд интернетээр дамжуулан, компьютер эсвэл төхөөрөмжид татаж авсан программ хангамж, эсвэл дотоод орчинд дуудлага хийх боломжийг олгодог хамтын ажиллагааны технологийг ашигладаг байна.

Мөн эндээс цахим шүүх гэдэг нь тусдаа бие даасан шүүхийн институци байгуулах асуудал биш бөгөөд цахимаар тодорхой хэргүүдийг хянан шийдвэрлэх үйл явц гэдгийг ойлгож болно.

Цахим шүүх буюу цахимаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахын давуу тал:

- ✓ Цаасан суурьтай бичиг баримт, нотлох баримтыг боловсруулж шүүхэд гаргахад шаардагдах зардал, цаг хугацаа, ажлын ачааллыг бууруулах;
- ✓ Цахимжилт эрчимтэй нэмэгдэж байгаа энэ үед шүүхийн үйл ажиллагааг түүнтэй уялдуулж, интернет орчинд баримтыг хүлээн авах, илгээх гэх мэт үйл ажиллагааг хялбар хийх;
- ✓ Хавтаст хэргийн хамгаалалт сайжрах боломжтой буюу давагдашгүй хүчин зүйлийн улмаас цаасан материал устахаас сэргийлэх;
- ✓ Хэргийн оролцогчдод чирэгдэл учруулахгүйгээр шүүх хуралдаанд оролцуулах, өмгөөлөгч авах боломжийг нэмэгдүүлэх, өмгөөлөгчид цаг хугацаа орон зайнаас үл хамааран шүүх хуралд оролцох, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцтай танилцах боломжоор хангагдах;
- ✓ Цар тахлын нөхцөл байдлаас шалтгаан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа удаашрах, шүүх хуралдаан хойшлох явдлыг бууруулах ач холбогдолтой.

2.2. Цахимаар шүүх хуралдааныг зохион байгуулах эрх зүйн зохицуулалт

2019 оны 11 дүгээр 14-ний өдөр Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан нь Шүүхийн тухай хуулийг шинэчлэн батлах эрх зүйн шинэчлэлийн эхлэл болсон. Үүнтэй холбогдуулан Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль хүчингүй болж Шүүхийн тухай хууль

¹⁶ Шүүх эрх мэдэл сэтгүүл, 2020 он, Дугаар 1, Шүүхийн судалгаа мэдээлэл, сургалтын хүрээлэн, 119 дэх тал

¹⁷ <https://www.cisco.com/c/en/us/solutions/collaboration/what-is-web-conferencing.html> What is the web conference

(Шинэчилсэн найруулга 2021)-ийг баталсан бөгөөд тус хуулийн шинээр орж ирсэн зохицуулалт нь Шүүхийн тухай хуулийн 71 дүгээр зүйлд заасан “...тодорхой хэрэг маргааныг цахим шүүхээр шийдвэрлэх...” талаар ойлголт юм.

Шүүхийн тухай хууль батлагдахаас өмнө манай улсын хувьд Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд хэргийн оролцогч, зохигч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч, гэрч, шинжээч, орчуулагч, хэлмэрчийг зайнаас оролцуулах талаар зохицуулалт байгаагүй.

Харин Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 7.8 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Яллагдагчийг...дуу дүрсний төхөөрөмж ашиглан өөр газраас шүүхийн хэлэлцүүлэг, шүүх хуралдаанд оролцуулж болно” гэж заажээ. Гэвч эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд яллагдагч, шүүгдэгчийг ямар үндэслэлээр зайнаас дуу-дүрсний төхөөрөмж ашиглан шүүхийн хэлэлцүүлэг, шүүх хуралдаанд оролцуулах талаар тодорхой зохицуулалт тусгагдаагүй байна.

Эндээс үзвэл Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь “зайнаас оролцуулах” гэдэг нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нэг хэсэг болох шүүх хуралдааныг цахимаар явуулах тохиолдлыг л хамааруулж байгаа, бусад цахимаар хүсэлт гомдол авах, хэргийн хөдөлгөөнийг хянах талаар ойлголтыг багтаагаагүй байна.

Цахимаар шүүх хуралдаан хийх талаар улс орнуудын хувьд а.Эрх зүйн тодорхой зохицуулалтгүй ч цахим шүүх хуралдаан хийдэг¹⁸, б.Уг асуудлыг процессын хуулиар зохицуулдаг¹⁹, в.Бие даан тусгай хуулиар зохицуулдаг²⁰ орнууд гэж ангилдаг байна.²¹

Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2020 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор баталсан “Шүүхийн захиргааны байгууллагын стратеги төлөвлөгөө”²²-ний 3.3.3.2-т заасан “Шүүх цахимаар нэхэмжлэл хүлээн авах, өмгөөлөгч, хэргийн оролцогчтой цахимаар харилцах 3.3.3.3-т заасан “Цахим шүүхийн дэд бүтцийг (мэдээллийн сүлжээ, техник болон программ хангамж, мэдээллийн сан, мэдээллийн системийн загвар) бүрдүүлэх, шаардагдах хөрөнгийг санхүүжүүлэх «арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгажээ.

Мөн иргэн төвтэй шүүхийн үйлчилгээг бий болгож, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилтод хүрэхийн тулд Шүүхийн захиргааны байгууллагын стратеги төлөвлөгөөний 3.5.1-д заасан «Шүүхийн үйлчилгээ, зохион байгуулалт иргэн төвтэй, хүртээмжтэй байх чиглэлээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны болон бусад холбогдох хууль тогтоомжийг

¹⁸ Казахстан, Турк г.м

¹⁹ ОХУ г.м

²⁰ Шинэ Зеланд

²¹ Баян-Өлгий аймгийн эрүү, иргэний давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч С.Өмирбек, Шүүхүүдийн харьцуулсан судалгаа, 2020

²² https://www.judcouncil.mn/site/news_full/9991 Шүүхийн захиргааны байгууллагын стратеги төлөвлөгөө

боловсронгуй болгох” арга хэмжээг хэрэгжүүлэхээр тус тус заажээ.

Үүнээс үзвэл манай улсын хувьд процессын хууль эсвэл бие даасан эрх зүйн зохицуулалтыг хийх замаар цахимаар шүүх хуралдаан хийх нөхцөлийг бүрдүүлэх зорилготой гэж дүгнэж болохоор байна.

Түүнчлэн гадаад улсуудад цахимаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж буй тохиолдолд цахим гарын үсгийн ашигладаг. Манай улсын хувьд 2011 онд “Цахим гарын үсгийн тухай хууль”-ийг баталсан боловч цахим болон тоон гарын үсгийг хэрэглэхэд эрх бүхий байгууллагаас тусгай гэрчилгээ авсан байх шаардлагатай бөгөөд уг гэрчилгээг хаанаас олгох, хаанаас гаргуулах эсэх нь хуульд тодорхойгүй байна.²³

Харин цахим гарын үсгийн хэрэглээг судлан үзвэл манай улсын нийт иргэн, хуулийн этгээд төрийн байгууллагын хувьд 2021 оны 3 сарын байдлаар 20 мянга орчим тээгч, 500 орчим гэрчилгээтэй иргэн, 20 мянга орчим гэрчилгээтэй аж ахуй нэгж²⁴ байгаа нь нийт иргэн болон хуулийн этгээдийн тоотой харьцуулахад харьцангуй бага үзүүлэлт байгаа юм.

2.3. Цар тахлын үед цахим шүүх хуралдааныг зохион байгуулж буй практик

Коронавируст цар тахлын улмаас өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан шүүхээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар нэлээдгүй шийдвэрүүд гарсан.²⁵

Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2020 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 116 дугаар тогтоолын хавсралтаар гамшгаас хамгаалах өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үед баримтлах “Эрүү, иргэн, захиргааны шүүхийн хэргийн хөдөлгөөний түр аргачлал”-ыг баталжээ. Уг аргачлалд эрүү, иргэн, захиргааны анхан болон давж заалдах шатны журмаар хянан шийдвэрлэхэд шүүх хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт хүлээн авах, шүүх хуралдааны бэлтгэл хангах, шүүх хуралдаанд оролцогчийг дуу, дүрсний төхөөрөмж ашиглан цахимаар оролцуулах, шүүхийн шийдвэрийг гардуулах буюу хүргүүлэх, давж заалдах болон хяналтын журмаар гаргасан гомдол,

²³ Цахим гарын үсгийн тухай хууль, 2011

²⁴ <https://www.medeec.mn/p/163722> Зууны мэдээ сонин, Цахим гарын үсэгтгүй Дижитал үндэстэн нийтлэл

²⁵ Бүх шатны шүүх үйл ажиллагаандаа Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн 2020 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 60 дугаар захирамжаар баталсан “Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлын үед шүүгчийг 24 цагаар ажиллуулах журам, Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2020 оны 11 дүгээр сарын 24-ний 116 дугаар тогтоолоор “Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед шүүхийн Тамгын газраас авч хэрэгжүүлэх арга хэмжээний удирдамж”, Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын 2020 оны 11 дүгээр сарын 16-ний өдрийн 01/1183 дугаар зөвлөмж, Шүүхийн ерөнхий зөвлөлийн Гүйцэтгэх нарийн бичгийн даргын 2020 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 03/1195 дугаар албан бичиг, Улсын онцгой комиссын даргын 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 20 дугаар тушаалаар баталсан “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үед хэрэгжүүлэх хариу арга хэмжээний удирдамж” Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2018 оны А/274 дүгээр тушаалаар баталсан “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон орон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийг ажлын тусгай горимд шилжүүлэх, ажиллах журам”

эсэргүүцэлтэй, прокурорт буцаасан хэргийг холбогдох шүүх, прокурорын байгууллагад хүргүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахаар тусгаж өгчээ.

Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын үед бүх шатны шүүхэд нэхэмжлэл, гомдол, хүсэлтийг цахимаар гаргах эрх нээлттэй байсан бөгөөд уг ажиллагаанд шүүх тус бүр шүүхийн албаны цахим шууданг ашиглаж байна. Цар тахлын нөхцөл байдалтай холбоотойгоор бүх шатны шүүхүүд Зүүм, Скайф²⁶ болон бусад программ хангамжийг ашиглан шүүх хуралдааныг зайнаас явуулсан байна. Харин цахим хуралдаанд оролцох техник хэрэгсэлгүй, интернетийн сүлжээгүй орчинд байгаа хэргийн болон шүүх хуралдааны оролцогчдын шүүх хуралдаанд оролцох эрхийг хангах зайлшгүй тохиолдолд шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга байгаа танхимаас өөр танхимд оруулах байдлаар зохион байгуулжээ.

Ковидын халдвар бүртгэгдсэнээс хойш цахимаар шүүх хуралдаан явуулах байдал өмнөх 4 жилийн дунджаас 2-4 дахин нэмэгдсэн байгааг доор хүснэгтээс харж болох юм. Гэвч шүүхэд хүлээн авах хэргийн тоо багассан байгаа нь цар тахлын өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан хэрэг маргааныг хэрхэн цахимаар шийдвэрлүүлэх талаар иргэд төдийлөн мэдээлэлгүй байсантай холбоотой²⁷.

Хүснэгт 1: Дотоодод Ковидын халдвар бүртгэгдсэн жил хийгдсэн цахим шүүх хуралдааны тоог өмнөх жилүүдтэй харьцуулахад

Холбогдсон чиглэл	2015-2018	2019
Цахим хурал, зөвлөгөөн, семинар	34	26
Орон нутгийн шүүхийн шүүх хуралдаанд Улаанбаатар хотоос	230	746
Орон нутгийн шүүхийн шүүх хуралдаанд бусад орон нутгаас	311	620
Нийслэл дэх эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүх хуралдаанд хорих 461-р ангиас	243	402
Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүх хуралдаанд хорих 461-р ангиас	114	678
Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүх хуралдаанд хорих 461-р ангиас	95	163
Нийт	4186	2635

2019 оны байдлаар Анхан шатны шүүхээр хянан шийдвэрлэгдсэн эрүүгийн хэрэг өмнөх оныхоос 0.3 хувиар, иргэний хэрэг 23.7 хувиар тус тус өссөн бол захиргааны хэрэг 12.8 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Харин Монгол улсад коронавируст халдвар дотоодод халдварласан анхны тохиолдол бүртгэгдэж гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн

²⁶ Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүгч болон шүүгчийн туслахуудаас авсан судалгааны үр дүнд

²⁷ <https://khanlex.mn/wp-content/uploads/2021/05/QA-Paper-MON-version-COVID-19-Business-Issues-in-Mongolia-for-SMEs-updated.pdf> Ковид 19 ба онцгой нөхцөл байдлын үеийн арга хэмжээнүүдийн тухай

байдлын зэрэг тогтоосон үед анхан шатны шүүхийн хүлээн авсан, хэргийн тоо дунджаар 36.3 хувиар буурсан байна.²⁸

Хүснэгт 2: 2019 оны 11 дүгээр сарын 1-30-ны өдрийн байдлаар

№	Анхан шатны шүүх	Нийт Шүүхэд хүлээн авсан хэргийн тоо	Дүүргийн шүүхүүдэд	Улсын хэмжээнд хянан шийдвэрлэгдсэн	Улсын хэмжээнд шүүх хуралдаанд товлон зарласан	Хойшилсон
1	Эрүү	1322	723	1083	1299	285
2	Иргэн	5347	2890	3476	4912	1987
3	Захиргаа	215	145	174	782	399
	Нийт	6884	3758	4733	6993	2671

Хүснэгт 3: 2020 оны 11 дүгээр сарын 1-30-ны өдрийн байдлаар

№	Анхан шатны шүүх	Нийт Шүүхэд хүлээн авсан хэргийн тоо	Дүүргийн шүүхүүдэд	Улсын хэмжээнд хянан шийдвэрлэгдсэн	Улсын хэмжээнд шүүх хуралдаанд товлон зарласан	Хойшилсон
1	Эрүү	726	339	524	1056	527
2	Иргэн	3478	1878	2224	3189	1480
3	Захиргаа	182	113	53	452	392
	Нийт	4386	2330	2801	4697	2399
	Өмнөх оны мөн үетэй харьцуулахад буурсан тоо	-36.3	-38	-40.82	-32.8	-10.2

Шүүгч болон шүүгчийн туслах, хэргийн оролцогчид болон өмгөөлөгчдөөс авсан судалгааны үр дүн²⁹:

Оюутны зүгээс дүүргийн шүүхүүдээс Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийг сонгон авч шүүхийн шүүгчид, шүүгчийн туслах, өмгөөлөгч, хэргийн оролцогчид нийт 100 хүнээс анкетын аргаар судалгаа авсан болно. Судалгааны асуултуудын хувьд шүүгч болон шүүхийн ажилчид, өмгөөлөгч болон хэргийн оролцогчид гэж ангилан судалгааг авсан.

А. Шүүгч болон шүүгчийн туслахуудаас авсан судалгааны үр дүн:

1. Хөл хорионы үед хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад ямар хүндрэл бэрхшээл тулгарч байсан бэ гэсэн асуултад хариуцагчид нэхэмжлэл гардуулах, хэргийн материал танилцуулах, шүүх хуралдаан технологийн нөхцөлөөс болоод хойшлох, хэрэг хянан

²⁸ <http://www.judicature.mn/statistic/> Монгол улсын шүүхийн тайлан, 2019, 2020, 2021 оны 1 дүгээр улирал

²⁹ Шүүгч болон шүүгчийн туслахуудаас ижил асуултаар авсан.

шийдвэрлэх ажиллагаа удаашрах, шүүхийн технологийн хүрэлцээ муу, Zoom-ээр ихэнхдээ шүүх хурал явагддаг байсан бөгөөд албан ёсны эрхгүй бөгөөд хурдан тасардаг гэх мэт асуудал тулгардаг гэжээ.

2. *Цар тахлын нөхцөл байдлын үед шүүх хуралдаан ямар үндэслэлээр хойшилж байсан бэ* гэсэн асуултад хэргийн оролцогчдын интернет болохгүй байх, дата байхгүй байх, компьютер, утас байхгүй байх, технологийн асуудал, хэргийн оролцогчид ковидын халдвар авсан, ойрын хавьтал болсон зэрэг шалтгаан байсан гэжээ.
3. *Шүүх хуралдааныг цахимаар явуулахад техник хэрэгсэлгүй иргэдийг хэрхэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэрхэн оролцуулж байсан бэ* гэсэн асуултанд ихэнх тохиолдолд хойшлуулж байсан, цөөн тохиолдолд гар утсаар нь, цөөн тохиолдолд шүүхийн танхимаас оролцуулж байсан гэжээ.
4. *Шүүхийн технологийн ямар асуудал тулгарч байна* вэ гэсэн асуултад техникийн хүрэлцээ муу, шүүх хуралдаан цахимаар явуулахад хурал дундуур техник болон интернетийн улмаас тасалддаг, шуудангаар нэхэмжлэл хариу тайлбарыг илгээхэд зарим тохиолдолд оролцогчид хариу өгдөггүй, зарим хүмүүст цахим шуудан байдаггүй зэрэг хүндрэлүүд гарч байжээ.
5. *Иргэний хэргийн хөдөлгөөний түр аргачлалд заасанчлан иргэдийг иргэний танхим болон шүүхийн танхимд цахимаар хуралдуулахад тулгарсан бэрхшээлийн хувьд дуу бичлэг тасалддаг, хороодын иргэдийн танхим хүрэлцээ байхгүй, огт шүүх хуралдаан тэнд явагдаагүй гэжээ.*
6. *Цаашид технологийн хүрэлцээ, хүчин чадлыг нэмэгдүүлбэл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахимаар явуулах боломжтой гэж үзэж байна уу* гэсэн асуултад бүгд боломжтой гэж хариулжээ.

Б. Өмгөөлөгчид болон хэргийн оролцогчдоос авсан судалгааны үр дүн:

1. *Коронавируст цар тахлын үед шүүхээр хэрэг маргаанаа шийдвэрлүүлэхэд хүндрэл гарч байна уу* гэсэн асуултанд бүгд тийм гэж хариулсан байна.
2. *Уг нөхцөл байдалд ямар хүндрэл гарч байна* вэ гэсэн асуултад цаг хугацаа их алддаг, шүүхийн танхим, техникийн хүрэлцээ муу, хүн хоорондын зай байхгүй, эрүүл ахуйн шаардлага хангаагүй, зарим оролцогчийн техник болон биеийн байдлаас шалтгаалж хуралдаан их хойшилдог гэжээ.
3. *Цар тахал, хөл хорионы үед цахимаар шүүх хуралдаанд оролцож байсан уу* гэсэн асуултад дийлэнх хэсэг нь тийм гэж хариулсан байна.
4. *Цахимаар шүүх хуралдаанд оролцоход тулгарсан бэрхшээл юу байсан бэ* гэсэн асуултад шүүх хуралдаанд орохын өмнө шинээр

нотлох баримт, хүсэлт өгөхөд хүндрэлтэй байсан, хурал тасалддаг, биечлэн оролцох боломжгүй байсан, мэтгэлцэх зарчим хангаагүй зэрэг асуудлуудыг дурджээ.

5. *Цаашид цахимаар шүүх хуралдааныг явуулах боломжтой эсэх* гэсэн асуултад технологийн асуудал, интернетийн асуудлаа бүрэн шийдвэл ийнхүү оролцох нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаа сунгахгүй байх ач холбогдолтой гэжээ.

Явцын дүгнэлт: Дээрх судалгаанаас үзвэл судалгаанд оролцогчдын хувьд цахимаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахад тусгайлсан цахим систем байхгүйн улмаас иргэд шүүх хуралдаанд оролцохын өмнөх ажиллагаануудыг шуудан болон цахим шуудангаар хийж байсан байна. Ийнхүү хийхэд хугацаа алдах, хэргийн материалтай танилцаагүй гэсэн шалтгаанаар хуралдаан хойшлох үр дагавартай байсан байна. Харин шүүх хуралдааныг цахимаар хийх явцад техникийн саатал үүсэх, шүүх хуралдаан явагдах явцад интернет тасрах, төхөөрөмж гацах зэрэг асуудал үүсч байсан байна.

Өөрөөр хэлбэл, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хойшилсон шалтгаануудын нэлээдгүй хэсгийг технологи, цахим системийн боловсронгуй бус байдал эзэлж байна. Түүнчлэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахимаар явуулахад тусгайлан цахим хандалтын сайт байхгүй бөгөөд шүүгчийн туслахаас хэргийн оролцогчид руу мэйлээр болон шуудангаар нэхэмжлэл болон хэргийн материалын тодорхой хэсгийг явуулж, танилцав хариу цахим шууданг, тэмдэглэлийг хэрэгт хавсарган хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг үргэлжлүүлж байсан нь тоон гарын үсгийг төдийлөн хэрэглээгүйг илтгэж байна.

III. ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Улсуудыг сонгон авахдаа цахимаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хуульгүйгээр зохицуулдаг болон бие даасан хуулиар зохицуулдаг улсын жишээг оруулсан бөгөөд манай улсын хувьд эдгээр улсуудаас авч болох сайн туршлагыг илрүүлэхийг зорьсон болно.

3.1. Сингапур улсын цахим шүүхийн нөхцөл:

Улс төр эдийн засгийн эрсдэлийн зөвлөлдөөний (PERC) судалгаагаар Бүгд Найрамдах Сингапур Улс нь 2008 оны байдлаар Азийн хамгийн сайн шүүхийн системтэй улсад орсон болно. Мөн 2010 онд Дэлхийн шударга ёсны төслийн Эрх зүйт байдлын индекс нь Сингапурт өндөр орлоготой улс орнуудын иргэний шударга ёсыг хангахад эхний байранд орж байсан билээ.

Цахим шүүх ажиллагааны нэгдсэн систем (eLitigation) нь шүүхийн мэдээллийн технологийг улам бүр боловсронгуй болгоход чиглэсэн дараагийн алхам юм. 2000 онд Шүүхийн цахим бүртгэлийн систем (EFS) нь иргэний шүүх хуралдаанд хувьсгал хийж, шүүхийн баримт бичгийг цахим

хэлбэрээр бүрдүүлэх боломжийг олгосон. Шүүхийн цахим бүртгэлийн систем (EFS)-г анх 2000 оны 3 дугаар сард нэвтрүүлсэн байна³⁰.

Цахим шүүн таслах ажиллагааны нэгдсэн систем

Одоогийн хэрэгцээг хангах системийн уян хатан байдлыг хадгалахын ач холбогдлыг хүлээн зөвшөөрч Сингапурын шүүх Цахим шүүх ажиллагааны нэгдсэн системийг цогцоор нь хөгжүүлж Шүүхийн цахим бүртгэлийн системийн чадавхыг өргөжүүлэх замаар орчин үеийн техник, технологийн ололтыг нэвтрүүлж дараах систем, механизмыг үйл ажиллагаандаа ашиглаж эхэлсэн байна.³¹ Үүнд:

1. Сонсголын тусламжийн систем: Тодорхой хэмжээний сонсголын бэрхшээлтэй хүмүүс телекойл сонсголын аппаратаа ашиглан шүүх хуралд оролцохын тулд бүх шүүхийн танхим болон өрөөнүүдэд Сонсголын тусламжийн системийг суурилуулсан.

2. Төвлөрсөн дэлгэцийн удирдлагын систем: Хуульч, өмгөөлөгч болон олон нийт хамгийн сүүлийн үеийн шүүх хуралдааны жагсаалт болон шүүх хуралдааны бусад хуваарийг авч байхаар, Дээд шүүхийн байранд долоон Төвлөрсөн дэлгэцийн удирдлагын систем (CDMS) iKiosks байдаг. iKiosks-ийн холбоосыг Цахим шүүх ажиллагааны нэгдсэн систем (eLitigation) нэгтгэсэн бөгөөд энэ нь дүүргийн шүүгч дүүргийн бүртгэгч, хурлын жагсаалт, хурал зохион байгуулах газар, түүнчлэн Дээд шүүхийн байрны эргэн тойронд хялбар навигаци хийх интерактив лавлах зэрэг мэдээлэл өгдөг. Интерактив дарааллын дугаар олгох систем (i-QMS) нь дампуурлын тухай өргөдлөөс бусад бүх өргөдлийг бүртгэх боломжтой.

3. Дижитал хөрвүүлэлтийн систем: Энэхүү систем нь эцсийн дижитал аудио бичлэгийг шүүх хуралдааны шүүгчийн тайлбартай синхрончлох боломжийг олгодог. Энэ функц шүүгчдэд аудио бичлэгийг хянахын тулд хайх, тоглуулах функцийг гүйцэтгэх, мөн шүүх хуралдааны дараа холбогдох тайлбарыг оруулах боломжийг олгодог. Түүнчлэн Дээд шүүхийн Дижитал хөрвүүлэлтийн систем (DTS) нь алсаас транскрипци (хуулбарыг) хийх боломжийг олгодог бөгөөд ингэснээр шүүхийн бичигч танхимд бичлэн ирэх албагүй байдаг. Дээд шүүхийн Дижитал хөрвүүлэлтийн систем (DTS) -г 2005 оны 8 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн Дээд шүүхийн байрны бүх хурлын танхимд ашиглах боломжтой болсон бөгөөд үүнээс хойш бүх бүртгэгчдийн шүүх хуралдааны танхимуудад байршуулсан.

4. Цахим гарын үсэг: Талууд болон гэрчүүд зөв танхим, зааланд оролцохыг баталгаажуулахын тулд цахим тэмдэглэгээг шүүхийн танхим, шүүх хуралдааны танхим бүрийн гадна талд байрлуулна.

5. Цахим шүүх хурал: Улсын Дээд шүүхийн байрны бүх шүүхийн танхимууд цахим шүүх хурлыг хөнгөвчлөхийн тулд шаардлагатай сүлжээний дэд бүтцээр хангасан. Өмгөөлөгч нь шүүхийн байранд

³⁰ https://assets.publishing.service.gov.uk/government/uploads/system/uploads/attachment_data/file/761378/SINGAPORE.pdf State Court of Singapore, Why E court system

³¹ <file:///C:/Users/User/Downloads/132-345-1-PB.pdf> Electronic Courts And The Challenges In Managing Evidence: A View From Inside The International Criminal Court

өөрийнхөө зөөврийн компьютерээ авчирч, хэргийн материалын цахим файлд хандаж, зохих технологийг ашиглан хэргээ танилцуулж болно.

6. Хөдөлгөөнт технологийн тоног төхөөрөмжийн үйлчилгээ:

Технологийн дэвшлийг ашиглан илүү олон хуульч, өмгөөлөгчид өөрсдийнхөө хэргийг илүү сайн танилцуулахыг уриалахын тулд хөдөлгөөнт мэдээллийн технологийн хэрэгслийг бүх шүүхийн танхим, зааланд ашиглах боломжтой. Сингапурын шүүх нь хуульч, өмгөөлөгчдөд хэргийг илүү үр Дүнтэй харуулах боломж олгох дэвшилтэт технологийг ашигладаг. Тухайлбал, Дээд шүүхийн байран дахь бүх шүүх хурлын танхимууд видео хуралд зориулсан плазма дэлгэц, видео камертай. Хуульч, өмгөөлөгчид нь зөөврийн компьютерээ аудио-визуал системтэй холбож болох бөгөөд ингэснээр хүн бүр нэгэн зэрэг дэлгэц дээр нотлох баримтыг үзэж болно. Эдгээр шүүх дэх визуализаторууд нь 3D объектууд эсвэл хэвлэмэл баримт бичгийн зургийг авах, томруулах боломжийг олгодог.³²

7. Скайп програм: Скайп программ нь дүүргийн бүртгэгчдэд агуулгад нийцээгүй хэргүүдийг сонсох боломжийн олгодог. Скайпын тусламжтайгаар өмгөөлөгч нь өөрийнхөө оффис дээрээ видео хурлаар виртуал цахим шүүх хуралд оролцох боломжтой бөгөөд ингэснээр талууд, тэдний өмгөөлөгчид цаг хугацаа болон зардлаа хэмнэж чаддаг байна.

3.2. БНСУ-ын цахим шүүхийн нөхцөл:

Тус улсад 2014 онд батлагдсан Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд цахим баримтыг хэрэглэх тухай хуулиар цахим шүүхтэй холбогдох гол харилцааг зохицуулж байна.³³

Уг хууль нь хуулийн үйлчлэх хүрээ; цахим мэдээллийн системийн ашиглалт хяналт; цахим баримтад тулгуурласан иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулах; цахим баримтыг хүлээн авах, шүүх хуралдааны тэмдэглэл зэргийг цахимжуулах цахим баримтыг илгээх, мэдэгдэх; цахим баримтыг цаасан хэлбэрээр илгээх, гардуулах; нотлох баримтыг шинжлэн судлах; давж заалдах шатны шүүхэд гомдол мэдүүлэх; шүүхийн зардал; тус хуулийн зохицуулаагүй асуудлын талаар УДШ-ийн журмаар зохицуулах тухай агуулгаас бүрддэг.

Тус хуулийн зорилго нь иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд цахим баримтыг хэрэглэх тухай үндсэн зарчим болон процедурыг зохицуулснаар иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны цахимжилтыг эрчимжүүлж, тус ажиллагааны шуурхай, ил тод байдлыг дээшлүүлснээр иргэний зөрчигдсөн эрхийг сэргээхэд оршино гэжээ.³⁴ Тус хуулийн үйлчлэх хүрээ нь дараах процесс ажиллагаанд хамаарна:³⁵

³² <https://www.judiciary.gov.sg/> Singapore Court System

³³ <file:///C:/Users/User/Downloads/DB14-Improving-court-efficiency.pdf>, Improving court efficiency: the Republic of Korea's e-court experience

³⁴ <https://eng.scourt.go.kr/eng/judiciary/eCourt/eTrials.jsp> Supreme Court of Korea, The Electronic Case Filing System (ECFS, <http://ecfs.scourt.go.kr>) is the Korean Judiciary's electronic litigation system

³⁵ <https://wipo.lexres.int/edocs/lexdocs/laws/en/kr/kr028en.pdf>

- ✓ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль;
- ✓ Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль;
- ✓ Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль;
- ✓ Патентын тухай хууль;
- ✓ Иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн тухай хууль;
- ✓ Үүрэг гүйцэтгэгчийг дахин хөрөнгөжүүлэх болон дампуурлын тухай хууль;
- ✓ Онцгой ажиллагааны тухай хуулиуд гэжээ.³⁶

Цахим мэдээллийн системийг бий болгох, түүний ашиглалтыг Шүүхийн захиргааны дээд байгууллага зохион байгуулна.³⁷ Тус системийг ашиглах гэж буй этгээд нь УДШ-ийн журамд зааснаар хэрэглэгчийн бүртгэлд бүртгүүлэх хэрэгтэй.³⁸ Шүүхийн захиргааны дээд байгууллага нь дараах тохиолдолд бүртгэлтэй хэрэглэгчийн үйлчилгээ авах эрхийг зогсоох болон бүртгэлийг устгах эрхтэй:

1. Бүртгэлтэй хэрэглэгч нь жинхэнэ хэрэглэгч биш болох нь тогтоогдсон;
2. Хэрэглэгчийн бүртгэлд бүртгүүлэх болон хэрэглэгчийн бүртгэлийн мэдээллийг шинэчлэх үед худал агуулгатай мэдээллийг оруулсан;
3. Бусад бүртгэгдсэн хэрэглэгчийн үйлчилгээ авах эрхэд саад учруулах, мэдээллийг хулгайлах зэргээр уг системийг ашиглан явагдаж буй иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад саад учруулсан;
4. Санаатайгаар болон ноцтой болгоомжгүй байдлаас болж уг системийг ашиглах явцад саад учруулсан;
5. УДШ-ийн журамд заасан бусад үндэслэл байгаа тохиолдолд гэжээ.

Шүүхэд баримтыг гаргах гэж буй этгээд нь уг баримтад цахим гарын үсгийг зурсан байна. Мөн шүүгч, шүүгчийн туслах болон бусад шүүхийн захиргааны ажилтнууд шүүхийн шийдвэр, тэмдэглэл зэргийг цахим хэлбэрээр үйлдэх, эсхүл тэдгээр баримтыг цахим хэлбэрт хувиргасан тохиолдолд УДШ-ийн журамд зааснаар шүүхийн цахим гарын үсгийг ашиглана. Бүртгэлтэй хэрэглэгчийн хувиар цахим мэдээллийн системийг ашиглаж, иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохдоо зөвшөөрсөн этгээд нь шүүхэд гаргах баримтыг тус системийг ашиглан УДШ-ийн журамд зааснаар цахимаар гаргах ёстой.

Шүүгч шүүгчийн туслах болон бусад шүүхийн захиргааны ажилтан нь бичгээр гаргасан шийдвэр, тэмдэглэл зэргийг цахимаар үйлдэх, эсхүл тус баримт бичгийг цахим хэлбэрт хувиргаж, нэгдсэн системд оруулах ёстой. Шүүгчийн туслах нь УДШ-ийн журамд заасан үндэслэл байхгүй бол цахим бус хэлбэрээр гаргасан баримтыг цахим хэлбэрт хувиргаж, шүүхийн цахим гарын үсгийг зурж нэгдсэн системд оруулна.

БНСУ нь цахим шүүхийн үйл ажиллагааг 2011 оноос нэвтрүүлсэн

³⁶ Мөн тэнд

³⁷ Мөн тэнд

³⁸ Мөн тэнд

туршлагатай орон бөгөөд тус улсад цахимаар нэхэмжлэл гаргах e-Filling, цахимаар хэргийн хөдөлгөөнд хяналт тавих e-Case management, цахимаар шүүх хуралд оролцох e-Court гэсэн цахим шүүхийн 3 үндсэн үйл ажиллагаа бүрэн нэвтэрчээ. Харин эрүүгийн хэргийн шүүхэд ашиглах боломжтой эсэх нь судлагдаж байгаа аж.

Тус улсад цаасан болон цахим шүүхийн үйл ажиллагааг сайн дурын үндсэн дээр хийж буй бөгөөд төрийн байгууллага оролцсон хэрэг болон өмгөөлөгчтэй оролцож буй хэргийн хувьд цахим шүүхээр үйлчлүүлэхийг идэвхтэй санал болгодог байна.³⁹

Шүүхийн статистикаас нь үзэхэд 2016 оны байдлаар шүүхээр шийдвэрлэгдэж буй нийт иргэний хэргийн 60 орчим хувьд цахим шүүхийг ашиглаж байна гэсэн тоо гарсан байна.

Түүнчлэн хэргийн оролцогч, хэргийн аюулгүй байдлыг хангах үүднээс цахим шүүхийн нэгдсэн системд нэвтрэхийн тулд хэрэглэгчийн бүртгэлд хамрагдах ёстой. Цахим шүүхээр үйлчлүүлэхэд хэрэглэгчийн бүртгэлээс гадна цахим гарын үсэг болон NPKI (National public key infrastructure) цахим баталгаажуулалтын системийг ашигладаг. Ингэснээр цахим шүүхээр үйлчлүүлэгчийн ID буюу хэрэглэгчийн хаягийг хулгайлах, жинхэнэ хэрэглэгч мөн бишийг ялгах ач холбогдолтой.

IV. ДҮГНЭЛТ

Дан ганц цар тахал гэлтгүй дижитал системд дэлхий нийтээр шилжиж буй нөхцөлд, хэргийн оролцогчдын хүсэлтийн дагуу шүүх хуралдааныг цахимаар явуулах хэрэгцээ шаардлага өдрөөс өдөрт тулгарч буй.

Манай улсын хувьд Цар тахлын нөхцөл байдлаас үүдэн хэргийн оролцогчийн шүүхээр хэрэг маргаанаа шийдвэрлүүлэх эрхийг хангахын тулд урьдын жилүүдтэй харьцуулбал цахим шүүхийн хэрэглээг нэмэгдүүлсэн. Ийнхүү нэмэгдүүлсэн ч шүүх болон иргэдийн техникийн хүрэлцээгүй байдал, цахимаар явуулах бэлтгэл хангалтгүй байсны улмаас иргэд нэхэмжлэлээ шуудангаар хүргүүлэх, нэхэмжлэлийн хувийг хариуцагчид шуудан болон цахим шуудангаар гардуулах, хэргийн материалын тодорхой хэсэгтэй шуудангаар болон цахим шуудангаар танилцах, хуралдааны товыг шуудан болон цахим шуудангаар мэдэгдэж байсан. Гэвч ийнхүү цахим систем байхгүй, технологийн хүрэлцээгүй байдал, шуудан болон цахим шуудангийн хэрэглээ нь шүүх хуралдааныг хойшлох, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаа сунахад нөлөөлсөн байна.

Бусад улсуудын хувьд цар тахлаас өмнө цахим шүүхийг хэрэглээнд нэвтрүүлсэн бөгөөд цахим шүүхийн гурван шаардлага болох E-Filling, E-Court, E-Case management гэсэн шаардлагуудыг бүгдийг нэвтрүүлсэн байна. Харин манай улсын хувьд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчийг зайнаас оролцуулахаар заасан ч ямар

³⁹ Шүүх эрх мэдэл сэтгүүл, 2020 он, №1, Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэн, Цахим шүүхийн талаарх гадаадын зарим орны туршлага, 119 дэх тал

тохиолдолд зайнаас оролцуулах талаар хангалттай зохицуулалт байхгүй. Иргэний болон захиргааны хэрэг хянан шийдвэрлэх хуулиудад энэ талаар огт зохицуулалтгүй, мөн бие даасан эрх зүйн зохицуулалт байхгүй байгаа юм.

Манай улсын хувьд 2011 онд Цахим гарын үсгийн тухай хуулийг баталсан ч хэрэглээнд төдийлөн нэвтрүүлээгүй, цахимаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахад түүнийг ашиглаагүй нь учир дутагдалтай байгаа юм. Түүнчлэн цахим гарын үсгийг хэрэглээнд оруулахын тулд түүнийг олгох шаардлагыг ч мөн тодорхой болгох хэрэгтэй нь судалгааны явцад харагдаж байна.

Дан ганц цахим гарын үсгээс гадна иргэдийн хэргийн хөдөлгөөнийг шуудан болон цахим шуудангаар явуулах нөхцөлийг өөрчилж тусгайлсан системтэй болох нь Шүүхийн тухай хуульд заасан төсвийг хэмнэх, иргэнд шүүхийн хүртээмжтэй болгох зорилтыг хангах арга зам юм.

V. ДЭВШҮҮЛЖ БҮЙ САНАЛ

Энэхүү илтгэлийнхээ хүрээнд дараах саналыг дэвшүүлж байна:

Цахим шүүхийн хэрэглээг төлөвшүүлэх, түүний явцад хэргийн оролцогч болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нууцлалыг хангахын тулд эрх зүйн зохицуулалтыг бий болгож, бие даасан цахим системийг хөгжүүлэх шаардлагатай:

- ✓ **Цахим системийг цогцоор хөгжүүлэх:** E-Filling, E-Court, E-Case management буюу шүүхэд гаргадаг мэдүүлэг, мэдээ баримт зэргийг цахимаар гаргах, тухайн цахимаар гаргасан нэхэмжлэл, хариу тайлбарын үндсэн дээр цахимаар шүүх хуралдаан явуулах, ийнхүү цахим системд оруулсан хэргийн оролцогчдод нээлттэй мэдээллийг хянах арга хэмжээг бие даасан цахим системээр хөгжүүлэх шаардлагатай.
- ✓ **Эрх зүйн зохицуулалтад ямар тохиолдолд цахимаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэглэхийг тодорхойлох:** Ийнхүү цахимаар хэрэг маргаан шийдвэрлэхэд талуудын хүсэлтийн үндсэн дээр тодорхой хэргүүдэд ашиглах бөгөөд бусад улсуудын жишигтэй адил иргэний хэргийн тэр дундаа хөдөлмөрийн болон гэрээний маргаан гэх мэт хэргүүдэд ашиглахыг санал болгох нь зүйтэй болов уу. (Харин захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд төрийн нууцын талаар асуудал хөндөгдөж байгаа тохиолдолд хэргийг цахимаар шийдвэрлэх нь зохисгүй юм.)
- ✓ **Цахим гарын үсгийг хэрэглээнд өргөнөөр нэвтрүүлэх:** Ийнхүү нэвтрүүлэхдээ Цахим гарын үсгийн тухай хуульд заасанчлан гэрчилгээг олгох бөгөөд тийнхүү гэрчилгээг ямар байгууллага хэрхэн олгох талаар зохицуулалтыг тодорхой болгох нь зүйтэй.

- ✓ **Цахим шүүхийг нэвтрүүлэхэд түүнийг олон нийтэд таниулах,** хэрэглээг сурталчлах, хэрэглээг нэмэгдүүлснээр өмнө дурдсан давуу талуудыг шүүх эрх мэдлийн салбарт авчрах боломжтой.

VI. АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

6.1. Хууль, хуульчилсан акт

- ✓ Монгол Улсын Үндсэн хууль, 1992
- ✓ Цахим гарын үсгийн тухай хууль, 2011
- ✓ Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, 2016
- ✓ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, 2002
- ✓ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 2017
- ✓ 2021 оны Төсвийн тухай хууль, 2020
- ✓ Монгол Улсын Шүүхийн тухай хууль, 2021
- ✓ Захиргааны хэргийн хөдөлгөөний түр аргачлал
- ✓ Эрүүгийн хэргийн хөдөлгөөний түр аргачлал
- ✓ Иргэний хэргийн хөдөлгөөний түр аргачлал

6.2. Ном сурах бичиг, гарын авлага

- ✓ Б.Чимид, Үндсэн хуулийн мэдлэг, УБ, 2008
- ✓ Г.Совд, Н.Жанцан, Ж.Амарсанаа, С.Жанцан, Монгол улсын Үндсэн хуулийн тайлбар, УБ, 2000
- ✓ Баян-Өлгий аймгийн эрүү, иргэний давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч С.Өмирбек, Шүүхүүдийн харьцуулсан судалгаа
- ✓ Н.Лүндэндорж, Шүүх эрх мэдэл, УБ, 2017
- ✓ Шүүх эрх мэдэл сэтгүүл, 2020 он, Дугаар 1, Шүүхийн судалгаа мэдээлэл, сургалтын хүрээлэн

6.3. Цахим эх сурвалж

- ✓ https://www.judcouncil.mn/site/news_full/9991
Шүүхийн захиргааны байгууллагын стратеги төлөвлөгөө
- ✓ <https://khanlex.mn/wp-content/uploads/2021/05/QA-Paper-MON-version-COVID-19-Business-Issues-in-Mongolia-for-SMEs-updated.pdf> Ковид 19 ба онцгой нөхцөл байдлын үеийн арга хэмжээнүүдийн тухай
- ✓ <http://www.baabar.mn/article/shuukhiig-gaduurkhsan-ulsiiin-tusuw>
Шүүхийн гадуурхсан улсын төсөв нийтлэл
- ✓ <https://www.mglbar.mn/news/3990> Нийтийн мэдээлэл буюу мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай асуудал нийтлэл
- ✓ <http://www.judoinstitute.mn/statistic/> Монгол улсын шүүхийн тайлан, 2019, 2020, 2021 оны 1 дүгээр улирал

- ✓ <https://www.medee.mn/p/163722> Зууны мэдээ сонин, Цахим гарын үсэггүй Дижитал үндэстэн нийтлэл

6.4. Гадаад эх сурвалж

- ✓ <file:///C:/Users/User/Downloads/DB14-Improving-court-efficiency.pdf> Improving court efficiency: the Republic of Korea's e-court experience
- ✓ TOMLINSON, JOE. "Front Matter." Justice in the Digital State: Assessing the Next Revolution in Administrative Justice, 1st ed., Bristol University Press, 2019, pp. i–iv, <https://doi.org/10.2307/j.ctvndv808.1>.
- ✓ <https://www.jstor.org/stable/pdf/j.ctt1wn0qx3.7.pdf> Evaluating e-Justice: The Design of an Assessment Framework for e-Justice Systems
- ✓ https://assets.publishing.service.gov.uk/government/uploads/system/uploads/attachment_data/file/761378/SINGAPORE.pdf State Court of Singapore Why E court system
- ✓ <file:///C:/Users/User/Downloads/132-345-1-PB.pdf> Electronic Courts And The Challenges In Managing Evidence: A View From Inside The International Criminal Court
- ✓ <https://www.judiciary.gov.sg/> Syngapore Court System
- ✓ <file:///C:/Users/User/Downloads/DB14-Improving-court-efficiency.pdf>, Improving court efficiency: the Republic of Korea's e-court experience
- ✓ <https://eng.scourt.go.kr/eng/judiciary/eCourt/eTrials.jsp> Supreme Court of Korea, The Electronic Case Filing System (ECFS, <http://ecfs.scourt.go.kr>) is the Korean Judiciary's electronic litigation system
- ✓ <https://wipo.lex-res.wipo.int/edocs/lexdocs/laws/en/kr/kr028en.pdf>
- ✓ <https://efiling.court.go.ke/> E-Filing, E-Court, [file:///C:/Users/User/Downloads/53-122-1-SM%20\(1\).pdf](file:///C:/Users/User/Downloads/53-122-1-SM%20(1).pdf) Differentiated Use of Electronic Case Management Systems